МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ”

Судалгааны төрөл: **Хэрэгжилтийн үнэлгээ**
Судалгааны код: **БГСТ-25/010**
Хугацаа: **2025.3.13-2025.4.11**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: “Богд судалгааны хүрээлэн” НҮТББ

Улаанбаатар хот
2025

АГУУЛГЫН ТОВЬЁГ

Удиртгал.....1-2

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон үндэсний хууль тогтоомж нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай нэгдсэн үндэсний байгууллагын конвенцод нийцэж буй байдал.....3-4

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенцын хэрэгжилтийн үнэлгээ.....5-143

2.1.Конвенцын 3 дугаар зүйлд заасан “Нийтлэг зарчмууд”.....5-11

2.2.Конвенцын 4 дүгээр зүйл заасан “Нийтлэг үүргүүд”.....12-27

2.3.Конвенцын 5 дугаар зүйлд заасан “Адил тэгш байдал, үл алагчлал”.....27-33

2.4.Конвенцын 6 дугаар зүйлд заасан “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд”.....34-37

2.5.Конвенцын 7 дугаар зүйлд заасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд”.....38-44

2.6.Конвенцын 8 дугаар зүйлд заасан “Мэдлэг ойлголтыг дээшлүүлэх”.....44-48

2.7.Конвенцын 9 дүгээр зүйлд заасан “Хүртээмж”.....48-54

2.8.Конвенцын 10 дугаар зүйлд заасан “Амьд явах эрх”.....54

2.9.Конвенцын 11 дүгээр зүйлд заасан “Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал”.....55-58

2.10.Конвенцын 12 дугаар зүйлд заасан “Хуулийн өмнө тэгш байх эрх”.....58-61

2.11.Конвенцын 13 дугаар зүйл заасан “Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрх”.....61-67

2.12.Конвенцын 14 дүгээр зүйлд заасан “Эрх чөлөө, хувийн халдашгүй байх эрх”.....67-70

2.13.Конвенцын 15 дугаар зүйлд заасан “Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх”.....70-73

2.14.Конвенцын 17 дугаар зүйлд заасан “Хувийн нэгдмэл байдлыг хангах эрх”.....73-76

2.15.Конвенцын 18 дугаар зүйлд заасан “Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх”.....77-79

2.16.Конвенцын 19 дүгээр зүйлд заасан “Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх”.....79-82

2.17.Конвенцын 20 дугаар зүйлд заасан “Хувийн хөдөлгөөнийг дэмжих”.....82-85

2.18.Конвенцын 23 дугаар зүйлд заасан “Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх”.....86-88

2.19.Конвенцын 24 дүгээр зүйлд заасан “Сурч боловсрох эрх”.....88-91

2.20.Конвенцын 25 дугаар зүйлд заасан “Эрүүл мэндээ үйлчилгээгээр хангагдах эрх.....91-97

2.21.Конвенцын 26 дугаар зүйлд заасан “Нөхөн сэргээлт”.....97-105

2.22.Конвенцын 27 дугаар зүйлд заасан “Ажил хөдөлмөр эрхлэлт”.....105-113

2.23.Конвенцын 28 дугаар зүйлд заасан “Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал”.....114-119

2.24.Конвенцын 29 дүгээр зүйлд заасан “Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрх”.....119-128

2.25.Конвенцын 31 дүгээр зүйлд заасан “Статистик болон мэдээлэл цуглуулах”.....128-133

2.26.Конвенцын 32 дугаар зүйлд заасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал”.....134-138

2.27.Конвенцын 33 дугаар зүйлд заасан “Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих”.....139-143

Гурав. Нэгдсэн үндэсний байгууллагын хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт 2015 онд ирүүлсэн зөвлөмж, конвенцын 2 ба 3 илтгэлийг боловсруулах богино асуумжийн дагуу сайжруулах, шинэчлэх хууль тогтоомжийн жагсаалт.....144

Дөрөв.хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах чиглэлээр гадаад улс орны хууль тогтоомж харьцуулсан судалгаа.....144-165

Тав. Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж, санал.....166-182

Зургаа. Ном зүй.....183-186

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

1. ААНБ – Аж Ахуйн Нэгж Байгууллага
2. БЗД – Баянзүрх Дүүрэг
3. БШУЯ – Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
4. ГБХНХЯ – Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
5. ЗГ – Засгийн газар
6. МҮОНРТ – Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
7. НҮБ – Нэгдсэн Үндэстний Байгууллага
8. НҮБХС – Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
9. ОХУ – Оросын Холбооны Улс
10. ОУБ – Олон Улсын Байгууллага
11. УИХ – Улсын Их Хурал
12. ТББ – Төрийн Бус Байгууллага
13. ХБХ – Хөгжлийн Бэрхшээлтэй Хүн
14. ХЗДХЯ – Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам
15. ҮСХ – Үндэсний Статистикийн Хороо
16. ХЭҮК – Хүний Эрхийн Үндэсний Комисс
17. ХБХСЗХТ – Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Сэргээн Засах Хөгжлийн Төв
18. ХБХЭТК – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
19. ХБХЭтХ – Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
20. ХХК – Хариуцлагатай Хязгаарлагдмал Компани
21. ЭШУС – Эрүү Шүүлтээс Урьдчилан Сэргийлэх Хороо
22. ЭМЯ – Эрүүл Мэндийн Яам
23. ЭМДЕГ – Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий Газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон мэдээлэл.....4

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон мэдээлэл, хөгжлийн бэрхшээлийн ангилал.....4

Хүснэгт 3. Боловсролын ерөнхий хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....13

Хүснэгт 4. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....16

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....16

Хүснэгт 6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....16

Хүснэгт 7. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....17

Хүснэгт 8. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллын орон сууцжуулах тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....17

Хүснэгт 9. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....17

Хүснэгт 10. Төмөр замын тээврийн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....18

Хүснэгт 11. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....18

Хүснэгт 12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....18

Хүснэгт 13. Улс төрийн намийн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....19

Хүснэгт 14. Биеийн тамир спортын тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....19

Хүснэгт 15. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....21

Хүснэгт 16. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....21

Хүснэгт 17. Соёлын бүтээлч үйлдвэлэлийг дэмжих тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....21

Хүснэгт 18. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....21

Хүснэгт 19. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....22

Хүснэгт 20. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....22

Хүснэгт 21. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....23

Хүснэгт 22. Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой зүйл, хэсэг, заалт.....23

Хүснэгт 23. Хөдөлмөрийн тухай хуулийн 1999 болон 2021 онуудын харьцуулалт.....109

Хүснэгт 24. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгууль өгөх эрхийг зохицуулсан хуулийн зүйл, хэсэг, заалтууд.....121

Хүснэгт 25. Мэдээллийн эх үүсвэр.....130

Хүснэгт 26. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүн.....141

Хүснэгт 27. Боловсролын үнэлгээний үе шат, АНУ.....150

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Конвенцын хэрэгжилтийг үнэлэх дараалал……..……..5
Зураг 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын боловсролын түвшин ……...……..89
Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт.....89
Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувиар).....107
Зураг 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдал (тоон үзүүлэлт).....108
Зураг 6. Ажил хайгчаар бүртгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын түвшин.....108
Зураг 7. Сонгогчдын ирцийн мэдээлэл (хувиар)…….....…..123
Зураг 8. Сонгогчдын ирцийн мэдээлэл (насны бүлгээр)…….....…..123

УДИРТГАЛ

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх нийгмийн хандлагыг өөрчлөх чиглэлээр олон арван жилийн хөдөлмөрийн үр дүнд бий болсон [1] Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенц болон түүний нэмэлт протокол нь 2006 онд 12-р сарын 13-ны өдөр батлагдсан.[2] Тус конвенц болон нэмэлт протоколд 2025 оны 04 дүгээр сарын байдлаар 192 улс нэгдэн орсон байна.[3]

Монгол Улс 2008 оны 12-р сарын 19-ний өдөр баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг соёрхон батлах тухай” Монгол Улсын хуулиар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц (цаашид “Конвенц” гэх), түүний нэмэлт протоколыг соёрхон баталсан.[4]

Улмаар 2011 онд Монгол Улсын Засгийн газар конвенцын анхны тайлан илтгэлээ НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо (цаашид “хороо” гэх)-нд илгээсэн бөгөөд 2015 оны 04-р сарын 8 болон 9-ний өдөр Монгол Улсын анхны тайлан илтгэлийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны 188, 189 дүгээр хурлаар авч хэлэлцэж, 2015 оны 4-р сарын 17-нд дүгнэлт, зөвлөмж гаргаж, Монгол Улсын Засгийн газарт 37 зөвлөмж, 3 шаардлага, 1 хүсэлт хүргүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газар Зөвлөмжийн 32, 46-р заалтыг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээний талаар 12 сарын дотор буюу 2016 оны 4-р сарын 17-ноос өмнө бичгээр хариу өгөх, мөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хамруулж хоёр, гурав дахь тайлангаа нэгтгэн 2019 оны 6-р сарын 13-ны дотор НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд хүргүүлэхийг хүссэн байдаг. Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны болон бусад төлөөллүүд 2023 оны 08-р сары 17, 18-ний өдрүүдэд явагдсан НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны 658, 659 дүгээр хуралдаанд дээрх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн газрын тайлан, мэдээллийг танилцуулж, хамгаалсан.[5]

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгохоор заасан бөгөөд энэхүү үзэл баримтлалд суурилан Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа шинжээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баталгаажуулсан. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд амьд явах эрх, халдашгүй, чөлөөтэй байх, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох, гадаадад явах, эх орондоо буцаж ирэх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох зэрэг 50 гаруй

---

[1]United Nations, Department of Econimic and Social Affairs, Social Inclusion, Convention On The Rights Of Persons With Disabilities (CRPD) - https://social.desa.un.org/issues/disability/crpd/convention-on-the-rights-of-persons-with-disabilities-crpd.

[2]United Nations, Sixty-first session of the General Assembly by resolution A/RES/61/106, Convention On The Rights of Persons With Disabilities (CRPD).

[3]United Nations, Department of Econimic and Social Affairs, Social Inclusion, Convention On The Rights Of Persons With Disabilities (CRPD) - https://social.desa.un.org/issues/disability/crpd/convention-on-the-rights-of-persons-with-disabilities-crpd.

[4]Монгол Улсын Хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг соёрхон батдах тухай, 1 дүгээр зүйл. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдөр баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай., үзэх - https://legalinfo.mn/mn/detail/10034.

[5]Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, https://mlsp.gov.mn/content/detail/3389

үндсэн эрхийг баталгаажуулсан. Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд Монгол Улсын иргэний үндсэн үүргийг зааж, 19 дүгээр зүйлээр төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахыг тодорхойлсон билээ.

Түүнчлэн Үндсэн хуулиас эх авсан нийт 930 орчим хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагийн 95 хууль тогтоомжид (2025 оны 04 дүгээр сарын байдлаар) хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар тусгасан байх бөгөөд тэдгээрийг холбогдох зүйл, хэсэг, заалтаар дэлгэрүүлэн зохицуулжээ.[6]

Энэхүү үнэлгээний гол зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг баталгаажуулсан дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцтой Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, дотоодын бусад хуулиуд хоорондын нийцэл, давхардал, зөрчил, хийдэл байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, үр дүнд үндэслэн бодлогын зөвлөмж болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг дэвшүүлэхэд оршино.

[6]Хавсралт – 1, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц дотоодын хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зохицуулалтын харьцуулсан хүснэгт.

НЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ НЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦОД НИЙЦЭЖ БУЙ БАЙДАЛ

Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг баталгаажуулсан суурь хууль нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль юм. 2023 оны 06 дугаар сарын байдлаар Монгол Улсад 854 хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж[7] байх ба тэдгээрийн 81 хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зүйл заалтууд тусгайлан орсон байдаг.[8] Мөн 2017 онд ХНХЯ, БШУЯ, ЭМЯ-ны хамтарсан тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2022 он дуустал, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр” зэргийг тухай бүр батлан хэрэгжүүлж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбогдсонхууль тогтоомжуудад нийцүүлэн гаргасан хэм хэмжээний актууд (дүрэм, журам, стандарт)-ыг шүүн үзвэл журам - 19, дүрэм 4, стандарт - 12[9] болон аргачлал, жишиг зэрэг нийт 120 орчим эрх зүйн баримт бичиг байна.

Улсын Их Хурлаас 2006 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын асуудлын үйлчилгээг л зонхилон зохицуулж байсан бол 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалд өртөхөөс хамгаалах, хориглох, түүнчлэн нийгмийн (боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, соёл, спорт г.м) харилцаанд бусдын адил тэгш эрхтэй оролцох боломжийг хангах зохицуулалтыг тусгасан. Мөн энэ хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүнд нэн тэргүүн тулгамдаж байгаа нийтийн тээвэр, зам, орон сууц, тэдний онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэх байдлаар хүртээмжтэй байдлыг хангахын тулд хэрэгжүүлэх арга хэмжээг заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс 2 жилийн дараа уг хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн зохицуулалт зорилгодоо хүрч чадаагүй, талууд нэгдмэл ойлголтод хүрээгүй, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаагүйгээс төсөв хөрөнгө дутагдалтай, хүний нөөц, чадавх сул, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Түүнчлэн хуулийн зохицуулалтын давхардал 24.4 хувь, зөрчил 35.5 хувь, хийдэл 13.3 хувь байгаа тул хууль хоорондын нийцлийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай талаар дүгнэжээ.[10]

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйлээс 34 дүгээр зүйл хүртэл (конвенцын 34-50 дугаар зүйл болон конвенцын нэмэлт протокол нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Хорооны үйл ажиллагааг зохицуулсан тул хэрэгжилтийг авч үзэхгүй) зүйл, хэсэг, заалт бүрийг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжууд, тэдгээрийн зүйл, хэсэг, заалтуудтай харьцуулахад Монгол Улсын Үндсэн хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбогдсон зүйл,

[7]Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем Legalinfo.mn сайд 2023 оны 06-р сарын 24-ний өдөр хандав.
[8]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, “Бэрх биш ээлтэй” төсөл, “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт – 2021”, Эрдэм шинжилгээний онол практикийн хурлын эмхтгэл, 17 дахь тал.
[9]Хавсралт – 2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх дүрэм, журам, стандартын жагсаалт, 2023.
[10]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка төсөл, Хууль зүйн доктор, Д.Сүнжид, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”, 2018 он, 57-83 дахь тал.

хэсэг, заалт 11, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд 100 зүйл, хэсэг, заалт, бусад хуулиудад 172 зүйл, 144 хэсэг, 125 заалт тус тус хуульчлагдсан байна.

Үндэсний хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг баталгаажуулах конвенцод нийцсэн зохицуулалт тусгагдсан хэдий ч хуулийн бүхий л зүйл, хэсэг, заалт шууд зорилгодоо хүрч чадаагүй, хууль хэрэглээний хувьд нэгдмэл байдал төлөвшөөгүй, улмаар шаардлагатай хөрөнгө мөнгө болон хүний нөөцийн бэлтгэх шилжилтийн бэлтгэл үе байх хугацаагүйгээр хууль үйлчилж эхэлсэнтэй холбоотой хуулийг хэрэгжүүлэх механизм, хоорондын уялдаа холбоо сул, төрийн байгууллагуудын үүрэг зарим талаар хэт ерөнхий тусгагдсан, мөн хуулийг хэрэглэж байгаа албан хаагчдын хандлага, мэдлэг, туршлагатай холбоотой[11] бэрхшээл, шийдвэрлэх асуудлууд үүсэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлага зарим талаар хэвээр үргэлжилсээр байна.

Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон мэдээллийн хувьд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны мэдээллээр нийт 115,115[12] байсан бол 2023 оны мэдээллээр энэ тоо 111,228 болж буурсан байна.

Хүйс	2021	2022	2023
Эмэгтэй	45922	49096	47430
Эрэгтэй	60247	66019	63798
Нийт	**106169**	**115115**	**111228**

Хүснэгт - 1.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон мэдээлэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн ангиллаар авч үзвэл харааны бэрхшээлтэй иргэн 12,696, ярианы бэрхшээлтэй 4220 иргэд, сонсголын бэрхшээлтэй 8780, хөдөлгөөний бэрхшээлтэй 21064 иргэд, оюун ухааны хомсдолтой 0 иргэн, сэтгэцийн бэрхшээлтэй 21639 иргэд, хавсарсан 7580 иргэд, бусад хөгжлийн бэрхшээлтэй 39136 иргэд байна гэсэн судалгааг Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас гаргасан байна.[13] Үүнээс 2023 оны 06 дугаар сарын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүйсийн тоо, Улаанбаатар хот, хөдөө орон нутагт байгаа иргэдийн тоон мэдээллийг дараах хүснэгтээр харуулав.

№	Хөгжлийн бэрхшээлийн ангилалаар	Эрэгтэй хүний тоо \улсын хэмжээнд\	Эмэгтэй хүний тоо \улсын хэмжээнд\	Нийт
1.	Харааны бэрхшээл	7488	4565	12053
2.	Хэл ярианы бэрхшээл	2040	1578	3618
3.	сонсголын бэрхшээл	4275	3525	7800
4.	хөдөлгөөний бэрхшээлтэй	12116	7902	20018
5.	сэтгэцийн бэрхшээлтэй	11439	9957	21396

[11]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка төсөл, Хууль зүйн доктор, Д.Сүнжид, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”, 2018 он, 88 дахь тал.

[12]http://www.gadpwd.gov.mn/index.php/page/591

[13]Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 04-р сарын 10-ны өдрийн албан бичгийн хавсралт.

6.	хавсарсан	4316	3093	7409
7.	Бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	22124	16810	38934

Хүснэгт – 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон мэдээлэл, хөгжлийн бэрхшээлийн ангиллаар /2023 он/.[14]

ХОЁР. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсад нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилт болон түүнтэй холбоотой эрх зүйн орчныг тодорхойлох, үнэлэх тусгайлсан аргачлал байдаггүй тул Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль, тус хууль нийцүүлэн гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал” болон зургаадугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа, холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-ыг удирдлага болгон ашиглалаа.

Зураг 1. Конвенцын хэрэгжилтийг үнэлэх дараалал:

Дээрх ерөнхий аргачлал болон Хууль тогтоомжийн тухай хууль, тус хуульд нийцүүлэн боловсруулсан бусад аргачлалд үндэслэн конвенцийн хэрэгжилт, цаашлаад тэдгээрийг хэрэгжүүлж буй бусад хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтуудыг хэрэгжилтийн үнэлэхийг зорино.

Конвенцын 3 дугаар зүйлд заасан “Нийтлэг зарчмууд”-ийн тухайд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын зарчмуудыг дотоодын хууль тогтоомжид тусгагдсан байдал:

а) сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;

a. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх зарчмыг зааж, 31 дүгээр зүйлд хувийн нууцыг хамгаалах, 32 дугаар зүйлд бие даан амьдрах эрхийг баталгаажуулахаар нарийвчлан зохицуулсан.

[14]Мөн тэнд

b. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т хүний эмзэг мэдээлэлд эрүүл мэндийн мэдээлэл хамаарахаар, 4.1.15-д "эрүүл мэндийн мэдээлэл" гэж хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг ойлгохоор заасан бөгөөд хүний эмзэг мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах 9 дүгээр зүйлд хүний эмзэг мэдээллийг хуульд заасан төрийн байгууллагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагад тайлбар, мэдүүлэг, нотлох баримт гаргах гурван зорилгоос өөрөөр ашиглахыг хориглохоор тусгасан.

c. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1-д худал мэдээлэл тараах гэмт хэрэг, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах зохицуулалт нь бүх хүнд адил үйлчилнэ.

d. Боловсролын ерөнхий хуулийн 8.3-т “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийн дагуу ганцаарчилсан сургалт явуулж болно.” гэж заасан.

e. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1.3-т “бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх” гэж тусгасан.

b) алагчлахгүй байх;

a. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т ”хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг ойлгохоор заасан бөгөөд 5 дугаар зүйлийн 5.1.1-д хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих зарчмыг баримтлахыг заасан.

b. 2021 оноос хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг ... хөгжлийн бэрхшээлээр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглохоор заасан.

   Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т иргэнийг сурч боловсроход ... нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэндээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангахаар зохицуулсан.

   Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд ” 4.1.Гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэнэ.”, “4.2.Иргэнийг гэрлэхэд нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.” гэж заасан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нэгэн адил үйлчилнэ.

c. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1.3-т “бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх” гэж тусгасан.

d. Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд шударга ёсны зарчмын хүрээнд 1.2 дахь хэсэгт гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад ... хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй болохыг заасан. Мөн хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт ялгаварлан гадуурхах гэмт хэргийг 2017 онд анх удаа тусгайлан заасан. “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан.

c) нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;
   a. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зарчмыг баримтлахаар 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй болохыг заасан бөгөөд тус хуулийн хоёрдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх, гуравдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ, Дөрөвдүгээр бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх, Тавдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, Зургаадугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, Долдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олон түшиглэн хамруулан хөгжүүлэх, Наймдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, Есдүгээр бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад эрх, Арван нэгдүгээр бүлэг Төрийн байгууллага, хуулийн этгээдийн үүрэг гэсэн бүлэгт нарийвчилан зохицуулсан.
   b. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуультай уялдаатайгаар Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Улс төрийн намын тухай, Биеийн тамир, спортын тухай, Барилгын тухай, Автозамын тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай, Соёлын тухай, Биеийн тамир, спортын тухай зэрэг бусад хуулийн холбогдох заалтаар тухайлан зохицуулжээ.

d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;
   a. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх, 5.1.4-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх зарчмыг баримтлахаар заасан.

b. Энэхүү зарчим нь конвенцын 3 дугаар зүйлийн a,b,c,e,f-д заасан зарчмуудтай нягт уялдаа холбоотой, цогцоор хэрэгжих тул бусад зарчмын тайлбараас зохих мэдээллийг авах боломжтой.

e) тэгш боломж олгох;

a. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх зарчмыг баримтлахаар зааж, тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д "хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг ойлгохоор томьёолжээ.

b. Боловсролын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх зарчмыг баримтална гэж; 10 дугаар зүйлийн 10.1.9-д “хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангагдах”, 10.1.11-д “ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах;” эрхтэй гэж, 13 дугаар зүйлийн 13.2.2-т багш нь “суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх” үүрэгтэй гэж, 31 дүгээр зүйлийн 31.1.6-д сум, дүүргийн Засаг дарга нь “тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх” гэж, 38 дугаар зүйлийн 38.2-т “Хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломж олгох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоож санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.” хэмээн тус тус зааснаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн сурч боловсрох явцад бусдын адил тэгш боломжоор, сургалтын орчноор хангах зохицуулалтуудыг тусгасан байна.

c. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.1 дэх хэсэгт Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үүрэгтэй. 144.2 дахь хэсэгт Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна. 144.3 дахь хэсэгт Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө хэмээн заасан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15 дугээр зүйлийн 15.1.4-т хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний

урамшууллыг нэг удаа олгох; 15.1.5-д хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулахаар тус тус заажээ.

d. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхийг боловсрол, хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн салбарт хангах зорилгоор төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 29.1.1.хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх; 29.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах; 29.1.3.гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг тэдгээрийн сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэшлийн түвшинд чанартай үзүүлэх; 29.1.4.гэрч, хохирогчийг хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн байхаар зохицуулжээ. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тэгш боломж олгох хуулийн зохицуулалт юм.

f) хүртээмжтэй байх;

a. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зарчмыг баримтлахаар заасан бөгөөд тус хуулийн хоёрдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх, Гуравдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ, Дөрөвдүгээр бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх, Тавдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, Зургаадугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, Долдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олон түшиглэн хамруулан хөгжүүлэх, Наймдугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, Есдүгээр бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад эрх, Арван нэгдүгээр бүлэг Төрийн байгууллага, хуулийн этгээдийн үүрэг гэсэн бүлэгт нарийвчлан зохицуулсан. Ялангуяа энэ хуулийн гуравдугаар бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, орон сууц, дэд бүтцийн байгууламж, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх талаарх зарим зохицуулалт тусгагдсан.

b. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.4 дэх хэсэгт “Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх

бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.”, 62.3.Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна.”, 66 дугаар зүйлийн 66.9 дэх хэсэгт “Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар саналаа өгч болно.”

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн хурлын Төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуульд Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулий зохицуулалттай адил агуула бүхий хуулийн хэсэг, заалтыг 61.3 61.4, 62.1 дэх хэсэгт заажээ.

c. Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх; 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт Барилга байгууламжийн зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шаардлагыг тусгана хэмээн заасан.
d. Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т “Төрөөс боловсролын хүртээмж, суралцах тэгш нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээг улсын болон орон нутгийн төсөв дэх ачааллыг бууруулж, үе шаттай шийдвэрлэх зорилгоор дараах нөхцөлөөр хөрөнгө оруулалтын элэгдлийн зардлыг нэг хүүхдэд ногдох норматив тогтоон жил бүр санхүүжүүлж болно”, 39.10.3-т “төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж багатай, нэмэлт элсэлт авах боломжгүй байршилд аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан сургалтын зориулалтаар барьсан барилга, байгууламжийг эзэмших, ашиглахтай холбогдсон зардал.” гэж, 42 дугаар зүйлийн 42.1.3-т “боловсролын салбар, хүний нөөц, техник, технологийн хөгжил дэвшил, чанар, хүртээмж зэрэг чиглэлээр шилдэг туршлага, ололтыг нэвтрүүлэхэд хамтран ажиллах” эрхийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоонд олгосон байна.

g) эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй байх;
   a. Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургаадугаар зүйлийн 16.11-д улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй хэмээх заалтад нийцүүлэн салбар хууль тогтоомжоор эмэгтэй, эрэгтэйчүүдийн тэгш эрхийн зарчмыг салбар бүрт баталгаажуулдаг.
   b. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд боловсрол, эрүүл мэнд, төрийн алба, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, эдийн засаг, гэр бүлийн хүрээнд долоон чиглэлээр тодорхойлон заасан.
   c. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах, тухайн хүүхэд, залуучуудын онцлог, хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг

ердийн сургуулиудад зохион байгуулах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээхээр тусгажээ.

е) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах.

d. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх зарчмыг баримтлахаар заасан.

e. Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна; 5.1.4-т иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана; 39.7 дэх хэсэгт Орон нутгийг боловсон хүчнээр хангах, чухал хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн авьяасыг дэмжих, орлого багатай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол эзэмшихэд зориулж сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох бөгөөд тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална. 42.1 дэх хэсэгт Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна. 43.2.7-д суралцагчийн онцгой авьяас, чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх, урамшуулан дэмжих, өнчин, амьжиргааны түвшин доогуур, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг сурах нөхцөл бололцоогоор төрөөс хангах; 44.2.8-д хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн бие эрхтэн, хөгжлийн онцлогийг хүндэтгэн үзэж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бусдын адил тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх үүргийг тус тус заажээ.

Товч дүгнэлт: Конвенцын үндсэн 8 зарчмын агуулгуудыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тодорхойлон заасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд зарчмуудыг голчлон зохицуулж, салбарын бусад хуульд төрөлжсөн харилцааг нарийвчилсан байдлаар зохицуулжээ.

Энэхүү конвенцын үндсэн 8 зарчим нь конвенцын бусад заалтуудтай нягт уялдаа, холбоотой бөгөөд бусад заалтад зарчмыг дэлгэрэнгүй тайлбарлаж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхой зохицуулсан байдаг тул конвенцын бусад заалтын хэрэгжилт тус бүрийг судалгааны дараах хэсгээр нарийвчлан авч үзэж, практикт хэрэгжилтийг үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.

Конвенцын 4 дүгээр зүйлд заасан “Нийтлэг үүргүүд”-ийн тухайд

Конвенцын 4 дүгээр зүйлд:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчилалгүйгээр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг оролцогч улсууд хангаж, хөхиүлэн дэмжих үүрэг хүлээнэ. Эл зорилгоор улсууд дараах үүрэг хүлээнэ;

а) энэхүү конвенцод заасан эрхийг эдлүүлэхийн тулд хууль тогтоох, захиргааны болон холбогдох бусад арга хэмжээ авна;

Монгол Улсын хувьд конвенцод заасан бүхий л эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эдлүүлэхийн шаардлагатай эрх зүйн орчны шинэтгэлийг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд үүний жишээ нь Конвенцын анхан тайланг хэлэлцүүлж, хорооны зөвлөмж 2015 онд ирсний дараа буюу 2016 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн суурь харилцааг зохицуулсан үндсэн хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинэчлэн баталсан явдал юм. Мөн энэхүү хуулийг дагалдан нийт 17 хэм хэмжээний акт (дүрэм, журам, аргачлал зэрэг) гарах ёстой хэдий ч үүнээс 10 нь батлагдан хүчин төгөлдөр үйлчилж байна.

Цаашилбал, 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаатай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам тус хуулийн хэрэгжилтийг үнэлүүлсэн бөгөөд тус үнэлгээгээр хуулийн олон салбарын харилцааг нэг хуульд тусгах гэж оролдсон, зохицуулалтын хүрээ хязгаараа зөв тогтоогоогүй, хуулийг хэрэгжүүлэх зардал, төсвийг орхигдуулсан зэрэг шалтгаанаас хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа талаарх дүгнэлт[15] байна.

Мөн 2022-2023 онуудад Монгол Улсын Засгийн газраас Конвенцын 9 дүгээр зүйлд заасан хүртээмжийн хэсэгтэй холбоотойгоор “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлэн санал авч байна.

Тэрчлэн 2023-2025 онуудад батлагдсан нийт 80 орчим хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон хүртээмжтэй байдлаар зохицуулалт агуулсан нийт 20 хууль тогтоомж байна. Үүнд:

2023, 2024, 2025 ОНД БАТЛАГДСАН МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТУУД

I. Боловсролын ерөнхий хууль /2023.07.07/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	3.1.24	Хуулийн нэр томьёоны тодорхойлолт	"ялгаатай хэрэгцээ" гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг.
2.	5.1.3	Боловсролын зарчим	тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх;
3.	6.5	Боловсрол эзэмшүүлэх сургалтын хэл	Сонсголын бэрхшээлтэй суралцагчид боловсрол эзэмшүүлэх сургалт, үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан дохионы хэлээр явуулна.

[15]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүйн доктор Д.Сүнжид, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, 2018 он 65-68 дахь тал.

4.	8.3	Боловсрол эзэмшүүлэх сургалтын хэлбэр	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийн дагуу ганцаарчилсан сургалт явуулж болно.
5.	10.1.9	Суралцагчийн эрх, үүрэг	хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангагдах;
6.	10.1.11	Суралцагчийн эрх, үүрэг	ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах;
7.	11.6	Суралцагчийн нийгмийн баталгаа	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохирох хэрэглэгдэхүүн, дэмжих үйлчилгээгээр хангагдана.
8.	13.2.2.	Багшийн эрх, үүрэг, багш, ажилтны нийгмийн баталгаа	суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх;
9.	16.3	Боловсролын стандарт	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байр, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дадлага сургалтад хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчинд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасан холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөнө.
10.	17.8	Боловсролын байгууллага	Энэ хуулийн 17.6-д заасан төв нь танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлж болно.
11.	17.9.	Боловсролын байгууллага	Боловсролын, эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төв ажиллуулж болно.
12.	27.1.11	Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд ашиглах ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагыг батлах;
13.	28.2.7	Боловсролын асуудал	өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад хоол хүнсний

		эрхэлсэн орон нутгийн байгууллага	хангамж, сургалтын орчны аюулгүй байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тохирох орчныг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
14.	31.1.6	Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх	тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;
15.	32.1.3	Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх	тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;
16.	36.4	Боловсролын төлөвлөлт, тайлагналт	Энэ хуулийн 36.1, 36.2, 36.3-т заасан этгээд боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалт болон нөөцийг хуваарилах, сургалтын байгууллага байгуулах, бүтэц, хамран сургах тойрог тогтооход хүн амын нягтаршил, суурьшил, дэд бүтэц, бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулсан газар зүйн мэдээллийн системд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.
17.	38.2.	Боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт	Хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломж олгох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоож санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.
18.	38.5.4	Боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт	цэцэрлэгт хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоол, сургуулийн суралцагчийн дотуур байрны хоолны зардал;
19.	38.8	Боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт	Нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, бүс, орон нутгийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээнд үндэслэн мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн авьяас, чадварыг дэмжих, зорилтот бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгоно.
20.	39.1	Боловсролын сургалтын байгууллагын орчин	Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.
21.	39.9	Боловсролын сургалтын байгууллагын орчин	Боловсролын сургалтын байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон бусад хуульд заасны дагуу тэгш боломж олгосон, хүртээмжтэй, хувь хүний хөгжил, сурч боловсрох

			хэрэгцээ шаардлагыг хангасан таатай орчин бүрдүүлсэн байна.
22.	39.10	Боловсролын сургалтын байгууллагын орчин	Төрөөс боловсролын хүртээмж, суралцах тэгш нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээг улсын болон орон нутгийн төсөв дэх ачааллыг бууруулж, үе шаттай шийдвэрлэх зорилгоор дараах нөхцөлөөр хөрөнгө оруулалтын элэгдлийн зардлыг нэг хүүхдэд ногдох норматив тогтоон жил бүр санхүүжүүлж болно:
23.	39.10.3	Боловсролын сургалтын байгууллагын орчин	төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж багатай, нэмэлт элсэлт авах боломжгүй байршилд аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан сургалтын зориулалтаар барьсан барилга, байгууламжийг эзэмших, ашиглахтай холбогдсон зардал.
24.	42.1.3	Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны эрх, үүрэг	боловсролын салбар, хүний нөөц, техник, технологийн хөгжил дэвшил, чанар, хүртээмж зэрэг чиглэлээр шилдэг туршлага, ололтыг нэвтрүүлэхэд хамтран ажиллах;

II. Гэрийн тэжээвэр амьтны тухай /2023.12.08/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	8.3.	Асран хамгаалагч, түр харагчийн эрх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.12-т заасан хөтөч нохойтойгоо олон нийтийн газар, орон сууцны орчны газар, гудамж, талбай болон олон нийтийн үйлчилгээний газар чөлөөтэй зорчих, нэвтрэх, үйлчлүүлэх эрхтэй.

III. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /2023.07.07/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	21.22	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт	Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.
2.	35.9.4	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, нийгмийн даатгалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг байгууллага, судлаач, ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль ёсны эрх ашгийг хамгаалах байгууллагын

			төлөөллийг хуралдаанд оролцуулж, тайлбар, мэдээлэл авч, саналыг сонсох;

IV. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай /2023.07.07/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	16.1.2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх	тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл 19 нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд;
2.	16.1.3	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх	тэжээгчийн хууль ёсоор асран хамгаалж, харгалзан дэмжиж байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл 19 нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон ач, зээ;
3.	16.1.4	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх	тэжээгчийг нас барахын өмнө энэ хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн, эсхүл хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон эхнэр, нөхөр, тэжээн тэтгэх өөр хүнгүй эцэг, эх.

V. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай /2023.11.10/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	1.7	Нийгмийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:	1.7.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл - 2,809.100,000₮

VI. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай /2023.12.07/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	1.1	Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төрөл, хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахад оршино.
2.	7.1	Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан	Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна:

3.	7.1.1	Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан	нийслэлийн нийтийн тээвэрт ашиглах автобусны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
4.	18.1.3	Нийслэлийн Засаг даргын чиг үүрэг	иргэний явганаар зорчих зам, дэд бүтцийн хүртээмж, дугуйн замын сүлжээг сайжруулах, нэмэгдүүлэх;

VII. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай /2023.07.07/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	4.4	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмших хугацаа, элсэх нас	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд зургаан настай хамрагдаж болно.
2.	6.5	Тэгш хамран сургалт	Сургуулийн захиргаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй зөвшилцөн тухайн суралцагчийн танхимд хичээллэх хугацааг уян хатан тогтоож болно. Уг тогтоосон хугацаа нь ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөгөөр судлах хичээлийн цагийг өөрчлөх үндэслэл болохгүй.
3.	6.7	Тэгш хамран сургалт	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч энэ хуулийн 14.1, 14.3-т зааснаас гадна тусгай хэрэгцээт боловсролын багш, багшийн туслах, эмч, сувилагч, сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтантай байна.
4.	6.9	Тэгш хамран сургалт	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллаж байгаа багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгоно.
5.	7.4	Сургалтын хэл	Боловсролын ерөнхий хуулийн 6.5-д заасан сонсголын бэрхшээлтэй суралцагч ерөнхий боловсролыг бичгийн болон монгол дохионы хэлээр эзэмшинэ.
6.	11.9	Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн	Харааны бэрхшээлтэй, энэ хуулийн 7.2-т заасан суралцагчид зориулан сурах бичгийг хөрвүүлнэ. Үндэстний цөөнх, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эх хэлний сурах бичгийг зохионо.
7.	17.1.4	Удирдах болон бусад ажилтны үүрэг	сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, урвалж бодис, хэрэглэгдэхүүн, сурах бичиг, ном, гарын авлагын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, энэ асуудлаар олон нийтийн оролцоо, түншлэлийг хөгжүүлэх;
8.	17.1.7	Удирдах болон бусад ажилтны үүрэг	байгууллагын соёл төлөвшүүлэх, суралцагчид ээлтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэхэд хамт олныг манлайлан удирдах;

9.	18.5	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнээс хамааран боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль байж болно.
10.	18.6	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага	Энэ хуулийн 18.5-д заасан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
11.	28.6.4	Нутгийн удирдлагын үүрэг, хариуцлага	хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих;

VIII. Төмөр замын тээврийн тухай /2023.07.07/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	5.1.2	Төмөр замын тээвэрт баримтлах зарчим	үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангасан, тогтвортой байх;

IX. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай /2023.05.04/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	8.1.3	Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага	бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх;

X. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /2023.06.16/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	8.4.5	Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, давуу эрх тооцох	ажиллах хүчний 30 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуй эрхлэгч үйлдвэрлэсэн.
2.	10.9	Тендер шалгаруулалтын зохион байгуулалт	Захиалагч энэ хуулийн 12.7-д заасан тусгайлсан шаардлагын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сургах, нийгмийн амьдралд оролцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээр гэрээний үүрэг гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно.
3.	12.3	Техникийн тодорхойлолт	Техникийн тодорхойлолтод хүний эрүүл мэнд, байгаль орчин, уур амьсгалд нөлөөлөх нөлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх шалгуур үзүүлэлтийг тусгаж болно.

4.	56.5.5	Худалдан авах ажиллагааны улсын байцаагч	энэ хуулийн 10.9-д зааснаар, эсхүл давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг зохих ёсоор оролцуулаагүй, эсхүл давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй.

XI. Улс төрийн намын тухай /2023.06.16/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	6.1.1	Биеийн тамир, спортын үйл ажиллагааны зарчим	биеийн тамир, спортын үйл ажиллагаа нийтэд хүртээмжтэй, тогтвортой байх;
2.	8.5	Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх	Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана.
3.	9.4	Улс төрийн намын үйл ажиллагааг цахимаар явуулах, ил тод байдлыг хангах	Нам цахим хуралдаан, санал хураалтыг зохион байгуулахдаа цахим системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах боломжит арга хэмжээг авах бөгөөд нууц санал хураалтыг цахимаар явуулсан тохиолдолд түүний нууцлалыг алдагдуулахгүй.
4.	26.3.1	Улс төрийн намын орлогын эх үүсвэр	төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх;
5.	27.7	Төрийн санхүүжилт	Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.
6.	56.5.5	Худалдан авах ажиллагааны улсын байцаагч	энэ хуулийн 10.9-д зааснаар, эсхүл давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг зохих ёсоор оролцуулаагүй, эсхүл давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй.

XII. Биеийн тамир спортын тухай /2024.06.05/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга

1.	7.1.2	Биеийн тамир, спортод эрхэмлэн баримтлах ёс зүйн хэм хэмжээ	хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, үзүүлсэн амжилт, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;
2.	11.1.20	Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	хөгжлийн бэрхшээлтэй тамирчныг паралимп, дифлимп, тусгай олимпын наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх;
3.	14.1.5	Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан ажилтантай байх;
4.	22.5	Биеийн тамир, спортын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа	Магадлан итгэмжлэх журам, шалгуурт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд тэгш хамруулах, тэдний хичээллэх хэрэгцээ, шаардлагад нийцсэн орчин бүрдүүлэх үзүүлэлтийг тусгана.
5.	30.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагаа	Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан дэмжлэг үзүүлнэ.
6.	30.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагаа	Хөгжлийн бэрхшээлтэй хүний идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын тэмцээн, наадамд оролцоход төрийн байгууллага, спортын холбоо, спорт клуб дэмжлэг үзүүлж ажиллана.
7.	30.3	Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагаа	Спортын тэмцээн, наадамд хөгжлийн бэрхшээлтэй тамирчныг бие эрхтэн, хөгжлийн онцлогоор адил түвшинд өрсөлдүүлэх зарчмыг баримтална.
8.	30.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагаа	Энэ хуулийн 30.3-т заасан зарчмыг хангах зорилгоор улсын хэмжээний спортын тэмцээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй тамирчны ангиллыг олон улсын дүрмийн дагуу тогтоох комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг биеийн тамир, спорт, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
9.	30.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн	Хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан тамирчны эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

		тамир, спортын үйл ажиллагаа	
10.	33.1.4	Биеийн тамир, спортын ажилтан, арга зүйч, тамирчин, дасгалжуулагчийн нийгмийн баталгаа	хөгжлийн бэрхшээлтэй тамирчин бусад тамирчны нэгэн адил нийгмийн баталгаагаар хангагдах.
11.	36.4	Биеийн тамир, спортын барилга байгууламж, сургалтын орчин, спортын хэрэгсэл материал	Өмчийн хэлбэр харгалзахгүй биеийн тамир, спортын барилга байгууламж, заал, талбай нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байна.

XIII. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай /2024.11.08/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	3-р зүйлийн 1.7	Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл - 2,353,800,000₮

XIV. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай /2024.01.12/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	4.1.9	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зарчим	тэгш хүртээмжтэй байх;

XV. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай /2024.05.16/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	6.1	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжихэд баримтлах зарчим	Ил тод, нээлттэй, тэгш, хүртээмжтэй байх;

XVI. Төрийн тусгай хамгаалалтын тухай /2024.06.05/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	42.8	Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн нийгмийн баталгаа	Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон төрийн тусгай

			хамгаалалтын алба хаагч, уг үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхтэй холбоотой зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.

XVII. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /2024.06.05/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	6.1.6	Хот, тосгоны удирдлагын зарчим	нийтийн аж ахуйн үйлчилгээг оршин суугчдад тэгш, хүртээмжтэй хүргэх;
2.	12.1.22	Хотын нийтлэг чиг үүрэг	нийтийн тээвэр, такси үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хотод тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээ;

XVIII. Хүүхэд хамгааллын тухай /2024.01.17/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	5.1.3	Хүүхэд хамгааллын зарчим	хүүхэд хамгаалал нь тогтолцоонд суурилсан, гэр бүл төвтэй, олон талт, цогц, мэргэшсэн, дагнасан, шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй байх;
2.	15.3	Кейс менежментийн үе шат	Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрч заавал оролцуулна.
3.	34.1.2	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг авах, мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;
4.	34.1.11	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах талаар хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хууль сахиулах байгууллагын алба хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан

			төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

XIX. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай /2024.06.05/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	5.2.1	Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн талаар баримтлах бодлого, зарчим	хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг чанартай, аюулгүй, эмчилгээний өндөр идэвхтэй эм, эмнэлгийн хэрэгслээр тогтвортой, хүртээмжтэй хангах, нөөц бүрдүүлэх;
2.	11.1.1	Хангамжийн байгууллагын нийтлэг үүрэг	зайлшгүй шаардлагатай, чанарын баталгаатай, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр тогтвортой, хүртээмжтэй хангах;
3.	26.4	Эмийн зар сурталчилгаа	Эмийн зар сурталчилгаа нь харааны бэрхшээлтэй хүнд зориулсан дуун тайлбар, сонсголын бэрхшээлтэй хүнд зориулсан дохионы хэл, эсхүл бичгэн тайлбартай байна.
4.	39.4	Эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгаа, таниулах үйл ажиллагаа	Эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгаа нь харааны бэрхшээлтэй хүнд зориулан дуун тайлбар, сонсголын бэрхшээлтэй хүнд зориулсан дохионы хэл, эсхүл бичгэн тайлбартай байна.

XX. Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай /2025.01.23/

№	Заалт	Зүйлийн нэр	Агуулга
1.	4.1.5	Хархорум хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим	хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа оршин суугчийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн, нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, хүмүүнлэг, олон төвт хотын тогтолцоог хөгжүүлэх;
2.	8.1.13	Хархорум хотын төлөвлөлтөд тавигдах шаардлага	хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан хөтөчтэй явган хүний зам, дуут гэрлэн дохио, тээврийн хэрэгслийн зогсоол, нийтийн тээврийн хэрэгслийн тоноглол, олон нийтийн үйлчилгээний барилга байгууламжид ариун цэврийн өрөө төлөвлөх;
3.	11.2.1	Хархорум хотын хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах	эрүүл мэнд, боловсрол, соёлын зэрэг нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хотод тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх;

4.	11.2.8	Хархорум хотын хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах	харилцаа холбооны сүлжээг сайжруулж хотын интернэт хэрэглээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
5.	11.4	Хархорум хотын хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах	Хот энэ хуулийн 11.2-т заасны дагуу үүсгэх оршин суугчид зориулсан мэдээллийн системийг хөгжлийн бэрхшээлтэй хүн саадгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Дээрхээс үзвэл сүүлийн 2 жил орчмын хугацаанд шинээр эсхүл хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийг шинэчлэн найруулах, өөрчлөх явад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй болон хүртээмжтэй холбоотой зохицуулалтыг ерөнхий болон нарийвчилсан хэлбэрээр тусгасан байна.

b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах явдлыг үүсгэж байгаа бүхий л хууль тогтоомж, дүрэм, журам, зан заншил, уламжлалыг арилгах, өөрчлөх бүхий л зохистой арга хэмжээг авна;

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн бүхий л харилцаанд алагчлах явдлыг таслан зогсоох, түүнийг бий болгож байгаа бүхий л хууль тогтоомж, дүрэм журмыг өөрчлөх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2018 онд “Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ”-г хийж гүйцэтгэсэн байна.

Судалгааны дүгнэлтэд:

1. Хууль зүйн салбар: хөгжлийн бэрхшээлтэй хүний шударга шүүхээр шүүлгэх, оролцох эрхийг хангасан хэдий ч Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг ойлгомжтой, тайлбарлаж өгөх, эрхээ хамгаалахад орчуулагчаар үнэ төлбөргүй хангах ажил хийгдээгүй байна.

2. Боловсролын салбар: Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч эшлэл, авсан заалт өөрчлөгдөөгүй, Бага, дунд боловсролын тухай хуулийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн насны зөрүү”-г тодорхойлж сурч боловсрох эрхэд ялгаварлан гадуурхалтыг бий болгох тухай заасан. Халамжийн цэцэрлэгийн тухай заалтыг Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд суулгаж өгсөн хэдий ч хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байгаа төдийгүй тусгай цэцэрлэг, сувиллын цэцэрлэг, асрамжийн цэцэрлэг, халамжийн цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ, хувийн цэцэрлэгүүд, яслийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг боловч тэдний оюуны хөгжилд анхаардаггүй байна.

3. Дэд бүтцийн салбар: хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчиход шинээр ашиглалтад орсон хэсэг шаардлага хангаж байгаа хэдий ч нэгэнт баригдсан зам, барилгын саадыг хэрхэн сайжруулах тухай зохицуулалт тусагдаагүй, нийтийн тээврийн 10 хувиар хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчих тухай заалт амьдралд нийцэхгүй, хэрэгжилтэд төлбөр ногдуулах төдий асуудлыг шийдэж байгаа нь тэдний эрхийг зөрчин ялгаварлан гадуурхалтад өртөхөд хүргэж байна.

4. Нийгмийн даатгал, хадгаламж, хамгааллын салбар: халамж асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд зэрэгт үзүүлэх үйлчилгээг тэдгээрийн онцлог шаардлагад тулгуурлан хөгжүүлэх, ердийн өвчин, тарилгын дараах хүндрэл, ахуйн ослын талаар зохицуулсан хууль болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс үүссэн харилцаанд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаар зохицуулсныг холилдуулан утгыг

алдагдуулснаас үүдэн иргэдийн эрхийг зөрчих, нийтээр ялгаварлан гадуурхалтад өртөх нөхцөлийн бүрдүүлэхэд хүргэсэн байна.

5. Бусад салбар: Гаалийн тариф татварын тухай хуулиар тоноглогдон үйлдвэрлэгдсэн тусгай зориулалтын автомашиныг бүхэлд амьдралын туршид нэг удаа оруулж ирэх нь учир дутагдалтай байна. Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ баримтлах бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээлтэй, эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангах улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөр боловсруулж ажиллаж байх тухай тусгасан хэдий ч хэрхэн хангаж ажиллах тухай тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна.” гэжээ.

c) төрийн бүхий бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих явдлыг тусгана;

Улсын Их Хурал, Засгийн газраас 2020 оноос хойш батлагдсан бодлого, хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээрх холбогдох зохицуулалт, авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт тогтмол тусгагдаж байна. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын 2020 рны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “АЛСЫН ХАРАА - 2050” Монгол Улсын Урт Хугацааны Хөгжлийн Бодлогын баримт бичгийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.18-д “Иргэд эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн улмаас санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.”, 2.2.34-т “Эрүүл зөв дадал хэвшил эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах багш, мэргэжилтэн, сургагч багш нарыг бэлтгэж мэдлэг, чадвар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах, сургах арга зүйг тогтмол сайжруулах боломжийг бүрдүүлнэ”, 2.6.14-т “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.” зэрэг нийт 16 зорилтыг дэвшүүлсэн.[16]

d) энэхүү конвенцод үл нийцэх үйлдэл, эс үйлдэл, эсхүл дадал зуршил гаргахаас татгалзаж, төрийн эрх бүхий албан тушаалтан, байгууллагыг энэхүү конвенцод нийцсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явдлыг хангана;

Энэхүү чиглэлд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 402 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журам”-д зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл чухал үүрэг гүйцэтгэж байна. Тус зөвлөлийн ажиллах журмын 3.2-т “Дарга нь Монгол Улсын сайд, Засгийн гарын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд дарга нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл байна.”, мөн журмын 8.1-д “Зөвлөл нь бүх төрийн захиргааны төв байгууллагад дэд зөвлөл, аймаг, нийслэл, дүүрэгт салбар зөвлөлтэй байна.” гэж зааснаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан нийт 16 төрийн захиргааны төв байгууллага (яамд) болон аймаг, нийслэл, дүүрэг дэргэдээ дэд зөвлөл, салбар зөвлөлийг тус тус ажиллуулахаар заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын орон тооны бус бүтэц бий болсон нь төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, төрийн оролцоотой хуулийн этгээдүүдэд ажиллаж байгаа

[16]Монгол Улсын Их Хурлын 2020 рны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “АЛСЫН ХАРАА - 2050” Монгол Улсын Урт Хугацааны Хөгжлийн Бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Хоёр хүний хөгжил.

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээр байгууллагын үйл ажиллагаанд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг төрийн байгууллага, албан тушаалтан зөрчихгүй байх, конвенцыг баримтлах чухал алхам болсон гэж үзэж байна.

Харин энэхүү зөвлөлийн үйл ажиллагаа болон түүний салбар, дэд зөвлөлийн талаар конвенцын хэрэгжилтийн үнэлгээний дараагийн хэсгүүдэд дэлгэрэнгүй авч үзнэ.

е) аливаа этгээд, байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах явдлыг устгахад чиглэгдсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна;

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээрх хуулийн этгээдийн нийтлэг үүргийг хуульчилсан. Үүнд:

43.1.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

43.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэх;

43.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдүүлэхдээ олон улсын чиг хандлагын дагуу түгээмэл загвар хэрэглэхийг эрхэмлэх;

43.1.3.нийтийн зориулалттай үйлчилгээний болон бусад байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлэх;

43.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралын идэвхтэй оролцоо, түүний амжилт, бүтээлийг хамт олонд нь сурталчлах, урамшуулах;

43.1.5.хөгжлийн бэрхшээлтэй болсон хүнд түүнийг ажиллуулж байсан байгууллагын хувьд тусламж, дэмжлэг үзүүлэх;

43.1.6.өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 43.1.5-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх;

43.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчихийг үл тэвчих;

43.1.8.ажилтан тухайн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон нь шүүхээр тогтоогдсон бол хохирлыг нөхөн төлөх;

43.1.9.хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандартыг хангаж ажиллах;

43.1.10.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Хуулийн 43.1.10-т дурдагдсан “хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг” хэсгийг Барилгын тухай хууль, Автозамын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг 100 орчим хууль тогтоомжоор дэлгэрүүлэн зохицуулагдсан бөгөөд хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах явдлыг устгахад чиглэгдсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авах талаар эрх зүй орчинд дахь зохицуулалт хангалттай бий болсон гэж үзэж байна. Харин тэдгээрийн практикт ямар байгаа талаар конвенцын бусад заалтуудын хэрэгжилтийн үнэлгээний талаар дэлгэрэнгүй авч үзэх болно.

і) туслалцаа үйлчилгээг сайжруулах үүднээс энэхүү конвенцод заасан эрхийг эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцаж ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудыг сургах ажлыг дэмжих.

Тусгай цэцэрлэг, ерөнхий боловсролын тусгай сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан 395 багш, удирдах ажилтан, туслах багшийг сургасан байна. ЕБС-ийн сургуулийн бага ангид 72 туслах багш ажиллаж байна. "Журам чиглэл шинэчлэн батлах тухай " 2014 оны Засгийн газрын 71 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах замаар тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр суралцаж байгаа магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлын хэмжээ, олгох асуудлыг шийдвэрлэхээр ажиллажээ. Мөн МУБИС-ын Боловсрол судлалын

сургууль дээр Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн тэнхимийг 2017 оны 12 дугаар сард байгуулан ажиллуулж байна. Өнгөрсөн хугацаанд 1 жилийн хөрвөх сургалтаар 113 багш, 3.5 жилийн бакалаврын сургалтаар 44 оюутан, үүнээс сонсголын бэрхшээлтэй 16 оюутан тус тус төгссөн. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 86,3 хувьтай, 2021-22 оны хичээлийн жилийн байдлаар тус тэнхимийн 1-4 дүгээр ангид нийт 59 оюутан суралцаж байна.[17]

Товч дүгнэлт: Конвенцын нийтлэг үүргүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын зүгээс шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнд эрх зүйн орчны шинэчлэл, шаардлагатай хууль тогтоомж, дүрэм, журмуудыг баталж байгаа байдал чухал байр суурь эзэлж байна. Нийтлэг байдлаар авч үзэхэд конвенцын нийтлэг үүргүүдийг эрх зүйн орчинд бүрэн тусгасан гэж үзэж болохоор байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлалд өртөж байгаа эсэх талаар нэгдсэн судалгаа явуулах, сүүлийн жилүүдэд гаргаж байгаа бодлого хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар тусгах, төрийн байгууллага болон хувийн байгууллагын аливаа үйл ажиллагаанд тэднийг хүндэтгэх чиглэлд эрх зүйн болон төрийн институцын хэмжээнд хэд хэдэн ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Харин эдгээр ажлын хэрэгжилт, үр дүнгийн талаар конвенцын бусад зүйлүүдийн хэрэгжилтийн үнэлгээний явцад дэлгэрэнгүй авч үзнэ.

<u>Конвенцын 5 дугаар зүйлд заасан “Адил тэгш байдал, үл алагчлал”-ын тухайд:</u>

Конвенцын 5 дугаар зүйлд зааснаар оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энгийн хүмүүстэй адил адил тэгш байдал бий болгох, нийгмийн аливаа харилцаанд алагчлал бий болохоос сэргийлэх зорилгоор:

1.Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд хуулиар ямарваа нэгэн алагчилалгүйгээр тэгш хамгаалуулж, адил ашиг хүртэх эрхтэй болохыг оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө.

2.Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчлах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямарваа хэлбэрийн алагчлалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно

3.Тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, алагчиллыг устгах үүднээс оролцогч улсууд нь боломжит зохицлыг хангах бүхий л алхмыг хийнэ.

4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш байдлыг *de facto* хангах, ийм байдлыг бий болгоход чиглэсэн зайлшгүй шаардлагатай тусгай арга хэмжээнүүдийг энэхүү конвенцын агуулгад алагчилал гэж үзэхгүй.

Конвенцын 5 дугаар зүйлийн хэрэгжилт:

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа шинжээр ялгаварлан гадуурхахыг хориглох үзэл баримтлалд тулгуурлан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ернөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай, Боловсролын тухай хууль, Цэргийн албаны тухай хууль зэрэг үндэсний хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн

[17] Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн албан ёсны цахим хуудас, Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимйн танилцуулга, үзэх - https://ses.msue.edu.mn/Category/dep

амьдралд оролцох, нөхөн сэргээгдэх, сурч боловсрох, бусдын адил ажил, хөдөлмөр эрхлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах эрхийг баталгаажуулж өгчээ.

Мөн Эрүүгийн хуулийн 14.1.1-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол эрүүгийн хариуцлага тооцох зохицуулалтыг тусгасан. Тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ялгаварлан гадуурхах гэмт хэргийн шинжийг өргөжүүлж уг гэмт хэргийг боловсролын байгууллагын орчинд, цахим сүлжээ ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэхээр тусгасан.

2022 оны 12 дугаар сард батлагдсан Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгаар гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох асуудлыг шинээр тусгасан ба энэ хүрээнд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн хохирогч болсон бол Иргэний хуульд заасан гэм хорын хохирол нэхэмжлэх эрхтэй байх зохицуулалтыг бүрдүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, байгууллага, хэлтэс, салбар нэгж нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангаж, хөгжлийн бэрхшээлтэй алба хаагч, түүний гэр бүлийн гишүүд, хоригдлын эрхийг хамгаалж 2020-2021 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүний эрхийг хангах чиглэлээр 1 багц буюу 40 цагийн сургалтыг “Нийгмийн халамжийн чиглэлээр хийгддэг ажлууд”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Өөртөө итгэх итгэл” зэрэг сэдвүүдээр зохион байгуулсан.[18]

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө, үйлчилгээг бэрхшээлийн онцлогт нь тохируулан зохион байгуулж байгаа бөгөөд "Сэтгэл зүй, оюун санааны есөн дэвшил” хөтөлбөрийн сургалт, “Миннесота загвар эмчилгээ”-ний сургалт, "Танин мэдэхүй зан үйлийг засах” сургалтад нийт алба хаагчдыг хамруулсан.[19]

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-т заасны дагуу сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад хэлмэрч оролцуулахыг мэдэгдэн, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох эрхээр ханган ажилласан. [20]

Нийслэлийн дүүргүүдийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Прокурорын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэстэй хамтарч 173 хорооны Хамтарсан багийн гишүүдэд хөгжлийн бэршээлтэй хүний талаарх ойлголтыг сайжруулж чадавхжуулах сургалтыг 13 удаа зохион байгуулж, харааны бэрхшээлтэй иргэдэд брайл үсгээр хэвлэгдэн гарсан тусламжийн хуудас 2450 ширхэгийг тарааж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах ажлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Нийслэлийн ЕБС-ийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг аливаа төрлийн осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ээлтэй

[18] Монгол Улсын Засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийгн тухай” Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2 болон 3 дугаар тайлан, 2023 он, 8 дахь тал.
[19] Мөн тэнд.
[20] Мөн тэнд.

орчин бүрдүүлэх чиглэлээр 75 дугаар сургуулийн захиргаа болон багш, нийгмийн ажилтнуудад 32 удаагийн сургалтыг зохион байгуулж, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, мэдээлэл, тусламжийн хуудас 3700 ширхэгийг брайл үсгээр хэвлэн тарааж, талаар мэдээлэл өгсөн.[21]

Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 256 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын барилгын дүрэм, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл зохиох дүрмийн 3.5, 3.6-д заасны дагуу Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газрын нэг, хоёрдугаар хэлтэс, Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн байрны орц хэсгийн шатанд налуу зам хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг Цагдаагийн байгууллагын үйлчилгээ авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.

Улсын Их Хурлаас 2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.3-т “тохирох хэрэглэгдэхүүн" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;” ойлгохоор хуульчилсан бөгөөд мөн тус хуульд тус нэр томьёог ашигласан, тохирох хэрэглэгдэхүүнтэй холбоотой зохицуулсан 11 хуулийн хэсэг, заалтууд тусгагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 235 дугаар тогтоолоор Тэгш хамран сургах боловсролын талаар авах арга хэмжээний тухай баталсан бөгөөд бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, анги танхимыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ашиглах боломжтой стандарттай байхаар тоноглож, тохижуулах цогц арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх зайлшгүй шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүний зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан шийдвэрлэж байхыг, бүх шатны сургалтын байгууллагын шинээр баригдах хичээлийн болон дотуур байрны барилгын зураг төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй загвараар боловсруулах, барих ажилд хяналт тавьж ажиллахыг даалгасан байна.

Боловсролын сайдын 2020 оны А/184 тушаалын хавсралтаар “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчин бүрдүүлэх журам”-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар сургалтын орчинд тавих шаардлага, стандартыг тодорхойлж, иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009;Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS:6782:2019; Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага MNS:6799:2019, Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS:6558:2015, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS:6781:2019 стандартыг баримтлахаар заасан. Тохирох хэрэглэгдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна: суралцагчийн хэрэгцээнд нийцсэн, бусад суралцагчийн адил тэгш нөхцөлөөр сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжийг хангахад чиглэсэн;суралцагчийн нас, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн, хэрэглэгчийн онцлогт тохируулан өөрчлөх боломжтой, ашиглахад хялбар байх; мэдээлэл харилцааны технологи, тоног төхөөрөмж, программ хангамж, нэмэлт болон туслах үйлчилгээ нь

[21]Мөн тэнд.

суралцагчийн онцлог, хэрэгцээг хангахуйц байхаар тусгажээ. Түүнчлэн багш, ажилчид, эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад зориулан тохирох хэрэглэгдэхүүнийг ашиглах сургалтыг тогтмол зохион байгуулах, холбогдох зардлыг жил бүрийн төсөвт тусгахаар зохицуулжээ. Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох жур”щмын 3.2 дахь хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад санхүүжилт олгоҳдоо нэг суралцагчийн хувьсах зардлын нормативыг гурав дахин нэмэгдүүлж тооцохоор тусгасан. Энэхүү 2012 оны 185 дугаар Засгийн газрын тогтоолд 2020 оны 208 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж ердийн хэв шинжтэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид хүүхдийн хөгжлийн ахиц, багшийн ачааллыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс олгохоор зохицуулжээ.

2006 оноос эхлэн тусгай хэрэгцээт боловсролын хөрвөх 1 жилийн ангийг 101 багш төгсөж, 2018 онд МУБИС-д “Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим” байгуулагдсан. Одоо 100-гаад оюутан суралцаж байна. 2018-2019 оны хичээлийн жилд Оросын Холбооны Улсад “Тусгай хэрэгцээт боловсролын багш” мэргэжлээр 10 оюутан, МУБИС-ийн “Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим”-д 91 оюутан суралцаж байна.

Ерөнхий боловсролын оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө; Оюуны хөгжлийн бэрхшээлтэй ахлах ангийн хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө; Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө; Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөөг тус тус шинэчлэн баталсан.

Ердийн ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид нэмэгдэл хөлс олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан суралцуулах багш, ажилтныг бэлтгэх, давтан сургах, сургалтын арга зүй, сурах бичиг боловсруулах арга хэмжээг шат дараатай авч байна.

b) Иргэний барилга, зам, замын байгууламж, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахтай холбогдуулан “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай” MNS 91.040.10: 2009 стандарт, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг тооцсон төлөвлөлт”, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайн төлөвлөлт” барилгын дүрэм, “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт”, “Сургалт хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох” заавар, “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилгын технологийн зураг төсөл” барилгын дүрэм, “Үр тариа хадгалах болон боловсруулах байгууламж”, “Үйлдвэрийн газрын байгууламж” зэрэг 10 гаруй норм ба дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагын талаар тусган мөрдүүлж байна. Жишээлбэл, Барилгын тухай хуулийн 11.1-д “Барилгын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:” 11.1.6-д “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах: барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх” шаардлагыг тусгасан бол, Автозамын тухай хуулийн 4.1.11-д “...”замын байгууламж" гэж бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шуудуу, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг

хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламжийг;” ойлгохоор тус тус заасан.

Эдгээр хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах зорилгоор орон сууц, оффис, үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, соёлын төвийн зориулалттай барилга, байгууламжийн ажлын зураг төсөлд барилга, архитекторын бие даасан шинжээчдээр магадлалын дүгнэлт гаргуулж байна. Засгийн газраас 2017 онд баталсан “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүн орж ажиллах болсонтой холбогдуулан өнгөрсөн онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чадавхи бэхжүүлэх сургалтыг аймгуудад зохион байгуулсан. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй дэд бүтэц бий болгох чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Архитекторын мэргэшсэн зэрэг горилогчдод зориулсан сургалт”-ын хөтөлбөрт энэ чиглэлээр 2-4 цагийн хичээл, барилгын салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрт хот төлөвлөлт, барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн арга хэмжээг тусгах сэдвээр хичээл оруулж, зохих мэдлэг олгож байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд Барилга, хот байгуулалтын яамнаас Зам, тээврийн хөгжлийн яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй хамтран Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт заасан зорилтыг бодитоор хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжийг сайжруулах, салбар дундын зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах зорилгоор Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, олон нийт, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас санал авч ажиллаж байна.[22]

c) Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг аж ахуйн нэгж байгууллагад квот тогтоох болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хувиараа хөдөлмөр, аж ахуй эрхлэхийг дэмжих, ХБХ-ийг ажиллуулж буй ажил олгогчийг дэмжих гэсэн арга замуудаар дэмжиж байна. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 144.1 дэх хэсэгт зааснаар ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үүрэгтэй.

d) 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлд бие даан амьдрах эрхийг зохицуулсан бөгөөд 32.3 дахь хэсэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална хэмээн заасан. Энэхүү 2017 оны А/184 тушаалын хавсралтаар батлагдсан журмыг 2021 онд А/187 ХНХЯ-ны сайдын тушаалын хавсралтаар шинэчлэн баталж, мөрдүүлж байна.

[22] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан ёсны цахим хуудас, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагын төлөөллүүд хэлэлцлээ, https://mlsp.gov.mn/content/detail/1659.

е) Монгол Улсын Сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын тэргүүлэн ажиллаж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журмын 4.1-д зааснаар Зөвлөл нь төрийн захиргааны төв байгууллагын дэргэд орон тооны бус дэд зөвлөлтэй байхаар заасан. Тодруулбал, дараах салбарын төрийн захиргааны төв байгууллагын дэргэд дэд салбар зөвлөлүүд ажиллаж байгаа талаарх мэдээлэл нээлттэй байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- Батлан хамгаалахын яам;
- Сангийн яам;
- Соёлын яам;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
- Хууль зүй, дотоод хэргийн яам;
- Хүнс хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- Эрчим хүчний яам.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн үндсэн чиг үүрэг нь хорооноос өгсөн зөвлөмжийн 1 дэх хэсэгт заасан “...Оролцогч улс улсын хөгжлийн бэрхшээлтэй холбоотой үл алагчлалын хууль тогтоомжид конвенцыг хэрэгжүүлэх стратегийн нэг хэсэг болох уялдаа холбоотой дотоодын хууль тогтоомжийн үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд яамд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг оролцуулах зохицуулалт дутмаг” талаарх хэсгийг хэрэгжүүлэх буюу хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлаар салбар дундын зохицуулалтыг хэрэгжүүлэх, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Барилга хот байгуулалтын яам, Сангийн яам зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн харилцаанд шууд хамааралтай салбарын уялдаа холбоог сайжруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн зорилготой. Харин дээр дурдсан мэдээлэл нь ил тод нээлттэй байгаа 9 яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орох тооны бус дэд зөвлөлийн үйл ажиллагааны талаар конвенцын 9 дүгээр зүйл буюу хүртээмжийн хэсэгт илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.

Монгол Улсын Засгийн газраас 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2023 онд батлагдсан Боловсролын ерөнхий хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх болон адил тэгш суралцах, сургалтын байгууллага, сургуулийн орчимд үл алагчлалыг хориглохтой холбоотой чухал зүйл, хэсэг, заалтууд тусгагдсан байгааг өмнө дурдсан.

Засгийн газраас санаачилсан Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар тэдний нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн бие даан оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аливаа саад учрахаас урьдчилан сэргийлэх, учирч буй саадыг арилгах мөн тэдэнд барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо болон үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг тусгайлан тус хуулиар зохицуулахаар тусгасан. Энэхүү хуулийн хамрах хүрээ, бүлэг, онцлог зохицуулалтын талаар конвенцын 9 дүгээр зүйлийн хэрэгжилтийг үнэлгээг үнэлэх явцад дэлгэрэнгүй авч үзэх болно.

Дотоодын хууль тогтоомжийг уялдаа холбоотой, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд яамд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг оролцуулах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн хэрэгжилтийг

хангах хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр ахлуулан ажиллуулж байна.

Аймаг, нийслэл, дүүрэгт Засаг даргаар удирдуулсан салбар зөвлөлүүд, яамдад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлүүд байгуулагдан ажиллаж байна. Эдгээр орон тооны бус зөвлөлүүд нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, орон тооны бус дэд болон салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн зөвлөмж, чиглэл өгч ажиллаж байна. Үүний дагуу дэд зөвлөл бүрт тухайн салбарт мэргэшин ажилладаг төрийн бус байгууллагуудын төлөөлөл орж ажиллах болсон нь бодлого шийдвэр бодитой гарах, эргээд төрийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж бүрдсэн юм. Мөн дэд зөвлөл бүр оны эхэнд тухайн жилд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, жилийн эцэст тайлагнадаг бас нэгэн тогтолцоо бий болсон нь маш том ахиц дэвшил юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт үр дүнгийн 7, үйл ажиллагааны 116 шалгуур үзүүлэлтийг тусгасан бөгөөд хэрэгжилтийг эдгээр шалгуур үзүүлэлтээр хянаж байна.

Хууль болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг 2018 онд Улсын их хурал, Засгийн газрын шийдвэрээр байгуулсан. Тус агентлагт 35 хүн ажилладаг бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенци, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт, салбар дундын зохицуулалтыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжих, нийгмийн амьдралд оролцох оролцоог дэмжих, төрийн үйлчилгээнд хамрагдахад нь туслах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Товч дүгнэлт: Конвенцын 5 дугаар зүйлд заасан адил тэгш байдал, үл алагчлалтай холбоотой хэсэг, заалтууд болон 2015 онд хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийн тухайд Монгол Улсын хувьд онцлох өөрчлөлт нь 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль байна. Түүнчлэн боловсролын салбар, дэд бүтцийн салбар, хөдөлмөр эрхлэлтийн салбар, эрүүл мэндийн салбарт тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, түүний стандартын талаар ахиц дэвшилтэй эрх зүйн зохицуулалт, дагалдах журам батлагдаж, хэрэгжиж эхэлсэн нь ахиц дэвшилттэй алхам болжээ. Тохирох хэрэглэгдэхүүн стандартыг мөрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, эсхүл эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл оролцсон байдлаар тохиромжтой, нийцтэй байдлыг үнэлж, сайжруулах, улсын хэмжээнд жигд хангах, дэд бүтэц, орон сууц, барилга байгууламжийн хүртээмжтэй байдлыг сайжруулах чиглэлээр цаашид сайжруулах шаардлагатай асуудлууд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл, яамдад салбар зөвлөл, аймаг, нийслэлд дэд зөвлөл ажиллаж байгаа нь үр дүнтэй бөгөөд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг 2018 онд байгуулсан нь ач холбогдолтой байна гэж үзлээ.

<u>Конвенцын 6 дугаар зүйлд заасан “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд”-ийн тухай:</u>

Конвенцын 6 дугаар зүйлд:

“1.Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй охид нь давхар алагчлалд өртөж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, үүнтэй холбогдуулан тэдэнд хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, адил тэгш эдлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.

2. Оролцогч улсууд нь энэхүү конвенцод заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлүүлэх явдлыг баталгаажуулах зорилгоор эмэгтэйчүүдийг бүх талаар хөгжүүлэх, аж байдлыг нь дээшлүүлэх болон эмэгтэйчүүдийн эрх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохих бүхий л арга хэмжээг авна.” гэж заасан.

Конвенцын 6 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын Үндсэн хууль болон боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, гэр бүлийн харилцааг зохицуулж буй салбарын хуулиудад эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан, эсхүл ямар нэг хязгаарлалт тогтоосон зүйл заалт байхгүй. Хуулийн эдгээр зүйл заалтад хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд нэгэн адил хамаарна, харин эмэгтэйчүүдэд зориулан тусгай хэрэгцээг харгалзах, дэмжих зохицуулалтууд салбар хуульд заасан байдаг.

Монгол Улс 1981 онд Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцод нэгдэн орж, 2011 онд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг, 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг тус тус батлан хэрэгжүүлж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт Хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн, жирэмсэн эмэгтэй, ахмад настны хэрэгцээ, шаардлагыг харгалзана хэмээн заасан.

ГБХНХЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичиг, олон улсын аливаа гэрээ конвенцын тайлан, бодлого хөтөлбөр боловсруулах бүх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулж ажилладаг талаар тайландаа дурджээ. [23] Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийн талаарх тоон мэдээлэл, нийгэмд тулгамдаж буй асуудлууд цөөнгүй байна.

Тодруулбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоон мэдээлэлд дурдагдсанаар Монгол Улсад 2023 оны байдлаар нийт 111,228 хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 47430 нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд байдаг.[24]

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн оролцоог боловсролын салбарт авч үзвэл 2022-2023 оны хичээлийн жилд нийт 145,267 оюутан дээд боловсролын байгууллага буюу их, дээд сургуульд суралцаж байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид

[23] Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хорооноос ирүүлсэн асуумжийн хариулт, 2020 он, 22 дахь тал.
[24]Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 04-р сарын 10-ны өдрийн мэдээлэл. 2025 он.

ердөө 0.28 хувь буюу 414 байна. Үүний 184 нь эрэгтэйчүүд бол, 230 нь эмэгтэйчүүд байна.[25]

Түүнчлэн Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн тоон мэдээллээс харахад 2022 онд нийт 19,256 хүн элсэж байгаа хэдий ч тэдгээрийн 1.7 хувь нь буюу 328 нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна. Мөн хүйсийн талаас нь үзвэл нь 57.6 хувь буюу 189 нь эрэгтэй, 43.4 хувь буюу 139 нь эмэгтэй хүмүүс тус тус байна.[26]

Эрүүл мэндийн яамны мэдээлэлд дурдсанаар эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жирэмсэн эхэд хүлээлт, чирэгдэл үүсгэхгүй үйлчлэх зорилгоор Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/102 дугаар тушаалаар “Жирэмсний хяналт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний журам”-ыг баталсан. Мөн тус байгууллагын даргын А/162 дугаар тушаалын дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих сарын аян” өрнүүлж, Өргөө, Амгалан амаржих газарт нугасны гэмтэлтэй 60 эмэгтэйг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, Баянхзүрх дүүргийн эрүүл мэндийн төв хөгжлийн бэрхшээлтэй 100 гаруй эмэгтэй нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.[27]

Монгол Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 15 ба түүнээс дээш насны хөдөлмөр эрхлэх чадвартай хөгжлийн бэрхшээлтэй нийт 98,243 хүн байгаагаас байнгын ажиллагч 7591, тохиолдлын шинжтэй 5733, түр ажиллагч 245, төрийн албанд 1456 хүн ажиллаж байна. 15 буюу түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 67 151 буюу 68.4 хувь нь ажилгүй, үлдсэн 31 092 буюу 31.6 хувь нь ажил эрхэлж байна.[28]

Ажил хайгчаар бүртгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 33.9 хувь нь Улаанбаатар хотод, 61.1 хувь нь орон нутагт оршин суудаг бөгөөд 27 хувь нь өмнө нь ажил эрхэлж байсан бол 73 хувь нь огт ажил эрхэлж байгаагүй байна.[29]

2021 онд хөгжлийн бэрхшээлтэй нийт 264 хүний дунд явуулсан судалгаагаар хөдөлмөр эрхлэлтийн төвшин 33%-тай байсан ба ажил эрхлэгчдийн дийлэнх буюу 39 нь сувилагч, тогооч, засварчин гэх мэргэжилтэй байсан. Мөн хөдөлмөр эрхлэгчдийн 40% нь 400,000-700,000₮-ний цалинтай байсан ба ажлын сэтгэл ханамжийн байдалд 63% нь хангалуун, 21% нь маш хангалуун, 16% нь хангалуун бус гэж хариулсан. Хөдөлмөр эрхлэгч иргэдийн ажлын байранд асуудал тулгардаг уу гэсэн асуулгад 47% нь тийм гэж хариулсан ба түгээмэл тулгамддаг асуудал нь ажлын ачаалал их, ажлын цаг их, дотоод

[25]Боловсрол, шинжлэх ухааны яам, Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 2022/2023 оны тоон мэдээлэл, 2023.
[26] Боловсрол, шинжлэх ухааны яам, Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн 2022-2003 оны хичээлийн жилийн мэдээ, насны ангиллаар, 2023.
[27]Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улсын дахь хүний эрх, эрх чөлөөний байдлн талаарх 19 дэх илтгэл, 2020 он, 232 дахь тал.
[28]Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар “Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчийн статистик тоон мэдээ” 2021. http://www.gadpwd.gov.mn/index.php/page/277
[29]Мөн тэнд.

орчин муу, зориулалтын шат байдаггүй, цахилгаан шатны хэрэгцээ зэргийг дурдсан байсан.[30]

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд бэрхшээлтэй тулгардаг ч хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс ажилд орох боломж хоёр дахин илүү байдаг ажээ. Жендерт суурилсан хүчирхийлэлд өртөх магадлал буюу бэлгийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, анхаарал халамж авалгүй орхигдох, онц хүнд гэмт хэргийн мөлжлөгт өртөх эрсдэл хөгжлийн бэрхшээлгүй эмэгтэйчүүдээс гурав дахин их байдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүл төлөвлөлтийн нөхцөл байдал мөн хурцадмал байгаа буюу 20-с дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 32,8% нь огт гэрлээгүй, 14,9% нь салсан буюу бэлэвсэн амьдралтай байна. Тэдэнд гэр бүл төлөвлөлт нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг дутмаг байгаагаас гадна олон нийт, эмч мэргэжилтнүүд тэдний хүүхэд төрүүлэх, хүнтэй гэрлэх эрхтэй мэдрэмжтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй хандлагатай холбоотой.[31]

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд 2021 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн чанарын судалгаа”-г хөндлөнгийн судалгааны байгууллагаар гүйцэтгүүлсэн. Судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй хэлбэр, түвшин, нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлсноос гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүчирхийлэлд өртөж буй байдлаа ухамсарлан ойлгох, бусдад мэдээлэх, тусламж үйлчилгээ эрэлхийлэх ойлголт, зан үйлийг тодорхойлсон бөгөөд судалгааны тайланг холбогдох төрийн байгууллагын ажилтнууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 16 төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлж, цаашид энэ чиглэлээр тодорхой төлөвлөгөө гарган хамтран ажиллахаар шийдвэрлэсэн байна.[32]

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр ажилладаг судалгааны байгууллагаас 2020 онд Гэр бүлийн хүчирхийллийн талаар явуулсан судалгаанд 150 хөгжлийн бэрхшээлтэй хүн хамрагдсан бөгөөд хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 74 хувь нь Гэр бүлийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өмнө нь өртжээ. ҮСХ-оос 2017 онд гүйцэтгэсэн Жендерт суурилсан хүчирхийллийн үндэсний хэмжээний судалгааны дүнгээр Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэсэн үр дүнтэй харьцуулбал хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүлийн хүчирхийлэлд өртөх байдал ойролцоогоор хоёр

[30]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, “Бэрх биш ээлтэй” төсөл, “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт – 2021”, Эрдэм шинжилгээний онол практикийн хурлын эмхтгэл, Г.Гал-Эрдэнэ, А.Анар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн төвшинг тогтоох нь”, 102 дахь тал.

[31]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, “Бэрх биш ээлтэй” төсөл, “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт – 2021”, Эрдэм шинжилгээний онол практикийн хурлын эмхтгэл, У.Бадамсүрэн, “Харааны бэрхшээлтэй иргэдийн гэр бүл төлөвлөлтөд тулгамдаж буй зарим асуудал,” 59 дэх тал.

[32]Монгол Улсын Засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийгн тухай” Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2 болон 3 дугаар тайлан, 2023 он, 9 дэх тал.

дахин өндөр байна. Тэдний дийлэнх нь (72.1%) эмэгтэйчүүд, насны бүлгээр харьцуулж үзвэл, 31-ээс дээш насныхны өртсөн байдал бусад бүлгээс илүү өндөр байна.[33]

Мөн 2015 онд хорооноос өгсөн зөвлөмжид "... хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдрал, болон гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх" талаар тодорхой тусгасан ч бодит байдалд 20-с дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 32,8% нь огт гэрлээгүй, 14,9% нь салсан буюу бэлэвсэн амьдралтай байна. Тэдэнд гэр бүл төлөвлөлт нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг дутмагаас гадна олон нийт, эмч мэргэжилтнүүд тэдний хүүхэд төрүүлэх, хүнтэй гэрлэх эрхтэй, мэдрэмжтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй хандлагыг зайлшгүй өөрчлөх шаардлага бий болжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй 150 орчим хүн хамрагдсан судалгаанд оролцогчдын 74 хувь нь Гэр бүлийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өмнө нь өртсөн байгаа нь конвенцын заалт болон зөвлөмжийн холбогдох хэсгүүд практикт бүрэн хэрэгжиж чадахгүй байгааг илтгэж байна.

Товч дүгнэлт: холбогдон судалгаанд дурдсан мэдээлэл, статистикаас дүгнэхэд конвенцын 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг аливаа алагчлалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, үндсэн эрх, эрх чөлөөг эдлүүлэх заалт, болон 2015 онд зөвлөмжид дурдсан зөвлөмж бүрэн хэрэгжиж чадаагүй, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, нөхөн үржихгүй, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, гэр бүлийн хүрээний хүчирхийллээс хамгаалах талаар сайжруулах ажиллагааг эрчимжүүлэх зайлшгүй хэрэгцээ байна.

Конвенцын 7 дугаар зүйлд заасан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд"-ийн тухайд:

Конвенцын 7 дугаар зүйлд:

"-Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хангах бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.

-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ хүүхдийн ашиг сонирхлыг нэн түрүүн харгалзан үзнэ.

-Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил нь өөрсдийн нас болон биеийн онцлогт тохирсон байдлаар өөрт нь хамаарах аливаа асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлүүлэх бөгөөд энэхүү эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээл болон насны онцлогт тохирсон туслалцаа үзүүлэх явдлыг хангана." хэмээн тус тус заасан.

Конвенцын 7 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

[33]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, "Бэрх биш ээлтэй" төсөл, "Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт – 2021", Эрдэм шинжилгээний онол практикийн хурлын эмхтгэл, Г.Жаргалмаа, Н.Болормаа, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс", 30-31 дэх тал.

Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1990 онд нэгдэн орж, 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг баталсан бөгөөд 2016 онд уг хуулийг хүчингүй болгож Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинээр баталсан. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр /2017-2021/-ийг батлан хэрэгжүүлсэн байна. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03 дугаар Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/476 дугаар Ерөнхий боловсролын сургуулийн орчин дах хүүхэд хамгааллын бодлогыг батлан, мөрдүүлж байна. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүүхдийг хүчирхийлэх, зүй бусаар харьцах, орхих, үл хайхрахаас сэргийлэх, бүх төрлийн бие махбодын шийтгэлийг бүрэн хориглох, сэргийлэх арга хэмжээг авч байна. Тухайлбал, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд:

“10.1.Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах хариу үйлчилгээ үзүүлнэ:

10.1.1.мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах;

10.1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх;

10.1.3.аюулгүй байдлыг хангах;

10.1.4.дэмжих, холбон зуучлах;

10.1.5.хүүхдийн эрхийн хууль зүйн х
орооны үйлчилгээ үзүүлэх;

10.1.6.гэр бүлд нь эргэн нэгтгэх.

10.2.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ.” гэж заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхтэй холбоотой цогц эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

28.1.Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, тэдэнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээг гэр бүл, хамт олонд нь түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хүүхдийн хөгжлийн төвийг байгуулан, хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд тусгай хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг төрөөс дэмжинэ.

28.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол болон сэргээн засах үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.

28.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд хамруулна.

28.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах, хүүхдийн эрхийг хамгаалах, боловсролын болон төрийн эрх бүхий холбогдох байгууллага хэрэгжүүлнэ.

28.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой аливаа бодлого, шийдвэрийг гаргах явцад тэднийг үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангана.

28.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдээ өсгөн бойжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгоход төрөөс дэмжлэг үзүүлнэ.

28.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргийг тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээх бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг хориглоно.

28.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд тэтгэлэг төлөгч нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт тэтгэлэг төлнө.” хэмээн тус тус заажээ.

Түүнчлэн Гэр бүлийн тухай хууль, Иргэний хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх давхар хамгаалагддаг.

Хөгжих эрх нь хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хэлэх бөгөөд амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр эдэлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Төв комисс ХНХЯ-ны бүтцэд, салбар комисс 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна. Салбар комисс нь 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий салбар дундын үйл ажиллагааг хэрэгжүүлэх орон тооны бус комисс бөгөөд бүрэлдэхүүнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, гэр бүлийн салбарын болон эцэг эхчүүдийн төлөөлөл ордог байна.[34] Комиссын дүрмийг Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Төв болон Салбар комиссын эрх үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, үйл ажиллагаанд тавих хяналт, мэдээллийн сан, шаардлагатай тохиолдолд комиссын хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг зохицуулалтыг нэмж тусгасан.[35]

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2 дугаар зүйлийн 2.1.19 дэх заалтад “Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж, сургалтын байгууллагын орчны стандартыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохируулгад орчныг бүрдүүлж, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг хүүхэд, хэрэглэгчдэд ээлтэй болгох ажлыг үе шаттайгаар төлөвлөж хэрэгжүүлнэ” гэж заасан.

[34] Монгол Улсын Засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2 болон 3 дугаар тайлан, 2023 он, 9 дэх тал.

[35] Мөн тэнд.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулж, Хүүхдийн төлөө санг байгуулсан. Тус хуулийн 212.3.3-т олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэхээр заасан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих” журмыг баталсан. Тус журамд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн олон улсын тэмцээн уралдаанд оролцох зардлыг Хүүхдийн төлөө сангаас гаргахаар тусгасан. Уг журам хэрэгжиж эхэлснээс хойш автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос 8,8 тэрбум төгрөг, “Хүүхдийн фонд” төрийн бус байгууллагаас 2,1 тэрбум төгрөг, байгууллага, иргэдээс өгсөн хандив 15,5 сая төгрөг, нийт 10,9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Үүнээс шагнал урамшуулалд 2021 онд 15 хүүхдэд 25 сая төгрөг, 2022 онд 117 хүүхдэд 249,4 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхдэд дэмжлэг үзүүлэхэд 23,3 сая төгрөг, нийт 121 хүүхдэд 272,7 сая төгрөгийг зарцуулах шийдвэр гарсан байна.[36]

Харин Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон холбогдох хууль тогтоомжид тусгагдсан зорилтын хэрэгжилтийг харж болох зарим судалгааг эрх бүхий байгууллагын дүн шинжилгээн дээр үндэслэн гарсан байгааг доор дэлгэрүүлэн авч үзэв.

ХЭҮК-ын БШУЯ-тай хамтран хийсэн судалгаанд хамрагдсан дотуур байрын 85.7 хувь нь хүүхэд хөгжлийн өрөөтэй хэдий ч талбайн хэмжээ 30м2 -аас доошгүй байх стандарт шаардлага 25 хувьд огт хангагдаагүй, өрөөг хөгжим, зурагт, компьютер, буйдан, хүүхдийн сэтгэхүй, оюун ухаан хөгжүүлэх төрөл бүрийн тоглоом, шаардлагатай бусад эд зүйлсээр хангасан байдал 8.3 хувьд огт хангагдаагүй, 58.3 хувьд зарим талаар хангагдсан байдалтай байна. Зарим дотуур байрын хүүхэд хөгжлийн өрөө нь байнга түгжээтэй байдгийн улмаас хүүхдүүд хүссэн үедээ үйлчлүүлж чаддаггүй байна.[37]

Дээрх дотуур байрны зарим дотуур байр нь дотроо бие засах өрөөтэй боловч шугам сүлжээ нь гэмтсэн учир гадна модон бие засах газар ашигладаг бөгөөд бие засах газар нь хаалга, цоожгүй, ариутгал, халдваргүйжүүлэлт хийгддэггүй, гэрэлтүүлэг муу, эрэгтэй дотуур байрын ариун цэврийн өрөөнд суултуур бүрийн дунд тусгаарлах хаалтыг бүрэн хийгээгүй, суултуургүй, дотор ариун цэврийн өрөөтэй боловч зөвхөн хөнгөн бие засахад зориулагдсан төдийгүй 88 хувь нь бага насны хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан суултуур, угаагуур, шүршүүр байхгүй байна.[38]

Түүнчлэн хоёр дотуур байр тутмын нэг нь дотроо номын сантай байсан ба нийт хүүхдийн 20 хувьд нэг дор үйлчлэх боломж бүхий ширээ сандал байх шаардлагыг 28 хувь нь хангаагүй, номын сангийн нэг хүүхдэд ногдох талбай нь 2.4 м2 -аас доошгүй байх шаардлага 28 хувьд нь хангагдаагүй, номын санд хүүхдийг хичээл давтах боломжоор хангаж, сурах бичиг, хичээлийн нэмэлт даалгавар, бусад ном гарын авлагыг байрлуулсан байх шаардлага 43 хувьд нь хангагдаагүй байна гэж судлагдсан.[39]

---

[36] Монгол Улсын Засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2 болон 3 дугаар тайлан, 2023 он, 11 дэх тал.

[37] Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 2023 он, 314-315 дахь тал.

[38] Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 2023 он, 308 дахь тал.

[39] Боловсрол, шинжлэх ухааны яам, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, “Эс Ай Си Эй” ХХК, “Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн

БШУЯ-ны сайдын 2018 оны А/155 дугаар тушаалын хавсралтаар ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал, 2019 оны А/292 дугаар тушаалын хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам, Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслийн жагсаалт, 2020 оны А/305 Хэл ярианы хөгжил сургалтын жишиг хөтөлбөр, 2020 оны А/296 дугаар тушаалын хавсралтаар Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар, 2021 оны А/177 дугаар тушаалын хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам, 2022 оны А/553 дугаар тушаалын хавсралтаар Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлийг тус тус баталсан бөгөөд уг баримт бичгийн 5-д заасан зорилтот бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй, алслагдмал болон малчин өрх зэрэг нийт 11 зорилтот бүлгийг нэрлэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-д “төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн бэрхшээлээс нь үл хамаарч бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулах арга хэмжээ авна.”, 14.3.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах, тухайн хүүхэд, залуучуудын онцлог, хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад зохион байгуулах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээх арга хэмжээ авна.” гэж заасан.

Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 7 дугаар зүйлийн 1-д “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хангах бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.”, 24 дүгээр зүйлийн 24.1-д “Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө.” гэсэн заалттай нийцэж байна. Гэвч Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль /2008/-ийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэгт “...хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно,” гэж ердийн цэцэрлэгт зөвхөн хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хэт цөөн тоотойгоор суралцахаар тогтоосон нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч боловсрох эрхийн хүрээнд ялгаварлан гадуурхаж, тэднийг бусад хүүхэдтэй адил тэгш сурах болон харилцах нөхцөл боломжийг хязгаарлаж байгаа нь дээрх конвенцын заалттай зөрчилдөж байна.[40] Харин 2023 оны 07-р сарын 07-ны өдөр батлагдсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 4.4-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд зургаан настай хамрагдаж болно гэж заажээ. Гэтэл энэхүү зохицуулалт нь мөн л хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ялгамжтай байдал бий болгосон буюу хүүхдүүд хоёроос тавантай настай хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломжтой байхаар тус хуулийн 4.2-т заасан атлаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 6 настай хамруулахаар ялгамжтай тусгажээ.

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2015 онд Хүн амын хөгжил, нийгмийн

боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”, 2023 он, 133 дахь тал.

[40] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл, 2017 он, 70 дахь тал.

хамгааллын яамтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа төрийн болон хувийн өмчийн Баянзүрх дүүрэг дэх Сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолбор, Энэрлийн түүчээ төрийн бус байгууллагын дэргэдэх Хүслийн ордон цэцэрлэг, Сүхбаатар дүүрэг дэх 186 дугаар цэцэрлэг, Баянгол дүүрэг дэх Бяцхан сувд цэцэрлэгт хяналт шалгалт хийсэн юм. Баянзүрх дүүрэг дэх Сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолборын барилга нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй, аюулгүй байдал болон ашиглалтын шаардлага хангаагүй, анхнаасаа газар хөдлөлтийн эсрэг техникийн шийдэлгүйгээр баригдсан, ажиллах нөхцөл алдагдсан, олон жилийн ашиглалтын явцад хоцрогдол (мораль)-ын элэгдэлд орсон, инженерийн шугам сүлжээ хэвийн найдвартай ажиллах боломжгүйд хүрсэн нь Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт “хүн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан байх” гэж заасан шаардлагад нийцэхгүй, уг барилгын ашиглалтыг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн бүрмөсөн зогсоож, тайлан тэнцлээс хасах асуудлыг холбогдох байгууллагад хууль тогтоомжийн дагуу тавьж шийдвэрлүүлэх талаар Мэргэжлийн хяналтын байгууллагын акт, дүгнэлт гарсан бөгөөд цэцэрлэгийн барилгыг шинээр барихаар шийдвэрлэсэн боловч[41] эдгээр асуудал шийдэгдсэн эсэх мэдээлэл байхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх, тэгш хамран сургалтыг дэмжих хүрээнд ЖАЙКА–гийн дэмжлэгтэйгээр “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”–ийг 4 тусгай болон 8 ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлж байна. Мөн НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Тэгш хамран сургалттай, эрүүл чанартай сургалтын орчин” төслийг 6 сургууль дээр хэрэгжүүлж, 90 гаруй сурагч, 550 гаруй иргэдийг хамруулсан байна. Түүнчлэн аймаг, орон нутгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эрүүл мэнд, нийгмийн хамгааллын орон тооны бус салбар комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үзлэг оношлогоонд хамруулах, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, сургууль завсардсан хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг тулгуурлан зохион байгуулж байна. Эдгээр комиссоос 2018 онд давхардсан тоогоор 5000 орчим хүүхдийг ийм үйлчилгээнд хамруулж, орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх төв байгуулах, сургууль хамрагдаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийг байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг рашаан сувилалд сувилуулах, нарийн мэргэшлийн эмчийн үзлэг оношилгоо эмчилгээнд хамруулах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байгаа талаар ГБХНХЯ-аас мэдээлжээ.

Малчин өрхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад байрлах дотуур байр, журам, стандартын хэрэгжилтийг хянах механизм, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон ганцаарчилсан дэмжлэгийг одоогоор практикт цөөхөн хэрэгжүүлж байна.

Мөн 2015 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох, бусадтай харилцах чадварыг сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулсан талаар зарим

[41] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл, 2017 он, 71 дэх тал.

арга хэмжээг дурджээ. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хэрхэн харилцах, тэдний нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилготой амьдрах ухааны сургалтын 9 багц модуль боловсруулан 21 аймаг, 9 дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудыг оролцуулан сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулсан. Сургагч багш нар тухайн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй 15-34 насны залуучуудад амьдрах ухааны цогц сургалт зохион байгуулж байна. Энэхүү сургалтын үр дүнд орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад чиглэсэн санал санаачилгууд гарсан талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тайлагнасан.

Мөн конвенцын 7 дугаар зүйл нь боловсролын харилцаатай нягт уялдаатай байгаа тул конвенцын хэрэгжилтийн үнэлгээний 24 дүгээр зүйлийн хэрэгжилтийн тайлбарт холбогдох статистик, мэдээллийг дэлгэрэнгүй оруулсан болно.

Товч дүгнэлт: Конвенцын 7 дугаар зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдийн нэгэн адил хүний бүх эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн, адил тэгш эдлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх арга хэмжээнд нэн тэргүүнд тэдний ашиг сонирхлыг хүндэтгэх зааltын хэрэгжилт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох бусад ажлуудыг Монгол Улсын холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд авч хэрэгжүүлж байна.

Нөгөөтээгүүр шинээр батлан мөрдүүлж байгаа хууль тогтоомжуудад хүнийг хөгжлийн бэрхшээл, тусгай хэрэгцээтэй эсэхээр нь ялгаравласан зохицуулалт тусгах байдлаар эрхийг хязгаарласан байна.

Ялангуяа Боловсролын яамнаас сүүлийн жилүүдэд тэгш хамран сургах бодлогыг хэрэгжүүлэх, зорилтот бүлгийн боловсролыг дэмжих талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж байгааг тэмдэглэж байна. Гэвч 2022 оны байдлаар 12,476 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 2818 буюу 32 хувь нь ерөнхий боловсролын сургуульд суралцаж чадахгүй байна. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмших боломжийг бүх талаар бүрдүүлэхийн тулд, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэнд мониторинг хийх, суралцах орчин нөхцөл, тохирох хэрэглэгдэхүүн, ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулах, дэмжлэгийг хүртээмжтэй болгох хэрэгцээтэй байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдэд шууд нөлөөлөх асуудлаар тэдэнтэй зөвлөлдөх асуудлаар тоо, мэдээлэл, хийсэн судалгаа дутмаг тул энэ талаар ГБХНХЯ-аас тусгайлан санал асууж, дүгнэн тэдний хөгжлийн бэрхшээл болон насанд нь тохирох тусламж дэмжлэг үзүүлж, тохирсон хариу үйлчилгээ санал болгох талаар судлах нь зүйтэй байна.

<u>Конвенцын 8 дугаар зүйлд заасан “Мэдлэг ойлголтыг дээшлүүлэх” тухайд:</u>

Конвенцын 8 дугаар зүйлд:

“1. Оролцогч улсууд нь дараах үр дүнтэй, холбогдох арга хэмжээг нэн түрүүн авах үүрэгтэй:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг ойлголтыг нийгмийн бүх хүрээ, ялангуяа гэр бүлийн хүрээнд нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төр, нандин чанарыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;

b)амьдралын бүх үе шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд хор уршигтай, хохирол учруулахуйц, ялангуяа нас, хүйс зэрэгт үндэслэсэн дадал зуршлыг бий болгохуйц нийгэмд тогтсон хэв маягтай тэмцэх;

c)хөгжлийн бэрхшээлтэй хүний чадавх, тэдний оруулж буй хувь нэмрийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх;

2. Эдгээр арга хэмжээ нь дараах төрөлтэй байж болно:

a)дараах төрлийн үр нөлөөтэй олон нийтэд чиглэгдсэн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх олныг хамарсан ажлыг санаачилж, зохион байгуулах;

(i)хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүлээн зөвшөөрөх байдлыг бий болгох;

(ii)хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар эерэг ойлголт, нийгмийн зөв хандлагыг тогтоохыг дэмжих;

(iii)хөгжлийн бэрхшээлтэй хүний үр чадвар, авьяас билиг, чадавх, түүнчлэн ажлын байр болон хөдөлмөрийн зах зээл дээр тэдний оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрүүлэх явдалд дэмжлэг үзүүлэх;

b)боловсролын тогтолцооны бүхий л түвшин, ялангуяа бүх хүүхдэд бага наснаас эхэлж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх;

c)бүх төрлийн хэвлэл мэдээллийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг энэхүү конвенцын зорилгод нийцүүлэн дүрслэн харуулахыг дэмжих;

d)хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх танин мэдэхүй, сурталчилгааны ажлыг хөхиүлэн дэмжих.” гэж заасан.

Конвенцын 8 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд конвенцод тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдлэг, ойлголтыг нийгэмд эергээр бий болгох, нэр төр, нандин чанарыг бий болгох зорилгоор зохицуулалтуудыг тусгасан байна:

7.1.Гэр бүл болон нийгмийн бүхий л хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх зорилгоор төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

7.1.2.Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зөв ойлголтыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого хэрэгжүүлэх;

7.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх эерэг хандлагыг төлөвшүүлэх асуудлыг бүх шатны боловсролын байгууллагын сурах бичигт тусгайлан тусгаж, сургалт, хичээлийн агуулгаар дамжуулан хэрэгжүүлэх;

7.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлд өгөх, сургалт, сурталчилгаа явуулах арга хэмжээг зохион байгуулах;

7.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэх, түүнд чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, гэр бүл, иргэдийн санал санаачлагыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгыг агуулсан арга хэмжээг зохион байгуулан холбогдох зардлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган шийдвэрлэх.

ЖАЙКА байгууллагын Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх" төслийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал" сургалтыг зохион байгуулж 32 хөгжлийн бэрхшээлтэй сургагч багшийг бэлтгэж, тэдний тусламжтайгаар 250 гаруй удаа сургалт зохион байгуулж, 8500 гаруй төрийн албан хаагч болон хувийн хэвшлийн ажилтнуудыг хамруулсан байна. Түүнчлэн уг сургалтыг ХНХЯ өөрийн харьяа 45 байгууллагад, бүх яамдын дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлүүд өөрсдийн эрхлэх салбарын хүрээнд зохион байгуулсан байна. Энэхүү сургалтад Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, нийслэлийн боловсролын газар, аймаг дүүрэг дэх хүүхэд харах үйлчилгээний багш нар зэрэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл хамрагдсан бөгөөд сургалтад хамрагдсан байгууллагуудын орчин, хүртээмжийн байдалд тодорхой өөрчлөлтүүд гарч байна. Цаашид уг сургалтад эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, спортын салбарын ажилтнуудыг хамруулахаар төлөвлөсөн[42] талаар онцолсон байна.

ХНХЯ, НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын Бээжин дэх төлөөлөгчийн газартай хамтран 2019 онд "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"-ийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөгжлийн бэрхшээлийн талаарх нийгмийн хандлагыг өөрчилж, тэдэнд боломжийг олгосон эерэг хандлагыг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийг татан оролцуулж нөлөөлөх зорилгоор хэвлэл, мэдээллийн салбарт ажиллаж буй сэтгүүлчдэд зориулсан сургалтын модулийг боловсруулан 25 сэтгүүлчийг сургагчаар бэлтгэсэн байна. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй дэд бүтэц, мэдээллийн хүртээмж, эрүүл мэнд, боловсролын тусламж үйлчилгээ, нийгмийн халамж хамгааллын үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, байнгын ажлын байр зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд хөшүүрэг болно[43] гэж үзэж байгаа талаар дурдсан.

Мөн Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Залуучуудын хөгжлийн төв 2018 оныг "Зорилтот бүлгийн залуучуудын оролцоог дэмжих жил" болгон зарлаж, "Монголын Залуучуудын өдөр"-ийг угтсан "Залуучуудын хөгжлийн сар"-ыг тэмдэглэн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын дуу хоолойг сонсох, үзэл бодлоо нэгдэн илэрхийлэх боломжийг олгох, мөн тэдний биеийн тамир, спорт болон оюуныг хөгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор "Тэгш эрх-Тэгш боломж" сэдэвт өдөрлөгийг зохион байгуулсан байна. Уулзалтаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс үзүүлдэг нийгмийн халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн олон улсын түвшний бодлого, шийдвэрийн талаар ойлголт өгч, тэдний

[42] Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хорооноос ирүүлсэн асуумжийн хариулт, 2020 он, 27 дахь тал.

[43] Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хорооноос ирүүлсэн асуумжийн хариулт, 2020 он, 28 дахь тал.

дунд спортын тэмцээн зохион байгуулсан нь тэдэнд өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, нийгмийн харилцаанд оролцох идэвх оролцоо сайжруулахад нөлөөлсөн байна. Эдгээр үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ТББ-ууд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын болон тэдний эрх ашгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөгчид тогтмол оролцсон байна.[44]

Мөн ХНХЯ-наас “Халамжаас хөдөлмөрт” арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг эерэгжүүлэх, ээлтэй ажлын байр, орчин, дэд бүтэц бий болгох зорилгоор “Бэрх Биш Ээлтэй” аяныг өрнүүлж, хөгжлийн бэрхшээл судлал салбар дундын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээний хурлыг 2021 онд “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт-2021”, 2022 онд “Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж” сэдвийн дор 2013 оноос өнөөг хүртэл 10 дахь удаагаа зохион байгуулжээ. [45] Тус хуралд Цагдаагийн ерөнхий газар, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын хүрээлэн, Боловсролын зээлийн сан, Насан туршийн боловсролын үндэсний төв, ХНХЯ-ны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, их дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн Улаанбаатар хот төдийгүй орон нутгийн Засаг даргын тамгын газар зэрэг байгууллагуудын хууль эрх зүй, хөдөлмөр, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн чиглэлээрх нийт 88 илтгэл ирүүлснээс үзэхэд хөгжлийн бэрхшээлийн талаарх судалгаа, шинжилгээний ажил маань улам өргөжиж, салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх[46] үндсэн суурь болж байгаа тухай онцолсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2019 оноос 2023 оны хооронд хийж гүйцэтгэсэн хурал, уулзалт, хэлэлцүүлэг болон бусад олон нийтийн ажлын тухайд түүвэрлэн авч үзвэл:

1.Улаанбаатар хотод 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгресс;

2. Архангай аймгийн Хөгжлийн Бэрхшээлтэй иргэдийн зөвлөлөөс 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “Хүртээмжтэй ирээдүй” уулзалт;

3.Говьсүмбэр аймагт 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын арга хэмжээ;

4.Увс аймагт 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан арга хэмжээ;

5.Ховд аймагт 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Хүртээмжтэй ирээдүй арга хэмжээ;

6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газраас 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлдөх уулзалт;

---

[44] Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хорооноос ирүүлсэн асуумжийн хариулт, 2020 он, 26 дахь тал.

[45]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, “Бэрх биш ээлтэй” төсөл, “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт – 2021”, Эрдэм шинжилгээний онол практикийн хурлын эмхтгэл, 7 дахь тал.

[46]Мөн тэнд.

7.Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлтэй уулзалт;

8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбар зөвлөл 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрт хэрхэн хамрагдах зэрэг асуудлаар арга хэмжээ;

9.Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс 2022 оны 04, 05 дугаар саруудад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох өдөрлөг;

10.Орхон аймагт 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо” нэгдсэн арга хэмжээ;

11.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй оюутан, залуучуудын чуулга уулзалт;

12.Өмнөговь аймагт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэл бүтээлийн “Ээлтэй экспо-2022” арга хэмжээ;

13.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар, Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, нийслэлийн төвийн 6 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүд хамтран 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Бид бүгдийг чадна" арга хэмжээ;

14.ХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн "Disability Expo 2022" арга хэмжээ;

15."И-Монгол академи" УТҮГ-ын Цахим ур чадварын газраас 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр “Харааны бэрхшээлтэй сурагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт;

16.Замын-Үүд суманд 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөг;

17.Баянзүрх дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр “Хайрын бэлэг” арга хэмжээ;

18.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга барил” сургалт;

19.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 2023 оны 04 дүгээр сард “Аутизмыг таниулах, хандлагаа өөрчилье, эергээр хүлээж авъя” арга хэмжээ;

20.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллагын ажилтан албан хаагчдад хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт;

21.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монгол улсын их сургууль тус тус хамтран 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “Мэргэжлээ зөв сонгоё” өдөрлөг, арга хэмжээг тус тус зохион байгуулсан байна;

22.ГБХНХЯ нь 2023 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо” ТББ-тай хамтран нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшлийн 16 аж ахуйн нэгж, байгууллагын 160 автобусны жолоочид “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа хандлага”, “Нийтийн тээврээр зорчиход тулгардаг нийтлэг асуудлууд, харилцаа хандлага” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Товч дүгнэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд ялангуяа сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээнд тодорхой төсөв өнөөдрийг хүртэл төсөвлөж байгаагүй боловч салбар зөвлөл, дэд зөвлөл, байгууллагууд, донор байгууллага, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даасан, хараат бус, эрхтэй хүн гэдэг эерэг дүр зураг бий болгох ойлголт нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Энэхүү олон нийтийн мэдлэг, хандлагад нөлөөлөх үйл ажиллагааны үр дүн шууд биш аажмаар илрэх зүй тогтолтоа тул хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхах үйлдэл, эс үйлдэл багасч, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо өссөнөөр дүгнэх боломжтой юм.

<u>Конвенцын 9 дүгээр зүйлд заасан “Хүртээмж”-ийн тухайд:</u>

Конвенцын 9 дүгээр зүйлд зааснаар:

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад, тотгорыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээг *inter alia* дараах газарт авна:

a) барилга байшин, зам, тээвэр болон сургууль, орон сууцны байр, эмнэлгийн газар, ажлын байр зэрэг бүх төрлийн доторх болон гаднах байгууламж;

b) мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн үйлчилгээ тухайлбал, түргэн тусламжийн болон цахим үйлчилгээ.”

Конвенцын 9 дүгээр зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг төрөөс бий болгох, нийгмийн бүхий л төрлийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нэмэгдүүлэх тодорхой зохицуулалтыг Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зэрэг бусад салбарын хуульд тогтоомжид тусгасан.

а)Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин нөхцөл, үйлчилгээг бий болгохтой холбоотой зохицуулалтууд тусгагдсан байдаг ч бие даан ажиллаж, амьдрахад шаардлагатай дэд бүтцийг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд тавих шаардлагуудад төдийлөн нийцэхгүй, уялдаа холбоо сул байдаг. Барилга байгууламж, зам, нийтийн тээвэр, зогсоол зэрэг дэд бүтцийн хүртээмжийн хаягжилт, угтах үйлчилгээ, цахим хуудас, телевиз зэрэг мэдээллийн хүртээмжийн

чиглэлээр үнэлгээний бэрхшээл Хорооноос ирүүлсэн зөвлөмжтэй уялдуулан 2015 оноос эхлэн төр, төрийн бус байгууллага хамтран зохион байгуулсаар иржээ. Үүнд:[47]

1. Эрүүл мэндийн яамны захиалгаар 2015 оны 9 сард эмнэлгийн орчин дахь хүртээмжийн үнэлгээ хийх төсөл хэрэгжсэн. Хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар Монголын тэргэнцэртэй иргэдийн холбоо ажиллаж, 5 дүүргийн эрүүл мэндийн төвийн орчны хүртээмжид үнэлгээ хийж зөвлөмж гаргасан;

2. ХНХЯ, Хүний Эрхийн Үндэсний Комиссын санаачлагаар 2016 он хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран Улаанбаатар хотын төрийн захиргааны төв байгууллагуудад хүртээмжийн үнэлгээ хийсэн;

3. ХНХЯ, ЖАЙКА ОУБ-ын хамтран хэрэгжүүлсэн “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд 2016 онд Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээ, зогсоолын орчин, веб сайт, телевиз, хаягжилтад хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн;

4. Мөн төслийн хүрээнд ТББ-уудтай хамтран 2017 оны 4 дүгээр сард шинэ нисэх буудлын барилгад дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмж гарсан;

5. ХНХЯ-ны харьяа Сэргээн Засалт, Сургалт, Үйлдвэрлэлийн төв, “Түгээмэл Хөгжил төв” ТББ хамтран 2017 онд нийслэлийн 9 дүүргийн 30 цэцэрлэгт хүртээмжийн үнэлгээ хийсэн;

6. Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага/GIZ/-ын захиалгаар “Түгээмэл хөгжил төв” ТББ 2018 оны 2 дугаар сард Дархан-Уул аймгийн Уул уурхай, эрчим хүчний политехникийн коллежийн гадаад болон дотоод орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулагдсан дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулсан;

7. ХНХЯ-ны харъя Сэргээн Засалт, Сургалт, Үйлдвэрлэлийн төв, “Түгээмэл хөгжил төв” ТББ хамтран 2018 оны 4 дүгээр сард Сэргээн засах эмнэлгийн шинэ болон хуучин байр, гадаад орчинд дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээг хийж, зөвлөмж гарсан;

8. Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага/GIZ/-ын захиалгаар “Түгээмэл хөгжил төв” ТББ 2018 оны 5 дугаар сард захиалгаар Өмнөговь аймгийн Даланзадгад хотын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн гадаад болон дотоод орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардагдах орон зайн дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээг хийж, зөвлөмж гарсан;

9. Монгол Улсын Сайд, Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус Үндэсний зөвлөлийн болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх дэд зөвлөлийн 2018 оны үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын дэд бүтцийн хүртээмжийн байдалд үнэлгээ хийж, стандартад нийцүүлэх санал боловсруулах, шийдвэрлэх талаар тусгасны дагуу нийт 43 төрийн байгууллагад гадаад болон дотоод орчны дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийж зөвлөмж гарсан;

10. Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгресс”-ийг 2019 онд Улаанбаатар хотод зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээг зарим зочид буудал болон буудал орчмын олон нийтийн үйлчилгээний газрууд, нийтийн эзэмшлийн 10 байршилд явган хүний замд хүртээмжийн үнэлгээ хийж зөвлөмж гаргасан;

[47]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийн танлцуулга, 2023 оны 03-р сарын 30-ны өдөр.

11. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны өдрийн А/190 дугаар тушаалаар “Саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг Улаанбаатар хотын хэмжээнд судалж, хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрээр үнэлгээ хийх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан Улаанбаатар хотын төвийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн авто зам, замын байгууламж, нийтийн тээврийн үйлчилгээний саадгүй байдал, хүртээмж, Төрийн ордон, бүх яамд, нийслэлийн ЗДТГ, төвийн 6 дүүргийн ЗДТГ (нийт 24 байгууллага)- ын барилга байгууламж, төрийн захиргааны болон мэдээллийн технологи, вэб сайт, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжид үнэлгээ хийж, нэгдсэн дүгнэлт гаргасан.[48]

Мөн эрх зүйн орчныг хүрээнд Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2016 онд УИХ-аар батлаж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангахтай холбоотой зүйл, заалтуудыг шинээр нэмж тусган, холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэх ажил үргэлжилж байна. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд уг төсөлд хот байгуулалтад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашиг, хэрэгцээг хангахтай холбоотой заалтуудыг боловсронгуй болгох, шинээр нэмж тусгахаар ажиллаж байна. “Авто зогсоолын тухай” хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэний авто тээврийн хэрэгсэлд зориулсан авто зогсоолын хэсгийг тогтоосон норм, дүрэм, стандартын дагуу байгуулсан байх зэрэг асуудлыг тусгаад байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 123 дугаар тушаалаар "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 31-23-22/ барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баталсан. Энэхүү норм ба дүрэм хэрэгжснээр хүртээмжийг бодит амьдралд хэрэгжүүлэхэд захиалагч, зураг төсөл зохиогч, магадлан, барилгын гүйцэтгэгч, хяналтын байгууллагын харилцан уялдаа сайжирна. Энэ нь бүх хүний аюулгүй, илүү ая тухтай амьдарч, ажиллах, сурч боловсрон өөрийгөө хөгжүүлэх боломжтой архитектурын таатай орчинг төлөвлөж бүтээн байгуулахад техникийн чухал баримт бичиг болсон.[49]

Улмаар Барилгын тухай, Хот байгуулалтын тухай хуулиудын дагуу Барилгын хөгжлийн төв нь хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх шатанд “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” /БНбД 30-01-04/, "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНбД 31-23-22/, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага” /БД 31-101-04/”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт” /БД 31-112-11/ болон холбогдох бусад норм, стандартын шаардлагыг хангуулан хянаж баталгаажуулан ажиллаж байна.[50]

Эдгээр хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах зорилгоор орон сууц, оффис, үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, соёлын төвийн зориулалттай барилга, байгууламжийн ажлын зураг төсөлд барилга, архитекторын бие даасан шинжээчдээр магадлалын дүгнэлт гаргуулж байна. “Архитекторын мэргэшсэн зэрэг горилогчдод зориулсан сургалт”-ын хөтөлбөрт 2-4 цагийн хичээл, барилгын

[48]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Саадгүй байдал, хүрээмжийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал /төсөл/, 1.2.практик шаардлага 2023.

[49] Монгол Улсын Засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2 болон 3 дугаар тайлан, 2023 он, 11 дэх тал.

[50] Монгол Улсын Засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2 болон 3 дугаар тайлан, 2023 он, 11 дэх тал.

салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрт хот төлөвлөлт, барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн арга хэмжээг тусгах сэдвээр хичээл оруулж, зохих мэдлэг олгохыг зорьж байгаа аж.

Хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг манлайлан загвар болгох зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/93 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нийслэл дэх 37 байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй байдалд үнэлгээ хийх ажлыг “Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”, “Түгээмэл хөгжил”, “Сонгино” бие даан амьдрах төв гэсэн хүртээмжийн үнэлгээгээр мэргэшсэн төрийн бус байгууллагууд хийж гүйцэтгэжээ. Энэхүү үнэлгээ нь тус салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй загвар, хүртээмжтэй орчин бүрдүүлэх ажлын нэгэн чухал хэсэг болж байна. Үнэлгээний үр дүнг үндэслэн 2019 онд бүх аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн үйлчилгээний танхимыг хүртээмжтэй болгохоор Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-тэй хамтран ажиллаж байна.

Мөн ХНХЯ-ны барилга, байгууламжийг хүртээмжтэй болгох ажлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний үүсгэн байгуулсан “Рехтус” ХХК-иар гүйцэтгүүлсэн байна. Энэ ажлын үр дүнд 3 ариун цэврийн өрөөг хүртээмжтэй болгон шинэчлэн засварлаж, 50 гаруй метр тактелин зам, 100 гаруй метр ханын бариулыг шинээр хийсэн. Яамны 2 хурлын заалыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгон засварлаж, тохижуулаад байна. Бүх өрөөний хаяг, давхрын мэдээллийг брайль үсгээр хийж, тэргэнцэртэй иргэдэд зориулсан өргөх төхөөрөмжийг байрлуулаад байна. Ингэснээр ХНХЯ бусад төрийн байгууллагад загвар болохуйц, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төдийгүй бүх хүнд таатай, ээлтэй, хүртээмжтэй орчин бүрдүүлэхээр ажиллаж байгаа[51] талаар дурдагджээ.

Гэсэн хэдий ч Улаанбаатар хүн ам ихээр явдаг төвийн дүүргийн 12 барилга нь “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин” MNS 6055:2009 стандартад нийцэж байгаа эсэхийг судлахад тэдгээр барилгын 75 хувь нь стандартад нийцээгүй дүн гарсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдөж байгаа буюу хүртээмж хангалтгүй байгааг илтгэнэ.

b) Монгол Улсын Их Хурлаас 2019 онд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийг баталсан бөгөөд энэхүү хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 21.3-т заасан шаардлагад дараах бүтээлийн хувь хэмжээг тодорхойлно”, мөн зүйлийн 23.5.4-т “хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлэг” гэж заасан бөгөөд товчхондоо телевизээр гарч байгаа тодорхой төрлийн нэвтрүүлэгт заавал дохионы хэл ашиглахаар заасан.

Энэ нь хорооноос өгсөн зөвлөмжийг хоёр дахь хэсэгт заасан “дохионы хэл болон брайлыг хууль ёсны болгож, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэй,

[51] Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хорооноос ирүүлсэн асуумжийн хариулт, 2020 он, 7 дахь тал.

олон төрлийн контентуудын тоо хэмжээг ихэсгэх” хэсгийг хэрэгжүүлж байгаа илрэл гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх мэдээллийг хүртээмжийг нэмэгдүүлэх, орчин үеийн төхөөрөмж болон программ хангамжийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2022 оны 01-р сарын 10-наас 12-ны өдрүүдэд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд вэбсайт болон аппликэйшнийг ээлтэй болгох нь” сэдэвт сургалтын зохион байгуулсан байна.[52]

Цахим хөгжил, харилцаа, холбооны яамнаас 2022 оны 11-р сарын 22-ны өдөр харааны бэрхшээлтэй суралцагчдад цахим ур чадвар дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан байна. Тодруулбал, "И-Монгол академи" УТҮГ-ын Цахим ур чадварын газраас харааны бэрхшээлтэй сурагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Мэдээллийн аюулгүй байдал” сэдвээр зохион байгуулжээ. Тус сургалтад нийслэлийн Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн харааны бэрхшээлтэй сурагчдыг хамруулсан байна.[53]

Тус яам БНСУ-ын дэмжлэгтэйгээр байгуулсан Цахим ур чадвар олгох төвийг байгуулсан бөгөөд тус төв хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх боломжтой байна. Төв нь 354 м.кв талбайгаас бүрдэх бөгөөд тус төв 2 сургалтын өрөөтэй бөгөөд нэг сургалтын өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй, тэр дундаа харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан тоног төхөөрөмж, шаардлагатай тусгай хэрэгслүүдийг байрлуулсан байна.[54]

Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар мэдээлэл хариуцагч нь мэдээллээ байнга нээлттэй, ил тод байлгах шаардлагатай 68 төрлийн мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр үнэлж, иргэдийн мэдэх эрхийг хангах үүрэгтэй бөгөөд ЦХХХЯ-ны Салбарын хяналтын газар мэдээллээ бүрэн үнэлж ирүүлээгүй, байгууллагуудад хугацаатай үүрэг, чиглэл өгч ажилласан. Энэхүү ажлын хүрээнд 2023 оны 04-р сарын 12, 13-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар ажиллаж Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь харьяа Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төв гэсэн 3 байгууллагатай бөгөөд өгсөн үүрэг чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг ирүүлэхийг даалгасан байна.[55]

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн олон үйл ажиллагааг санхүүжүүлдэг гол сан болох Нийгмийн халамжийн сангийн мэдээллийг ил болгосон бөгөөд 2008 оноос хойш давхардсан тоогоор 21,6 сая иргэнд 14 төрлийн 7,5 их наяд төгрөгийн халамж олгосон байна. Мөн 2022 онд давхардсан тоогоор 1,3 сая иргэнд 515,6 тэрбум төгрөг зарцуулжээ. Халамжийн 14 төрлөөс 3 нь буюу хөгжлийн бэрхшээлтэй

[52]Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан ёсны цахим хуудас, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд вэбайт болон аппликейшнийг ээлтэй болгох нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа – үзэх https://mddc.gov.mn/mn/5016/.
[53]Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан ёсны цахим хуудас, “Харааны бэрхшээлтэй сурагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сурагалт боллоо”, https://mddc.gov.mn/.
[54]Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан ёсны цахим хуудас, “Цахим ур чадвар олгох төв”-ийн танилцуулга, 2023 оны 12-р сарын 23-ны өдөр, https://mddc.gov.mn/.
[55]Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан ёсны цахим хуудас, “ЦХХХЯ-ны Салбарын хяналтын газар Ус цаг уур орчны шинжилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газруудад ажиллалаа.” – үзэх https://mddc.gov.mn/mn/12686/.

иргэн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлдэг 969 хуулийн этгээдэд олгосон санхүүгийн мэдээлэл ил болсон байна.[56]

УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 101-д “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил”, “Амьдралын чанар ба дундаж давхарга” гэсэн зорилгуудад заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам **Саадгүй байдал, хүртээмжийн тухай** хуулийн анхдагч төслийг Засгийн газраас боловсруулаад байна.

Тус хуулийн зорилгыг хууль санаачлагч хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар тэдний нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн бие даан оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аливаа саад учрахаас урьдчилан сэргийлэх, учирч буй саадыг арилгах мөн тэдэнд барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо болон үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах байхаар тодорхойлжээ.[57]

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулж байгаа Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн анхдагч төсөлд дараах агуулга бүхий хуулийн зохицуулалтууд тусгагджээ:

a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах явдлыг үүсгэж байгаа бүхий л хууль тогтоомж, дүрэм журам, зан заншил, уламжлалыг арилгах, өөрчлөх бүхий л зохистой арга хэмжээг авах;
b) төрийн бүх бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих явдлыг тусгана;
c) энэхүү конвенцод үл нийцэх үйлдэл, эсхүл дадал зуршил гаргахаас татгалзаж, төрийн эрх бүхий албан тушаалтан, байгууллагыг энэхүү конвенцод нийцсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явдлыг хангана;
d) аливаа этгээд, байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах явдлыг устгахад чиглэгдсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна;
e) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээг хангахад чиглэсэн аль болох хамгийн бага тохируулга шаардагдах бөгөөд хамгийн бага үнэ өртөгтэй энэхүү конвенцын 2 дугаар зүйлд тодорхойлсон түгээмэл загвар бүхий бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмж болон хэрэгслийг зохион бүтээх, боловсруулах, энэ талаар судалгаа шинжилгээ хийхийг хөхиүлэн дэмжих, тэдгээрийг ашиглахад дэмжлэг үзүүлэх, түүнчлэн стандарт, гарын авлагыг боловсруулахдаа түгээмэл загварыг тусгуулах явдлыг дэмжинэ;
f) хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохирсон, юуны өмнө өртгийн хувьд хямд шинэ технологи, түүний дотор мэдээлэл харилцааны технологи, хөдөлгөөн хөнгөвчлөх хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологийг боловсруулах, энэ талаар судалгаа шинжилгээ хийхийг хөхиүлэн дэмжих;

[56] Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан ёсны цахим хуудас, “Тусгай сангуудын мэдээллийг ил болголоо”, https://mddc.gov.mn/mn/5016/.
[57] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Саадгүй байдал, хүрээмжийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал /төсөл/,Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, 2023.

g) хөдөлгөөн хөнгөвчлөх хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологи, ялангуяа шинэ технологи, тусламж үзүүлэх бусад хэлбэр, нэмэлт үйлчилгээ болон объектын талаарх мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох;
h) туслалцаа, үйлчилгээг сайжруулах үүднээс энэхүү конвенцод заасан эрхийг эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцаж ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудыг сургах ажлыг дэмжих.

2023 оны байдлаар Засгийн газраас боловсруулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Монгол дохионы хэл, Брайль үсгийн стандартын тухай өөрчлөлтийг тусгасан байна.

Товч дүгнэлт: Дүгнэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх конвенцын заалтыг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар, яамдаас холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнээс онцлох үйл ажиллагаа Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөл боловсруулж УИХ-д өргөн барихаар бэлтгэж байгааг онцлох нь зүйтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа нөхцөл байдлын нарийвчлан тодорхойлох сургуулиудын хэрэглэгдэхүүн, боловсон хүчин хангалтгүй байгаа буюу 42 багшаас авсан судалгаанд тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд зориулсан брайл үсгийн хэрэглэгдэхүүн байдаг эсэх асуултад 19% нь тийм, 81% нь үгүй, мөн дохионы хэл мэддэг багш байдаг эсэх асуултад 95% нь одоо сурч байгаа, 5% нь үгүй гэж харилсан судалгааны хариултаас тус тус харагдаж байна.

Цаашид мэдээллийн технологийн ололт амжилтыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд сайжруулахад тогтмол анхаарах шаардлагатай.

8.Конвенцын 10 дугаар зүйлд заасан “Амьд явах эрх”-ийн тухайд:

Конвенцын 10 дугаар зүйлд “Оролцогч улсууд нь хүн бүр амьд явах салшгүй эрхтэй гэдгийг дахин нотолж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил энэ эрхээ бүрэн дүүрэг эдлэх явдлыг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээ авах”-аар заасан.

Конвенцын 10 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;” гэж заасан буюу амьд явах эрхийг Монгол Улсын бүхий л иргэний заавал эдлэх амьд явах эрхийн нэн тэргүүний эрх байхаар Үндсэн хуульд тусгасан. Түүнчлэн Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Нэмэлт II Протоколд нэгдэн орох тухай хуулийг 2012 оны нэгдүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон батлаж, Монгол Улс цаазаар авах ялгүй орон болсон.

НҮБ-ын 1982 оны XVI чуулганаар "...гишүүн орнууд...хамгийн ноцтой гэмт хэрэгт ч цаазаар авах ял шийтгэлийг хязгаарлах ёстой” гэсэн зөвлөмжийг гаргасан байдаг. Уг

зөвлөмжийг хэрэгжүүлэх олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, зайлшгүй шаардлага манай улсад байсан бөгөөд хүний эрхийн үндэсний байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комисс нь цаазаар авах ялыг халах асуудлыг хөндөн судалж, санал, зөвлөмжийг удаа дараа гаргасаар ирсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталж, 2017 оны 07-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/[58]-д хуулийн аравдугаар бүлэгт Хүний амьд явах эрхийн эсрэг Хүнийг алах, Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах, Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, Эх нярай хүүхдээ алах, Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох зэрэг 6 төрлийн гэмт хэргийг хуульчилсан.

Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтууд нь а)хүний амьд явах эрхийг баталгаажуулах, б)хүн ямар ч хүнд гэмт хэрэг үйлдсэн байсан амь цаазаар авах ял оноохгүй байх үндсэн хоёр эрх зүйн дагавартай.

Мөн Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.7-д “хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд, жирэмсэн болохыг мэдсээр байж;” хүнийг алсан бол тухайн гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй байхаар авч үзэж арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэхээр заасан нь биеэ хамгаалж чадахгүй нөхцөл байдалд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрхийг нарийвчлан хамгаалах эрх зүйн зохицуулалт болж өгсөн.

Товч дүгнэлт: Конвенцын 10 дугаар зүйлийн хэрэгжилт Эрүүгийн хуульд тусгаж, хамгаалсан байна. Түүнчлэн төрийн эрх бүхий байгууллага болон бусад этгээдээс хөгжлийн бэрхшээлтэй хүний амьд явах эрхийг ямар нэг байдлаар зөрчсөн, тэдний энэхүү эрхийг бусад хүмүүсийнхээс ялгамжтай байдлаар авч үзсэн тохиолдол байхгүй байна.

Конвенцын 11 дүгээр зүйлд заасан “Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал”-ын тухайд:

Конвенцын 11 дүгээр зүйлд:

“Оролцогч улсууд олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын хүний эрхийн хэм хэмжээг оролцуулан олон улсын эрх зүйгээр хүлээлгэсэн үүрэгтэй нийцүүлэн эрсдэл бүхий байдал, тухайлбал зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн гамшиг, байгалийн аюул гамшиг тохиолдсон үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангахад чиглэсэн шаардлагатай бүхий арга хэмжээг авна” гэж заасан.

Конвенцын 11 дүгээр зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Конвенцын 11 дүгээр зүйлийн хэрэгжилт нь эрх зүйн орчинд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн есдүгээр бүлэг буюу “Хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад эрх” бүлгийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт “Хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал зэрэг онцгой байдал бий болох үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ тухай

[58]Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №7.

хүртээмжтэйгээр мэдээлэх, тухайн үед амь нас, эрүүл мэндийг нь онцгой байдлын нөхцөлтэй уялдуулан хамгаалах үүргийг төрийн холбогдох байгууллага хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх" талаар заасан.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд гамшиг, аюулт үзэгдэл, осол хэмээх хуулийн нэр томьёог хуульчилсан бөгөөд гамшгийн үед авах арга хэмжээг зохицуулсан. Тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт мэргэжлийн ангийг бүрдүүлэх иргэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамаарахгүй болохыг заасан харин Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид зэвсэгт мөргөлдөөн, байгалийн аюул гамшиг зэрэг эрсдэлт нөхцөл байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах талаарх тусгайлсан зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12-р сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаалаар "Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах заавар", "Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө боловсруулах заавар", "Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ыг тус тус баталсан.[59]

Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах зааврын 3.2.1.Б-д "Хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт"-ийг тусгахаар заасан. Үүнд: "хүн ам, өрхийн тоо /насны бүлэг, хүйсээр, амьжиргааны түвшин/ нягтрал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, шилжилт хөдөлгөөн, ... нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар оруулна" гэж заасан. Мөн 3.4.3-т "Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө" хэсэгт "гамшгийн голомтоос иргэдийг шилжүүлэх тухай зарлан мэдээлэх, ... хөгжлийн бэрхшээлтэй болон өвчтэй хүмүүсийг хэрхэн нүүлгэн шилжүүлэх" талаар заавал тусгахаар заажээ.

БНХАУ-д 2019 онд сүүлээр дэгдэж дэлхий даяар ихээхэн хохирол учруулсан Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал нь конвенцын 11 дүгээр зүйлд тусгагдсан эрсдэл бүхий нөхцөл байдалд шууд хамаарах бөгөөд цар тахал идэвхтэй дэгдсэн 2020 болон 2021 онуудад улс орны хэмжээнд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комисс зэрэг төрийн эрх бүхий байгууллагаас олон тооны шийдвэр, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Төрийн эрх бүхий байгууллагын холбогдох шийдвэрийн биелэлтийн явцад хүний эрх, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдсөн тохиолдол цөөнгүй байв.

Ковид-19 цар тахлын улмаас тогтоосон хөл хорионы үеэр хувиараа хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нэн эмзэг байж, орлого нь тасарчээ. 2020 оны 12 дугаар сард Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооноос явуулсан судалгаанд оролцсон 196 хүний 49 хувь нь цар тахлын улмаас ажил орлогогүй болсон, 15 хувь нь орлого буурсан, 15 хувь нь амьдрал хүндэрсэн, 21 хувь нь амьжиргаанд өөрчлөлт гараагүй гэжээ. [60] Хөл хорионы улмаас орлого нь тасарсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид найдахаас өөр аргагүй болсон нь хоол хүнсний хэрэглээгээ багасгах, шим тэжээлтэй хоол хүнс худалдан авч

[59]Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг, Онцгой байдлын ерөнхий газар, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, https://nema.gov.mn/n/49519.
[60]Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, "Ковид-19 ба хөгжлийн бэрхшээл чанарын судалгааны тайлан", УБ, 2021 он.

чадахгүй болоход хүргэсэн гэжээ.[61] Энэ дүр зураг 2020 оны 5 болон 12 дугаар сард “Түгээмэл хөгжил төв” төрийн бус байгууллагаас хийсэн судалгаагаар мөн харагдаж байна. Судалгаанд оролцсон 20-60 насны 100 хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 76-гийнх нь орлого буурчээ.

Ковид-19 цар тахлын үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар зарим арга хэмжээ авчээ. Эрүүл мэндийн сайдын А/29 албан даалгаврын дагуу 9 дүүргийн Эрүүл мэндийн төв болон 4 нэгдсэн эмнэлгээс 1374 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд гэрээр зөвлөгөө өгөх, хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлсэн гэжээ.[62] Хөл хорионы улмаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний эмнэлгийн тусламж авах эрх ноцтой зөрчигдсөн талаарх мэдээлэл Хүний эрхийн үндэсний Комисст бүртгэгдээгүй боловч амралт, сувиллын газар хаагдсаны улмаас шаардлагатай нөхөн сэргээх эмчилгээ, сувилахуйн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй, эрүүл мэнд нь доройтсон талаар иргэд мэдээлж байсан. Ковид-19 цар тахлын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээг харгалзан орлого, эм, ахуйн хэрэгцээт бүтээгдэхүүнээр хангах, нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрх, сурч боловсрох эрхийг хангах асуудлууд хүндээр тулгарч[63] энэхүү зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээг хэрхэн авах тухай зааварчилгаа, эрх зүйн зохицуулалт байгаагүйн улмаас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс шаардлагатай зааварчилгаа, зөвлөмжийг Засгийн газар, Улсын онцгой комисс зэрэг байгууллагуудад хүргэн ажиллаж байсан байна.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас гамшгаас хамгаалах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нарт сургалт зохион байгуулж улсын хэмжээнд 2020 онд 98 хүнийг 9 удаа 9 цагийн, 2021 онд 463 хүнийг 26 удаа 42 цагийн, 2022 онд 324 хүнийг 8 удаа 16 цагийн сургалтад хамруулсан. Хөгжлийн бэрхшээлийг нийгэмд зөвөөр таниулах “Бэрх биш ээлтэй аян”, “Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлье” нэгдсэн арга хэмжээ, Гал унтраах тактикийн сургуульд “Тэргэнцэртэй иргэнийг аврах ажиллагаа” сургалт, “Гал түймэр болон газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх” арга хэмжээ, “Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх” арга хэмжээ, “Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх” сэдвээр зохион байгуулсан сургалтуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан байна.[64]

Товч дүгнэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 36 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хууль хоорондын нэр томьёог нийцүүлэх хэрэгцээтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан байдаг учир эрсдэл бүхий нөхцөл байдал үүсэхэд энэ тухай хүртээмжтэйгээр мэдээлэх, шаардлагатай тохиолдолд тусгай баг гарган ажиллах зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах талаарх тусгайлсан зохицуулалтыг “Гамшгаас хамгаалах тухай” хуульд нэмэх шаардлагатай.

[61]Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо "Ковид-19 ба хөгжлийн бэрхшээл чанарын судалгааны тайлан", УБ, 2021 он.
[62]Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2021 оны 03-р сарын 01-ний өдрийн 1/151 дүгээр албан бичиг.
[63]Монгол Улсын дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 87-88 дахь тал.
[64] Монгол Улсын Засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2 болон 3 дугаар тайлан, 2023 он, 11 дэх тал

Харин конвенцын зөвлөмжийн хоёр дахь хэсэгт заасан хүмүүнлэгийн яаралтай тусламж болон эрсдэлийн нөхцөл байдалд туслах үндэсний төлөвлөгөө боловсруулах, түүнийг бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүн дотроос сонсголгүй хүмүүст хүртээмжтэй байх хэмээн заасны дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зааварт хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар тусгасан хэдий ч сонсголгүй хүмүүст хэрхэн мэдээлэл хүргэх, хүртээмжтэй байлгах талаар нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй.

Мөн конвенцын 11 дүгээр зүйлд заасан эрсдэл бүхий нөхцөл байдал бий болсон Коронавируст халдварын дэгдэлтийн эд үе буюу 2020-2021 онуудад Засгийн газар, Улсын онцгой комиссын зүгээс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст яаралтай тусламж хүргэх, тэднийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах тусгайлсан төлөвлөгөө, үйл ажиллагааны заавар байгаагүй бөгөөд үндсэн төлөвлөгөөний зарим хэсгээр зохицуулж байсан нь тэдний эрх зөрчигдөж байсан бөгөөд Хүний Эрхийн Үндэсний комисс шаардлагатай зөвлөгөө, зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байсан нь энэ чиглэлийн эрх зүйн орчин, түүнд үндэслэсэн төлөвлөгөө, үйл ажиллагааг даруй бий болгох шаардлагатай харуулж байна.

Хүний эрхийн Үндэсний комиссын 21 дэх илтгэлд гамшгаас хамгаалах үндэсний төлөвлөгөө, авах хариу арга хэмжээ, заавар зөвлөгөөг шинэчлэн боловсруулах тухай УИХ-д санал болгож оруулсаны дагуу үндэсний төлөвлөгөө боловсруулах, үүнд нэг зорилтот бүлэг болгон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх үйлчилгээ, авах арга хэмжээ, хамгаалалтын талаар зохицуулах хэрэгцээ хэвээр байна.

<u>Конвенцын 12 дугаар зүйлд заасан “Хуулийн өмнө тэгш байх эрх”-ийн тухайд:</u>

Конвенцын 12 дугаар зүйлд:

“1.Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүний нэгэн адил хуулийн өмнө адил тэгш байх эрхтэйг дахин нотолж байна.”

2.Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрх зүйн чадамжтай байх явдлыг хүлээн зөвшөөрнө.

3.Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхэд нь шаардагдах дэмжлэг туслалцааг хүртээмжтэй байлгах үүднээс шаардлагатай арга хэмжээ авна.

4.Оролцогч улсууд нь эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй, зохистой хамгаалалтыг бий болгохуйц эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх арга хэмжээг олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу авна. Эрх зүйн чадамжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ийм хамгаалалт нь тухайн хүний сонголт, хүсэл зоригт нийцсэн, эрхийг хүндэтгэсэн, сонирхлын зөрчилгүй, сөрөг нөлөөгүй, хувийн нөхцөл байдалд нь тохирсон, байж болох хамгийн богино хугацаанд байх бөгөөд бүрэн эрхт, хараат бус, бие даасан байгууллага, эсхүл шүүхийн зохих шатны байгууллага түүнийг тогтмол хянаж байна. Эдгээр хамгаалалт нь тухайн хүний эрх, ашиг сонирхол аль хэр хөндөгдөнө төдий чинээний хэмжээтэй байна.

5.Энэ зүйлийн заалтуудын дагуу оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эд хөрөнгө эзэмших, түүнийг өвлөх, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх болон банкны зээл, үл хөдлөх хөрөнгийн барьцаат зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрхийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эд хөрөнгийг хүсэл зоригийг нь үл хамааран хураахгүй байх явдлыг баталгаажуулна.” хэмээн тус тус заасан.

Конвенцын 12 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэх суурь зарчмыг тусгасан. Энэхүү үзэл санаанд тулгуурлан Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зэрэг үндэсний хууль тогтоомжуудаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн амьдралд оролцох, нөхөн сэргээгдэх, сурч боловсрох, бусдын адил ажил, хөдөлмөр эрхлэх, нийгмийн хамгаллын үйлчилгээ авах тэгш эрхийг баталгаажуулж өгчээ.

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй” гэж нарийвчлан зохицуулсан байна. Мөн бусад салбарын хууль тогтоомжуудад хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг тухайлан заасан. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” хэмээн заасан.

Харин энэхүү ажиллагааг шүүхийн нөхцөлд явуулах харилцааг зохицуулсан нарийвчилсан хууль тогтоомж болох Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.3-т “сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох;” ажиллагаа шүүхийн онцгой ажиллагаанд хамаарах бөгөөд шүүхийн журмаар ийнхүү тооцуулах хүсэлтийг дараах этгээд, доорх журмаар гаргахаар тус хуульд зохицуулсан. Үүнд:

“141.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлуулах тухай сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах тухай хүсэлтийг уг иргэний гэр бүлийн гишүүн, эсхүл сонирхогч бусад этгээд /сонгуулийн хороо, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга/, асран хамгаалах байгууллага, эрүүл мэндийн байгууллага шүүхэд гаргана.

141.2.Хүсэлтийг уг иргэний оршин суугаа буюу эмчлүүлж байгаа газрын шүүхэд гаргана.

141.3.Хүсэлтэд сэтгэцийн өвчний буюу мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас уг иргэний өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох буюу өөрийгөө зөв удирдаж чадахгүй байгаа байдлыг тодорхой дурдаж холбогдох нотлох баримтыг хавсаргана.”

142.1.Хүсэлт хүлээн авсан шүүх нь сэтгэцийн эмгэг судлалын шинжээч томилон шинжилгээ хийлгэж, тухайн иргэний сэтгэцийн байдал, өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох, өөрийгөө зөв удирдаж чадах эсэх талаар дүгнэлт гаргуулна.

142.2.Шинжилгээ хийлгэхээс зайлсхийсэн этгээдэд шүүгчийн захирамжийн дагуу албадан шинжилгээ хийлгэж болно.

142.3.Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ асран хамгаалах байгууллагын төлөөлөгч, харгалзан дэмжвэл буюу асран хамгаалбал зохих этгээдийг шүүх хуралдаанд оролцуулж болно.” хэмээн тус тус заасан.

НҮБ-ийн хөгжлийн бэрхшээлтэй Хүний эрхийн хорооноос 2015 онд өгсөн зөвлөмжид “...Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа оюуны болон сэтгэц нийгмийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийн амьдралын талаар сонголт хийх, бусдын нэгэн адил хуулийн чадамжаа эдлэх эрхийг баталгаажуулах хууль ёсны арга хэмжээнүүд хангалтгүй байна. Мөн хөгжлийн бэрхшээлээсээ болоод сэтгэл зүйл хязгаарлалтад орсон хүнийг хуулийн байнгын чадамжгүй гэж үзэн хүний асуудлууд болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой шийдвэр гаргахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асран хамгаалагч нарт оролцогч улс зөвшөөрөл олгож байна.” гэсэн хэсэгтээ одоо ч зөрчилдсөөр байгаа бөгөөд Монгол Улсын хуулийн дагуу оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрийн өмч хөрөнгөтэй холбоотой болон бусад асуудлаар шийдвэр гаргах эрх хангагдаж чадаагүй хэвээр байгаа гэж үзэх үндэслэл болно.

Тодруулбал, Иргэний хуулийн 18.2, 18.3, 18.4 болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133, 142, 143 дугаар зүйлүүдэд тус тус зааснаар оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүнийг шүүхээр эрх зүйн чадамжгүй гэж тогтоох, улмаар түүнтэй холбоотой шийдвэр гаргах бүх эрхийг түүний нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хэлцэл хийхээр заасныг хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэл, зориг, саналыг заавал харгалзан үзэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийн оролцоог хангах зохицуулалтыг зайлшгүй бий болгох, конвенцын зөвлөмжийг биелэлтийг хангах шаардлага бий болоод удаж байгаа бөгөөд аливаа оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцооход түүний оролцоо, эрхээ хамгаалах боломж огт байхгүй байна. Жишээлбэл, Иргэн М-ийн өмчлөлд байсан газар болон байшинг М-ийн асран хамгаалагч нь банкны барьцаанд тавиад зээл авчихсан. Зээлээ төлж чадаагүйн улмаас иргэн М газар, байшингаа Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газарт хураалгахад хүрсэн.[65]

Тэрчлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн онцлогт тохирсон хэлбэрээр хуулийн чадамжаа хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл олж авахад хүндрэлтэй хэвээр байна. Жишээлбэл: сонсголгүй иргэдийн мэдээлэлгүй байдлыг ашиглан эд хөрөнгийг хууль бусаар эзэмших, өв залгамжлалыг нь дур мэдэн өөрийн нэр дээр шилжүүлэх, банкны зээлийн өрөнд тавьж барьцаалах гэх мэтээр хувийн өмчид зүй бусаар халдан орон гэргүй болсон сонсголгүй иргэд их байна.Тэднийг зүй бусаар хуурч залилан, хохирол учруулсан иргэдэд тооцох хариуцлага сул байна.[66] Мөн харагны бэрхшээлтэй иргэн банкнаас зээл авч чаддаггүй. Учир нь Иргэний хуулийн 42.6 –д “Өвчин болон бичиг үсэг мэдэхгүйн улмаас гарын үсгээ өөрөө зурж чадахгүй этгээдийн итгэмжлэлээр өөр этгээд төлөөлөн хэлцэлд гарын үсэг зурж болно.” Мөн хуулийн 64 дүгээр зүйлд “итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх шаардлага” тавьжээ. Гэтэл харагны бэрхшээлтэй иргэдийн хувьд

[65]Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороонд Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаас илгээж буй Сүүдэр илтгэл, 2023 он, 18 дахь тал.
[66]Мөн тэнд.

гарын үсэг зурах боломжгүй өөрийн дардас ашигладаг учраас банкны хэлцэл хийх боломжгүй болдог.[67]

Харин энэ чиглэлд хийж хэрэгжүүлж буй зарим нэг ажлын тухайд үндэсний, бүсийн болон орон нутгийн түвшинд төрийн албан хаагч, шүүгч, нийгмийн ажилтнуудад тусламжтайгаар шийдвэр гаргах механизмын талаар болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хуулийн чадамжийн талаар сургалт зохион байгуулах хүрээнд бүх нийтийн эрх зүйн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, сурталчилгааны www.ekhutuch.mn портал цахим хуудсанд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх" сэдвээр агуулга мэдээлэл бэлтгэн оруулж, иргэдэд зориулсан хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны "Өрхийн эрх зүйн хөтөч" /гарын авлага/ ном бэлтгэн хэвлүүлж байна. Уг номонд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэх харилцааны онцлог, нийгмийн халамж, тусламж, үйлчилгээ" сэдвийг багтаав. Мөн иргэдийн эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, өөрийн нийт албан хаагчдад хүний эрхийн асуудлаар хичээл сургалт зохион байгуулж, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын хуульчдын холбоотой хамтран хүний эрхийн асуудлаар сургалт явуулах сургалт багш бэлтгэж байна.

Товч дүгнэлт: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хуулийн өмнө эрх тэгш байх үндсэн зарчмын агуулгыг конвенцод нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудад тусгаж өгсөн хэдий ч 2002 онд батлагдсан Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг зайлшгүй өөрчлөх шаардлага үүссэн байна.

Товчхондоо хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхийн журмаар тогтоох, шүүхэд хүсэлт гаргах, шүүхийн ажиллагааг явуулах бүхий л үйл ажиллагаанд оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэний өөрийн нь оролцоо, түүний хүсэл зориг, санал бодлыг сонсох, харгалзан үзэх хуулийн зохицуулалт байхгүй бөгөөд энэхүү ажиллагаа бүхэлдээ тэдний оролцоогүйгээр, бусад этгээдээс хамааралтайгаар явагдаж байна. Нөгөөтээгүүр тэд бид даан хэлцэл хийх, хэлцлийн хэлбэрийн шаардлагыг биелүүлэх тухайлсан нөхцөлийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан бий болгох нь зүйтэй.

Конвенцын 13 дугаар зүйл заасан "Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрх"-ийн тухайд:

Конвенцын 13 дугаар зүйлд:

"1.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр шүүхийн шатны бүх үйл ажиллагаа, түүний дотор мөрдөн байцаалт болон шүүхийн өмнөх шатны бусад ажиллагаа зэрэг хууль эрх зүйн бүх ажиллагаанд шууд болон шууд бус оролцох үүрэг, тухайлбал гэрчийн хувьд үр нөлөөтэй оролцох явдлыг байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээ болон насны онцлогт нийцсэн хэрэглэгдэхүүн ашиглах замаар шүүх ажиллагаанд хүртээмжтэй, үр дүнтэй оролцох эрхийг оролцогч улсууд хангана",

[67]Мөн тэнд.

“2.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шүүх ажиллагаанд үр дүнтэй, хүртээмжтэй оролцох нөхцөлийг хангах үүднээс оролцогч улсууд шүүхийн байгууллагуудад тухайлбал, цагдаа болон хорих ангийн албан хаагчдыг зохих сургалтад хамруулах явдлыг дэмжинэ” гэж тус тус заажээ.

Конвенцын 13 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан “Монгол Улсад хүн бүр үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, түүнчлэн аж ахуйн нэгж байгууллага өмчийн хэлбэр, эрх хэмжээний ялгаваргүйгээр хуулийн өмнө эрх тэгш байна.” гэсэн зарчмын үндсэн дээр Монгол Улсын шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Үндсэн хууль, эрүү, иргэн, захиргааны салбарын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудад энэ талаарх нарийвчилсан зохицуулалтыг тусгажээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт “Хэргийн оролцогч монгол хэл мэдэхгүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэйн улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол шүүгч тэдгээрийн хүсэлтээр орчуулагч, хэлмэрчийг захирамж гарган томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.” хэмээн зааж, тус зүйлд хэлмэрч, орчуулагчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой заасан.

Үүнтэй ижил агуулга бүхий зүйл, хэсэг, заалт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт “Хэргийн оролцогч монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий бол түүний хүсэлтээр орчуулагч, хэлмэрчийг шүүгч захирамж гарган томилно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч орчуулагч, хэлмэрчийн үүргийг гүйцэтгэхийг хориглоно” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдах”-аар зааж, мөн хуулийн 9.4 дүгээр зүйлд хэлмэрч, орчуулагчийн талаар заасан.

Монгол Улсын Шүүхийн 2020 оны тайланд хөгжлийн бэрхшээлтэй иргэд шүүхийн үйлчилгээ авах, шүүн таслах ажиллагаанд оролцох боломжийг хангах зорилгоор дараах тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн талаар дурджээ. Үүнд:

- Тамгын газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тэдгээрийн тав тухтай байдлыг хангах, хүндрэл саадгүй үйлчлүүлэхэд зориулж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтарч тусгай хэрэгцээний налуу шатыг өөрсдийн ажилчдын хамтаар хийж гүйцэтгэсэн;[68]
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газраас 2020 онд иргэд, албан байгууллагын эрх зүйн боловсролыг дээшлүүлж чанаржуулах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы хэлмэрчтэй мэдээллийг богино хугацааны бичлэг хэлбэрээр цуврал болгон гаргасан;[69]

[68] Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, (2020 он), 144 дэх тал.
[69] Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, (2020 он), 145 дахь тал.

- Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар нь шүүхийн үйлчилгээг иргэд, олон нийтэд хүртээмжтэй хүргэх, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх зорилгын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу замыг стандартын шаардлагад нийцүүлэн шинээр барьж ашиглалтад оруулсан;[70]
- Дорнод аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2020 онд 17 өрөөнд 5.327.700 төгрөгийн засвар үйлчилгээ хийж, Шүүхийн үйлчилгээний төвд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх /тусгай гэрэлтүүлэг, брайль үсэг, харааны шил, зориулалтын сандал, хүлээлгийн буйдан зэргээр тохижуулсан;[71]
- Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газраас иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг сурталчлах, хялбаршуулсан гарын авлага, аудио, видео брошюр бэлтгэх арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан видео шторкийг бэлтгэн шүүхийн байранд болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд хүргэсэн;[72]
- Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар нь Хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай иргэдэд зориулан шүүхийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, мэдээлэл авах, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.[73] Үүнд:
    - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор тус шүүхийн захиргааны ажилтнууд АНХ санаачлан ДОХИОНЫ ХЭЛНИЙ ХЭЛМЭРЧ, ОРЧУУЛАГЧТАЙ танилцуулга, Монгол Улсын Шүүхийн тайлан ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ 182 2020 он шторкийг бэлтгэн тусгай хэрэгцээт иргэний мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж ажилласан
    - Мөн харааны бэрхшээлтэй, сул хараатай, өндөр настай иргэдэд зориулан Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл хэрхэн гаргах, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тухай ойлголт зэрэг 20 гаруй гарын авлага, танилцуулгыг товгор /брайл/ үсгээр хэвлэж, харааны бэрхшээлтэй иргэдэд хүргэж ажиллажээ.

Харин Монгол Улсын Шүүхийн 2021 оны тайланд хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээ авах, шүүн таслах ажиллагаанд оролцох боломжийг хангах зорилгоор дараах тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн талаар байна. Үүнд:

- Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Иргэн танд тусалъя” нэртэй мэдээллийн самбар байрлуулсан ба тус самбарт харааны бэрхшээлтэй иргэдэд брайль үсэгтэй нэхэмжлэлийн загвар, эрх үүрэг зэргийг байршуулснаар харааны бэрхшээлтэй иргэд мэдээлэл авах илүү ойр болсон. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Иргэн танд тусалъя” нэртэй мэдээллийн самбар байрлуулсан ба тус самбарт харааны бэрхшээлтэй иргэдэд брайль үсэгтэй нэхэмжлэлийн загвар, эрх үүрэг зэргийг байршуулснаар харааны бэрхшээлтэй иргэд мэдээлэл авах илүү ойр болсон.[74]

[70] Мөн тэнд, 161 дэх тал.
[71] Мөн тэнд, 162 дахь тал.
[72] Мөн тэнд, 167 дахь тал.
[73] Мөн тэнд, 181 дэх тал.
[74] Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, (2021 он), 147 дахь тал.

- Дархан-Уул аймаг дахь шүүхийн тамгын газраас:
    - Шүүхийн тамгын газраас иргэдэд үзүүлэх шүүхийн үйлчилгээ, ил тод, нээлттэй байдлыг хангах, мэдээллийн цахим болон биет орчныг сайжруулах арга хэмжээний хүрээнд харааны бэрхшээлтэй иргэдэд шүүхэд мэдүүлэх эрхийн талаарх ойлголтыг өгөх зорилгоор “Шүүхэд мэдүүлэх эрх” гарын авлагыг бэлтгэн гаргасан. Гарын авлагад хэрхэн шүүхэд хандах, нэхэмжлэл, гомдол хэрхэн гаргах талаарх дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд шүүхэд түгээмэл гаргадаг зарим нэхэмжлэл, давж заалдах шатны шүүхэд гаргах гомдлын загварыг брайл үсгээр хэвлэн гаргаснаараа онцлогтой.[75]
    - Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан иргэдийн төлөөлөгчийн тухай ойлголт, эрх үүрэг болон иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд хэрхэн гомдол гаргах вэ? гэсэн сэдэвт мэргэжлийн дохионы хэлмэрчээр дохионы орчуулгатай шторк бэлтгэн гаргасан. Энэхүү шторкийг шүүхийн цахим сайт болон Дархан-Уул аймгийн Залуучууд театрын гадна талын сурталчилгааны лед дэлгэцээр иргэд олон нийтэд хүргэж ажилласан.[76]
    - Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1981 онд жил бүрийн 12 дугаар сарын 03-ны өдрийг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ өдрийг угтан шүүхийн тамгын газраас Дархан-Уул аймаг дахь тэргэнцэртэй иргэдийн холбоо, Дархан-Уул аймаг Хараагүйчүүдийн холбооны салбар зөвлөлтэй хамтран 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр “Шүүхэд мэдүүлэх эрх”-ийн талаар мэдээлэл өгч уулзалт, ярилцлагыг зохион байгуулжээ.
- Дундговь аймгийн шүүхийн тамгын газраас шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн тодорхой хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг бөгөөд 2021 онд тус шүүхийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд илүү ойртуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хараа болон сонсголын бэрхшээлтэй иргэдийг шүүх хуралдаанд оролцоход шүүх хуралдааны явц тод жигд сонсгох чихэвч, хэргийн материал, нотлох баримттай танилцахад зориулж томруулдаг шилийг шүүх хуралдааны 2 танхимд байршуулсан;[77]

Дээрх байдлаар төв болон орон нутгийн шүүх, шүүхийн тамгын газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шүүхийн үйл ажиллагаанд оролцох боломжийг илүү хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх зэргээр боломжит хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг ханган ажиллахыг эрмэлзэж байна. Гэвч 2022 он болон 2023 оны тайланд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хангах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгаагүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэрч, хохирогч, яллагдагч эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад орчуулагч, хэлмэрч авах, түүнтэй мэдүүлэг өгөх эрхтэй байхаар заасан бөгөөд тус хуульд орчуулагч, хэлмэрчтэй холбоотой харилцааг зохицуулсан нийт 54 хэсэг, заалт байна. Гэсэн хэдий ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогч, яллагдагчаас хэлмэрч, орчуулагчгүйгээр байцаалт авсан, хүчээр гарын үсэг зуруулсан, зарим тохиолдолд

[75] Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, (2021 он), 171 дэх тал.
[76] Мөн тэнд.
[77]Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, (2021 он), 178 дахь тал.

мөрдөгч нар гэрч, хохирогч, яллагдагчийг орчуулагч, хэлмэрч авах эрхээр хангаагүй зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчлийн талаар мэдээлэл гарсаар байна.

Харин цагдаагийн байгууллагаас сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй буюу утсаар ярьж, дуудлага, мэдээлэл өгөх чадамжгүй иргэдээс яаралтай тусламжийн дуудлага мэдээллийг хүлээн авах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор богино зурвасаар дуудлага, мэдээлэл хүлээн авах программ хангамжийг 2020 оны 02 дугаар сард боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн ба 2021 онд 91 яаралтай тусламжийн дуудлагыг хүлээн авсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчил шалгах шийдвэрлэх ажиллагаанд сонсголгүй иргэдэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан мэдүүлэг, тайлбар авах болон бусад шаардлагатай үед мэргэжлийн хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээг 2016 оноос хойш Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо ТББ[78] үзүүлсээр ирсэн бөгөөд тус байгууллагын тайланд "...*2022 онд дохионы хэлний орчуулгын үйлчилгээг мэргэжлийн хэлмэрч орчуулагчдаар дамжуулан Цагдаагийн Ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, замын цагдаагийн алба, Хар тамхитай тэмцэх газар, Нийслэлийн 9 дүүргүүдийн цагдаагийн газар, хэлтсүүд, дүүргүүдийн шүүх, дүүргүүдийн замын цагдаагийн газрууд, Говьсүмбэр, Өмнөговь, Төв аймгууд гэх мэт цагдаа шүүхийн бүхий л байгууллагаас ирсэн албан бичгийн дагуу хамтран ажиллаж, мэдүүлэг, шүүхийн үйл ажиллагаанд дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээг үзүүлсэн байна. 2022 онд өмнө дурдсан байгууллагуудын албан хүсэлтийн дагуу нийт 75 орчим сонсголгүй иргэдийн иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээг үзүүлэхдээ нэг хүн, нэг хэрэг дээр 3-10 цагийн орчуулгын үйлчилгээг үзүүлсэн ба эдгээр нь нийтдээ 161.5 цагийн, 8'882'500 төгрөгийн үйлчилгээг үзүүлсэн*" талаар дурдсан.[79]

Тус байгууллага 2016 оноос хойш 2022 оны 7 дугаар сарыг дуустал хугацаанд цагдаа шүүхийн байгууллагад дохионы хэлээр орчуулга үзүүлсэн Дохионы хэлний хэлмэрчдийн төлбөрийг төлж ирсэн бөгөөд үүнийг он оноор авч үзвэл:

- 2016 онд 237.93 цагийн 6,899,970 төгрөгийн үйлчилгээ;
- 2017 онд 122.2 цагийн 3,543,800 төгрөгийн үйлчилгээ;
- 2018 онд 167.52 цагийн 4,858,080 төгрөгийн үйлчилгээ;
- 2019 онд 145.56 цагийн 5,822,400 төгрөгийн үйлчилгээ;
- 2020 онд 185.64 цагийн 10,210,200 төгрөгийн үйлчилгээ;
- 2021 онд 155,67 цагийн 9,111,850 төгрөгийн үйлчилгээ;

[78] Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо ТББ нь 2011 онд байгуулагдсан, 2013 онд Дэлхийн дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбооны "Үндэсний гишүүн" байгууллагаар элссэн, Хүн Амын Хөгжил Нийгэм Хамгааллын Яамны Батламжтай (2012.12.03) дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллага юм. Сонсголгүй иргэд нийгэмд бие даан амьдрах, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчын үйлчилгээгээр хүний эрхийг хангах зорилготой үйл ажиллагаагаа явуулдаг тул 2016 оноос эхлэн Улаанбаатар хотын Цагдаагийн газартай байгуулсан хамтын ажиллагаан ми санамж бичгийн хүрээнд сонсголгүй иргэд эд хууль эрх зүйн мэдээлэл хүртээмжтэй хүргэх, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтын ажиллагаагаа эхлүүлээд одоог хүртэл үргэлжлүүлж байна.

[79]"Дохио хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо" НҮТББ-аас Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хошууч Генерал Ж.Болдод хүргүүлсэн "Дохионы хэлний хэлээр хэлмэрчилсэн ажлын тухай" албан бичиг, 2022 он; Дохио хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо" НҮТББ, "Монгол дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгэнэий тайлан", 2023 он.

- 2022 оны 10 сарын байдлаар 161.5 цагийн 8,882.500 төгрөгийн үйлчилгээг тус тус үзүүлсэн бөгөөд нийт 25,144,450 байна.

Харамсалтай нь тус байгууллага 2016 оноос хойш цагдаа шүүхийн байгууллагад дохионы хэлээр хэлмэрчилсэн ажлын хөлсийг дангаараа хариуцаж, хэлмэрчдэд нь ажилласан цагийн хөлсийг төлж ирсэн бөгөөд цаашид энэхүү зардлыг санхүүжүүлэх боломжгүй болсон тул 2022 оны 8 дугаар сараас энэхүү үйлчилгээг зогсоосон байна.[80] Ийнхүү "Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо" төрийн бус байгууллага өөрийн хөрөнгөөс дохионы хэлмэрчид төлсөн төлбөр болох нийт 25,144,450 төгрөгийг төрийн эрх бүхий байгууллагаас авч чадаагүй байгаа бөгөөд үүнээс үүдэн тус байгууллагын үйл ажиллагаа тасалдахад хүрэх буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх зөрчигдөж болзошгүй нөхцөл бий болжээ.

Цагдаагийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын хамтран ажиллах санамж бичиг[81] байгуулж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнээс яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл богино зурвасаар хүлээн авах программыг боловсруулан, нийслэл хотод оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй 2744 иргэний утасны дугаарын мэдээллийг программд оруулан 2019 оны 2 дугаар сараас дээрх иргэдээс яаралтай тусламжийн дуудлага хүлээн авах үйл ажиллагааг эхлүүлсэн. 2020 онд 91, 2021 онд 103 иргэнээс яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг богино зурвасаар хүлээн авч, холбогдох байгууллагуудад дамжуулж шийдвэрлүүлсэн[82].

Түүнчлэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчид нар 2186 эрүүгийн хэргийн, 2289 төлбөрийн чадваргүй холбогдогчид үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлснээс хөгжлийн бэрхшээлтэй 48 иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэн ажиллажээ[83].

Товч дүгнэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад иргэдийн адил шүүхийн бүх шатны үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох боломжийг хууль тогтоомжоор хангасан байна. Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй хүмүүс шүүх хуралдаанд оролцсон тохиолдолд тусгай хэлмэрчийг оролцуулах гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй иргэд шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох нөхцөлийг эрх зохицуулалт орчинд бий болгожээ.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот дахь шүүхүүд болон 21 аймаг дахь шүүхүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шүүхийн үйлчилгээг ойртуулах, шүүхэд ажиллаж байгаа шүүхийн захиргааны ажилтнуудыг сургах, бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх тодорхой ажлуудыг зохион байгуулж байгааг дурдах нь зүйтэй.

Харин цагдаагийн байгууллагын зүгээс сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдээс дуудлага, мэдээлэл хүлээн авах зорилгоор тусгайлсан программыг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглан 2020 онд 91, 2021 онд 103 иргэнээс яаралтай тусламж, мэдээллийг богино зурвасаар хүлээн авч, холбогдох байгууллагад асуудлыг шилжүүлсэн нь сайшаалтай байна.

Гэхдээ зарим тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа мөрдөгч, прокурор гэрч, хохирогч, яллагдагчийг орчуулагч, хэлмэрч авах эрхээр хангаагүй, заавал энэхүү эрхийг хангах ёстой гэдгээ өөрсдөө мэдээгүй тохиолдолд гарч байгааг эрх бүхий байгууллагуудад мэдээлж, зөрчлийг таслан зогсоох, хөгжлийн

[80]Мөн тэнд.
[81]Цагдаагийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хооронд 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.
[82]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагааны мэдээллийн лавлах", 70, 74 дэх талууд.
[83]Мөн тэнд.

бэрхшээлтэй хүмүүсийн талаарх сөрөг хандлагыг зогсоох шаардлагатай байна. Мөн дохионы хэлний хэлмэрчийн зардлыг төсөвт суулгаж, тухай бүр шийдвэрлэх хэрэгцээтэй болохыг дурдаж байна.

Конвенцын 14 дүгээр зүйлд заасан "Эрх чөлөө, хувийн халдашгүй байх эрх"-ийн тухайд:

Конвенцын 14 дүгээр зүйлд:

"1.Оролцогч улсууд нь бусадтай адил тэгш байх эрхийг хангах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүний дараах эрхийг хангана",

a) эрх чөлөөтэй байх, хувийн халдашгүй эрхээ эдлэх;

b) хуульд заасан үндэслэл, журмаас гадуур тэдгээр хүний эрх чөлөөг үл хасах, эсхүл зөвхөн хуульд нийцсэн журмын дагуу эрх чөлөөг хасах болон аль ч тохиолдолд хөгжлийн бэрхшээл нь эрх чөлөөг нь хасах үндэслэл болохгүй байх",

"Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх чөлөөг аливаа журмын дагуу хассан бол уг тохиолдолд оролцогч улсууд нь бусадтай адил тэгш нөхцөлийн үндсэн дээр боломжит хэрэглэгдэхүүнээр хангахыг оролцуулан энэхүү конвенцын зорилго, зарчим болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байдлаар тэдэнд хандах явдлыг хангана" гэж тус тус заажээ.

Конвенцын 14 дүгээр зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь хэсэгт "халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;" гэж заасан бөгөөд үүнд нийцүүлэн хүний халдашгүй байдлыг хамгаалсан холбогдох бусад хуулийн зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж байна.

Энэ нь хүний хүний бие, эд хөрөнгө, нэр төр, хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, орон байрны халдашгүй эрхийг албан тушаалтан болон бусад хүмүүсийн дур зоргоороо аашлан халдах явдлаас хамгаалах асуудлыг Үндсэн хуулийн хэмжээнд баталгаажуулсан учраас эдгээр эрх чөлөөнд хэн боловч хуульд заасан үндэслэл, журмаас гадуур халдах эрхгүй байна.[84]

a) Эрүүгийн хуулийн арван гуравдугаар бүлэгт "Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг"-ийг хуульчилсан бөгөөд бүлэгт Хүн худалдаалах, Хүн хулгайлах, Хүн барьцаалах, Хүнийг хүчээр алга болгох, Заналхийлэх, Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх, Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, Хууль бусаар баривчлах саатуулах, Хувь хүний нууцад халдах, Хувь хүний нууцыг задруулах, Хууль бусаар мөрдөж мөшгөх, Албадан хөдөлмөрлүүлэх, Худал мэдээлэл талаарх зэрэг нийт 14 төрлийн гэмт хэргийн хуульчилсан.

Түүнчлэн 2013 оны 01-р сарын 03-ны өдөр батлагдсан Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн тавдугаар бүлэгт "Сэтгэцийн эмгэгтэй хүнийг эмнэлэгт албадан эмчлэх, аюулгүй байдлыг хангах, түүнд үзүүлэх нийгмийн халамжийн туслалцаа"-ны талаар зохицуулсан.

[84] Г.Совд нарын хамтын бүтээл. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2000 он,110 дахь тал.

Тус хуулийн 12 дугаар зүйлд зааснаар сэтгэцийн эмгэгтэй хүнийг албадан эмчлэх зохицуулалт нь:

12.1.Сэтгэцийн эмгэгтэй хүнийг дараах тохиолдолд албадан эмчилнэ:

12.1.1.өөртөө болон нийгэмд аюултай үйлдэл хийхийг завдаж байгаа тохиолдолд урьдчилан сэргийлэх зорилгоор;

12.1.2.өөрөө болон түүний хууль ёсны төлөөлөгч нь эмчилгээ, шинжилгээний талаар зөвшөөрөл өгөх боломжгүй бөгөөд эмчилгээ, шинжилгээ нь тухайн хүний эрүүл мэнд, сэтгэцийн байдалтай тохирч байгааг эмнэлгийн эрх бүхий мэргэжилтэн нотолж байгаа.

12.2.Сэтгэцийн эмгэгтэй хүнийг эмнэлэгт албадан эмчлэхдээ Эрүүл мэндийн тухай хуулийн 25.1-д заасны дагуу сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмчийн магадлагааг үндэслэх ба эмнэлгийн мэргэжилтэн нь албадан эмчлэх үндэслэлийг сэтгэцийн эмгэгтэй хүн, түүний хууль ёсны төлөөлөгчид нэн даруй мэдэгдэнэ.

12.3.Эмнэлэгт албадан эмчлүүлсэн, нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүний сэтгэцийн байдал нь албадан эмчлүүлэх заалттай тохирч байгаа эсэхийг түүнийг эмнэлэгт хэвтсэнээс хойш 72 цагийн дотор тусгай комисс магадлан тогтооно.

12.4.Энэ хуулийн 12.3-т заасан Магадлан тогтоох комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

12.5.Албадан эмчлэх шаардлагатай сэтгэцийн эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. хэмээн заасан.

Үүний дагуу Эрүүл мэндийн сайдын 2014 оны 05-р сарын 30-ны өдрийн №180 “Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай” тушаалаар дараах гурван журмыг батлсан байна. Үүнд:

1. Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам;
2. Магадлан тогтоох комиссын бүрэлдэхүүн ажиллах журам;
3. Албадан эмчлэх шаардлагатай сэтгэцийн эмгэгийн жагсаалтыг тус тус батлсан байна.

Тэгвэл Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлд Сэтгэцийн эмгэгтэй хүний аюулгүй байдлыг хангах, 14 дүгээр зүйлд сэтгэцийн эмгэгтэй хүнд үзүүлэх нийгмийн халамжийн туслалцааны талаарх харилцааг зохицуулсан бөгөөд тус зүйлд:

“13.1.Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүнд шаардлагатай тохиолдолд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн тусгаарлах болон номхотгох аргыг хэрэглэх бөгөөд тусгаарлах болон номхотгох аргын жагсаалт, тэдгээрийг хэрэглэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

13.2.Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүнд яаралтай тусламж үзүүлэх болон эмнэлгээс оргосон тохиолдолд түүнийг эрэн сурвалжилж олох, эмнэлэгт хүргэх үйлчилгээнд цагдаагийн байгууллага хамтран ажиллах үүрэгтэй.

13.3.Сэтгэцийн эмгэгтэй хүнийг хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн орчин нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эмгэгтэй хүний хууль ёсны эрх ашиг, аюулгүй байдлыг хангахуйц нөхцөлийг бүрдүүлсэн байна.” гэж заасан.

14.1.Мэргэжлийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн сэтгэцийн эмгэгтэй хүнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох, асрамж, үйлчилгээнд хамруулах асуудлыг эрх бүхий байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Дээрх эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор нийгэмд оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг зөрчих, тэднийг нийгмээс гадуурхах, төрийн байгууллагын ажилтнуудын зүй бусаар харьцах зэрэг тохиолдлууд гарсаар байна.

Монгол Улсын 2016 оны байдлаар нийт 22.356 сэтгэцийн эмгэгтэй хүн бүртгэлтэй байгаагийн 14.586 нь сэтгэцийн архаг эмгэгтэй байна. Үүнээс орон нутагт буюу 21 аймагт 10.445, нийслэлд 4.141 хүн байна.[85]

Шүүхээс 2013-2016 онуудын хугацаанд нийт 18 иргэнийг (2013 онд 4, 2014 онд 6, 2015 онд 8) эрх зүйн чадамжгүйд тооцож, шүүх сэтгэцийн эмгэг судлалын дүгнэлт гаргасан байна.[86]

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх хэсэгт “сэтгэцийн эмгэгтэй хүнийг хоол, хувцас, орон байраар хангах, асран халамжлах үүрэгтэй.”, мөн зүйлийн 11.1.5 дахь хэсэгт “сэтгэцийн эмгэгтэй хүнийг эмнэлгээс гаргах ... үүрэгтэй.”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргийг тэдний эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчид хүлээх бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг хориглоно” гэж тус тус заасан боловч Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлж эдгэрэл сайжрал авсан эмчлүүлэгчийг эмнэлгээс гаргахаар ар гэрт нь хандахад ирж авдаггүй, эмнэлгийн байгууллага эмчлүүлэгчийг өөрсдийн зардлаар орон нутагт хүргэж өгөхөд хүлээн авахаас татгалздаг байна. Иймээс гэр бүлийн гишүүн, үр хүүхдээ тэжээн тэтгэхээс зайлсхийж буй хүмүүст холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцдог байх шаардлагатай байна.[87]

Жишээ: Өвчтөнийг эмнэлгээс гаргах тухай ар гэрт нь мэдэгдэхэд ирж авдаггүй. Зарим тохиолдолд эмнэлэг зардал гаргаж өвчтөнийг орон нутагт нь хүргэж өгөхөд ар гэрийнхэн нь хүлээж авдаггүй, гэртээ оруулдаггүй. Ийм байдалтайгаар эмнэлэгт урт хугацаагаар хэвтэж байгаа 5-6 хүн байна. Мөн ар гэрийнхэн нь гэртээ байлгахыг хүсээгүйгээс өвчин сэдрээгүй байхад хуурамч дуудлага өгч хэвтүүлэх шалтаг тоочдог. Түргэн тусламжийн 103 дугаарын дуудлагаар 1 эмч, 1 сувилагч дуудлагад 37 явдаг. Эмч нарын аюулгүй байдлыг хангаж, хамгаалах хэрэгсэл хэрэглэх боломжгүй. Дуудлагаар явахаар өвчтөний ар гэрийхэн гарч зугтах, өвчтөн эмч рүү дайрч цохих, нулимах, доромжлох асуудал их тохиолддог. Цагдаагийн албан хаагчийн тусламжийг авах хуулийн заалттай ч цагдаагийн албан хаагч тэр бүр тусламж үзүүлж чаддаггүй. Иймээс 103 дуудлагаар явахдаа тусгайлан хамгаалагчтай байх шаардлагатай байдаг. (Хяналт шалгалтын үеэр эмч нартай хийсэн ярилцлагаас).[88]

ХЭҮК-ээс Улсын Их Хуралд 2016 онд хүргүүлсэн зөвлөмжид “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх

[85] Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, 2016 он, 32 дахь тал.
[86] Мөн тэнд.
[87] Мөн тэнд, 36 дахь тал.
[88] Мөн тэнд.

7 дахь илтгэл (2008 он), 11 дэх илтгэл (2012 он), 12 дахь илтгэл (2013 он), 13 дахь илтгэл (2014 он), 14 дэх илтгэл (2015 он)-ээр тус тус өгсөн санал, зөвлөмжийн дагуу сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн төрөлжсөн асрамжийн газар байгуулах асуудлыг 2016 онд багтаан шийдвэрлэж, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвд байгаа Асрамжийн клиникт асруулж буй сэтгэцийн эмгэгтэй давхар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдарч буй орчин нөхцөлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах, тэдний хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх”[89] талаар тусгасан хэдий ч энэхүү зөвлөмж өнөөг хүртэл хэрэгжээгүй.

Товч дүгнэлт: Конвенцын 14 дүгээр зүйлд тусгагдсан “...оюуны болон сэтгэц нийгмийн бэрхшээлтэй хүмүүсийг албадан эмнэлэгт хэвтүүлэх, институтэд байлгах гэх мэтээс хамгаалах” харилцааг зохицуулсан хууль тогтоомж 2015 оноос өөрчлөгдөөгүй бөгөөд, цаашид нарийвчлан зохицуулах хэрэгцээ хэвээр байна.

Гэмт хэрэгт холбогдсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээллийн сан цагдаагийн байгууллага, прокурор, шүүхэд бий болсон, энэ хэсэгтэй холбоотой зөвлөмжийг биелүүлжээ. Гэм буруу нь нотлогдоогүй байхад гэм буруутайд тооцохгүй байх, хамгаалах эрх болон шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хамгаалалтыг холбогдох хууль тогтоомж, дагаж гарсан журам, стандартаар зохицуулжээ.

Конвенцын 15 дугаар зүйлд заасан “Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх”-ийн тухайд:

Конвенцын 15 дугаар зүйлд:

“Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Ялангуяа, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй”.

“Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш байх эрхийн үндсэн дээр эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс урьдчилан сэргийлэх бүхий л үр дүнтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн буюу бусад арга хэмжээг авна” гэж тус тус заасан.

Конвенцын 15 дугаар зүйлийн хэрэгжилтийн нөхцөл байдал:

Мөн НҮБ-аас 1984 оны 12-р сарын 10-ны өдөр баталж, 1987 оны 06-р сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод Монгол Улс 2000 оны 11-р сарын 02-ны өдөр нэгдсэн орсон.

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлд хуульд хэрэглэсэн нэр томьёог "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх" гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг” дурдсан утгаар ойлгоно гэж тайлбарласан. Цагдан хорих төвүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээ, шударга ёсны тогтолцоог бий болгох, цагдаагийн үйл ажиллагааг удирдлагаар хангах бүх үүрэг хариуцлага ХЗДХЯ-нд оногдсон байна гэж

[89] Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, 2016 он, 134 дэх тал.

НҮБ-ын ЭШУС Дэд хороо дүгнэжээ. “Энэ нь сонирхлын ноцтой зөрчилд хүргэж болох бөгөөд урьдчилан сэргийлэх ойлголтын үүднээс авч үзвэл оновчгүй, эрх мэдлийн хуваарилалтын эсрэг чиглэсэн, цагдан хорих систем болон эрүүгийн шударга ёсны тогтолцоог үр дүнтэй удирдахад хохирол учруулж болзошгүй байгаа талаар мөн онцолсон.[90]

Мөн хэн нэгэнд эрүү шүүлт тулгасан тохиолдолд гэмт байхаар хуульчилсан буюу Монгол Улсын Эрүүгийн хуульд “Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”[91] гэж заасан.

Прокурорын байгууллагын мэдээлэлд 2017 оны сүүлийн хагас жил болон 2018-2022 оны байдлаар улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 13.9 /Хууль бусаар баривчлах/, 14.1 /Ялгаварлан гадуурхах/, 21.12 /Эрүү шүүлт тулгах/ гэмт хэргүүдэд нийт 385 гомдол, мэдээлэл бүртгэгдэн 471 хүн шалгагдсанаас 359 гомдол, мэдээлэл буюу 93,2 %, 449 хүн буюу 95,3 % нь тус тус цагдаагийн алба хаагчтай[92] холбоотой талаарх тус тус мэдээллүүд бүртгэгдсэн.

Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас гадна Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 429 дүгээр тушаалаар “Байгууллагын стандарт”, 2017 оны А/262 дугаар тушаалаар “Хэлний бэрхшээлтэй хүнд туслах /код 238/ журам”, мөн оны А/263 дугаар тушаалаар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх /код 326/ журам”-ыг тус тус батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газар, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага хооронд 2017 онд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд “Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хууль зүйн салбарын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй иргэний эрхийг хамгаалах цагдаагийн алба хаагчдын мэргэжлийн сургалтын хөтөлбөр, зөвлөмж боловсруулан төв, орон нутгийн цагдаагийн байгууллагуудад хүргүүлэн, биелэлтэд нь хяналт тавьж ажилласан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлийн 17 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/57 дугаар тушаалаар баталсан “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага” журмын дагуу мэдүүлэг авах тусгайлан бэлдсэн, уулзалт мэдүүлгийн, насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөнүүдийг бэлтгэн прокуророос тусгай зөвшөөрөл гаргуулах тухай ажлын чиглэлийг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хүргүүлж, мэдүүлэг авах 297 өрөөнд прокурорын зөвшөөрөл гаргуулан авснаас мэдүүлэг авах тусгайлан бэлтгэсэн өрөө 65, уулзалт мэдүүлгийн өрөө 185, насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөө 47 байна.

---

[90]Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 сарын 11- ээс 20-ны өдрүүдэд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмжүүд” (2017), §23-24, 91, дам ишлэв.

[91]Эрүүгийн хууль, 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт.

[92]Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2022 он тайлан”, 2023 он, 13 дахь тал.

Канадын сангийн хөрөнгө оруулалтаар 5 өрөөг 100 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр тоноглон тохижуулж, байцаалт, таньж олуулах ажиллагаанд ашиглаж байна.

“Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ын дагуу иргэд хүлээн авах, уулзалт, мэдүүлэг авах өрөөг дуу, дүрсний бичлэгээр бэхжүүлэх төхөөрөмжөөр тоноглож, бичлэгийг устгах, засварлахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл хадгалах серверийг тусгай өрөөнд байрлуулж, хэвийн үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 2016 онд 74, 2017 онд 169, 2018 онд 165, 2019 онд 75, нийт 481 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 413 нь эрэгтэй /хүүхэд 15/, 68 нь эмэгтэй /хүүхэд 10/ байна. Хэргийн төрлөөр нь авч үзвэл хүнийг алах 14, хүний эрүүл мэндэд хохирол учруулах 187, залилах 23, дээрэмдэх 13, хулгайлах 130, хүчиндэх 20, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 6, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих 20, бусад 68 хэрэгт холбогдон шалгагджээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын эрүүл мэндийг хамгаалан тэднийг тогтмол хугацаанд эмчилгээ, үйлчилгээнд хамруулж байгаа бөгөөд тайлант хугацаанд хорих анги, байгууллагын нийт 75 хоригдлын группийг сунгажээ. Мөн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран өндөр настанд төрөөс “Насны хишиг” олгох журмын дагуу холбогдох тэтгэмжийг 70 хоригдолд, хорих ангиас суллагдан гарсан өөрийн гэсэн орон гэргүй, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 609 иргэнд 730.8 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгуулсан байна.

Түүнчлэн суллагдахын өмнөх сургалтад хамрагдаж буй хоригдлуудад "Нийгмийн халамжийн тухай хууль, "Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох тухай журам", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Босго шугам шинэчлэн тогтоох тухай" 2018 оны А/14 дүгээр тушаалын дагуу халамж үйлчилгээнд шаардагдах бичиг баримтын бүрдэл сэдвээр сургалтууд зохион явуулж байна.

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим санд[93] эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 онд улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн 11970 хэргийн шийтгэх тогтоол авагдсан байх ба уг шийтгэх тогтоолоос хөгжлийн бэрхшээлтэй иргэн шүүгдэгчээр оролцсон хэргийг шүүж үзэхэд 25 хэрэгт шүүгдэгчээр оролцож, гэм буруутайд тооцогдсон байна. Тус эрүүгийн хэрэгт хөгжлийн бэрхшээлтэй 20 эрэгтэй, 5 эмэгтэй холбогдсон байх ба хүний эрүүл мэндэд хохирол учруулсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж байна.

2022 онд улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн 12986 хэргийн шийтгэх тогтоолоос хөгжлийн бэрхшээлтэй иргэн шүүгдэгчээр оролцсон 22 хэрэг[94] байх ба тус эрүүгийн хэргүүдэд хөгжлийн бэрхшээлтэй 18 эрэгтэй, 4 эмэгтэй холбогдсон байна. 2023 онд улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн 13108 хэргийн шийтгэх тогтоолоос шүүгдэгчээр оролцсон 28 хэрэг байх ба хүйсээр ялгаж үзвэл 22 нь эрэгтэй 6 эмэгтэй шүүгчдэгч байна. Харин 2024 онд улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн 14085 хэргийн шийтгэх тогтоолоос хөгжлийн бэрхшээлтэй иргэн шүүгдэгчээр оролцсон 29 хэрэг байх ба хүйсээр ялгаж үзвэл 24 эрэгтэй 5 нь эмэгтэй шүүгдэгч байна.

---

[93]Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим санд 2023 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдөр хандав. https://shuukh.mn/cases/2/1.

[94]Мөн тэнд.

Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрүүдэн шүүх, энэхүү ажиллагаанд тусгайлан журам баримтлахтай холбоотой нарийвчилсан эрх зүйн зохицуулалт өнөөг хүртэл байхгүй байгааг анхаарах шаардлагатай.

Товч дүгнэлт: Цагдаа, прокурор болон Хүний эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагад эрүү шүүлттэй холбоотой ирсэн гомдол, холбогдох тоон мэдээлэл нь тооны хувьд зөрүүтэй байгаа хэдий ч тухайлан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй холбогдсон, тэдний эрхийг ноцтой зөрчсөн талаарх мэдээлэл байхгүй байна.

Монгол Улсын хувьд Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд заасны дагуу Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааг албажуулж, тус гишүүн хуульд заасан шаардлагатай үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхээс гадна Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайланг 2022 оноос эхлэн гаргаж, энэ талаарх мэдээлэл Монгол Улсад илүү нээлттэй болж байгаа сайшаалтай байна.

Харин 2021 болон 2022 оны нийт 25,000 гаруй шүүхийн шийдвэрүүдээс шүүлт хийж үзэхэд нийт 50 орчим хэрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс холбогдсон бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрүүдэн шүүсэн, хүнлэг бус харьцсан, нэр төрийг нь доромжилсон тоон мэдээлэл байхгүй байна.

Конвенцын 17 дугаар зүйлд заасан “Хувийн нэгдмэл байдлыг хангах” эрхийн тухайд:

Конвенцын 17 дугаар зүйлд:

“Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусдын нэгэн адил өөрийнхөө бие махбодь болон сэтгэхүйн нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрхтэй” талаар заасан.

Конвенцын 17 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улс сэтгэцийн эрүүл мэндийн тухай бие даасан хуулийг анх 2000 онд баталж, улмаар 2013 онд уг хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас баталсан. Мөн Архидан согтуурахтай тэмцэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай, Тамхины хяналтын тухай хуулиуд, Монгол Улсын Засгийн газрын “Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний нэгдүгээр хөтөлбөр (2002-2007), Засгийн газрын 2009 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний хоёр дахь хөтөлбөрийг 2010-2019 он хүртэл хоёр үе шаттайгаар хэрэгжүүлсэн.[95]

Засгийн газраас өнгөрсөн таван жилийн хугацаанд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн нөхцөл байдал, үйл ажиллагаа, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018-2020 онд нийт 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, төвийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг сайжруулжээ. 2021 оны байдлаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь 525 ортой үйл ажиллагаа явуулж байгаагаас 200 гаруй нь асрамжийн клиник буюу асрамжийн тусламж, үйлчилгээ үзүүлж ажиллаж байна.[96]

ХЭҮК-оос 2007, 2015 онд Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрхээ эдлэх боломжийг нь нэмэгдүүлэх үүднээс Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчид болон асруулагчдын эрхийн хэрэгжилтэд удаа дараа хяналт шалгалт хийж шаардлагатай арга хэмжээ авахуулахаар ХЭҮК-ын гишүүний шаардлагыг хүргүүлэхийн зэрэгцээ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11, 15 дахь илтгэлүүдэд тусгаж байсан. Энэ асуудлаар Монгол Улсын

[95] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл, 2022 он, 342 дахь тал.

[96] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл, 2022 он, 343 дахь тал.

Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2013 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 11 дэх илтгэлийг хэлэлцсэн тухай” 02 дугаар тогтоолын 10 дахь хэсэгт “Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст зориулсан асрамжийн газар байгуулах асуудлыг нэн даруй шийдвэрлэх”, мөн Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 11 сарын 16-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоолын 1.3 дахь хэсэгт “Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн төрөлжсөн асрамжийн газар байгуулах хөрөнгө, санхүүжилтийг судлан шийдвэрлэх”, 1.4 дэх хэсэгт “Сэтгэцийн эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээний тусгай хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангах, эмчилгээ хийх орчин нөхцөлийг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх” чиглэлийг Засгийн газарт хүргүүлсэн байдаг.[97] Гэсэн хэдий ч Засгийн газраас уг асрамжийн газрыг байгуулахтай холбогдуулан 2017 онд эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх, 2018 онд зураг төсөв батлан барилгын ажлын явцыг 50 хувьд хүргэх, 2019 онд барилга байгууламжийг улсын комисс хүлээн авч үйл ажиллагааг эхлэх зэрэг төлөвлөгөө боловсруулсан боловч өнөөгийн байдлаар ЭМЯ, ХНХЯ-ны хамтарсан тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдсанаас өөр тодорхой ахиц дэвшил гараагүй байна.

Мөн ХЭҮК-оос 2021 онд Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа байдал, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх, халдашгүй чөлөөтэй байх эрх, хэрцгий, халдашгүй чөлөөтэй байх, хүнлэг бус харьцаа, шийтгэлээс ангид байх, мэдээлэл авах зэрэг эмчлүүлэгчийн хувийн халдашгүй байдлын эрх, эмчлүүлэгчийн нийгмийн оролцоо, харилцаа, хэвийн амьдрах боломжийг дэмжих үйл ажиллагаа, эмчлүүлэгч хууль зүйн туслалцаа авах, төвийн удирдлага, төрийн бусад байгууллагад өргөдөл гомдол гаргах эрхийн асуудалд хяналт шалгалт хийсэн байна.[98] Хяналт шалгалтаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөр үйлчлүүлж байгаа болон хэвтэн эмчлүүлж байгаа сэтгэцийн өвчтэй хүмүүс хамгийн дээд зэргийн сэтгэцийн эмчилгээ, үйлчилгээг хүртэх, хүн ёсоор, нэр төрөө хүндэтгүүлэн харьцах эрх болон ямар нэгэн ялгаварлан гадуурхалтаас ангид байж, эдийн засгийн, бэлгийн болон бусад хэлбэрийн мөлжлөг, бие махбодын хүчирхийлэл, хүнлэг бус хэрцгий харьцаанаас хамгаалуулах эрх зөрчигдөх эрсдэл байна гэж дүгнэжээ.

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүний хүүхэд төрүүлэх эрх

Монгол улсын хууль тогтоомжид оюуны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүний хүүхэд төрүүлэх эрхийн талаар ерөнхий зохицуулжээ. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд “хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх”[99], Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд “өөртөө болон нийгэмд аюултай үйлдэл хийхийг завдаж байгаа тохиолдолд урьдчилан сэргийлэх зорилгоор албадан эмчилгээ хийх”, “эмчилгээ, шинжилгээ нь тухайн хүний эрүүл мэнд, сэтгэцийн байдалтай тохирч байгааг эмнэлгийн эрх бүхий мэргэжилтэн нотолж байгаа тохиолдолд албадан эмчилгээ хийх” бөгөөд тухайн албадан эмчилгээ тохирч байгаа эсэхийг эмнэлэгт хэвтсэнээс хойш 72 цагийн дотор тусгай комисс магадлан тогтооно хэмээн тус

[97]Мөн тэнд.

[98]Мөн тэнд 344 дэх тал.

[99]29 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх

29.1.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхийг боловсрол, хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн салбарт хангах зорилгоор төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

29.1.1.хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх;

тус[100] зохицуулжээ. Мөн Үр хөндөлтийг зохицуулах журамд[101] “сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийг бичгээр авсан тохиолдолд хожуу үед үр хөндөх” боломжтой тухай заажээ. Үүнээс үзэхэд, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй нь өөрт тохирсон үйлчилгээг авах эрхтэй байна.

Нөгөөтэйгүүр өөртөө болон нийгэмд аюултай үйлдэл хийхийг завдаж байгаа гэдэг нь хүүхэд төрүүлэх нь тухайн эхийн эрүүл мэндэд аюултай эсхүл төрүүлэх хүүхдийн эрүүл мэндэд аюултай гэж үзсэн тохиолдолд албадан эмчилгээ хийх үү? мөн эмнэлгийн эрх бүхий мэргэжилтэн нотолж байгаа буюу эмчийн үзсэнээр үр хөндөх, ургийг төрүүлэхгүй байх нь тухайн хүний эрүүл мэнд, сэтгэцийн байдалтай тохирч байгаа хэмээн үзэж албадан эмчилгээ хийх эсэх нь тодорхойгүй харагдаж байна.

Албадан эмчилгээг хийсний дараа тусгай комисс магадлан тогтоохоор заасан нь сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах урьдчилан сэргийлэх дүгнэлт гаргах шинжгүй хэмээн дүгнэж болохоор байна. Мөн Үр хөндөлтийг зохицуулах журмын дагуу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлөөр хожуу үед үр хөндөх эрхийг олгосон[102] байгаа нь тухайн эмэгтэйн эрүүл мэндэд ч аюултай. (Тус журмыг батлан гаргасан Эрүүл мэндийн сайдын тушаалын үндэслэх хэсэгт заасан Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого", Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор баталсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" Үндэсний хөтөлбөр нь хүчингүй болсон байна. Гэсэн хэдий ч тус журам нь хүчин төгөлдөр хэвээр байна.)

Тус журманд зааснаар жирэмслэлт нь эхийн амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон, ургийн эмгэг нь амьдралд үл нийцэх гажиг болох нь тогтоогдсон, 18 хүртэлх насны охид өөрөө хүсвэл эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрсөн, 40-өөс дээш насны эмэгтэй өөрөө хүссэн, цусан төрөл ойртсон нь нотлогдсон болон бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн гэх 6 шалтгаанаас бусад тохиолдолд хориглосон хэмээн заасан ч сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид тэдний хүсэлт, зөвшөөрлөөр хожуу үед үр хөндөх эрхийг олгосон нь хэт явцуу заалт болжээ.

---

[100] 12 дугаар зүйл. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг эмнэлэгт албадан эмчлэх

12.1. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг дараах тохиолдолд албадан эмчилнэ:

12.1.1. өөртөө болон нийгэмд аюултай үйлдэл хийхийг завдаж байгаа тохиолдолд урьдчилан сэргийлэх зорилгоор;

12.1.2. өөрөө болон түүний хууль ёсны төлөөлөгч нь эмчилгээ, шинжилгээний талаар зөвшөөрөл өгөх боломжгүй бөгөөд эмчилгээ, шинжилгээ нь тухайн хүний эрүүл мэнд, сэтгэцийн байдалтай тохирч байгааг эмнэлгийн эрх бүхий мэргэжилтэн нотолж байгаа.

12.2. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг эмнэлэгт албадан эмчлэхдээ Эрүүл мэндийн тухай хуулийн 25.1-д заасны дагуу сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмчийн магадлагааг үндэслэх ба эмнэлгийн мэргэжилтэн нь албадан эмчлэх үндэслэлийг сэтгэцийн эмгэгтэй хүн, түүний хууль ёсны төлөөлөгчид нэн даруй мэдэгдэнэ.

12.3. Эмнэлэгт албадан эмчлүүлсэн, нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүний сэтгэцийн байдал нь албадан эмчлүүлэх заалттай тохирч байгаа эсэхийг түүнийг эмнэлэгт хэвтсэнээс хойш 72 цагийн дотор тусгай комисс магадлан тогтооно.

[101] Эрүүл мэндийн сайдын 2010 оны 04-р сарын 01-ний өдрийн “Үр хөндөлтийг зохицуулах тухай журам”

[102] 9. Хожуу үед үр хөндөхөд дараах баримт бичгийг бүрдүүлж, “Үр хөндөлт”-ийн түүхэнд хавсаргана. Үүнд:

9.1. Эмч нарын зөвлөгөөний шийдвэр,

9.2.Үр хөндүүлэх эмэгтэйн өөрийнх нь, 18 хүртэлх насны охидын эцэг, эх, асран хамгаалагчийн, иргэний эрх зүйн чадамжгүй сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийг бичгээр авсан байна.

Учир нь тухайн эмэгтэйн сэтгэцийн байдал, хүүхэд төрүүлэх хүсэл зоригоо илэрхийлэх болон ирээдүйд хүүхэд өсгөх чадвартай эсэхийг тогтоох процесс ажиллагаагүйгээр хожуу үед үр хөндөх эрхийг бусдад олгосон нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүний хүүхэд төрүүлэх, гэр бүлтэй болох болон эрүү шүүлтээс ангид байх /өөрийн хүсэл зоригийн эсрэг үр хөндүүлэх/ эрхийг ноцтой зөрчиж байна хэмээн үзэж байна. Мөн сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүний хүүхэд төрүүлэх, гэр бүлтэй болох эрхийг хангах зорилгоор бусад илүү хязгаарлалт багатай аргууд болон урьдчилсан сэргийлэх аргын тухай зохицуулсан журам дутмаг байна.

Жишээ: Нэгэн аймагт амьдардаг тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас жишээ татья.

Уг эмэгтэй 38 настай. 18 настай охинтой. Саяхан хоёр дахь амьдралаа эхлүүлсэн боловч жирэмслээгүй. Тэрбээр ярихдаа, "Нөхөр маань хүүхэд нэхээд, жирэмслэхгүй болохоор эмчид үзүүлтэл үрийн сувгийг минь анхны хүүхдээ төрүүлэх үед боосон байна гэж хэлсэн. Учрыг лавлатал өмнөх нөхөр маань ээжтэй ярилцаад шийд гаргасан, надад хэлээгүй байсныг саяхан мэдсэн. Би нөхөртөө энэ байдлаа хэлж чадахгүй, цаашид яахаа мэдэхгүй байна" гэсэн. Тухайн хүнд хэлэлгүйгээр үрийн сувгийг нь боох явдал бол нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийг зөрчсөн маш том жишээ юм.[103]

Товч дүгнэлт: Сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой эрх зүйн зохицуулалт Монгол Улсад хэд хэдэн хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа бөгөөд үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй шууд холбогдох хууль нь Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бодлого, хөтөлбөрүүд байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа үндэсний төв, түүний үйл ажиллагаа өнөөг хүртэл маргааны сэдэв хэвээр байсаар байгаа ба тухайн байгууллагад хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүсийн эрх зөрчигдөж болзошгүй байгаа нь Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын явуулсан хяналт, шалгалтаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөр үйлчлүүлж байгаа болон хэвтэн эмчлүүлж байгаа сэтгэцийн өвчтэй хүмүүс хамгийн дээд зэргийн сэтгэцийн эмчилгээ, үйлчилгээг хүртэх, хүн ёсоор, нэр төрөө хүндэтгүүлэн харьцах эрх болон ямар нэгэн ялгаварлан гадуурхалтаас ангид байж, эдийн засгийн, бэлгийн болон бусад хэлбэрийн мөлжлөг, бие махбодын хүчирхийлэл, хүнлэг бус хэрцгий харьцаанаас хамгаалуулах эрх зөрчигдөж болзошгүй гэх дүгнэлтээр тогтоогдсон байна.

Мөн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар ХЭҮК-ээс Засгийн газарт холбогдох арга хэмжээг авхуулахаар удаа зөвлөмж хүргүүлсэн бөгөөд зөвлөмжид Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст зориулсан асрамжийн газар байгуулах асуудлыг нэн даруй шийдвэрлүүлэх талаар тодорхой тусгасан хэдий ч энэхүү хэсэг өнөөг хүртэл хэрэгжээгүй байна.

Цаашилбал, Оюуны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүний хүүхэд төрүүлэх эрхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын зохицуулалт нь конвенцын заалт болон хорооноос 2015 онд өгсөн зөвлөмжтэй хэр нийцэж байгааг авч үзэхэд зөвлөмж бүрэн хэрэгжиж чадаагүй байна.

Тодруулбал, Эрүүл мэндийн сайдын оюуны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид тэдний хүсэлт, зөвшөөрлөөр хожуу үед үр хөндөх эрхийг олгосон “Үр хөндөлтийг зохицуулах тухай” журам өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилсээр байгаа бөгөөд энэ талаарх зөвлөмжийн хэсэг биелэгдээгүй

[103]Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комиссын боловсрол, судалгааны хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Өнөржаргалын 2021 оны 11-р сарын 13-ны өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөр үржихүйн эрхийн талаар” ярилцлага.

байна.

Конвенцын 18 дугаар зүйлд заасан “Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх”-ийн тухайд:

Конвенцын 18 дугаар зүйлд:

“1.Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бусадтай адил чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг хангана. Үүнд:

a)иргэний харьяалал олж авах болон өөрчлөх эрх мөн иргэний харьяаллыг хүсэл зоригоос нь гадуур буюу хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хасахыг хориглох;

b)иргэншлийг нь нотолсон бичиг баримт, эсхүл өөрийг нь тодорхойлох бусад төрлийн биеийн байцаалтыг олж авах, эзэмших, ашиглах, эсхүл чөлөөтэй зорчих эрхээ хэрэгжүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай цагаачлалын журам зэрэг холбогдох дүрэм журмыг ашиглах эрхийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хасахыг хориглох;

c)төрөлх улсыг нь оролцуулан аливаа улсыг орхин явах;

d)өөрийн эх орондоо эргэн ирэх эрхийг хөгжлийн бэрхшээлийн улмаас, эсхүл хүсэл зоригоос гадуур хязгаарлаж болохгүй.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно” хэмээн хуульчилсан. Иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжид энэхүү эрхээ чөлөөтэй сонгох, тус эрхийг нь хуулиар ямар нэгэн байдлаар хязгаарласан зүйл байхгүй, түүнчлэн дээрх байдлаар хууль тогтоомжид тусгайлан хуульчилсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрхийг бүрэн хангаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд төрөхөөс, эсхүл төрсөн даруй улсын бүртгэлд бүртгэгдэх, нэртэй болох, иргэний харьяалал олж авах болон боломжийн хэрээр эцэг эхээ мэдэх, тэднээрээ асран тэтгүүлэх эрхтэй.[104]

2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрсөн даруйд улсын бүртгэлд бүртгэх, нэртэй болох, иргэний харьяалал олж авах эрхийн тухайд:

Хүүхдийн эрхийн конвенцын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Хүүхэд төрмөгцөө бүртгүүлэх, төрсөн цагаасаа нэр авах, иргэний харьяалалтай болох, түүнчлэн эцэг эхээ боломжийн хэрээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрх эдэлнэ” гэж заасан.

Улсын бүртгэлд бүртгэх, нэртэй болох эрхийн тухайд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт **“**Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах комисс /цаашид "Комисс" гэх/ тогтооно”, 37.2.1 дэх заалтад “0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс” тогтооно.

[104]Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 38 дугаар зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэх”, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 37.2-т заасан комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ”, 38.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 38.1-д заасан үнэмлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болно”, 38.3 дахь хэсэгт “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд бүртгэл, статистикийн төрийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгнө” гэж тус тус заасан.

Дээрх хуульд заасны дагуу 16 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүгнэлтээр тогтоож, тус дүгнэлтийг үндэслэн бүртгэж, үнэмлэх олгох асуудлыг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлдэг байна.

Харин шинээр төрсөн иргэнийг Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Эцэг, эх, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл эрх бүхий байгууллагын төлөөлөгч хүүхэд төрсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор дараах баримт бичгийг бүрдүүлж, төрсний бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасан. Өөрөөр хэлбэл, шинээр төрсөн хүүхдэд регистрийн дугаар олгож, төрснийг баталж, иргэний бүртгэлийн дугаартай төрсний гэрчилгээ[105] олгож, Монгол Улсад төрснөөр[106], түүнчлэн, эцэг эх нь хоёулаа Монгол Улсын харьяат байсан үед төрсөн хүүхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт буюу түүний гадна төрснөөс хамаарахгүй Монгол Улсын харьяат байна.[107]

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенцын 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд төрөхөөс, эсхүл төрсөн даруй улсын бүртгэлд бүртгэгдэх, нэртэй болох, иргэний харьяалал олж авах эрхийг хууль тогтоомжоор хуульчилсан байна.

Боломжийн хэрээр эцэг эхээ мэдэх, тэднээрээ асран тэтгүүлэх эрхийн тухайд:

Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй” гэж заасан. Түүнчлэн, Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийн хамгаалуулах эрхийг тусгайлан хуульчилсан. Ийнхүү хуульд тусгахдаа хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй[108] гэж заасныг дурдах нь зүйтэй.

Хөгжлийн бэрхшээлээс үл хамааран насанд хүрээгүй хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргийг дээрх хуульд заасны дагуу эцэг, эхийн хүлээсэн үүрэг байдаг.

[105] Улсын бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт
[106] Харьяатын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт
[107] Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт
[108] Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг.

Харин хөдөлмөрийн чадвар гэдэг нь аливаа ажлыг амжилттай хийж чадах нөхцөл, чадлыг хэлнэ.[109] Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг, хөдөлмөрийн магадлал комисс тогтоодог[110] бөгөөд ийнхүү хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрах, тэжээн тэтгэх үүрэг нь эцэг, эхэд нь хүлээхээр хуульчилсан.

Түүнчлэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэгт "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргийг тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээх бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг хориглоно" гэж зааснаас дүгнэхэд дээрх үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг хориглохоор хуульчилж өгсөн байна.

Товч дүгнэлт: Конвенцын 18 дугаар зүйлд заасан эрхийн талаарх дотоодын хууль тогтоомжийн нөхцөл байдлыг авч үзэхэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулиар биеллээ олсон байна. Нөгөөтэйгүүр, дээрх үүргээ хэрэгжүүлээгүй, үүргээ биелүүлэхээс зайлсхийсэн тохиолдол нь зөрчлийн шинжтэй бол Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулах, хэрэв уг үүргээ биелүүлээгүй, үүргээ хэрэгжүүлээгүй нь гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тооцогдохоор бол Эрүүгийн хуульд тусгаж, хариуцлагыг зохицуулах шаардлагатай.

Эцэг, эхээ мэдэх эрхийг Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан хуульчлаагүй, зөвхөн гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсан бол үрчлэн авсан эцэг, эх нь хүүхдийнхээ эх орон, эцэг, эхийг нь мэдүүлэх үүргийг хүлээсэн байх тул Гэр бүлийн тухай хуульд заах нь конвенцод нийцнэ.

Конвенцын 19 дүгээр зүйлд заасан Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрхийн тухайд:

Конвенцын 19 дүгээр зүйлд:

"Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний бусдын нэгэн адил ердийн оршин суугаа газартаа амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, тухайн оршин суугаа орчиндоо бүрэн дүүрэн хамрагдаж оролцохыг дэмжих үүднээс дараах нөхцөлийг хангах замаар зохистой, үр дүнтэй арга хэмжээ авна:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын нэгэн адил оршин суух газар болон хаана, хэнтэй амьдрах эсэхээ чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой бөгөөд тусгай нөхцөл байдалд амьдрахыг шаардахгүй;" заасан.

Конвенцын 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

а) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлд бие даан амьдрах эрхийг дараах байдлаар хуульчилжээ. Үүнд:

32.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхтэй.

[109] Я.Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь, 1966 он, 706 тал.
[110] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.3 дахь заалт.

32.2.Хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрх нь хангагдана.

32.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

32.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг иргэн, хуулийн этгээд үзүүлж болно.

32.5.Бие даан амьдрахад дэмжих үйлчилгээг үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтыг нийслэл, аймгийн халамжийн үйлчилгээ хариуцсан төрийн байгууллага гүйцэтгэнэ.

32.6.Энэ хуулийн 32.2, 32.3, 32.4, 32.5-ыг хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын оролцоог хангана.

32.7.Төрөөс хараагүй хүнийг тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах хөтөч нохойг тусгайлан сургаж бэлтгэх ба дотоодод сургаж бэлтгэсэн хөтөч нохойны үнийг есөн жилд нэг удаа олгоно. Хөтөч нохойг сургах, түүнийг хэрэглэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

32.8.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино. Энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг нийслэл, орон нутгийн төсөвт жил бүр тусган, хэрэгжүүлнэ.

Хөгжлийн бэрхшээл нь төрөл хэлбэрээр янз бүр байхын зэрэгцээ хүнд хөнгөнөөрөө ч мөн эрс ялгаатай. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлийн хүндрэлээс хамааран хөгжлийн бэрхшээлтэй хүний хийх үйлдлийн хязгаарлалт харилцан адилгүй байдаг. Өдөр тутмын өөртөө үйлчлэх үйлдлээ хөндлөнгийн хүний тусламжгүй гүйцэтгэх чадваргүй хүмүүс байдаг.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. [111]

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тушаалаар баталсан журмын хэрэгжилт хангалтгүй байсан тул Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А\187 дугаар “Журам батлах тухай” тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, Хувийн туслах үйлчилгээнд тавигдах шалгуур"-ыг хоёрдугаар, "Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд тавигдах шалгуур"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталжээ.

[111]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”, танилцуулга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын албан ёсны цахим хуудас https://mlsp.gov.mn/content/detail/33.

Уг журамд зааснаар 16-аас дээш насны 70 хувиас дээш хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн “Хувийн туслах үйлчилгээ”-гээр дамжуулан бие даан амьдрах эрхээ эдлэх боломж бүрдэх бөгөөд хувийн туслах нь тусгай сургалтад хамрагдсан байх шаардлага тавьсан. Одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх “Түгээмэл хөгжил төв” нь хувийн туслахуудыг бэлтгэн гаргаж байгаа бөгөөд нийт 250 гаруй хувийн туслах бэлтгэгдээд байна.

ХНХЯ-наас Нийгмийн халамжийн тухай хуульд заасан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-ээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах эрхийг хангах зарим хэлбэрийн үйлчилгээг үзүүлж байна. Уг үйлчилгээнд бие даан амьдрах эрхтэй холбоотой амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах; зөвлөгөө өгөх, өдрийн үйлчилгээнд хамруулах; гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах зэрэг үйлчилгээ багтдаг.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн зорилтот бүлэгт Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.5-д заасны дагуу төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж байна. 2016 онд нийт 7760 хүнд 1.6 тэрбум, 2017 онд нийт 10379 хүнд 1.6 тэрбум, 2018 онд нийт 21220 хүнд 3.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий үйлчилгээ үзүүлсэн байна. Түүнчлэн 2021 онд Улсын хэмжээнд 12 асрамж үйлчилгээний байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 434 иргэн хамруулснаас 259 ахмад настан, 175 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлсэн байна.[112]Улсын хэмжээнд 7,815 хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан бусдын байнгын асрамжинд байна.[113]

ХНХЯ-наас ЖАЙКА байгууллагатай хамтран хоёр дахь шатны төслийг эхлүүлэхээр болсон бөгөөд уг төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даасан байдлыг дэмжих тогтолцоог бий болгох бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахаар тусгаад байна. Үүнд чиглэлийн ажлууд хийгдэх талаар дараах мэдээлэл байна. Үүнд:

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах асуудлыг хариуцсан тогтолцооны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, орон нутагт туршилтын төсөл хэрэгжүүлэх;

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг хангах талаар орон нутгийн удирдлагуудад ойлголт өгч, шаардлагатай сургалт явуулах;

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн талаар санал боловсруулах зэрэг болно.

Товч дүгнэлт: Конвенцын 19 дүгээр зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх болон хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг авч үзэхэд эрх зүйн зохицуулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон бусад хууль хүртээмжийн талаар заасан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А\187 дугаар “Журам батлах тухай” тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, Хувийн туслах үйлчилгээнд

[112] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дах илтгэл, 2023 он, 376 тал

[113] Ц.Сүхбаатар, “Монголын ахмадуудын өнөөгийн байдал, цаашдын хандлага, зорилтын тухай”, Философийн хүрээлэн, Монголын ахмадын холбоо, “Ахмадуудын нийгэм эдийн засгийн байдал, цаашдын хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл”, 2019 он, 22 дугаар тал.

тавигдах шалгуур"-ыг хоёрдугаар, "Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд тавигдах шалгуур"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталжээ.

Хүртээмжтэй байх Конвенцын 9 дүгээр зүйлд дурдсан судалгаанд хамрагдсан байгууламжуудын 90% нь авто зогсоолдоо хөгжлийн бэрхшээлтэй хүний авто зогсоолын төлөвлөлт хийгээгүй, зогсоолын өргөн стандарт бус өргөн, тэмдэг тэмдэглэгээ 90% байхгүй, 8 байгууллагын налуу зам нь стандарт бус зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрах болон тухайн орчиндоо оршин байх нөхцөл хангалтгүй хэвээр байна.

Иймд конвенц болон зөвлөмжийг хэрэгжилтийг эрх зүйн орчинд бүрдүүлсэн тул тэдгээрийг хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ хэрэгцээтэй хэвээр байна.

Конвенцын 20 дугаар зүйлд заасан Хувийн хөдөлгөөнийг дэмжих тухайд:

Конвенцын 20 дугаар зүйлд:

“Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даасан байдлыг байж болох хамгийн дээд түвшинд хангах замаар хувийн хөдөлгөөнийг хангах үүднээс дараах хэлбэрээр үр дүнтэй бүх арга хэмжээг авна:

a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн хөдөлгөөнийг тэдний сонгосон аргаар, сонгосон цаг хугацаанд нь аль болох хамгийн бага зардлаар хангах явдлыг дэмжих;

b) чанарын шаардлага хангасан хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах технологи болон туслагчид болон дэмжлэг үзүүлэгчдийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аль болох хамгийн хямд өртгөөр хүртэх явдлыг дэмжих;

c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдэнтэй ажилладаг мэргэшсэн ажилтнуудыг хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах;

d) хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах технологиудыг үйлдвэрлэж боловсруулахдаа аж ахуйн нэгжүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлгөөний бүхий л тал, хэрэгцээг харгалзаж байх явдлыг хангах” гэж заасан.

Конвенцын 20 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд дараах байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн хөдөлгөөнтэй холбоотой хөдлөх болон туслах хэрэгсэл, шаардлагатай технологи, бусад хэрэгслийн талаар хуульд дараах тусламж, хөнгөлөлтийг үзүүлэхээр заасан. Үүнд:

“26.1.Энэ хуулийн 3.1-д заасан хүнд нийгмийн халамжийн сангаас доор дурдсан тусламж, хөнгөлөлт үзүүлнэ:

26.1.2. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох;

26.1.4. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох”-оор хуульчилсан.

Үүний дагуу 18 хүртэл насны хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан, эсхүл өсөлтийн улмаас таарахгүй болсон тохиолдолд тухай

бүр 100 хувь нөхөн төлж байна. Мөн 18 нас хүрээгүй хүүхэд болон нийгмийн даатгалын сангаас протез, сэргээн засалттай холбогдох хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүний дотоодод хийлгэсэн протез, худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгож байгаа талаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам мэдээлсэн. Энэ арга хэмжээнд нийгмийн халамжийн сангаас 2018 онд 15,5 мянган хүнд 2,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол нийгмийн халамжийн сангаас олгодог хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтөд 2021 онд 10.1 тэрбум төгрөгийг төсөвлөсөн.[114]

Гэвч хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэхэд хиймэл эрхтэн, туслах хэрэгслийн хүртээмж бага ялангуяа, шинэ технологи, мэдээлэл, харилцааны технологид суурилсан хиймэл эрхтний тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн хэрэглээ, хүртээмж хязгаарлагдмал байдал сөргөөр нөлөөлсөөр байна.

Иймд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Нийгмийн халамжийн сангаас олгодог протез, ортопед, туслах хэрэгслийн жагсаалтыг шинэчлэх ажлыг 2019 оноос эхлэн зохион байгуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 05-р сарын 27-ны өдрийн 193 дугаар тушаалаар шинэчилж, улмаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12-р сарын 01-ний өдрийн дугаар 363 “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, орпотедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг батлах тухай” тушаалаар дахин шинэчлэн баталсан.

2020 онд батлагдсан тушаалд заасан дараах хөнгөлөлтийг дур дурдсанаар шинэчилсэн жагсаалтаа өөрчилж тусгасан. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг 5 жилд нэг удаа олгодог байсныг 3 жилд нэг удаа болгон өөрчилсөн;
- 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд, ортопед тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг 3 жилд нэг удаа нөхөн олгох;
- Харин ахмад настанд шүдний протезийг 3 жилд нэг удаа, бусад протез, ортопед, тусгай хэрэгслийг 5 жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгож байна.

Харин Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 363 дугаар тогтоолоор дараах нэр төрлийн хэрэгслийг нэмж тусгасан. Үүнд:

- Орчин үеийн технологийн дэвшилтэй холбоотойгоор хиймэл гар, хөл зэргийн протезийн шинэ төрлүүд болох БИОНИК хиймэл эрхтний сэлбэг, засвар үйлчилгээ;
- Бүрэн хараагүй, сонсголгүй хүний харилцаа холбооны хэрэгсэл /Ухаалаг гар утас/;
- Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хэл засал, харилцаа, мэдрэхүйг хөгжүүлэх туслах хэрэглэгдэхүүн, тайвшруулах хэрэгслүүд.[115]

Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэмжийн хэмжээг сард 188,000 төгрөгөөр, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.4-т заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох

[114]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2021 он, 65 дахь тал.
[115]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2021 он, 23 дахь тал.

асаргааны тэтгэмжийг сард 123,100, асаргааны тэтэмжийн хэмжээг 84,500 төгрөгөөр тогтоон 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн.

- Нийгмийн халамжийн сангаас олгож буй халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2020 оны 05 дугаар сараас эхлэн 2022 оныг дуустал сар бүр 288.0 мянган төгрөгт хүргэж 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн хэмжээгээр олгохоор шийдвэрлэсэн. /Засгийн газрын 2022 оны 60 дугаар тогтоол/;
- Засгийн газрын 2022 оны 60 дугаар тогтоолоор байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 288.0 мянган төгрөгт хүргэн олгож байгаа бөгөөд 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл олгосон.
- Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөн оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр нэг хүүхдэд 16 000 (арван зургаан мянган) төгрөг, 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр насанд хүрсэн нэг гишүүнд 32 000 (гучин хоёр мянган) төгрөгт хүргэж 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр олгосон;
- 2021 оноос эхлэн Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 100 хувь цахим хэлбэрээр олгож эхэлсэн;
- “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох зорилт тусгагдсан.

Энэ хүрээнд ХНХЯ нийгмийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд төрөөс үзүүлж буй халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг түргэн шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, төрд байгаа иргэний мэдээллийг тухайн иргэнээс шаардахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхийг зорьж улмаар 2020-2021 онд нийгмийн халамжийн нийт 26 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн.[116]

Товч дүгнэлт: Конвенцын 20 дугаар зүйл болон хорооноос 2015 онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам нийгмийн халамжийн сангаас тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг хууль заасан хугацаанд үзүүлэх, энэхүү нөхцөлийг тогтоосон жагсаалтын 1-2 жилийн давтамжтайгаар шинэчилсэн байна.

Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Бионик хиймэл эрхтний сэлбэг, засварын үйл ажиллагаанд тодорхой хөнгөлөлт авах, ухаалаг гар утас, харилцаа, мэдрэхүйг хөгжүүлэх туслах хэрэглэгдэхүүн, тайвшруулах хэрэгслүүдийн жишиг үнэ, түүнд олгох хөнгөлөлтийг эдлэх эрх зүйн орчин шинэчлэгдсээр байгаа нь сайшаалтай.

Харин нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийг хэмжээ нь 2020 оны жишгээр байгаа бөгөөд энэ нь 16,000-288,000 төгрөгийн хооронд байгаа нь Монгол Улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 550,000₮

[116]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2021 он, 23 дахь тал.

байхаар заасан)-нээс бага байгаа буюу хорооноос өгсөн зөвлөмжийн "..хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонголт хийх боломж олгож, тэтгэмжийг нэмж, чанартай туслах хэрэгсэл, технологи, үйлчилгээг олдоцтой болгох" хэсэг бүрэн биелэгдэж чадаагүй хэдий ч үүнтэй холбоотой нөхцөл байдал сайжирсаар байгаагийн илрэл гэж үзэж болох юм.

Конвенцын 23 дугаар зүйлд заасан Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх тухайд:

Конвенцын 23 дугаар зүйлд:

"1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэрлэлт, гэр бүл, эцэг эх, төрөл садангийн харьцаанд бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр алагчлах явдлыг устгах үр дүнтэй, шаардлагатай дараах арга хэмжээг авна:

а) гэрлэх насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүл болох эрхийг гэрлэх хүнийх нь бүрэн, чөлөөтэй өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хүлээн зөвшөөрөх**;**

b) хөгжлийн бэрхшээлтэй хүн нь хүүхдийн тоо, хүүхэд төрүүлэх хоорондын зайг чөлөөтэй шийдвэрлэх, хариуцах эрхтэй бөгөөд насныхаа онцлогт тохирсон мэдээлэл, нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн боловсрол эзэмшиж, эдгээр эрхээ эдлэхэд нь шаардлагатай нөхцөл бололцоо болон үр удмаа үлдээх тэгш боломжоор хангагдах;

с) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр үр удмаа үлдээх эрхээр хангах;

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих, итгэмжлэх, хүүхэд үрчлэх, эсхүл эдгээртэй ижил төрлийн арга хэмжээ хэрэв үндэсний хууль тогтоомжид тусгагдсан бол эдгээр арга хэмжээний хувьд эрх, үүргээр хангах бөгөөд ямар ч тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүүхэд өсгөхтэй холбогдсон үүргээ биелүүлэхэд нь зохих тусламжийг үзүүлнэ.

3. Оролцогч улсууд нь гэр бүлийн харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш эрхийг хангана. Энэхүү эрхийг хэрэгжүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нууцлах, орхих, үл тоомсорлох, хөндийрүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний гэр бүлийн гишүүдийг эхнээсээ л бүх талын мэдээллээр хангаж, үйлчилгээ болон туслалцаа үзүүлнэ.

4. Оролцогч улсууд нь холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тийнхүү хөндийрүүлэх нь хүүхдийн эрх ашигт хамгийн ихээр нийцэх тухай шүүхээр шийдвэрлэсний дагуу эрх бүхий зохих байгууллагаас тодорхойлохоос бусад тохиолдолд хүүхдийг өөрийнхөө хүсэл зоригоос гадуур эцэг эхээсээ тусгаарлагдахгүй байх эрхээр хангана. Ямар ч тохиолдолд эцэг эхийн аль нэг нь, эсхүл хоёулаа, эсхүл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар хүүхдийг эцэг эхээс нь тусгаарлаж болохгүй.

5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үндсэн гэр бүл нь асран халамжлах боломжгүй тохиолдолд төрөл садангийн гэр бүлийн хүрээнд асран хамгаалуулах бүх төрлийн арга хэмжээг авах бөгөөд ийм арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд тухайн оршин суугаа орчинд нь гэр бүлийн нөхцөлийг бий болгож асран хамгаална." гэж заасан.

Конвенцын 23 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад ""гэрлэлт" гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг" ойлгохоор хуульчилсан.

Харин тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 9.1-д заасан харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр буюу Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр Монгол Улсад гэрлэж болно.” гэж заасан. Улмаар Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд гэрлэхэд харшлах дараах 6 шалтгааныг заасан. Үүнд:

“9.1.Дараах байдал нь гэрлэхэд харшлах шалтгаан болно:

9.1.1.өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа бол;

9.1.2.гэрлэгчид хоёулаа, эсхүл хэн нэг нь энэ хуулийн 6.1-д заасан насанд хүрээгүй бол;

9.1.3.төрөл, садангийн хүмүүс хоорондоо гэрлэх;

9.1.4.харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоёр гэрлэх;

9.1.5.үрчлэгч, үрчлүүлэгч хоёр гэрлэх;

9.1.6.**гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол.**

9.2.Иргэний хуульд заасны дагуу насанд хүрээгүй хүнийг иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж зарласан нөхцөлд энэ хуулийн 9.1.2 үл хамаарна.” хэмээн хуульчилсан.

Энэ нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрхийг хязгаарлах байдлыг бий болгох хуулийн урьдчилсан нөхцөл байж болох юм. Гэсэн хэдий ч Гэр бүлийн тухай хуулийн 9.1.6 дахь заалт практикт хэрэгжих боломжгүй байгаа бөгөөд заалтад тусгагдсан “**удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй**” гэх ойлголтыг хэрхэн ойлгох нь Эрүүл мэндийн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжуудад тусгагдаагүй.

Харин Монгол Улсын Дээд шүүхийн 2008 оны дугаар 46 тогтоолоор “Гэр бүлийн болон Иргэний бүртгэлийн тухай хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” тогтоолын 3.4-т “3.4. Мөн зүйлийн 9.1.6-д заасан "гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй" байдал гэрлэхээс урьд, эсхүл хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу хийгдсэн мэргэжлийн эмнэлэгийн байгууллагын шинжилгээгээр тогтоогдсон байвал зохино. Гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй болох нь шинжилгээний дүгнэлтээр тогтоогдсон бол Иргэний бүртгэлийн байгууллага Иргэний бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасан журмын дагуу гэрлэлтийг бүртгэхээс татгалзана. Харин энэ байдал нь гэрлэснээс хойш илэрвэл хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д зааснаар гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцно. Удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй болох эсэх талаар маргаан үүсвэл Иргэний бүртгэлийн байгууллага болон сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх тухайн этгээдийн сэтгэцийн өвчтэй эсэх, уул сэтгэцийн өвчин нь удамших хандлагатай эсэхийг тогтоолгохоор мэргэжлийн шинжээч нарыг томилж, дүгнэлт гаргуулна.” гэж тус тус тайлбарласан.

Гэхдээ энэхүү Дээд Шүүхийн тогтоолоор тайлбарлагдсан хоёр хууль болох Гэр бүлийн тухай хууль /1999/ хүчин төгөлдөр үйлчилж байгаа бол, Иргэний бүртгэлийн тухай хууль /1999/ хүчингүй болсон бөгөөд тус хуулийг 2018 онд шинэчлэн найруулж, Дээд шүүхийн тайлбарт дурдагдсан заалтууд бүхэлдээ өөрчлөгдсөн. Иймээс Дээд шүүхийн тайлбарыг практикт шууд хэрэглэх эсэх тодорхойгүй байна.

Энэ нь конвенцын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэрлэх насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүл болох эрхийг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой хэсгийн хэрэгжилт эрх зүйн орчинд тодорхойгүй байгааг харуулж буй.

Харин хүүхэд үрчлэх эрх зүйн зохицуулалтын тухайд мөн 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуулийн 7 дугаар бүлгээр зохилуулагдаж байна.

Тус хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т зааснаар “Ганц бие, бусдын асрамжид байгаа 60-аас дээш настай төрөл, садан бус Монгол Улсын иргэн, 60-аас дээш настай гадаадын иргэн, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн болон хорих ял эдэлж байгаа хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.” гэж заасан.

Энэхүү хуулийн заалтаас харвал хөгжлийн бэрхшээлтэй иргэн /оюун санаа, сэтгэцийн өвчтэй, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсоноос бусад/ хүүхэд үрчлэх, хамт амьдрах эрх бүрэн нээлттэй байна.

Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүүхдийг тэднээс ямар байдлаар салгах, тусгаарлах, албадах арга хэмжээ авах тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд зөвхөн Гэр бүлийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан /хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэх зэрэг/ нөхцөл буюу хүүхдийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх үйлдэл гаргасан тохиолдолд хасах ерөнхий зохицуулалт үйлчилж байна.

Мөн конвенцын 23 дугаар зүйлийн 2, 3, 5 дахь хэсэгт заасан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүүхэд үрчлэх, хүүхэд өсгөх /гэхдээ зөвхөн тухайн хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй байх тохиолдолд/, гэр бүлийн харилцаанд тэдний эрх ашгийг нэн тэргүүнд тавих, эрсдэлт нөхцөл үүссэн тохиолдол асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоохтой зохицуулалтын тухайд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.4, 26.1.5, 26.1.8, 26.1.12, 26.1.13, 26.1.15, 26.3, 26.8/ болон Гэр бүлийн тухай хууль / 21-26 дугаар зүйл болон 54, 55, 56, 57, 59, 60/-иар тус тус тодорхой зохицуулсан байна.

Дээрхээс үзвэл хорооноос 2015 онд өгсөн зөвлөмжийн “...оролцогч улс бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүү болон охиноо асран хамгаалах, тэднийг үрчилж авах эрх болон хариуцлагыг баталгаажуулаагүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүүхэд үрчилж авах, хүүхэд өсгөх хариуцлагаа биелүүлэхэд нь тэдэнд туслах гэх мэт тэднийг эцэг, эх байх эрхээ эдлэхийг хорьсон бүх хуульиудыг дахин нягталж үзэх” гэсэн хэсэг оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүнээс бусад бүх тохиолдолд хэрэгжиж байгаа буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн хүү, охиноо асран хамгаалах, эсхүл хүүхэд үрчилж авах эрх нь нээлттэй байна. Харин үүнийг тусгайлан зохицуулсан хуулийн заалт Гэр бүлийн тухай хуульд байхгүй.

Мөн зөвлөмжийн “Тэдний хүүхэд өсгөх хариуцлага биелүүлэхэд тохирох тусламж үзүүлдэггүй” гэх хэсэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхий тухай хууль /2016/-иар тодорхой хэмжээнд шийдэгдсэн байна.

Товч дүгнэлт: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүл болох, хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, мөн тэд хүүхэд үрчлэхтэй холбоотой эрх зүйн орчны тухайд оюуны хөгжлийн бэрхшээлтэйгээс бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн конвенцод болон зөвлөмжид заасан эрх аливаа байдлаар хязгаарлагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэйгээс нь шалтгаалан тэднийг үр хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, эсхүл хүүхэд үрчилж авахыг хязгаарласан хууль тогтоомж зөвхөн оюуны хөгжлийн бэрхшээлээс бусад тохиолдолд байхгүй.
Мөн конвенцод болон зөвлөмжид заасан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд шаардлагатай тусламж, дэмжлэгийг төрөөс үзүүлэхэд нөхцөл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 онд шинэчлэн батлагдсанаар тодорхой хэмжээнд сайжирчээ.

Конвенцын 24 дүгээр зүйлд заасан Сурч боловсрох эрхийн тухайд:

Конвенцын 24 дүгээр зүйлд:

“Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямар нэг алагчлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараах зорилгод чиглэсэн бүх түвшний болон насан туршийн сургалтын боловсролын тогтолцоог бий болгоно:

a) хүний чадвар, нандин чанарын мэдрэмж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хүний ялгаатай байдлыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;
b) хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн шинж чанар, авьяас чадвар, бүтээлч чанар болон тэдний оюуны болон бие махбодын чадварыг байж болох хамгийн бүрэн дүүрэн хэмжээгээр хөгжүүлэх;
c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох.” гэж заасан.

Конвенцын 24 дүгээр зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Үндсэн хуулийн зааалтад нийцүүлэн иргэдийн сурч боловсрох эрхийг Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудаар тус тус зохицуулж, Монгол Улсын иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангахаар зохицуулсан байна.

Мөн “Бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлнэ” гэж заасан. Энэ нь хүний эрхийг ардчилсан хэм хэмжээнд нийцүүлсэн төдийгүй иргэд боловсрол эзэмшихэд өргөн эрх эдэлж, сурах арга хэлбэрээ сонгох боломж олгож байгаагийн баталгаа болж байна.

Монгол Улсын хэмжээнд 2021 оны байдлаар зургаа ба түүнээс дээш настай нийт 104,200 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэнийг боловсролын байдлаар нь

нарийвчлан авч үзвэл 16,815 буюу 16.1 хувь нь боловсрол эзэмшээгүй, 87,385 буюу 83.9 хувь нь боловсрол эзэмшсэн талаар статистик[117] байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болон нийт хүн амын аль алиных нь хувьд бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүн амын хувь хамгийн өндөр буюу 30 орчим хувь бөгөөд үүний дараагаар суурь, бага боловсрол орж байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 9.6 хувь нь дээд боловсролтой байхад нийт хүн амын дундах дээд боловсролтой хүн амын эзлэх хувь түүнээс 2.4 дахин өндөр байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй боловсрол эзэмшээгүй хүн амын хувь нийт хүн амаас 3 дахин өндөр байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний 20.8 хувь нь суурь боловсролтой, 13.6 хувь бага боловсролтой, үлдсэн боловсролгүй хүмүүсийн 72.6 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байна.

Зураг 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын боловсролын түвшин



Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох эрхтэй (14.1) бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэрхшээлээс нь үл хамааран бүх шатны боловсролд бүрэн хамруулах (14.3.2) тухай Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан нь тэгш хамруулан сургах бодлогод нийцжээ.

Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт

[117] Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны статистик мэдээ, 2021 он, үзэх - https://mlsp.gov.mn/content/detail/953

Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 12,476 хүүхэд байгаагаас 3,975 нь байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна. Үүнээс ерөнхий боловсролын сургуульд сурдаг 4307, Ерөнхий боловсролын тусгай сургуульд сурдаг 1208, огт сурдаггүй 2818, сургууль завсардсан 377 хүүхэд байна[118].

Дээрх статистикаас ерөнхий боловсролын сургуульд огт сурдаггүй болон сургууль завсардсан хүүхдийн тоон үзүүлэлт харьцангуй өндөр буюу хөгжлийн бэрхшээлтэй боловсрол эзэмшээгүй хүн амын хувь нийт хүн амын дунджаас 3 дахин их байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг хангах, ямар нэг алагчлалгүй, тэгш боломжийг эдлүүлэх үүднээс хууль тогтоомжид заасан болохыг Конвенцын 5, 7 дугаар зүйлийн тайлбарт дурдсан, харин практикт хэрэгжилтийн байдал дутмаг байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж – 2022 судалгааны хүрээнд хөгжлийн өөрчлөлттэй сурагчдын эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлж, багш сурагчид хөгжлийн өөрчлөлттэй сурагчтай ялгаварлан гадуурхахгүй тэгш харилцах, тэдний сурах орчинг бүрдүүлэх зорилгоор Төв аймгийн 27 сумын хөгжлийн өөрчлөлттэй сурагчидтай ажилладаг ЕБС, СӨБ-ын 42 багшаас дараах судалгааг хийсэн бөгөөд дараах үр дүн гарсан байна.

Үүнд: -сургууль, цэцэрлэгт тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд зориулсан суултуур 71% нь байдаг 29% нь үгүй, тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд зориулсан налуу зам 95% нь байдаг, 5% нь үгүй хэмээн хариулжээ. Тусгай хэрэгцээт сурагчдад шаардлагатай брайл үсгийн хэрэглэгдэхүүн 19% нь байдаг, 81% нь үгүй, дохионы хэл мэддэг багш байдаг эсэх асуултад 95% нь одоогоор сурч байгаа гэсэн бол үлдсэн 5% нь байхгүй, дэмжлэгийн багийн гишүүн бүр тэгш хамрах боловсролын талаар адил тэгш мэдлэгтэй байж, ГСТ-өө боловсруулахад бүгд оролцдог эсэхэд 52% нь тухайн хариуцсан багш ганцаараа ажилладаг, 29% нь бүх гишүүд адил тэгш оролцдог, үлдсэн 19% нь дэмжлэгийн багт байдаг боловч мэдлэггүй, хөгжлийн өөрчлөлттэй сурагчидтай ямар мэргэжлийн багш ажилладаг тухайд 2% нь тусгай хэрэгцээт мэргэжлийн багш, 38% нь албан бус Насан туршийн боловсролын багш, 29% нь сургуулийн өмнөх боловсрол, үлдсэн 31% бага ангийн багш хэмээн хариулжээ. [119]

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбогдсон олон төрлийн судалгаа, мэдээллээс дүгнэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдахад гол бэрхшээл нь орчны бэрхшээл болох орц, гарц, шат, довжоо, нойлын өрөө зэрэг байдаг. Сургуулиуд налуу зам, шат хийсэн хэдий ч стандарт нормыг хангаж чадаагүй байна. Өөрөөр хэлбэл гялгар, гөлтгөр материалаар хийсэн нь халтирч унах эрсдэлд оруулж байна. Ихэнх сургуулиуд шат, лифт, чиглүүлэгч зэргийг төлөвлөөгүй байна. Түүнчлэн нэг үндсэн багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүрч заахад бэрхшээлтэй, ачаалалтай байдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон ганцаарчилсан дэмжлэг хангалтгүй, мэргэжлийн тусгай хэрэгцээт боловсролын багш дутмаг байна.

Хуулийн хэрэгжилтийн хангах механизм, хөшүүрэг сул. Барилгын стандарт, норм-шаардлага хангахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар БШУСЯ-ны үүрэг хүлээсэн журам, стандартууд ихэнх нь батлагдаагүй зэргээс шалтгаалж байна.

Товч дүгнэлт: Конвенцын 24 дүгээр зүйлийн үндсэн агуулга Монгол Улсын боловсролын салбарын хууль тогтоомжид тусгалаа бүрэн олсон хэдий ч тэдгээрийн хэрэгжилт практикт төдий л сайн биш байгааг илэрхийлж байна.

---

[118]Үндэсний статистикийн хороо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хэлбэрээр, 2022 он.

[119] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, “Хөгжлийн бэрхшээл бүртээмж 2022”, Эрдэм шинжилгээний онол практиктикийн Х хурлын эмхэтгэл, 19-21 дэх тал.

БШУЯ-ны 2022 оны тоон мэдээлэлд 1498 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа талаар мэдээлсэн бөгөөд Улаанбаатарт 835, Зүүн бүсэд 112, төвийн бүсэд 199, Хангайн бүсэд 236, Баруун бүсэд 111 хүүхэд тус тус хамрагдаж байна.[120] Харин Ерөнхий боловсролын 1-12 дугаар ангиудад 5673 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа бөгөөд үүнээс бага ангид 2653 хүүхэд, дунд ангид 2285 хүүхэд, ахлах ангид 735 хүүхэд тус тус суралцаж байгаа нь нийт суралцагчдын тоотой харьцуулахад бага байна.

Орчны бэрхшээл болох орц, гарц, шат, довжоо, нойлын өрөө зэрэг байгаа бөгөөд сургуулиуд налуу зам, шат хийсэн хэдий ч стандарт нормыг хангаж чадаагүй байна. Өөрөөр хэлбэл гялгар, гөлтгөр материалаар хийсэн нь халтирч унах эрсдэлд оруулж байна. Ихэнх сургуулиуд налуу зам, шат, лифт, чиглүүлэгч зэргийг төлөвлөөгүй, мөн нэг үндсэн багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүрч заахад бэрхшээлтэй, ачаалалтай байдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон ганцаарчилсан дэмжлэг хангалтгүй зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй үндсэн нөхцөл болж байна.

Конвенцын 25 дугаар зүйлд заасан Эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах эрхийн тухайд:

Конвенцын 25 дугаар зүйлд:

“Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлалгүйгээр эрүүл мэндийн дээд түвшингийн стандартад хүрэх эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндтэй холбоотой нөхөн сэргээх эмчилгээг оролцуулан жендерийн онцлогийг харгалзсан эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах боломжийг баталгаажуулах бүхий л зохистой дараах арга хэмжээг авна. Тухайлбал, оролцогч улсууд нь:

a)хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн амд суурилсан нийтийн эрүүл мэндийн хөтөлбөр, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбарыг оролцуулан бусад хүнд хүргэдэгтэй ижил түвшин, чанар, стандарт бүхий үнэ төлбөргүй буюу худалдан авах чадавхад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөтөлбөрүүдээр хангах;

b)хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэнд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор шаардлагатай үйлчилгээнд хамруулах, эрт оношлох, зохих үед таслан зогсоох буюу багасгахад чиглэгдсэн болон хүүхдүүд, ахмадуудыг цаашид хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулах;

c)хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан эмнэлгийн үйлчилгээг бүх газарт тухайлбал, хөдөө орон нутагт ч аль болох гэрт нь ойр газар үзүүлэх

d)эмч, эмнэлгийн ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдад үзүүлдгийн нэгэн адил чанартай үйлчилгээ, тухайлбал хүний эрх, нандин чанар, хараат бус байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол олгох тусгай хэрэгцээ, төрийн эзэмшлийн болон хувийн эмнэлгийн байгууллагуудын ажилтнуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх замаар *inter alia* чөлөөтэй олж авсан мэдээллийн үндсэн дээр үзүүлнэ

e)эрүүл мэндийн даатгал, хэрэв дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бол амь насны даатгалын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлахыг хориглох бөгөөд эдгээрт шударга, боломжит үндэслэлээр даатгуулна

[120]Боловсрол, шинжлэх ухааны яам, 2022 оны боловсролын статистик тоон мэдээлэл, Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (бүс, аймаг, нийслэлээр), 2023.

f)хөгжлийн бэрхшээлийн улмаас эмнэлгийн тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ, эсхүл хоол хүнс, ундны асуудалд алагчилж, үгүйсгэхээс урьдчилан сэргийлэх” гэж заасан.

Конвенцын 25 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг суурь хууль тогтоомж болох Эрүүл мэндийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээ авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй холбоотой дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг заасан бөгөөд тус зүйлийн 8.9 дэх хэсэгт “Хүний амь насанд аюултай, хөгжлийн бэрхшээлд хүргэдэг ховор тохиолдох өвчин, эмгэгийг тодорхойлох аргачлалыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын чиг үүргийг заасан бөгөөд тус зүйлийн 16.17 дахь хэсэгт “Сувилахуйн төв нь байнгын асаргаа сувилгаа шаардах ахмад настан, архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.” гэж заасан.

Түүнчлэн, Эрүүл мэндийн тухай хуулийн 39^1 дүгээр зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”-г хуульчилсан бөгөөд тус зүйлийн 39^1.1-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн байнгын хяналтад байж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авна.” гэж заасан. Харамсалтай нь тус зүйлийн 39^1.2-39^1.5 дахь хэсгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай эм олгох журам, эм олгох арга хэмжээг санхүүжүүлэх, өрх, сум, дүүргийн эрүүл мэндийн төвд хүүхдийн мэргэшсэн эмч ажиллах, тус эмч нь шаардлагатай үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зохицуулалттай байсан хэдий ч эдгээр хэсгүүдийг хүчингүй болгосон байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хангахад эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дараах стандартуудыг батлан, мөрдүүлж байна. Үүнд: 2017 онд баталсан Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017, Клиникийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 6673:2017, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн стандарт MNS 6330:2017 стандартад Сэргээн засах тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай 23 нэр төрлийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг тусгажээ.

Түүнчлэн дараах хөтөлбөр, шалгуур, дүрэм, аргачлал, маягтыг баталсан байна,

- 2019 оны 12 дугаар сарын 6-ны өдөр Эрүүл мэндийн сайдын А/554 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуурын баталсан. Тус тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх нөхцөл хангах, орчныг бүрдүүлэх;
- Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А/807, А/216 дугаар хамтарсан тушаалаар байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг баталсан;
- 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Засгийн газрын 173 тоот тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын дүрмийг шинэчлэн баталсан. Тус тогтоолоор 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 200 дугаар тогтоолыг хүчингүй болгосон;

- 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Эрүүл мэндийн Сайд, Хөдөлмөр, нийгэм хамгааллын Сайдын хамтарсан А/807, А/216 тоот тушаалын дагуу "Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт"-ыг нэгдүгээр, "Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт"-ийг хоёрдугаар, "Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн иргэнийг үнэлэх шалгуур, үзүүлэлт"-ийг гуравдугаар, "Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэний тодорхойлолт"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсан байдаг;
- 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд, Боловсрол, шинжлэх ухааны Сайдын, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан А/220, А/475, А/812 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэг аргачлал, маягтыг шинэчлэн баталсан;
- 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлалыг тус тус баталсан байна.

Монгол Улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сан гэсэн хоёр эх үүсвэрээс санхүүждэг бөгөөд санхүүжүүлж байгаа хэлбэрийг авч үзвэл:

ЭМД-ын сангаас: хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ; амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ; өдрийн эмчилгээ, үйлчилгээ; хорт хавдрын болон бусад өвчний хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ; уламжлалт, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээ; өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл; өрх, сум, баг, аймаг, дүүргийн амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн бичсэн жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт; зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгсэл; өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ; хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ; жирэмсний 37 долоо хоногоос өмнөх ба төрсний дараах үеийн хавсарсан эмгэгийн эмчилгээ; магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ гэсэн 12 төрлийн тусламж, үйлчилгээний зардлыг,

Улсын төсвөөс: жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн эх барихын тусламж, үйлчилгээ; халдвар судлалын үйлчилгээ, заавал болон тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалт, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэл; гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн тусламж, үйлчилгээний болон нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа, арга хэмжээ; хүүхдэд үзүүлэх эмнэлгийн зарим тусламж, үйлчилгээ; хорт хавдар, сэтгэцийн эмгэг, халдварт өвчний зарим тусламж, үйлчилгээ; түргэн тусламжийн үйлчилгээ; эмнэлгийн яаралтай тусламж; аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврах явцад гэмтсэн, өвчилсөн иргэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ; удаан хугацааны нөхөн сэргээх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал; бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн

болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээ гэсэн 10 төрлийн тусламж үйлчилгээний зардлыг тус тус санхүүжүүлж байна.[121]

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Эрүүл мэндийн яам хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүргэх нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, хүртээмжтэй болгох, бүх хэлбэрийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамтаас хамгаалах чиглэлээр дараах үйл ажиллагааг ковид-19 цар тахлын үед болон сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн яамны дэргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд салбарын үндсэн үүргийн хүрээнд нэгдсэн зохицуулалтаар хангах зорилго бүхий орон тооны бус дэд зөвлөлийг байгуулан зөвлөлийн ажиллах журам, зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/174 дүгээр тушаалаар батлуулсан;
- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөөг ДЭМБ-тай хамтран боловсруулж батлуулсан. Энэхүү арга хэмжээний төлөвлөгөөнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн үржихүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусламж, үйлчилгээний сургалт мэдээллийг сайжруулах чиглэлээр тусгагдсан;
- Даатгуулагч /иргэн/-ний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан хөдөлмөрийн чадвар алдалтыг нотолгоонд суурилсан олон улсын жишигт нийцсэн байдлаар боловсруулан батлуулахаар ажиллаж байна;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, үйлчилгээг сайжруулах, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Дэлхийн эрүүл мэндийн 71 дүгээр ассамблейгаар туслах хэрэгслийн хүртээмжийг сайжруулах талаар тогтоол (WHA 71.8) батлагдсан. Уг тогтоолоор гишүүн орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх туслах хэрэгслийн судалгаа хийхээр төлөвлөсний дагуу Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/246 дугаар тушаалаар туслах хэрэгслийн судалгаа хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд тус яамнаас Үндэсний статистикийн хороотой хамтран судалгааг үндэсний хэмжээнд хийж, тоо мэдээг цуглуулах ажлыг зохион байгуулсан;
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/749 дугаар тушаалаар “Сэргээн засахын тусламж, үйлчилгээг хөгжүүлэх 2021-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан батлуулсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/746 дугаар тушаалаар “Тархины саатай хүүхдийн булчин чангаралд ботулин токсин-А тарилга хийх оношилгоо, эмчилгээний заавар батлах тухай” оношилгоо эмчилгээний зааврыг баталсан.[122]

Цар тахлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст яаралтай тусламж үзүүлэх хариу арга хэмжээний хүрээнд:

- Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Ажиллах журам батлах тухай” А/309 дүгээр тушаалаар Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах журам, бүрэлдэхүүн, ажил үүргийн чиг үүргийг баталсан. Энэхүү штабын ажиллах журамд цар тахлын

[121] Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хорооноос ирүүлсэн асуумжийн хариулт, 2020 он, 53 дахь тал.

[122] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2021 он, 34 дэх тал.

үед нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эрсдэлт бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах чиглэлээр тусгаж харьяа байгууллагад чиглэл хүргүүлсэн;

- Мөн цар тахлын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн батлагдсан төлөвлөгөөг харьяа байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан. Нэг хаалга нэг шинжилгээний хатуу хөл хорионы үед эрсдэлт бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй тусламж, үйлчилгээнд зайлшгүй хамрагдах шаардлагатай нийслэл хотын нийт 1076 иргэний тусламж, үйлчилгээний зохицуулалтыг хийсэн;
- Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан тусламж, үйлчилгээг зохицуулах Эрүүл мэндийн сайдын 3 тушаал, оношилгоо эмчилгээний зааврыг нийт 10 удаа шинэчлэн боловсруулсан байна;
- Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2021 оны А/381, А/98 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг эмчлэх 120 ор дэлгэн ажиллуулсан. Энэ хүрээнд нийт 24 хөгжлийн бэрхшээлтэй батлагдсан тохиолдол, 19 хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнд тусламж, үйлчилгээ үзүүлж хэвтүүлэн эмчилсэн байна.[123]

Ийнхүү Монгол Улс иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс гадна өрхийн эрүүл мэндийн, эмнэлгийн мэргэшсэн, эх барихын, эмнэлгийн яаралтай, сувилахуйн дагнасан, түргэн тусламжийн, сэргээн засахын гэсэн эмнэлгийн 7 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Эрүүл мэндийн албан журмын даатгалын тогтолцоонд нийт иргэдийн 90 орчим хувь нь хамрагдаж байна. 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай буюу амьжиргааны түвшин доогуур өрхийн гишүүн, хүүхдээ 2 нас хүртэл асарч байгаа эх, эцгийн төлбөл зохих шимтгэлийг төр хариуцан төлдөг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнхи нь төрөөс шийтгэлийг нь хариуцах бүлэгт багтдаг учир эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжтой. Түүнээс гадна улсын төсвөөс санхүүжүүлдэг 10 нэр төрлийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хамрагдах боломжтой.

Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай зарим төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн зардлыг олгох хөнгөлөх, инфляцийн түвшинтэй уялдуулан зардлын хэмжээг нэмэгдүүлэх зэргээр хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлдэг юм. Энэ хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 10 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г, 11 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн зардлыг санхүүжүүлэх, хяналт тавих журам”, “Эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн жагсаалт, түүний жишиг үнэ, даатгалын сангаас олгох төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн баталж мөрдүүлээд байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж сэргээн зах болон сувилахуйн дагнасан тусламж үйлчилгээний

[123]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2021 он, 35 дахь тал6

зохион байгуулалтыг нэмж тусгаснаар хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй эрүүл мэндийн байгууллагуудын бүтцийг шинээр бий болж байна. Үүнтэй холбоотойгоор сэргээн засах төв, сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвүүдийн бүтэц, үйл ажиллагааны стандартын төслийг боловсруулах, 2019 онд нийслэлийн Хан-Уул дүүрэгт 35 ортой сэргээн засах төв байгуулах ажил хийгдэж байна.

Түүнчлэн орон нутагт байгаа хөгжлийн бэрхгээлтэй хүмүүст чиглэсэн өөр нэг онцлох ажил нь "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх судалгаа" ба тус судалгааг 2020 онд хийсэн бөгөөд тус судалгааны үр дүн, зөвлөмжид тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих бүлгийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 30 сургагч багш бэлтгэх ба сургагч багш нар төслийн зорилтот орон нутагт 25 дэмжих бүлэг байгуулж 125 хөгжлийн бэрхшээлтэй хүн, 150 асран хамгаалагчид үйлчилгээ үзүүлнэ. Дэмжих бүлэг, үе тэнгийн сургагч нараар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хууль зүй, нийгэм, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих орон нутагт түшиглэсэн тогтолцоог бэхжүүлэхээр ажиллаж байна.[124]

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрүүл мэндийн үйлчилгээний талаар мэдээлэл өгч, зөвшөөрөлийг нь авч үйлчлэх талаар ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр төрийн албан хаагчид болон нийтийн үйлчилгээний байгууллагын ажилтнуудын дунд хийх сургалтыг ХБХ-ий эрх ашгийн төлөө ажилладаг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаатайгаар хийж байна. Тухайлбал, 2018 онд ЖАЙКА байгууллагын "Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал" сургалтыг зохион байгуулах хөгжлийн бэрхшээлтэй 32 сургагч багшийг бэлтгэсэн бөгөөд тэдний тусламжтайгаар зохион байгуулсан 229 удаагийн сургалтад төрийн албан хаагч, хувийн хэвшлийн ажилтнууд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудыг хамруулсан. Одоо энэ сургалтад эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг түлхүү хамруулахаар төлөвлөж байна. Эрүүл мэндийн салбарт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлийн онцлог, тэдэнд үйлчлэх арга зүйг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа боловч энэ чиглэлээр дорвитой арга хэмжээ авч чадахгүй байгаа.

Товч дүгнэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр хангагдах, нөхөн сэргээгдэх болон бусад төрлийн эмчилгээ үйлчилгээ авах эрх УИХ, ЗГ-аас гаргаж байгаа бодлого, хөтөлбөрүүд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, хуулийг дагалдаж баталсан журам, заавар, аргачлал зэрэгт тодорхой туссан.

Конвенцын 25 дугаар зүйл болон зөвлөмжид заасан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх тусгайлсан хөтөлбөр, эрх зүйн зохицуулалтыг Засгийн газар болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамнаас гаргаагүй байгаа хэдий ч 2021 оноос хойших Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдэд олон төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр (Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн үржихүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусламж, үйлчилгээний сургалт мэдээллийг сайжруулах, туслах хэрэгслийн судалгаа хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах, сэргээн засахын тусламж, үйлчилгээг хөгжүүлэх 2021-2026 оны үйл

[124]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа: Мэдээллийн лавлах", 2021 он, 76 дахь тал.

ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан) төлөвлөн хэрэгжүүлж байгааг онцлох нь зүйтэй байна.

Харин Ковид-19 цар тахлын үед Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн холбогдох бусад байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал хандуулж хөгжлийн бэрхшээлтэй тусламж, үйлчилгээнд зайлшгүй хамрагдах шаардлагатай нийслэл хотын нийт 1076 иргэний тусламж, үйлчилгээ үзүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг эмчлэх 120 ор дэлгэн ажиллуулсан. Энэ хүрээнд нийт 24 хөгжлийн бэрхшээлтэй батлагдсан тохиолдол, 19 хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнд тусламж, үйлчилгээ үзүүлж хэвтүүлэн эмчилсэн болон бусад үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн байна.

Конвенцын 26 дугаар зүйлд заасан Нөхөн сэргээлтийн тухайд:

Конвенцын 26 дугаар зүйлд:

“1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хараат бус байдлыг дээд зэргээр хангах, тэднийг бие махбодь, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхитай болгох, нийгмийн бүхий л хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломжийг олгох, эзэмшүүлэх үүднээс бүхий л үр дүнтэй, зохистой арга хэмжээ авна. Эл зорилгоор оролцогч улсууд, ялангуяа эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарт өргөн хүрээтэй сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ, хөтөлбөрүүдийг дараах арга замаар зохион байгуулан бэхжүүлж, өргөжүүлнэ:

a) тухайн хувь хүний зүгээс нэн түрүүн шаардлагатай байгаа хэрэгцээг олон талаас нь үнэлж, дүгнэсний үндсэн дээр аль болох эрт үед хэрэгжүүлж эхлэх;

b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тухайн оршин суугаа орчинд нь болон нийгмийн амьдралын бүхий л салбарт сайн дурын үндсэн дээр оролцуулах болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэдний амьдарч буй, ялангуяа хөдөө, орон нутаг дахь орчинтой нь аль болох ойртуулахад дэмжлэг үзүүлэх.

2. Оролцогч улсууд нь сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх салбарт ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудад зориулсан анхан болон үргэлжилсэн шатны сургалт зохион байгуулах ажлыг хөхиүлэн дэмжинэ.

3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээнд хэрэглэх туслах тоног төхөөрөмж, технологиудыг хүртээлтэй байлгах, тэдгээрийг хэрэглэх зааварчилгаа, мэдлэг олгох явдлыг хөхиүлэн дэмжинэ” гэж заасан.

Конвенцын 26 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Практикт тулгамдаж буй хамгийн томоохон асуудал нь кновенцийн 26 дугаар зүйл “Article 26. Habilitation and rehabilitation” нь **нөхөн сэргээлт** бус харин **сэргээн засалтын** ойлголтыг конвенц өөртөө агуулж байсан. Манай улс конвенцийн 2008 онд соёрхон баталж, 2017 албан ёсоор орчуулж, Төрийн мэдээлэлд хэвлүүлсэн хэдий ч ийнхүү орчуулахдаа конвенцийн 26 дугаар зүйлийг алдаатай орчуулсан байна. Тодруулбал, хүн бүр өөрийн онцлогт тохирсон байдлаар хамгийн дээд хэмжээнд амьдралд оролцох чадвар олж авахад чиглэнэ.

Энэ нь (rehabilitation) буюу сэргээн засах ойлголтоос ялгаатай:

- Rehabilitation нь алдагдсан чадварыг сэргээх,
- Habilitation нь өмнө нь эзэмшээгүй чадварыг хөгжүүлэх үйл явц юм.

Хүн хөгжлийн бэрхшээлтэй болж, нэгэнт буцаж хуучин байдалдаа орохгүй болсон нь тодорхой болсон тохиолдолд тухайн хүнийг бэрхшээлтэйгээ дасан зохицож, амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй нийгмийн амьдралд оролцуулж, нийгмийн нэг идэвхтэй гишүүн болгоход бэлтгэх үйл явц юм. Тухайлбал: аливаа өвчин, осол гэмтэлээс болж тухайн хүн адар тутмын амьдралдаа бүрэн дүүрэн оролцуулах боломжгүй байх үед зөвхөн эмнэлгийн талаас асуудлыг шийдэх гэж оролдолгүйгээр тухайн хүнийг байгаа байдлаар нь хүлээн авч цаашдын амьдралд бэлтгэх зайлшгүй шаардлага гарч байна.

Жишээ: Полиомиелит (халдварт саа) тусч, хоёр хөл нь саажсан хүүг эмч хөл дээр нь босгохын тулд бүхий л арга хэмжээнүүдийг авчээ. Хүү хэсэг хугацаанд хөл дээрээ явж чаддаг байгаад дараа нь өсч, жин нэмэгдсэний улмаас таяг дээрээ явж чадахаа байж, улмаар түүний хоёр мөр мултардаг болов. Улмаар тэрээр тэргэнцэр хэрэглэхээс өөр аргагүй болов. Энэ үед тэрээр 40 гарсан байлаа. Хэрэв хүүд эхнээс нь тэргэнцэр дээрх амьдралыг зааж өгсөн бол хүү цаг хугацаа алдахгүй, биеэ зовоохгүй, эмчлүүлж байсан хугацаандаа сурч боловсрох, нийгэмд тустай үйл хийх боломжтой байлаа. Тиймээс хэн нэгэн урт хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй байх нь тодорхой болбол түүнийг ирэх шинэ амьдралд нь бэлтгэх шаардлагатай. Хэрэгцээт үйлчилгээнүүд нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, Нийгэмшүүлэх болон бие даан амьдрах ур чадвар эзэмшүүлэх сургалт, hэл яриа, танин мэдэхүй, хөдөлгөөний анхан шатны хөгжлийн үйлчилгээнүүд зэрэг байж болно.

Иймээс конвенцийн 26 дугаар зүйлийн орчуулга буруу хийгдсэнээс үүдэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал зөвхөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд буюу эмнэлгийн эмчилгээ, сувилгаанд төлвөрч байна. Гэсэн хэдий ч сэргээн засахтай холбоотой агуулгууд мөн тусгагдсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн сэргээх, сэргээн засах арга хэмжээг төрөөс авч хэрэгжүүлэх талаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт хуульчилсан. Сэргээн засах цогц арга хэмжээнээс эмнэлэгийн чанартай тусламж, үйлчилгээний хүрээнд бие мах бодийг сэргээн засах арга хэмжээг Эрүүл мэндийн тухай хуулиар, оюун санааны буюу сэтгэцийн эрүүл мэндийг сэргээх засах арга хэмжээг Сэтгэцийн эрүүл мэндий тухай хуулиар тус тус зохицуулсан.

Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.21-д “..."сэргээн засах" гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах болон эмнэлгийн бусад мэргэжилтний хамтын цогц үйл ажиллагааг;” ойлгохоор заасан. Тус заалтаас үзвэл бие мах бодийн болон сэтгэцийн эрүүл мэндийг сэргээн засах ойлголтыг ялган зааглаагүй, цогцоор нь тайлбарласан.

Түүнчлэн Эрүүл мэндийн тухай хуульд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь өрхийн эрүүл мэндийн, эмнэлгийн мэргэшсэн, эх барихын, эмнэлгийн яаралтай, сувилахуйн дагнасан, түргэн тусламжийн, сэргээн засахын гэсэн төрөлтэй байхаар[125],

[125]Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг.

эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь “сэргээн засах төв” гэсэн төрөлтэй байхаар[126], сэргээн засах төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон бусад эмнэлгээс илгээсэн өвчтөнд амбулаторооp үйлчлэх, хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна[127] гэж тус тус зохицуулсан. Харин Сэтгцэийн эрүүл мэндий тухай хуульд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь сэтгэцийн эрүүл мэндийн анхны, амбулаторийн, хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн, нийгэм, хамт олонд түшиглэсэн, сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн, сэтгэц-нийгмийн сэргээн засахын гэсэн төрөлтэй байхаар[128] зохицуулсан боловч “сэргээн засах төв” байгууллагыг тусгайлан байгуулах зохицуулалт тусгаагүй.

Эрүүл мэндийн тухай хууль болон Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд заасан дээрх зохицуулалтууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенцын 26 дугаар зүйл болон 2015 онд хорооноос өгсөн зөвлөмжийн агуулгатай уялдсан бус нийгмийн бүхий л хүрээг хамарсан өргөн агуулгаар тайлбарлагдах, том цар хүрээг хамрах ойлголт байх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээн засах, нөхөн сэргээх агуулгыг бүрэн илэрхийлэхгүй байгааг онцлох нь зүйтэй.

Дээрхээс гадна Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хиймэл эрхтэн, туслах хэрэгслийн талаар зохицуулсан байна. Тодруулбал:

“20 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

20.1.Төрөөс хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

20.2.Эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах орчныг бүрдүүлэх, техник, тоног төхөөрөмж, эм, эмнэлэг, асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, эрт илрүүлгийн урвалж бодисын зардлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган шийдвэрлэнэ.

21 дүгээр зүйл. Хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл

21.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл, авах зардлыг Нийгмийн даатгалын, Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын, Тэтгэмжийн даатгалын, Эрүүл мэндийн даатгалын, Нийгмийн халамжийн сангаас тус тус санхүүжүүлнэ.” хэмээн тус тус заасан.

Сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ нь маш өргөн, мэргэжлийн ойлголт учир иргэд хөдөлгөөн болон хөдөлмөр засалчийг нэг үйлчилгээ хэмээн андуурч байна. Эдгээр нь тус тусын онцлогтой тусламж, үйлчилгээ үзүүлдэг, багаар ажилладаг мэргэжилтнүүд юм. Хэл засалчийн хувьд одоогоор бакалаврын түвшний мэргэжилтэн хараахан бэлтгэж эхлээгүй байна. Цөөн эмнэлэгт энэ чиглэлээр ажиллаж байгаа хүмүүс байдаг нь ихэвчлэн гадаадын мэргэжилтнүүдийг дагаж мэргэшсэн, эсвэл ОХУ-д суралцсан байдаг аж. Хэл ярианы үйл ажиллагаа төрөлхийн болон олдмолоор алдагдсан үед энэ мэргэжлийн эмч тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрэлт ихтэй мэргэжил.

[126]Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.10 дахь хэсэг.
[127]Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь хэсэг.
[128] Сэтгэцийн мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг.

Сэргээн засах анагаах ухааны хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч гэсэн гурван үндсэн мэргэжил байдгаас Монгол Улсад хөдөлгөөн засалчийг 2011 оноос, хөдөлмөр засалчийг 2014 оноос бэлтгэж эхэлсэн бол хэл засалчийг хараахан бэлдэж эхлээгүй байна. Бэлдэж буй хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалчийн ангид элсэн суралцагчдын тоо хангалтгүй байгаа зэргээс үзэхэд манайд мэргэжлийн сэргээн засалч дутагдалтай байна.[129]

Монгол Улсад 2022 оны байдлаар ЭМДЕГ-тай гэрээ байгуулан ажиллаж буй 46 сувилалд ажиллавал зохих хүний нөөцийг тооцож үзэхэд, улсын хэмжээнд хамгийн багадаа 92-184 мэргэжлийн хөдөлгөөн засалч, 46-138 мэргэжлийн хөдөлмөр засалч, 46 хэл засалч, нийгмийн ажилтан, эмнэлзүйн төрөлжсөн мэргэшлийн эмч шаардлагатай байна. Цаашлаад, 92-184 сэргээн засахын их эмч, 184-460 сэргээн засахын сувилагч, болон бусад мэргэжлийн хүний нөөц шаардагдаж байна. Ялангуяа, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч зэрэг манайд шинэ тутам мэргэжлийн салбарт бэлтгэгдэж буй хүний нөөцийн нийлүүлэлт дээрх эрэлтийг хангах боломжгүй байна.[130]

2021 оны судалгаагаар Монгол Улсад сэргээн засах тусламж, үйлчилгээ авах шаардлагатай 100 мянга гаруй иргэн бий гэсэн тооцоо гарчээ. 2012 онд сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээг 56 мянга орчим иргэн авсан бол 2021 онд энэ тоо 100 мянга болтлоо өссөн.[131] 2024 оны байдлаар нийт сэргээн засах тусламж, үйлчилгээ авсан хүний тоо 298,309[132] болж 2021 оноос хойш 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Харин хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээн засах нөхцөл байдлын илүү тодорхой жишээн дээр буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, нөхөн сэргээлтийн нөхцөл байдлын талаар авч үзье.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04-р сарын 03-ны өдрийн дугаар 125 “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв байгуулах тухай” тогтоолоор Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эмнэлгийн болон сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх, тэдний хөгжлийг дэмжих чиг үүрэг бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяанд байгуулж, дүрмийг хавсралт ёсоор баталсан[133] байдаг.

Тус байгууллага 2019 оноос буюу байгуулагдсан цагаас эхлэн 2025 оныг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь дараах үндсэн үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

1. Хөдөлмөр засал;
2. Хөдөлгөөн засал;
3. Хэл засал;

[129] Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын судалгаа, 2022 он, 22 дахь тал.

[130] Мөн тэнд.

[131] Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн албан ёсны цахим хуудас, Мэргэжлээс шалтгаалах өвчний төрөл, тоо, хувиар – 2021 он.

[132] Эрүүл мэндийн яам, сэргээн засах тусламж үйлчилгээний тоон үзүүлэлт - 2024 он.

[133] Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04-р сарын 03-ны өдрийн дугаар 125 тогтоолын нэг дэх хэсэг, үзэх - https://legalinfo.mn/mn/detail/15032.

4. Усан эмчилгээ;
5. Физик эмчилгээ;
6. Хөгжим засал;
7. Спорт эмчилгээ;
8. Нийгмийн хөгжлийн үйлчилгээ;
9. Туслах хэрэгсэлийн захиалга.[134]

Байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулсан мэдээллээс үзэхэд тус байгууллага 2021 оны байдлаар нийт 2000 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг байнгын хараа хяналтад байлган сэргээн засах үйлчилгээ тогтмол үзүүлж байгаа бол, давхардсан тоогоор 28,000 хүүхдэд нэг удаагийн үйлчилгээ үзүүлж, 9031 шинжилгээ авч, 22597 хүнд эмчилгээ үзүүлж байна.[135]

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн сүүлийн нэг жилийн (2022 оны 05-р сараас 2023 оны 05-р сар хүртэл) үйл ажиллагааны тухай авч үзэхэд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь 2022 оны 05 дугаар сараас 2023 оны 05 дугаар сарын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сэргээн засах чиглэлээр дараах үйл ажиллагаа, уулзалтыг хийсэн байна. Үүнд:

- 2022.05.11-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн ТЕЛЕМЕДИЦИН-ний баг, Баян-Өлгий аймаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны салбар зөвлөлтэй хамтран аймгийн Цэнгэл сумаас холбогдсон хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид болон эмч нарт зөвлөгөө өгч, зайнаас үзлэг оношилгоо хийсэн.
- 2022.05.13-ны өдөр ХБХСЗХТ нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран “хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлгийн өдөр“-ийг тохиолдуулан хүүхдийн хөгжлийн эрт илрүүлэг болон портеж хөтөлбөрийн талаар тодорхой мэдээлэл бэлтгэн нэвтрүүлэг хийсэн.
- 2022.5.15 өдөр ХБХСЗХТ нь ХНХЯ, ГБХЗХГ, СУГ, МҮОНРТ, ОУЭЗХБ, НГБХЗХГ, ОУХ-ын “Найрамдал” цогцолбор, ӨБХТ, ХТ-ийн 108 утас, МҮМ зэрэг байгууллагатай хамтран олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “ГЭР БҮЛИЙН ҮНЭ ЦЭНЭ” өдөрлөгийг зохион байгуулсан.
- 2022.05.15-ны өдөр “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар “Таван богд фүүдс пицца” ХХК-тай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Ами тами тасгийн байнгын асаргаатай хүүхдүүдэд “Бяцхан гараараа пицца урлая” өдөрлөгийг зохион байгууллаа.
- 2022.05.20-ны өдөр БЗД-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд дүүргийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч нарт зориулан "ХАЙР ГЭРЭЛТҮҮЛСЭН ЭЛЧ" өдөрлөг арга хэмжээг зохион байгууллаа.
- 2022.05.21-ны өдөр “Зөвлөх эцэг эхийн хөтөлбөр-2022” хөтөлбөрийн хүрээнд ХБХСЗХТ нь Хөгжлийн бэрхшээлттэй хүүхэдтэй эцэг эрхийн холбоотой хамтран

[134]Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн албан ёсны цахим хуудас, https://rdccd.mn/%d0%b1%d0%b8%d0%b4%d0%bd%d0%b8%d0%b9%d1%82%d1%83%d1%85%d0%b0%d0%b9/%d2%af%d0%b9%d0%bb%d1%87%d0%b8%d0%bb%d0%b3%d1%8d%d1%8d/, 2025 оны 04-р сарын 01-ний өдөр хандав.

[135]Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн албан ёсны цахим хуудас, https://rdccd.mn/nuur-huudas/, 2025 оны 04-р сарын 01-ний өдөр хандав.

“Бага насны хүүхдийн эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээ, хөтөлбөрүүд, “портеж” хөтөлбөр” талаарх сургалт зохион байгуулав.

- 2022.05.26, 27-ны өдрүүдэд ХБХСЗХТ нь "НАЛАЙХ" дүүрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй, хоцрогдолтой хүүхдүүдэд үзүүлэх тусламж, эрт илрүүлэг, арга зүйн дэмжлэг үзүүлэх” үзлэг, сургалтыг зохион байгуулсан.
- 2022.05.27-ны өдөр МҮОНРТ болон ХХҮЕГ-хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамж үйлчилгээ” сэдвээр ярилцлага хийсэн.
- 2022.05.27-ны өдөр “Нийслэлийн Онцгой Байдлын Газар”-ын “Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв”-тэй хамтран хөдөө орон нутаг, алслагдсан дүүргээс ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд гамшгаас хамгаалах анхан шатны мэдлэг олгох зорилгоор ХБХСЗХТ-өөр үйлчлүүлж байгаа хүүхдүүд, эцэг эх, асран хамгаалагчдад ГАМШГААС ХАМГААЛАХ, МЭДЛЭГ ОЛГОХ анхан шатны сургалтыг зохион байгууллаа.
- 2022.05.30-ны өдөр ХБХХЕГ-аас Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөгжлийн төвд байнгын асаргаа шаардлагатай ч эцэг, эх, асран хамгаалагчгүй Ами Тами тасгийн хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагууд, 5-14 насны 150 гаруй хүүхдийг хамруулан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд түүх, соёлын өвийг хүртээмжтэй хүргэж таниулах, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан эцэг, эх, асран хамгаалагчийн хамтаар спорт, соёл урлагаар хөгжүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.
- 2022.06.01-ны өдөр Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Бяцхан гэрэл-5” арга хэмжээ Сонгинохайрхан дүүрэг Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн хэлтэс -тэй хамтран зохион байгулав.
- 2022.06.03-ны өдөр “Зөвлөх эцэг эхийн хөтөлбөр-2022” хөтөлбөрийн хүрээнд ХБХСЗХТ нь Хөгжлийн бэрхшээлттэй хүүхэдтэй эцэг эрхийн холбоо болон ХБХХЕГ-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн хөгжил оролцоо, сэдэвжүүлэлтийн арга зам” сургалтыг зохион байгуулав.
- 2022.08.26-ны өдөр Нийслэлийн Онцгой байдлын газраас Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвтэй хамтран Гал түймэр унтраах, аврах ангиудын салааны захирагч, бүлгийн дарга нарт “Тусгай хэрэгцээт иргэдтэй харилцах сэтгэл зүйн онцлог” сэдэвт сургалтыг зохион байгууллав.
- 2022.09.07-ны өдөр нийгэмд байр сууриа эзлэн, өөрийгөө нээн хөгжүүлж яваа хөгжлийн бэрхшээлтэй залуусыг урин үйлчлүүлэгч, эцэг эхчүүддээ зориулсан Тархины саатай хүүхэд залуусыг дэмжих сангийн ерөнхий зохицуулагч, яруу найрагч Ц.Мөнхтулгын “Итгэхүй” илтгэлийг зохион байгуулсан.
- 2022.09.15-ны өдөр ХБХХЕГ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах үүргийнхээ хүрээнд Дүдү хүүхдийн музей, Монголын Дауны Холбоотой хамтран дауны хам шинжтэй болон ХБХСЗХТөвийн “Аами Таами” бүлгийн 3-18 насны нийт 16 хүүхдийг хамарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг шинэ, сонирхолтой орчинд цагийг зөв боловсон өнгөрөөх, илүү бодит орчинд ажил мэргэжлүүдийн дүрд хувирч, хөгжилтэйгөөр тоглонгоо суралцах, хөгжүүлэх зорилготой арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.
- 2022.09.20, 21-ний өдрүүдэд “Иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй, хоцрогдолтой хүүхдэд үзүүлэх тусламж, эрт илрүүлэг, арга зүйн дэмжлэг үзүүлэх” хоёр өдрийн сургалт Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газарт зохион байгуулагдлаа.
- 2022.09.21-ны өдөр ХБХСЗХТ нь ХБХХЕГ-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, чадавхжуулах” сургалтыг зохион байгууллаа.

- 2022.09.25-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, тэгш оролцоог хангах зорилгын хүрээнд пара хөнгөн атлетикийн ууган гавьяат тамирчин, ОУХМ Ж.Лхагважавын нэрэмжит “Дүнжингарав марафон” тэмцээн Дүнжингарав худалдааны төвийн талбайд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Биеийн тамир спортын улсын хороо хамтран зохион байгуулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн оролцсон.
- 2022.09.27-ны өдөр Invescore Property LLC, Инвескор Проперти ХХК -ийн 5 жилийн ойн хүрээнд ХБХСЗХТ-н үйлчлүүлэгч хүүхдүүдэд Practical Insurance / Практикал Даатгал ХХК хамтран 2,000,000₮ үнэ бүхий гэнэтийн ослын даатгалд үнэ төлбөргүй хамруулж, ойн хүрээнд зохион байгуулсан хөлбөмбөгийн тэмцээнд урилгаар оролцуулан, байгууллагын нэрэмжит гарын бэлгээ гардуулсан.
- 2022.10.07-ны өдөр ХБХСЗХТ нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль тогтоомж, нийгмийн оролцооны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болороо "ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?" сэдэвт лекц зохион байгуулав.
- 2022.10.08-ны өдөр зохион байгуулагдсан Монголын нүдний нийгэмлэгийн 31 дэх удаагийн эрдэм шинжилгээний бага хуралд ХБХСЗХТ-ийн нүдний эмч Т.Булган оролцож “Сул харааны сэргээн засалт” сэдвээр 300 гаруй нүдний эмч нарт илтгэл тавьсан.
- 2022.10.10-ны өдөр “Сэтгэцийн эрүүл мэндийн дэлхийн өдөр” болгон тэмдэглэж ирсэн. Тус өдрийг тохиолдуулан ХБХХЕГ нь Аутизмд хийсэн аялал ТББ, Турк улсын Собе аутизмын сан, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо хамтран “АВА-хэрэглээний зан үйлийн шинжилгээ” сургалтын арга зүйг нутагшуулах, багш нарыг чадваржуулах сургалтыг явуулав.
- 2022.10.24-ний өдөр Орхон аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн хүсэлтийн дагуу "Эрт үеийн хөгжлийн дэмжлэг оролцооны Портеж хөтөлбөрийн онол арга зүй" сэдэвт сургалтыг Орхон аймгийн ЕБС болон СӨБ-ийн 80-н арга зүйч, багш нарыг хамруулсан 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа.
- 2022.10.25-ны өдөр “СУРГУУЛИЙН ДЭМЖЛЭГИЙН БАГ”-ийн гишүүдийг чадавхжуулах, зөвлөн туслах хамтарсан сургалтыг ХБХСЗХТ нь ХБХХЕГ, БГД-ийн НХХ, БГД-ИЙН ХБХЭМБНХСК, ЕБС-ийн 70 дугаар сургуультай хамтран зөвлөн туслах сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 17-24-ний өдрүүдэд Баянгол дүүргийн хамран сургах тойргийн 19, 28, 40, 93, 113, 146 дугаар сургууль, Сэтгэмж цогцолбор сургууль, Эрдмийн өргөө цогцолбор сургууль, Эрдмийн ундраа цогцолбор сургуулиудад тус тус зохион байгууллаа.
- 2022.10.25-ы өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан "Disability Expo-2022" арга хэмжээнд Төвийн ЭМСЗГ, ТХНСЗГ-ын эмч мэргэжилтнүүд болон багш нараас бүрдсэн баг оролцож, зорин ирсэн эцэг эхчүүд, хүүхэд багачуудад зөвлөгөө, мэдээлэл, танилцуулгаа хүргэн ажиллаа.
- 2022.11.20-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан "Disability Expo-2022" арга хэмжээнд Төвийн ЭМСЗГ, ТХНСЗГ-ын эмч мэргэжилтнүүд болон багш нараас бүрдсэн баг оролцож, зорин ирсэн эцэг эхчүүд, хүүхэд багачуудад зөвлөгөө, мэдээлэл, танилцуулгаа хүргэн ажиллаа.
- 2022.11.21-30-ны хооронд МХБХ-ны Гишүүн Холбоодын GRASSROOTS тэмцээнийг дэмжих сарын аянд БХСЗХТ нь дэмжин оролцож байна.
- 2022.11.22-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх нь 2022" эрдэм шинжилгээний хурал зохион байгуулав.

- 2022.12.03-ны өдөр "Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн эрхийг Хамгаалах Олон Улсын Өдөр" Жаалхүү Фильм болон MOON FILM MEDIA-ийн хамт олонтой хамтран "Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Сэргээн Засах Хөгжлийн Төв"-ийн үйл ажиллагааг танилцуулав.
- 2022.12.07-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн хүүхдийн сэтгэл зүйч Г.Нямпагма “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэл зүйн онцлог, хүүхдийн сэтгэл зүйн үйлчилгээ” үзүүлэв.
- 2022.12.14-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, БНЭУ-н Indomedi Mongolia байгууллагатай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийн хүрээнд нээлттэй өдөрлөг зохион байгуулав.
- 2022.12.15-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдүүдэд сэргээн засах тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор БНЭУ-ын Aakash healthcare super speciality hospital, Монгол дах албан ёсны төлөөлөгчийн газар Индомеди Монголиатай хамтран хоёр өдрийн арга хэмжээ зохион байгуулагдлаа.
- 2023.01.09-ний өдөр ХБХСЗХТ нь ХБХХЕГ, БГД-ийн ЗДТГ-тай хамтран хамтран тус дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран суралцахад хүүхдийн онцлогтой байдлыг хүндэтгэн үзэх, нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох, суралцах, хөгжих орчинд найз нөхдийн эерэг харилцаа, оролцоог нэмэгдүүлэх тэдэнд бүтээлч, аз жаргалтай, аюулгүй, тасралтгүй хөгжих орчин бүрдүүлэх зорилгоор “Нэг сургууль-Нэг хүүхэд” аяныг зохион байгууллаа.
- 2023.02.10-ний өдөр ХБХСЗХТ болон ХБХХЕГ хамтран Баянгол дүүргийн 89-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн суралцагчдад хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийж, 15 багш, 1 эцэг, эхэд чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа.
- 2023.03.03-ны өдөр ХБХСЗХТ-өөс "Сонсгол хамгаалах дэлхийн өдөр"-ийг тохиолдуулан мэргэжлийн эмч хүүхдийн чих хамар хоолойн үзлэг хийж, зөвлөгөө өгөв.
- 2023.03.13-ны өдөр ХБХСЗХТ болон ХБХХЕГ хамтран Баянгол дүүргийн 96-р цэцэрлэгийн 50 гаруй хүүхдэд эрт илрүүлгийн үзлэг хийж, 27 багш, 3 эцэг, эхэд чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа.
- 2023.03.21-ны өдөр “Эрхэм нандин сувд” ТББ-ын хүсэлтийн дагуу Индомед Монголиа компаниар дамжуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, БНЭУ-ын Аакаш эмнэлэгтэй хамтран 2023 оны 03 сарын 17-ны өдөр телемедицин үйлчилгээгээр холбогдож ажиллалаа.
- 2023.04.02-ны өдөр Аутизмыг таниулах “хандлагаа өөрчилье, эергээр хүлээж авъя” аяны хүрээнд ХБХХЕГ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, СЗСҮТ-ийн Протез, ортопедийн үйлдвэрийн албан хаагчид байгууллагын үйл ажиллагаагаа танилцуулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.
- 2023.05.17-ны өдөр Хөдөлмөр нийгмийн хамгаллын салбарын нээлттэй өдөрлөгөөр ХБХСЗХТ нь иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч тус тус ажиллажээ.

2022 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх зорилгоор явуулсан явуулсан судалгаагаар “*Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, сэргээн засах тусламж, үйлчилгээ нь эрчимтэй хөгжиж буй шинэ тутам салбар боловч, энэ чиглэлийн олон улсын гэрээ конвенцод нэгдэн орж, үүрэг амлалт хүлээж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хууль тогтоомж, засгийн газрын үйл ажиллагааны*

хөтөлбөрт зэрэг бүх шатны бодлогын баримт бичгүүдэд эмнэлгийн нөхөн сэргээлтийн талаар тодорхой зорилт, хөтөлбөр дэвшүүлэн ажиллаж байна. Харин мэргэжлийн нөхөн сэргээлтийн бусад шатууд буюу сэтгэл зүйн нөхөн сэргээлт, нийгмийн нөхөн сэргээлт, ажлын байранд эргэн ороход чиглэсэн зорилт, үйл ажиллагаа, эрх зүйн орчин хомс байна. Иймээс, энэ чиглэлээр засгийн газрын тогтоол, дүрэм, журам, сайдын тушаал гэх мэт баримт бичиг үйлдэх шаардлага үүсээд байна. Өөрөөр хэлбэл, эмнэлгийн нөхөн сэргээх үйлчилгээ тодорхой зохицуулалттай, тогтолцоотой, тодорхой түвшинд үйлчилгээ үзүүлж буй боловч сэтгэлзүйн, нийгмийн нөхөн сэргээлт, ажлын байранд эргэн ороход чиглэсэн тодорхой тогтолцоо огт бүрэлдээгүй байгаа"[136] тухай дүгнэлт гарсан байдаг.

Товч дүгнэлт: Монгол Улсын хувьд конвенцын 26 дугаар зүйлийн агуулгыг алдаатай орчуулснаас үүдэн Монгол Улсын эрүүл мэндийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн сэргээх агуулга бүрэн тусгагдаж чадаагүй байна. Мөн конвенцийн 26 дугаар зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн сэргээх, сэргээн засах агуулгыг тухайд Эрүүл мэндийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд зохицуулсан байна.

Бүх насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан нөхөн сэргээлтийг конвенцод заасан эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарт өргөн хүртээх нөхцөлийг хараахан бий болгож чадаагүй хэдий ч нийгмийн тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн шаардлагатай арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Жишээлбэл, 2019 онд байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв бөгөөд тус төв нь хөдөлгөөн засал, хэл засал, нийгмийн хөгжлийн үйлчилгээ зэрэг 9 үндсэн эмчилгээ, үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд 2021 оны байдлаар нийт 2000 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг байнгын хараа хяналтад байлган сэргээн засах үйлчилгээ тогтмол үзүүлж байгаа бол, давхардсан тоогоор 28,000 хүүхдэд нэг удаагийн үйлчилгээ үзүүлж, 9031 шинжилгээ авч, 22597 хүнд эмчилгээ үзүүлж байгааг дурдах нь зүйтэй байна. Мөн тус байгууллагаас үзүүлж байгаа дээрх үйлчилгээнүүд ямар нэг үнэ төлбөргүй бөгөөд тухайн байгууллагын Эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн санхүүжүүлж байна. Сувилал, сэргээн засах төвд ажиллах шаардлагатай эмч, мэргэжилтэн, засалч буюу мэргэжлийн хүний нөөц дутмаг, бие мах бодь, оюун санаа, хөдөлмөр, мэргэжлийн нөхөн сэргээлтийн үйлчилгээ хангалтгүй байна.

Конвенцын 27 дугаар зүйлд заасан Ажил хөдөлмөр эрхлэлтийн тухайд:

Конвенцын 27 дугаар зүйлд:

"1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөр эрхлэх, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хүртээлтэй, нээлттэй байгаа, оролцож болох хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрлөх орчинд ажиллахаар чөлөөтэй сонгосон, эсхүл зөвшөөрлөө чөлөөтэй өгсөн нөхцөлд эрхэлж буй хөдөлмөрийнхөө үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох боломжтой байх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөдөлмөр эрхлэх явцдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг эдлүүлэх үүднээс зохистой арга

[136] Хөжглийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын судалгаа", 2022 он, 56 дахь тал.

хэмжээ, тухайлбал хууль тогтоох болон дараах арга хэмжээ авах явдлыг хангаж, хөхиүлэн дэмжинэ:

a) ажилд авах нөхцөл, хөлсөөр ажиллуулах, ажил олгох, ажил хөдөлмөр эрхлэх, мэргэжлийн хувьд өсөн дэвжих, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах явдлыг оролцуулан хөдөлмөрийн бүх хэвшилтэй холбогдсон бүхий л асуудалд хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлахыг хориглох;

b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр адил хөдөлмөрт ижил тэгш боломж, адил цалин хөлс авах, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах, тухайлбал, дарамт шахалтад өртөхгүй байх, өргөдөл гомдлоо барагдуулах эрх;

c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөрлөх, үйлдвэрчний байгууллагатай холбогдсон эрхээр хангах;

d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн чиг баримжаа олгох ерөнхий хөтөлбөр, ажлын дадал олгох, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалтад үр дүнтэйгээр хамрагдах боломжийг бий болгох;

e) хөдөлмөрийн зах зээлд ажил хайх, ажилд орох, ажиллах болон ажилдаа буцаж орох боломж нөхцөл, мэргэжлийн хувьд дэвших боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгох явдлыг хөхиүлэн дэмжих;

f) хувиараа хөдөлмөр эрхлэх, аж ахуйн нэгж байгуулах, нөхөрлөл, хоршоо ажиллуулах, хувийн бизнесээ эрхлэх боломжийг дэмжих;

g) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн албанд ажиллуулах;

h) зохих бодлого хэрэгжүүлэх, арга хэмжээ авах, түүний дотор тэдэнд зориулсан хөтөлбөр батлах, урамшуулал олгох зэрэг бусад арга хэмжээ авах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хувийн хэвшлийн байгууллагад хөдөлмөр эрхлэх явдлыг хөхиүлэн дэмжих;

i) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байранд боломжит хэрэглэгдэхүүнээр хангах;

j) хөдөлмөрийн нээлттэй зах зээлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажлын туршлага хуримтлуулах явдлыг хөхиүлэн дэмжих;

k) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжлийн болон техник мэргэжлийн нөхөн сэргээлт, ажлын байрыг нь хадгалах болон ажилд нь буцааж оруулах хөтөлбөрийг хөхиүлэн дэмжих.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мөлжлөг, боолын байдалд оруулахгүй байх, бусадтай адил тэгш байх үндсэн дээр албадан хөдөлмөрөөс хамгаалагдах

Конвенцын 27 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх тэгш эрхийг хангах, бусад иргэдтэй нэг адил ижил ажилд тэнцүү цалин хөлс авах, хөдөлмөрийн аятай тавтай нөхцөлөөр хангуулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих харилцааг Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль зэргээр зохицуулсан байна.

Хуулийн хүрээнд хөгжлийн бэршээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг үндсэн 4 хэлбэрээр дэмжиж байна. Үүнд:

- Квот /Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна/
- Квотын бус /Хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөрийн чадвар алдалтын бага хувьтай иргэнийг ажлын байраар хангах зарчмаар хэрэгждэг/

- Хөдөлмөр эрхлэлтийн хамгаалагдсан систем /хувираа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хэлбэр/
- Давуу эрх хуваарилах систем /Хөгжлийн бэрхшээлийн төрөлд нийцүүлэн ажлын байрыг олноор бий болгох/

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг холбогдох хуульд заасны дагуу тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өмчийн хэлбэр үл хамааран 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилуулах, хэрэв ажилуулаагүй бол хөдөлмөрийн хөлсний поод хэмжээтэй тэнцүү төлбөрийг төлөх, энэхүү төлбөрөөс чөлөөлөх нөхцөлийг заах зэрэг хэд хэдэн ач холбогдол бүхий зохицуулалтуудыг 144.1-144.8 дахь хэсгүүдэд тусгасан.

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17-19 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн талаар нарийвчлан заасан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцох боломжийг хангах, тусгай хэрэгцээг зүйлс ашиглах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг хуульчилсан.

Хөдөлмөрийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтын хугацааг уртасгах зэргээр бусад ажилтны нэг адил ажиллах тохиромжтой нөхцөлийг бүрдүүлсний зэрэгцээ аж ахуй нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах квотыг тогтоон, түүнийг биелүүлээгүй тохиолдолд төлөх төлбөрийн хэмжээг ААНБ-ын ажиллагчдын тоо, төлбөрийн хэмжээ, бүс нутгийн хөгжлийн ялгавартай байдлыг харгалзан тогтоон мөрдүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал:

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувиар).

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувиар)



2021 оны байдлаар манай улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны хөдөлмөр эрхлэх чадвартай нийт 98 243 хүн байгаагаас байнгын ажиллагч 7591, тохиолдлын шинжтэй 5733, түр ажиллагч 245, төрийн албанд 1456 хүн ажиллаж байна. 15 буюу түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 67 151 буюу 68.4 хувь нь ажилгүй, үлдсэн 31 092 буюу 31.6 хувь нь ажил эрхэлж байна.[137]

Ажил хайгчаар бүртгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 33.9 хувь нь Улаанбаатар хотод, 61.1 хувь нь орон нутагт оршин суудаг бөгөөд 27 хувь нь өмнө нь ажил эрхэлж байсан бол 73 хувь нь огт ажил эрхэлж байгаагүй байна.

Зураг 6. Ажил хайгчаар бүртгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын түвшин



Ажил хайгчаар бүртгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэн хагас нь буюу 49.9 хувь нь бүрэн дунд боловсролтой, 12.5 хувь нь дээд боловсролтой иргэд байна[138].

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлмөрийн нээлттэй зах зээлд оролцуулах эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн боловч хамрах хүрээ хязгаарлагдмал байгааг дээрх графикуудаас харж болно.

[137]Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар “Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчийн статистик тоон мэдээ” 2021 он. http://www.gadpwd.gov.mn/index.php/page/277.
[138]Хөдөлмөр нийгмийн хамгаллын яам . https://mlsp.gov.mn/content/detail/953

Конвенцийн заалт нь Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт болон түүнийг хэрэгжүүлэх хариуцлагын механизм руу шууд чиглэсэн тул Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилт, тэдгээрийн үнэлгээний талаар авч үзэх нь илүү ач холбогдолтой бөгөөд өмнө хэрэгжиж байсан болон шинэчлэгдсэн хууль тогтоомжуудын харьцуулсан хүснэгтийг доор авч үзэв.

Хүснэгт – 23. Хөдөлмөрийн тухай хуулийн 1999 болон 2021 онуудын харьцуулалт

1999 оны 05 дугаар сарын 14-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль	**2021 оны 07 дугаар сарын 02 өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/**
111 дүгээр зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөрийн харилцааг зохицуулжээ.	144 дүгээр зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулжээ.
	144.1.Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үүрэгтэй.
111.1-т “25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна”	144.2-т “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна”
111.2-т “Аж ахуйн нэгж, байгуулага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө”	144.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө”
111.3-т “Энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, төлбөрийн нийт хэмжээнээс хамааран Засгийн газраас тогтооно”	

	144.4-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах зэргээр тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн ажил олгогчийг энэ хуулийн 144.3-т заасан төлбөрөөс чөлөөлж, эсхүл хөнгөлж болно”
111.4.Энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн, уг хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.	144.5-т “Энэ хуулийн 144.3-т заасан төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журмыг Засгийн газар батална. Энэ төлбөрийг гагцхүү хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зарцуулах бөгөөд төлбөр хураалт, зарцуулалт, үр ашгийн талаар жил бүр олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлагнана”
111.5-т “Хөгжлийн бэрхшээлтэй, одой хүний биеийн байдал нь хөдөлмөр эрхлэхэд саад болохооргүй буюу хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй бол тэдгээрийг уг шалтгаанаар ажилд авахаас татгалзахыг хориглоно”	
111.6-т “Аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө”	
111.7-т “Аж ахуйн нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхлэх боломжтой ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”	
	144.6-т “Ажил олгогч энэ хуулийн 144.1-д заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгохыг хориглоно”
	144.7-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй”
	144.8-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асардаг ажилтан хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч түүнд гэрээсээ, зайнаас, бүтэн бус цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжит арга хэмжээг авна”

Дээрх хүснэгтээс үзвэл хуулийн шинэчилсэн найруулгад ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, 25 буюу түүнээс дээш ажилтантай байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах заалтыг агуулгыг өргөтгөн өмчийн хэлбэр үр харгалзах, хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулагүй бол төлөх төлбөрийг Засгийн газар тогтоох бус шууд тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоох, ажил олгогч энэ хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгохыг хориглох зэрэг хэд хэдэн дэвшилттэй заалтууд тусгагджээ.

Гэхдээ 1999 оны Хөдөлмөрийн тухай хуульд байсан 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах хэсэг буюу 4 хувь гэх квот хэвээр байна. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын тухайд 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол ямар шийтгэл оногдуулах талаар тухайн үед үйлчилж байсан Зөрчлийн тухай хууль /2015/-д ямар нэг шийтгэл, торгуулийн арга хэмжээ байгаагүй.

Тэгвэл Хөдөлмөрийн тухай хууль /2021/-д заасан 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол Зөрчлийн тухай хууль /2017/-ийн 10 дугаар зйүлийн 10.16 дугаар зүйлийн 10.16.1-д “Хуульд заасны дагуу ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл одой хүнийг ажиллуулах үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага сар бүр төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасны дагуу 1.учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулах (550,000 төгрөг), мөн хүнийг 150,000 төгрөгөөр торгох, аж ахуйн нэгжийг 1,500,000 төгрөгөөр тус тус торгохоор заажээ.

Түүнчлэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хамтран 2021 оны 07-р сарын 02-ны өдөр батлагдан, 2022 оны 01-р сарын 01-ний өдөр хэрэгжиж байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтэй холбоотой хуулийн зүйл болох тус хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг үнэлэх судалгааг 2022 онд гүйцэтгүүлсэн.Тус судалгааг Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн үнэлгээг 21 аймгийн 1,885 ААНБ, Улаанбаатар хотын 9 дүүргийн 1,758 ААНБ-ын хувьд хяналт-үнэлгээ, мониторинг хийлээ. Хяналт, үнэлгээнд хамрагдсан ААНБ-ын 56.3% нь төрийн, 43.7% нь хувийн хэвшлийн байгууллагууд хамруулан хийж гүйцэтгэсэн байна.[139]

Судалгааны тайланд дурдсанаар хамрагдсан 3,243 байгууллагын 2,440 нь буюу 75.3% нь хөдөлмөрийн тухай хуулийн 111.1-р (шинэчилсэн найруулгын 144.1) заалтыг бүрэн болон хагас хангадаг, 546 байгууллага буюу 16.8% нь огт хэрэгжүүлдэггүй, 249 байгууллага буюу 7.7% нь 25-с цөөн ажиллагчидтай, 7 байгууллага буюу 0.2% нь хүн

[139]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар III, “Хөдөлмөрийн тухай хуулийн 111 (шинэчилсэн найруулгын 144) зүйлийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн тайлан”, 2022 он, 7 дахь тал.

ажиллуулдаггүй ч төлбөр төлдөг байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан 3,643 ААНБ-ын 3,242 буюу 89 хувь нь мэдээлэл бүрэн бөглөгдсөн бол 401 ААНБ-ын хувьд нийт ажиллагчдын тоо эсвэл ажлын байраар хангасан ХБИ-ий тоо мэдээлэл тодорхой бус байгаа учир боловсруулалт хийхэд оруулах боломжгүй байна.

Мэдээлэл бүрэн бөглөгдсөн 3,242 ААНБ-д нийт 273,673 ажилтан, албан хаагч ажиллаж байгаа ба хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 9,593 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 7,256 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байна. Нийт судалгаанд хамрагдсан ААНБ-ын хувьд Баруун бүс 10.3 хувь, Хангайн бүс 17.8 хувь, Төвийн бүс 17.1 хувь, Зүүн бүс 6.5 хувь, Улаанбаатарын бүс 48.3 хувийг тус бүр эзэлж байна. ААНБ-уудыг үйл ажиллагааны чиглэлээр авч үзэхэд боловсролын байгууллага хамгийн өндөр буюу 33.3 хувь, Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа 11.3 хувь, үйлчилгээний салбар 9 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа 8.1 хувь, боловсруулах үйлдвэр 5.6 хувь, бусад салбар үлдсэн 32.7 хувийг бүрдүүлж байна. Мэдээлэл бүрэн бөглөгдсөн 3,242 ААНБ-д нийт 273,673 ажилтан, албан хаагч ажиллаж байгаа ба хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 9,593 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 7,256 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байна.

Хяналт, үнэлгээнд хамрагдсан байгууллагаас 1,986 ААНБ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квотоос 1,501 хүн илүү ажиллуулж байхад 703 ААНБ квотыг хагас хангасан, 7 ААНБ хүн ажиллуулахгүй төлбөр төлдөг, үлдсэн 546 байгууллага нь огт хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахгүй, төлбөр ч төлөхгүй байна. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын хэмжээнд 3,838 хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулах боломжтой. Хуулийн хэрэгжилтийн хангалт улсын хэмжээнд 60.0% байгаа бол энэхүү үзүүлэлт төрийн байгууллагуудад 59%, хувийн хэвшилд 61% байгаа[140] талаарх дүгнэлт гарчээ.

Түүнчлэн, тус судалгаанд оролцсон хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 87.7% нь одоогийн ажилдаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ, 93.1% нь орлого нэмэгдсэн, 86.5% нь хамт олон найз нөхөдтэй болсон, 95.6%-д тэдний өөртөө итгэх итгэлийг нэмэгдсэн гэж ажил эрхэлснээр гарсан ахиц дэвшлээ үнэлжээ. Ажил хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байранд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд хамт олон, хамтран ажиллагчид" (95.4%) гол туслагч, зөвлөгч байдаг болох нь судалгааны дүнгээс харагдаж байна.[141]

Хөдөлмөрийн тухай хууль /1999/-ийн 71 дүгээр зүйлийн 71.1-д "Долоо хоногийн ажлын цаг нь 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны болон хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд 36 цаг хүртэл байна." заасан бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дээд тал нь 36 цаг ажиллах хязгаалалт тогтоосон буюу нэг талаас тэдний эрхийг хязгаарласан шинжтэй байсан. Тэгвэл Хөдөлмөрийн тухай хууль /2021/-ийн шинэчилсэн найруулгын 85 дугаар зүйлд ажил олгогч дараах тохиолдолд ажилтны ажлын цагийг нь богносгоно: "85.1.1.ажилтны ажлын цагийг богиносгох тухай эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гарсан; 85.1.2.жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй ажилтны ажлын цагийг богиносгохоор эмнэлгийн магадалгаа гарсан; 85.1.3.үйлдвэрлэл дээр мэргэжил эзэмшүүлэх, мэргэшил дээшлүүлэх сургалтад

[140]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар III, "Хөдөлмөрийн тухай хуулийн 111 (шинэчилсэн найруулгын 144) зүйлийн хэрэгжилтэ хөндлөнгийн хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн тайлан", 2022 он, 8-9 дэх тал.
[141]Мөн тэнд, 9 дэх тал.

хамрагдаж байгаа ажилтны ажлын цагийг суралцаж байх хугацаанд нь” гэж тус тус буюу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг долоо хоногт хамгийн ихдээ 36 цаг ажиллах хязгаарлалтыг өөрчилсөн.

Товч дүгнэлт: Монгол Улс хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж болох 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн хуулийг шинэчлэн найруулж, шинэ хуулийг 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Хуулийн шинэчилсэн найруулгад хорооны зөвлөмж өгөх үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхтэй холбоотой үндсэн зохицуулалтууд тусгагдсан, мөн 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах хуулийн зохицуулалтын агуулга хэвээр байгаагийн сацуу тухайн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй төлөх төлбөрийг хөдөлмөрийн хөлстэй уялдуулсан, ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үүргийг хуульчилсан зэрэг хэд хэдэн дэвшилттэй заалтууд тусгагджээ.

Тус хуулиар хорооны зөвлөмжид дурдагдсан “...Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг долоо хоногт дээд тал нь 36 хүртэл цаг ажиллуулахаар хязгаарлалт тогтоож өгсөн нь тэднийг ажил хөдөлмөр хийх урам зориггүй болгож байна” гэх хэсгийг анхааралдаа авч Хөдөлмөрийн тухай хууль /2021/-д хөгжлийн бэрхшээлтэй хүн долоо хоногт дээд тал нь 36 цаг ажиллах хязгаарлалтыг хассан буюу зөвлөмжийн энэхүү хэсэг биелэгдсэн.

Мөн шинэ хуулийн хэрэгжилтийг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэхэд хуулийн хэрэгжилтийн хангалт улсын хэмжээнд 2022 оны байдлаар 60.0% байгаа бол энэхүү үзүүлэлт төрийн байгууллагуудад 59%, хувийн хэвшилд 61% байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын хэмжээнд 3,838 хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулах боломжтой байна.

Улмаар Хөдөлмөрийн тухай хуулийн 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах заалтыг хэрэгжүүлэх тохиолдолд тухайн байгууллага хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (2022 онд 420,000, 2023 онд 550,000 төгрөг)-тэй тэмцэх мөнгөн хөрөнгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөхөөр заасан.

Түүнчлэн хорооны зөвлөмжид тусгагдсан “...Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлмөр эрхлэхэд нь доод тал нь 4 хувьд ажлуулна гэсэн шаардлагыг сахиулдаг одоогийн тогтолцоог дахин хянаж үзэхийг Хороо Оролцогч улсад зөвлөж байна. Дээрх квотыг биелүүлээгүй тохиолдолд олгож байгаа санхүүгийн торгуулийн дүнг нэмж арга хэмжээ авч болох юм. Мөн квотын тогтолцоог хянах, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн шинэ бодлого боловсруулах гэх мэт хуульд нийцсэн арга хэмжээ авах” хэсгийг хэрэгжүүлэхээр Хөдөлмөрийн хуулийг бүхэлд нь шинэчилж, улмаар түүнд нийцүүлэн Хөдөлмөрийн хуулийн 144.2 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн хуульд заасан торгууль нь иргэнийг 150,000 төгрөг, аж ахуйн нэгжийг 1,500,000 төгрөг байгаа бөгөөд мөн учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулахаар заасан хорооны зөвлөмжийн энэхүү хэсэг хэрэгжиж байна.

Конвенцын 28 дугаар зүйлд заасан Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгааллын тухайд:

Конвенцын 28 дугаар зүйлд:

“1. Оролцогч улсууд нь хүрэлцэхүйц хоол хүнс, хувцас, орон байраар хангагдах эрх, амьдралын нөхцөлөө тасралтгүй сайжруулах явдлыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл амьжиргааны хүрэлцэхүйц түвшинд байх эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг эдлэх явдлыг хөгжлийн бэрхшээлийн улмаас үл алагчлах үндсэн дээр хөхиүлэн дэмжих зохистой арга хэмжээ авна.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгаалал хүртэх эрх, уг эрхийг хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан аливаа алагчилалгүйгээр эдлэх явдлыг хүлээн зөвшөөрч, эдгээр эрхийг эдлүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүднээс дараах зохистой арга хэмжээ авна:

a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг цэвэр усны үйлчилгээнд тэгш хамрагдах явдлыг хангах болон хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор шаардагдах, боломжийн өртөгтэй үйлчилгээ, тоног төхөөрөмж болон бусад туслалцааг хүртэх явдлыг хангах;

b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид болон хөгжлийн бэрхшээлтэй ахмад настнуудыг нийгмийн хамгаалал болон ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдэд хамрагдах явдлыг хангах;

c) ядуу нөхцөлд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээт зардал тухайлбал, шаардлагатай сургалт, зөвлөгөө, санхүүгийн туслалцаа болон түр хугацааны туслалцаа авахдаа төрөөс дэмжлэг авах боломжоор хангах

d) бүх нийтийг орон сууцаар хангах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах;

e) тэтгэвэр, түүнтэй холбоотой хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах.” гэж заасан.

Конвенцын 28 дугаар зүйлийн хэрэгжилт өнөөгийн нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгаалал хүртэх эрхийн талаар, 26 дугаар зүйлд нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн талаар тодорхой зохицуулсан. Үүнд:

25.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хоол хүнс, хувцас, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй бөгөөд энэхүү эрхийг хангах зорилгоор төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

25.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглээний протез, ортопед, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, асаргаа сувилгааны болон бусад туслах хэрэгслээр хангах;

25.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлж, туслах үйлчилгээ авах боломжоор хангах;

25.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн хамгаалллын болон нийгмийн халамжийн хөтөлбөрт хамруулах.

25.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах

хөрөнгийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний болон аймаг, нийслэлийн Засаг даргын жил бүрийн төсөвт тусгана.

25.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, нийгмийн даатгалд хамруулах асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулна.

26 дугаар зүйлийн 26.1.Энэ хуулийн 3.1-д заасан хүнд нийгмийн халамжийн сангаас доор дурдсан тусламж, хөнгөлөлт үзүүлнэ:

26.1.1.байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

26.1.2. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох;

26.1.3.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезын үнийг гурван жил тутам нэг удаа нөхөн олгох;

26.1.4. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;

26.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх;

26.1.6.насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;

26.1.7.дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд ирж, очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон доор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгох:

26.1.7.а.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь;

26.1.7.б.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа нэг иргэнд 50 хувь;

26.1.7.в.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувь.

26.1.8.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан, сувилалд дараалал харгалзахгүйгээр сувилуулах;

26.1.9.бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

26.1.10.нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

26.1.11.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;

26.1.12.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа олгох;

26.1.13.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох;

26.1.14.хараагүй хүний брайлийн үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;

26.1.15.нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгох;

26.1.16.аарцаг эрхтэний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх.

26.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж болно.

26.3.Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн болон тэдгээрийг асран хамгаалагчийг нийгмийн халамжийн үйлчилгээ, тусламжид хамруулна.

26.4. Энэ хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4, 26.1.5, 26.1.6-д заасан тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журам, жишиг үнийг Засгийн газар батална.

Засгийн газраас Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, амьжиргааны доод түвшингийн өсөлттэй уялдуулан нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгох тэтгэвэр, асаргааны тэтгэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан бөгөөд түүний үр дүнд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ сард 689,000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ сард 572,400 төгрөг[142], нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ сард 397,500 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээ, ялгаатай нөхцөл байдлыг харгалзан байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 445,000 төгрөгт[143] хүрээд байна. Энэ нэмэгдлийн үр дүнд нийгмийн халамжийн тэтгэвэр болон асаргааны тэтгэмжийн хэмжээ амьжиргааны доод түвшний хэмжээтэй дүйцэхүйц байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны 03-р сарын 01-ний өдрийн А/29 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан хүн амын амжиргааны доод түвшинг авч үзвэл баруун бүсэд 447,100 төгрөг, Хангайн бүсэд 447,300 төгрөр, Төвийн бүсэд 446,700 төгрөг, Зүүн бүсэд 446,400 төгрөг, Улаанбаатарт 454,200 төгрөг байна.[144]

Түүнчлэн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрмээр тодорхойлсон Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож шийдвэрлэдэг байгууллага юм.

[142] Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 12-р сарын 12-ны өдрийн 221 дугаар тогтоол.
[143] Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 12-р сарын 25-ны өдрийн 247 дугаар тогтоол.
[144]Үндэсний статистикийн хорооны даргын 2023 оны 01-р сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаал – үзэх - https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758238981791&showType=1.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл нь салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг мэргэжлийн түвшинд тогтоох үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дэргэд дэргэд орон тооны бус Сэтгэцийн өвчний салбар зөвлөл, Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөл тус тус ажиллахаар заасан.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн бүрэлдэхүүнд дарга, нарийн бичгийн дарга, нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч 10, мэдээллийн технологийн мэргэжилтэн 1, шинжээч эмч 6, даатгуулагч, ажил олгогчийн төлөөлөл тус бүр 1, нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, мэдээллийн технологийн мэргэжилтэн нь орон тооны байна. Харин Сэтгэцийн өвчний салбар зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэшлийн эмч 4, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл тус бүр 1, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй бол Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэшлийн эмч 4, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл болон хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл тус бүр 1, нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тогтоосон.

Даатгуулагч хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг бүрэн буюу 70 ба түүнээс дээш хувь, хагас /хэсэгчлэн/ буюу 70 хүртэл хувиар алдсан гэж ангилна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар “0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тодорхойлно” гэж заасныг 2023 онд нэмэлт, өөрчлөлт оруулж 0-18 нас болгон насны хязгаарыг нэмэгүүлсэн. Энэхүү заалтын дагуу аймаг, дүүрэг бүрт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Гэвч тус байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэмд дээрх хуулийн заалт тусгалаа олоогүй буюу насны хязгаарыг 0-16 нас гэж тодорхойлсон хэвээр байна.

Энэхүү комисс нь 0-18 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлон, байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тогтоон эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц хөтөлбөрт хамруулах ажлын зохион байгуулж байна. 2021 онд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч иргэн 105,607 байгаа нь манай улсын нийт хүн амын 3.2%-ийг эзэлж байна.[145]

Үүний дагуу 18 хүртэл насны хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг эдэлгээний хугацаа дууссан, эсхүл өсөлтийн улмаас таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн төлж байна. Мөн 18 нас хүрээгүй хүүхэд болон нийгмийн даатгалын сангаас протез, сэргээн засалттай холбогдох хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүний дотоодод хийлгэсэн протез, худалдан авсан ортопед, тэнгэнцэр

[145]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа: Мэдээллийн лавлах”, 2021 он, 16 дахь тал.

зэрэг тусгай хэрэгслийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгож байгаа талаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам мэдээлсэн. Энэ арга хэмжээнд нийгмийн халамжийн сангаас 2018 онд 15,5 мянган хүнд 2,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол нийгмийн халамжийн сангаас олгодог хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтөд 2021 онд 10.1 тэрбум төгрөгийг төсөвлөсөн.[146]

Гэвч хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэхэд хиймэл эрхтэн, туслах хэрэгслийн хүртээмж бага ялангуяа, шинэ технологи, мэдээлэл, харилцааны технологид суурилсан хиймэл эрхтний тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн хэрэглээ, хүртээмж хязгаарлагдмал байдал сөргөөр нөлөөлсөөр байна.

Иймд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Нийгмийн халамжийн сангаас олгодог протез, ортопед, туслах хэрэгслийн жагсаалтыг шинэчлэх ажлыг 2019 оноос эхлэн зохион байгуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 05-р сарын 27-ны өдрийн 193 дугаар тушаалаар шинэчилж, улмаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12-р сарын 01-ний өдрийн дугаар 363 “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, орпотедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг батлах тухай” тушаалаар дахин шинэчлэн батлалсан.

2020 онд батлагдсан тушаалд заасан дараах хөнгөлөлтийг дур дурдсанаар шинэчилсэн жагсаалтаа өөрчилж тусгасан. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг 5 жилд нэг удаа олгодог байсныг 3 жилд нэг удаа болгон өөрчилсөн;
- 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд, ортопед тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг 3 жилд нэг удаа нөхөн олгох;
- Харин ахмад настанд шүдний протезийг 3 жилд нэг удаа, бусад протез, ортопед, тусгай хэрэгслийг 5 жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгож байна.

Харин Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 363 дугаар тогтоолоор дараах нэр төрлийн хэрэгслийг нэмж тусгасан. Үүнд:

- Орчин үеийн технологийн дэвшилтэй холбоотойгоор хиймэл гар, хөл зэргийн протезийн шинэ төрлүүд болох БИОНИК хиймэл эрхтний сэлбэг, засвар үйлчилгээ;
- Бүрэн хараагүй, сонсголгүй хүний харилцаа холбооны хэрэгсэл /Ухаалаг гар утас/;
- Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хэл засал, харилцаа, мэдрэхүйг хөгжүүлэх туслах хэрэглэгдэхүүн, тайвшруулах хэрэгслүүд.[147]

“Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т төрөөс иргэн, бизнест үзүүлж байгаа үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж бүрэн цахимжуулах, хиймэл оюун ухааныг ашиглах, автоматжуулах боломжийг тодорхойлж, үйлчилгээ авах хугацаа болон үе шатыг 2 дахин бууруулах зорилт тусгагдсан.

[146]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2021 он, 65 дахь тал.
[147]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2021 он, 23 дахь тал.

Хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу үзүүлж байгаа тусламж үйлчилгээний талаар конвенцын 6, 7, 9, 25 зүйлийн хэрэгжилт хэсэгт танилцуулсан тул энэхүү хэсэгт дэлгэрүүлэхгүй байсан нь зөв гэж үзлээ.

Товч дүгнэлт: Үүнээс үзвэл Конвенцын болон зөвлөмжийн хэрэгжилт эрх зүйн орчинд, илүү тодорхой авч үзвэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд маш тодорхой тусгалаа олсон байна.

Харин үүний практик хэрэгжилтийг тодорхой жишээн дээр авч үзэхэд хэрэгжилт төдий л сайн биш байгаа бөгөөд Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, амьжиргааны доод түвшингийн өсөлттэй уялдуулан нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгох тэтгэвэр, асаргааны тэтгэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан бөгөөд түүний үр дүнд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ сард 689,000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ сард 572,400 төгрөг , нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ сард 397,500 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээ, ялгаатай нөхцөл байдлыг харгалзан байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 445,000 төгрөгт хүрсэн. Энэ нэмэгдлийн үр дүнд нийгмийн халамжийн тэтгэвэр болон асаргааны тэтгэмжийн хэмжээ амьжиргааны доод түвшний хэмжээнд хүрсэн нь 2024 оны амьжиргааны доод түвшин (446,400 - 454,200 төгрөг)-тэй ойролцоо байгаа хэдий ч эдгээр нь 2024 оны байдлаарх Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 660,000 төгрөгөөс бага байсаар байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар “0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тодорхойлно” гэж заасныг 2023 онд нэмэлт, өөрчлөлт оруулж 0-18 нас болгон насны хязгаарыг нэмэгүүлсэн боловч Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэмд дээрх хуулийн заалт тусгалаа олоогүй буюу насны хязгаарыг 0-16 нас гэж тодорхойлсон хэвээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгаалалтай холбоотой хөнгөлөлт дэмжлэгийн хугацаа ойртсон (Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг 5 жилд нэг удаа олгодог байсныг 3 жилд нэг удаа болсон), давтамж нэмэгдсэн, мөн нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөнгөлөлтийг хэмжээ 2018 онд 2,8 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 10.1 тэрбум төгрөг болж нэмэгдсэн зэрэг үзүүлэлтүүд байна.

Конвенцын 29 дүгээр зүйлд заасан Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийн тухайд:

Конвенцын 29 дүгээр зүйлд:

“Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс дараах үүрэг хүлээнэ:

а) бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан улс төр, нийгмийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох байдлыг дараах хэлбэрээр хангана.

- (i) сонгууль өгөх журам, байр, сонгуулийн хуудас нь ашиглахад зохистой, хүртээмжтэй болон ойлгох, ашиглахад хялбар байх явдлыг хангах;

-(ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгууль болон ард нийтийн санал асуулгад ямар нэг сүрдүүлэггүйгээр саналаа нууцаар өгөх, сонгуульд нэрээ

дэвшүүлэх, болон шаардлагатай тохиолдолд туслах болон шинэ технологи ашиглах замаар албан тушаал хаших, төр, засгийн байгууллагын аль ч түвшинд төрийн алба хаах эрхийг дэмжиж хамгаалах;

- (iii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгогчийн хувьд өөрийн санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүний тулд шаардлагатай тохиолдолд тэдгээр хүмүүсийн хүсэлтээр сонгосон хүний туслалцаатайгаар саналаа өгөх,

b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш байх үндсэн дээр ямар нэг алагчилалгүйгээр төрийн удирдах хэрэгт бүрэн дүүрэн, үр нөлөөтэй оролцох орчин бүрдүүлэх явдлыг идэвхтэйгээр хөхиүлэн дэмжиж, тэдний нийгмийн үйл хэрэгт оролцох оролцоог дараах хэлбэрээр дэмжих:

- (i) улс орны улс төрийн болон төрийн хэрэг, ялангуяа улс төрийн намуудын үйл ажиллагаа болон удирдлагатай нь холбоотойгоор үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох;

- (ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон улсын, үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд төлөөлөх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага байгуулах, тийм байгууллагад элсэх” гэж заасан.

Конвенцын 29 дүгээр зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.9 дэх хэсэгт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно” гэж Монгол Улсын иргэний улс төрийн үйл ажиллагаанд оролцох, сонгох, сонгогдох эрхийн талаарх суурь эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Түүнчлэн Монгол Улсад улс дахь төрийн намын үйл ажиллагаатай холбоотой харилцааг Улс төрийн намын тухай хууль /2005 он/, улс төрийн үйл ажиллагааны хамгийн гол илрэл болох сонгуулийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг 2018 оныг хүртэл нэг хуулиар зохицуулдаг байсныг өөрчилж, 2019 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг, 2020 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуулийн тухай хуулиудыг тус тус шинэчлэн баталсан бөгөөд сонгуулийн хувьд эрх зүйн цогц шинэчлэлтийг хийсэн.

Улс төрийн намын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд тус хуулийн 3 дугаар зүйлд улс төрийн намд эвлэлдэн нэгдэх Монгол Улсын иргэний эрхийг заасан ба тус зүйлд иргэний аливаа хөгжлийн бэрхшээл болон бусад нөхцөл байдлаас үүдэн гишүүн болох эрхийг хязгаарлах талаарх заалт байхгүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцох эрх бүрэн нээлттэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 04-р сарын 14-ны өдөр 2005 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг 46 зүйлтэйгээр боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн[148] бөгөөд тус хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нам, улс төрийн үйл ажиллагаанд оролцохтой холбоотой дараах зохицуулалтуудыг тусгасан байна.[149] Үүнд:

[148] Монгол Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүллээ, 2023.04.14 – үзэх https://www.parliament.mn/nn/29907/.

[149] Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн албан ёсны цахим хуудас, https://d.parliament.mn/tusul/3848c76b-3dd8-48a0-a34b-fc1f8c55d5a9.

-8.5.Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана

-26.3.Жил бүрийн намд олгох төрийн санхүүжилтийн дор дурдсан хувийг дараах зориулалтаар зарцуулна:

-26.3.1.төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сурган бэлтгэх;

-27.7.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сонгуулийн үйл ажиллагаанд ижил тэгш оролцох, санал өгөх, санал хураалтын үйл ажиллагааны бүхий л шатанд оролцоог хангах суурь зохицуулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг тухай хуульд тусгасан бол тус харилцааг нарийвчлан зохицуулсан шат шатны сонгуулийн хуулиудад дараах байдлаар тэдний санал өгөх эрхийг тусгажээ.

Хүснэгт – 24. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгууль өгөх эрхийг зохицуулсан хуулийн зүйл, хэсэг, заалтууд

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	**Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль /2019 он/**
30.1.Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	62.3.Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна. 62.4.Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна. 62.5.Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.
	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хууль /2020 он/ 56.3.Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна. 56.4.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг

	хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна. 56.5.Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.
	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай /2020 он/ 61.3.Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна. 61.4.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна. 61.5.Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооноос бие махбодын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саналаа нууцаар чөлөөтэй өгөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2008 оноос “Саналын хайрцгийг хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа өгөх боломжтой байдлаар байрлуулна”, “Санал тэмдэглэх бүхээгийг хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа нууцаар тэмдэглэх байдлаар бэлтгэнэ” хэмээн сонгуулийн хэсгийн хорооны болон санал авах байрыг бэлтгэх зааварт тусган хэрэгжүүлж байна. Сонгуулийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн сонгуулийн эрхийг хангах зорилгоор тэргэнцэртэй сонгогч орох боломжийг хангах, санал өгөх бүхээгийг тусгайлан тоноглох зэрэг арга хэмжээг авч, 2016 оны УИХ-ын сонгууль, 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд харааны бэрхшээлтэй сонгогчид зориулан санал авах байр бүрт брайль үсэг бүхий хавтас ашигласан.

Түүнчлэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ын 29 дүгээр зүйлд заасан “Улс төр, нийгмийн амьдралд оролцох” нөхцөл боломж манай улсад хэрхэн хангагдаж байгааг судлах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/37 тоот тушаалаар “Улс төрийн намын болон Сонгуулийн тухай хууль”-д үнэлгээ хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Ажлын хэсэгт Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо, Монголын хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн холбоо, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Түгээмэл хөгжил төв, Монголын сонсголгүй иргэдийн үндэсний холбоо, Монголын сонсголгүй иргэдийн үндэсний холбоо, Монголын сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө үндэсний зөвлөл, Тэгш нийгэм холбоо төрийн бус байгууллагуудын удирдах зөвлөлийн гишүүдээс оролцсон. Ажлын хэсэг МУ-д хэрэгжиж байгаа өнөөгийн хуулийн нөхцөл байдал, олон улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох болон сонгогдох эрхийг хэрхэн тусгаж хэрэгжүүлдэг талаар судалгаа, үнэлгээ, дүгнэлт, саналыг хэлэлцэж, гаргасан санал, дүгнэлтийг танилцуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ирцийн мэдээллийн авч үзвэл:

Сонгуульд санал өгөх эрхтэй хөгжлийн бэрхшээлтэй нийт сонгогчдын тоо 82013 байгаагаас сонгуульд оролцож саналаа өгсөн 40536 буюу 49.4 хувьтай, сонгуульд оролцоогүй 41477 буюу 50.6 хувьтай байна. Энэхүү тоон мэдээллээс хөгжлийн бэрхшээлтэй нийт сонгогчдын дийлэнх нь сонгуульд оролцоогүй болох нь харагдаж байна.

Зураг 7. Сонгогчдын ирцийн мэдээлэл (хувиар)



Зураг 8. Сонгогчдын ирцийн мэдээлэл (насны бүлгээр)



Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний комисс Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үеэр олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан хөгжлийн бэрхшээлтэй, зөрчлийн улмаас баривчлагдсан болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан,

цагдан хоригдсон, хугацаат цэргийн алба хаагчид, коронавируст халдварын улмаас хэвтэн эмчлүүлж байгаа гэрээр тусгаарлагдсан, ажиглалтад байгаа сонгогчдоос тусгаарлалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийн сонгох эрхээ эдэлж байгаа эсэхэд 2021 оны 6 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд хяналт үнэлгээ, мониторингийг хийж гүйцэтгэжээ.

Үнэлгээ, мониторингийн тайланд талаарх нөхцөл байдал тусгагджээ. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсэгт “Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.” гэж заасан. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэх талаар сонгуулийн хороод харилцан адилгүй ойлголттой байна. Тухайлбал зарим санал бэлтгэх бүхээгт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан тэргэнцэртэй иргэний дүрс бүхий наалтыг 80 санал авах байранд байршуулсан байсан бол 40 нь байршуулаагүй зарим санал авах байранд ийм бүхээг бэлтгэх талаар огт ойлголтгүй байв. Иймээс санал бэлтгэх бүхээгний өндөр нам зэргийг тохируулан хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэй байдлаар тоноглох, мөн санал авах байрны зохион байгуулалт нь сонсголын бэрхшээлтэй болон тэргэнцэртэй сонгогчид ойлгомжтой байлгах үүднээс нэгдсэн тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, стандартын бус жижиг ширээг ашиглахгүй байх нь зүйтэй байна. Түүнчлэн санал авах байрны хэмжээнээс хамаарч 2-6 хаалт бүхий ширээ байршуулсан байх ба хаалт дээр тогтоосон хөгжлийн бэрхшээлтэй тэмдэг тэмдэглэгээ өнгө загвар, харагдах хэлбэр өөр өөр байгааг жигдэлж, нэгдсэн байдлаар тараах, бүхээгний аль хэсэгт, ямар байдлаар тогтоохыг зааварчлах нь зүйтэй байна.[150]

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт “Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.” гэж заасан. Санал авах байрны 88 нь сургууль, цэцэрлэг, 20 нь сум баг, дүүргийн хорооны байранд, 12 нь бусад барилга байгууламжид байснаас сум баг, дүүргүүдийн хороодын байрны газар доорх давхар (подваль)-т болон цэцэрлэг, эсхүл сургуулийн 2 дээш давхарт байрлан, санал авах байрны орц гарц, налуу зам стандартад нийцээгүй огцом шаттай, налуу зам болон бусад зай талбайн хүртээмжгүй байдлаас тэргэнцэртэй сонгогч орох боломжгүй байв. Тухайлбал 9 нь газар доорх давхар (подваль)-т, 10 нь 2-оос дээш давхарт байршиж байна. Хэсгийн хорооны ажилтнууд хөгжлийн тэргэнцэртэй сонгогч ирсэн тохиолдол 2 ажилтны туслалцаатайгаар шатаар өргөж, буулгах, зөөх, эсхүл зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналыг нь авахаар зохион байгуулан ажиллаж байна гэсэн тайлбарыг хийж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хүний эрхийн мэдлэг, ойлголт дутмаг байна. Иймээс санал авах байрны орц, гарцын хүртээмжтэй байдал, зөөврийн налуу замыг стандартын дагуу хийхэд анхаарах шаардлагатайн зэрэгцээ цаашид санал авах байрыг газар доорх давхар (подваль)-т болон 2-оос дээш давхарт байршуулахыг хориглох, түүнчлэн хэсгийн хорооны ажилтнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд анхаарах нь чухал байна.[151]

[150] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Зорилтот бүлгийн сонгогчдын эрхийн хэрэгжилтэд хийсэн хяналт, үнэлгээ, мониторинг, 2021 он, 2 дахь тал.

[151] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Зорилтот бүлгийн сонгогчдын эрхийн хэрэгжилтэд хийсэн хяналт, үнэлгээ, мониторинг, 2021 он, 2 дахь тал.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна.” гэж заасны дагуу саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байсан бөгөөд зарим санал авах байранд томруулдаг шилгүй, ширээний гэрэлгүй, гэрэлтүүлэг хангалтгүй байв. Цаашид харааны бэрхшээлтэй сонгогчдод ялангуяа сул хараатай сонгогчдод зориулан гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх үүднээс ширээний гэрэлтэй байх, санал авах байрны самбарын мэдээллийн үсгийн фонтыг 16-аас доошгүй хэмжээгээр хэвлэн байрлуулах, түүнчлэн түр хэрэглүүлэх туслах хэрэгсэл болох томруулдаг шил, ойрын харааны шил, ширээний гэрэл зэргийг байрлуулж, хэвших нь зүйтэй байна.

4. Хэсгийн хороод хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдыг дугаар харгалзахгүй саналаа өгөх боломжоор хангаж ажиллахаар төлөвлөж байгаа нь сайшаалтай хэдий ч цар тахлын үед сонгогчид хоорондын зайг баримтлан санал авах ажиллагааг зохион байгуулахад хүлээх нөхцөл байдал үүсч болзошгүй юм. Хяналт үнэлгээ, мониторинг хийсэн санал авах байрны 51 нь хүлээлгийн сандалтай, 101 нь гадна, дотно орчинд хүлээлгийн сандал байхгүй байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэд удаан хугацаагаар зогсоход хүндрэлтэй байдгийг харгалзан санал авах байрны хаалганы гадна талд хүлээлгийн сандал байрлуулахад анхаарах хэрэгтэй байна.

5.Тухайн нутаг дэвсгэрт харьяалалгүй цагдан хоригдсон, баривчлагдсан сонгогчийн саналыг харьяалах хэсгийн хороодоос алслагдсан, цаг хугацаа хомс, санхүү, хүний нөөц дутмаг гэх шалтгаанаар зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналыг нь авахгүй байгаа нь Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, мөн хуулийн 58.1.4 дэх хэсэг, Сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авах нийтлэг журмын 4.2.5, 4.4-т заасныг тус тус зөрчиж байна. Иймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон сонгогчийн санал өгөх эрхийг хангах үүднээс зөөврийн хайрцгаар санал авах хугацааны талаарх журмын зохицуулалтыг эргэж харах, зохион байгуулалтын талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.[152]

Дээрх үнэлгээ, мониторингтой холбоотойгоор зорилтот бүлгийн сонгогчдын эрхийг хангаж, хамгаалах чиглэлээр анхаарах шаардлагатай дараах асуудлаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасныг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн эрхийг бүрэн хангуулах зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комиссын дараах зөвлөмжийг хүргүүлжээ. Үүнд:

1. Санал авах байрны дэд бүтцийг хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэй байдлаар тоноглон засах, Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн “Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага, санал авах байр бэлтгэх заавар батлах тухай” 23 дугаар тогтоолд заасан “Орчны хүртээмж ба MNS 6055:2009 стандарт”-д нийцүүлэхэд нэгдсэн зааварчилгаа өгч, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмолжуулах;

2. Санал авах байрыг газар доорх давхар (подваль) болон хоёроос дээш давхарт байршуулахыг хориглох;

[152] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Зорилтот бүлгийн сонгогчдын эрхийн хэрэгжилтэд хийсэн хяналт, үнэлгээ, мониторинг, 2021 он, 2-3 дахь тал.

3. Сонсголын бэрхшээлтэй, сул сонсголтой иргэнтэй харьцахад хамгийн тохиромжтой шийдэл нь дохионы хэлмэрч боловч сонгуулийн санал авах байр болгонд дохионы орчуулагч ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, сургалтуудыг тогтмолжуулах;

4. Санал бэлтгэх бүхээгний өндөр нам зэргийг тохируулан тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэй байдлаар тоноглох, ингэхдээ стандартын бус жижиг ширээг ашиглахгүй байх, санал авах байрны хэмжээнээс хамаарч 2-6 хаалт бүхий ширээ байршуулсан тохиолдолд бүхээгт тогтоосон хөгжлийн бэрхшээлтэй тэмдэг тэмдэглэгээ өнгө загвар, харагдах хэлбэр өөр өөр байгааг жигдэлж, нэгдсэн байдлаар тараах, бүхээгний аль хэсэгт, ямар байдлаар тогтоохыг зааварчлах;

5. Харааны бэрхшээлтэй болон сул хараатай сонгогч саналаа өгөхөд зориулан шаардлагатай мэдээллийг үсгийн фонтыг 16-аас доошгүй хэмжээгээр хэвлэн байрлуулж, түүнчлэн түр хэрэглүүлэх туслах хэрэгсэл болох томруулдаг шил, ойрын харааны шил, ширээний гэрэл зэргийг байрлуулж хэвших;

6. Санал авах байрны зохион байгуулалтыг сонсголын бэрхшээлтэй сонгогчид ойлгомжтой байлгах үүднээс нэгдсэн тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, шаардлагатай тохиолдолд тэдэнтэй харилцах самбар байршуулж, түүнд түгээмэл хэрэглэх үг, яриаг ойлгомжтой байдлаар зургаар дүрслэн үзүүлэх боломжийг бий болгох;

7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд удаан хугацаагаар зогсоход хүндрэлтэй байдгийг харгалзан тэдэнд зориулан түр хэрэглүүлэх туслах хэрэгсэл болох таяг тавих тавиур, хүлээлгийн сандал зэргийг байршуулж хэвших;
8. Зорилтот бүлгийн сонгогчдын боловсрол нэмэгдүүлэхэд үе шаттай арга хэмжээнүүдийг авах, хэрэгжүүлэх.[153]

Мөн 2024 онд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Шийдвэр гаргах төвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн дэмжлэгээр ХЭҮК-оос удирдаж явуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт” судалгааг боловсруулсан. Тус судалгаа болон бусад байгууллагуудаас 2020-2023 онд явуулсан тус бүлгийн асуудалд холбогдох судалгааны үр дүнг харьцуулсны үндсэн дээр ХЭҮК-оос гаргасан дүгнэлтэд дараах асуудлыг тусгасан байна.

Тодруулбал, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол өнөөгийн нийгмээс хамгийн их тусгаарлагдсан нийгмийн бүлэг юм. Амьдралын наад захын шийдвэрийг өөрөө гаргах дадал бага, бие даан амьдрах, нийгмийн харилцаанд оролцох чадвар сул, хөдөлмөр эрхлэхгүй, эдийн засгийн чадавхгүй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн идэвх, оролцоонд саад учруулж буй тэргүүлэх хүчин зүйлс байна. Орчны хүртээмжгүй байдал, бие даан чөлөөтэй зорчих боломжгүй, бэрхшээлийн онцлогт тохирсон байдлаар мэдээлэл авч чадахгүй байгаа нь нийгмийн идэвхтэй харилцааг хязгаарлах удаах хүчин зүйл болж байна. Орчны хязгаарлалт ялангуяа Улаанбаатар

[153]Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, Зорилтот бүлгийн сонгох эрхийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ, мониторингийн хийсэн илтгэх хуудас, 2021 он, 15 дахь тал.

хотын хувьд өвлийн улиралд нэмэгддэг. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс улс төр, нийгмийн амьдралд оролцох хүсэл, эрмэлзлэлтэй, өөрийгөө бусдаас ялгаатай гэж үзэх хандлага харьцангуй бага, хөгжлийн бэрхшээлтэй улс төрчийг дэмжих хандлага нийгмийн бусад гишүүдэд харьцангуй их байгаа тэдний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ үр дүнд хүрэх боломжтойг илтгэж байна. Богино хугацаанд улс төрийн намуудын санаачлага, хөгжлийн бэрхшээлтэй улс төрчдийг санхүүжилтээр дэмжлэх, урт хугацаанд боловсролын хүртээмж, чанарын өөрчлөлт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг хангахад бодитой түлхэц үзүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан нийгмийн харилцаанд орох хүсэл, өөртөө хамааралтай асуудлаар шийдвэр гаргах, улс төрийн оролцоонд хүйсийн ялгаатай байдал ажиглагдаагүй. Энэ нь нэг талаас өөрийн чадвар, чадавхын талаарх төсөөлөлд хүйс төдийлөн чухал нөлөө үзүүлэх хүчин зүйл биш болохыг, нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоо маш бага учраас хөгжлийн бэрхшээл ба нийгмийн бусад хүчин зүйлсийн харилцан хамаарлыг мэдрэх туршлага байхгүйг илтгэж болно”[154] гэжээ.

Дээрх судалгаа болон дүгнэлтийн хүрээнд ХЭҮК-оос дор дурдсан саналыг дэвшүүлсэн:

1. ХБХЭК-ын 33 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих бүтцийг тогтоон хуульчлах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүргээ биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хуулиудад нарийвчлан тусгах, хариуцлага тооцох механизмыг тодорхой болгох;

2. Бүх шатны сонгуульд нэр дэвшиж буй хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчид сурталчилгааны материал хэвлүүлэх, түгээх, хүртээмжтэй тээврийн хэрэгсэл, сурталчилгааны байраар хангах, дохионы хэлмэрч, хувийн туслах ажиллуулах зэрэг дэмжих үйлчилгээ авахад төрөөс санхүүгийн дэмжлэг, төлбөр, татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох;

3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд чуулганы танхим, хуралдааны мэдээлэл хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, онцлог хэрэгцээнд нийцсэн байх, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнд шаардлагатай хувийн туслах, дохионы хэлмэрч, туслах технологиор хангах зохицуулалт тусгах;

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чадавхжуулах, бие даан шийдвэр гаргах, сонголт хийх хэвшил, дадал төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Насан туршийн суралцахуйн төвийг түшиглэн ИНБуудтай хамтран зохион байгуулах;

5. Монгол Улсын цахим хөгжлийн бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанар, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн судалгаа, хөрөнгө оруулалтын арга хэмжээг тусган хэрэгжүүлэх.[155]

[154] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2024 он, 368 дахь тал.
[155] Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2024 он, 369 дэх тал

Товч дүгнэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийн талаарх хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улс төрийн намын тухай /2005/ хуульд тусгайлан заагаагүй бол тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр тусган, улс төрийн нам хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, мөн хуваарилагдсан төсвөөс тэдэнд чиглэсэн үйл ажиллагаа заавал явуулах, тэднийг эрхийг хүндэтгэх суурь зохицуулалтуудыг тусгасан нь сайшаалтай байна.

Харин сонгуулийн үйл ажиллагааг зохицуулсан сонгуулийн нэгдсэн хуулийг бүрэн шинэчилж, 2019 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг, 2020 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуулийн тухай хуулиудыг тус тус батлахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний санал өгөх эрхийг бүрэн хангах өмнөх хуульд байсан тусгайлсан зохицуулалтуудыг шинэчлэн найруулж, тусгасныг онцлох нь зүйтэй.

Гэсэн хэдий ч эдгээрийн хэрэгжилт хангалтгүй байгаа Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын хийсэн үнэлгээ, мониторингийн тайлангийн зарим санал бэлтгэх бүхээгт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан тэргэнцэртэй иргэний дүрс бүхий наалтыг 80 санал авах байранд байршуулсан байсан бол 40 нь байршуулаагүй зарим санал авах байранд ийм бүхээг бэлтгэх талаар огт ойлголтгүй, Санал авах байрны 88 нь сургууль, цэцэрлэг, 20 нь сум баг, дүүргийн хорооны байранд, 12 нь бусад барилга байгууламжид байснаас сум баг, дүүргүүдийн хороодын байрны газар доорх давхар (подваль)-т болон цэцэрлэг, эсхүл сургуулийн 2 дээш давхарт байрлан, санал авах байрны орц гарц, налуу зам стандартад нийцээгүй огцом шаттай, налуу зам болон бусад зай талбайн хүртээмжгүй байдлаас тэргэнцэртэй сонгогч орох боломжгүй зэрэг дүгнэлтээс харагдаж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуулийн идэвхий талаар авч үзэхэд сонгуульд санал өгөх эрхтэй хөгжлийн бэрхшээлтэй нийт сонгогчдын тоо 2021 оны байдлаар 82013 байснаас сонгуульд оролцож саналаа өгсөн 40536 буюу 49.4 хувьтай, сонгуульд оролцоогүй 41477 буюу 50.6 хувьтай байна. Энэхүү тоон мэдээллээс хөгжлийн бэрхшээлтэй нийт сонгогчдын дийлэнх нь сонгуульд оролцоогүй ажээ.

Конвенцын 31 дүгээр зүйлд заасан Статистик болон мэдээлэл цуглуулах тухайд:

Конвенцын 31 дүгээр зүйлд:

“1.Оролцогч улсууд энэхүү конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор бодлого, стратеги боловсруулах, статистик болон судалгааны мэдээллийг оролцуулан шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулах, тэдгээр мэдээллийг тухайн бодлогод ашиглах үүрэг хүлээнэ. Ийм мэдээллийг олж авах, цуглуулах ажиллагаа нь:

a)мэдээллийн нууцлал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй байдлыг хангахын тулд мэдээллийг хамгаалах тухай хууль тогтоомжийг оролцуулан бусад хууль тогтоомжоор олгосон хамгаалалтыг чанд сахих;

b)статистик мэдээллийг цуглуулах, ашиглахдаа хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаархи олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ болон ёс зүйн хэм хэмжээг чанд сахих.

2. Энэ зүйлийн дагуу цуглуулсан мэдээлэл нь зохих түвшинд тодорхой байх бөгөөд оролцогч улсууд энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд үнэлэлт өгөх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ эдлэх явцад учирч буй саад бэрхшээлүүдийг тогтоох, арилгахад түүнийг мөн хэрэглэнэ.

3. Оролцогч улсууд статистик эдгээр мэдээллийг түгээх үүрэг хүлээх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад хүнд эдгээр мэдээлэл нь хүртээлтэй байх явдлыг хангана.” гэж заасан.

Конвенцын 31 дүгээр зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралд хүрээлэн буй орчны зүгээс тулгарч буй саад тотгор, тэдгээрийн аж амьдралын байдал, зорилтот үйл ажиллагаан дахь оролцоо, ажил хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, ялгаварлан гадуурхалт зэргийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зэрэг нийгэм, эдийн засаг болон хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдийг тусгасан өргөн агуулгаар хөгжиж байна. Энэ утгаараа хөгжлийн бэрхшээлийн статистик олон салбарын асуудлыг хэмжээсжүүлэн судалдаг шинжлэх ухаан юм. Хөгжлийн бэрхшээлийн тархалтыг тодорхойлох зорилгоор мэдээллийг нэг хүнээс нийт хүн амд, тэдгээрийн нас, хүйс, арьс өнгө, нийгэм, эдийн засгийн байдал болон бусад онцлог шинж байдлаар нь боловсруулан гаргадаг.[156]

Үндэсний статистикийн хороо 2003 оноос эхлэн албан ёсны статистик мэдээлэл болох /хуучнаар Өрх, хүн ам, нийгмийн зарим үзүүлэлтийн тайлан НС-1 маягт/ Нийгмийн зарим үзүүлэлтийн тайлан НЗҮ-1, НЗҮ-1А маягтаар аймаг, нийслэлээс жил бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж нийтэд хүргэдэг ба Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр хөдөлмөрийн чадвараа тодорхой хувь хэмжээгээр алдаж, хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүмүүсийг хамруулдаг байна.[157]

Үндэсний статистикийн хорооны нийтэд илэрхий тавигдсан статистик мэдээллээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, оюун ухааны хомсдолтой, сэтгэцийн, хавсарсан, бусад гэж ангилан, хүйс, аймаг, нийслэлээр тоо мэдээлэл гаргадаг байна. [158] Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог гаргахдаа хөгжлийн бэрхшээлийн ангилал, хэлбэр, тоо, нас, хүйсээр нь статистик мэдээлэл гаргадаг байна.

Манай Улс статистикийн тоо мэдээллийг боловсруулахад дараах эх үүсвэрийг ашиглаж байна. Үүнд:

1. Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг харуулсан жил бүрийн мэдээлэл юм. Энэхүү мэдээнд эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр хөдөлмөрийн чадвараа тодорхой хувь хэмжээгээр алдаж, хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүмүүсийг хамруулдаг.

Статистикийн үйл ажиллагааг эрхлэн явуулах анхан шатны нэгж буюу баг, хорооны Засаг дарга, сумын Засаг даргын Тамгын газар, дүүрэг, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар нь Нийгмийн зарим үзүүлэлтийн тухайн жил (тайлант хугацаа)-ийн мэдээллийг батлагдсан маягтын дагуу жил бүрийн 12 дугаар сард цуглуулан дамжуулж, Үндэсний статистикийн хороо уг мэдээллийг дараа жилийн 1 дүгээр сард нэгтгэн боловсруулдаг байна.

2. Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүн ам зүй, нийгэм эдийн засгийн болон ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг цогцоор тодорхойлон судлах зорилгоор хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо

[156]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа, Мэдээллийн лавлах”, 2020 он, 12 дахь тал.
[157]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан ёсны хуудас үзэх -https://mlsp.gov.mn/content/detail/1173.
[158]Үндэсний Статистикийн Хороо, Статистийн мэдээллийн нэгдсэн сан, 2023 он.

мэдээллийг цуглуулж, нийтэд тархаасан. 2020 оны хүн ам орон сууцны тооллогын мэдээллийг цуглуулахдаа нийт өрхийн 10 хувийн мэдээллийг дэлгэрэнгүй цаасан асуулгыг, үлдсэн 90 хувийн мэдээллийг богино асуулга буюу интернэт, төрийн байгууллагын мэдээллийн сангуудын мэдээллийг ашигласан юм.

3. Өрхөд суурилсан түүвэр судалгаа нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөөлж болохуйц тодорхой хэсгийг сонгон авч дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх замаар бодлого хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлоход ашиглаж байна. Үндэсний статистикийн хороо нь тогтмол хугацааны давтамжтайгаар өрхөд суурилсан түүвэр судалгааг зохион байгуулдаг бөгөөд эдгээр судалгаанд тодорхой зорилго, агуулгын хүрээнд боловсруулсан арга зүйг ашигладаг. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаа, Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, Цаг ашиглалтын судалгаа зэрэг үндэсний хэмжээний төлөөллийг хангахуйц өрхөд суурилсан түүвэр судалгааны асуулгад хөгжлийн бэрхшээлийн талаарх асуултыг оруулж, мэдээллийг цуглуулдаг байна.[159]

Хүснэгт - 25. Мэдээллийн эх үүсвэр[160]



[159]Мөн тэнд.
[160]Мөн тэнд.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэхдээ “комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ. Уг үнэмлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, нэгтгэсэн "Мэдээллийн нэгдсэн сан"-г бүртгэл, статистикийн төрийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран бүрдүүлж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангана” гэж заасан.[161]

Манай улсад 2023 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 109,949 иргэн байгаагаас нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй 45 мянга гаруй хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр авч байгаа. Халамжийн энэхүү үндсэн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс гадна ахмад настан, одой иргэн, тэжээгчээ алдсан хүүхдүүд, өрх толгойлсон эцэг, эх гээд хүн амын таван бүлгийнхэн хамрагддаг. Халамжийн тэтгэврийг нийт 70 мянга орчим хүн авч байгаагийн 60 гаруй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн. Халамжийн буюу асаргааны тэтгэмжид байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд голчлон хамрагддаг. Тэтгэврээс гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэд асаргааны, амьжиргааг дэмжих, онцгой тохиолдлын гэх мэт тэтгэмжид зохих нөхцөл шалгуур хангасан бол хамрагддаг байна.[162]

Дээрх дурдсан статистик мэдээллээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой статистик мэдээллийг Боловсролын яам, Үндэсний статистикийн хороо хамтран Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлж байна. Үүнд:

- **Тухайн хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн тоо /2024/:**
    - хөгжлийн бэрхшээлтэй 2,150 хүүхэд, үүнээс Улаанбаатар хотод 1,199 хүүхэд, баруун бүсийн аймагт 193 хүүхэд, хангайн бүс 268 хүүхэд, төвийн бүс 313 хүүхэд, зүүн бүс 130 хүүхэд тус тус суралцаж байна;
- **Тухайн хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхдийн тоо /2024/:**
    - хөгжлийн бэрхшээлтэй 6,273 хүүхэд, үүнээс Улаанбаатар хотод 3,255 хүүхэд, баруун бүсийн аймагт 671 хүүхэд, хангайн бүс 1,066 хүүхэд, төвийн бүс 899 хүүхэд, зүүн бүс 382 хүүхэд тус тус суралцаж байна;
- **Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцаж байгаа суралцагчийн тоо /2024/:**
    - 653 суралцагч;
- **Их, дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудын тоо /2024/:**
    - 150,282 оюутнууд;
- **Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчдийн тоо /2022/:** 4,864 байна.[163]

Үндэсний статистикийн хороо болон холбогдох яамдуудын жил бүрийн статистик мэдээллээс гадна дараах судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн статистик мэдээллийг холбогдох чиглэлээр судалгаа явуулах байдлаар бүрдүүлж байна. Үүнд:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл

[161]Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 38 дугаар зүйл.

[162] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудас үзэх- https://mlsp.gov.mn/content/detail/2009.

[163]Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын цахим хуудас үзэх – http://www.gadpwd.gov.mn/ .

ажиллагаа”-ны мэдээллийн 2017 оны лавлахад улсын хэмжээнд хөдөлмөрийн насны 19974 хүн хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй тэтгэврийн насны хүн 3018 байна. Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн 73285[164], улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1599 хүүхэд цэцэрлэгт, 7279 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1637 нь ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцаж байна гэсэн мэдээллийг тусгасан байна. [165]

Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 100,993 хүн байна. Тэдний 40.8 хувь нь төрөлхийн, 59.1 хувь нь ахуйн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй 0-17 насны 10,407 хүүхэд байгаагаас 12.1 хувь нь харааны, 8.3 хувь нь хэл ярианы, 7.6 хувь нь сонсголын, 17,6 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй, 21.2 хувь нь хөдөлгөөний, 9.8 хувь нь хавсарсан бэрхшээлтэй байна гэсэн мэдээллийг тусгажээ.[166]

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”-ны мэдээллийн 2019 оны лавлахад 2018 оны эцэст Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 105.7 мянган иргэн байгаагийн 59.7 мянга нь эрэгтэйчүүд, 46.0 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44.4 хувь нь төрөлхийн, 55.6 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Энэ нь хүн амын дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өндөр байгааг харуулж байна. Улаанбаатар хотын хувьд 2018 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 35.6 мянган иргэн байгаагийн 19.7 мянга нь эрэгтэйчүүд, 15.9 мянга нь эмэгтэйчүүд байна. 0-15 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2357 буюу 20.7 хувиар буурсан, харааны бэрхшээлтэй хүний тоо 1867 буюу 19.3 хувиар нэмэгдсэн, сонсголын бэрхшээлтэй хүний тоо 135 буюу 1.6 хувиар нэмэгдсэн, хэл ярианы бэрхшээлтэй хүний тоо 982 буюу 18.5 хувиар буурсан, хөдөлгөөний бэрхшээлтэй хүний тоо 3187 буюу 17.3 хувиар нэмэгдсэн, сэтгэцийн бэрхшээлтэй хүний тоо 3367 буюу 19.8 хувиар нэмэгдсэн, хавсарсан бэрхшээлтэй хүний тоо 2838 буюу 28 хувиар буурсан, бусад төрлийн бэрхшээлтэй хүний тоо 1382 буюу 4.4 хувиар нэмэгдсэн талаар тусгажээ.[167]

3.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”-ны мэдээллийн 2020 оны лавлахад улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 1076 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байгаа, ерөнхий боловсролын сургуульд 6301 сурагч суралцаж байна гэсэн тоон мэдээлэл тусгагдсан байна.[168]

4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагааны мэдээллийн 2021 оны лавлахад сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж буй, ерөнхий боловсрол эзэмшиж буй, их, дээд сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний статистик мэдээллийг тусгасан байна.[169]

---

[164] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”-ны мэдээлэл, 2017, 23 дахь тал.

[165]Мөн тэнд, 35 дахь тал.

[166]Мөн тэнд, 2017, 73 дахь тал.

[167]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”-ны мэдээлэл, 2021, 17 дахь тал.

[168]Мөн тэнд, 44 дэх тал.

[169]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа, Мэдээллийн лавлах, 38-39 дахь тал.

5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын судалгаанд **"**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны статистик мэдээллээс харахад, Монгол Улсад 108,399 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (ХБИ) байгаа бөгөөд бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийт хүн амын 3.2 хувийг эзэлж байна. Хүйсийн хувьд, 57% нь эрэгтэйчүүд, 43% нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаанаар задлан үзвэл, 43 хувь нь төрөлхийн, 57 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна. Хэдийгээр ХБИ-ийн олонх (78.3%) нь ердийн өвчнөөс үүдэлтэй хөгжлийн бэрхшээл байгаа боловч, үлдсэн 21.7% нь зам тээврийн, үйлдвэрийн болон ахуйн осол, болон бусад шалтгаанаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна" гэжээ.[170]

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээллийг нууцлах, хамгаалах, мөн мэдээллийг зөв зохистой ашиглах, боловсруулах чиглэлд Монгол Улс сүүлийн жилүүдэд томоохон ахиц, дэвшил гаргасан. Тодруулбал, 2021 онд Хүний хувийн мэдээлэл тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулиар хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох харилцааг "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-иар зохицуулсан бөгөөд тус хуулийн мөн 2021 онд баталсан.

Товч дүгнэлт: Дээрхээс үзвэл манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэний статистик мэдээллийг Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар тус тус жил түр гаргаж байгаа боловч одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний статистик мэдээллийн нэгдсэн мэдээлэл гаргадаг, мөн олон нийтэд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тухай бүр танилцуулдаг, нээлттэй мэдээлдэг чиг үүргийг хуулиар хэрэгжүүлэх тусгайлсан бүтэц, байгууллага байхгүй байна. Мөн холбогдох төрийн байгууллагуудаас гадна судалгаа, шинжилгээ явуулах аргаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдсон дата мэдээлэл ихээр бий болж байна.

Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасан "энэхүү конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор бодлого, стратеги боловсруулах, статистик болон судалгааны мэдээллийг оролцуулан шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулах, тэдгээр мэдээллийг тухайн бодлогод ашиглах үүрэг хүлээнэ" гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэгдсэн статистик болон судалгааны мэдээллийг төвлөрүүлсэн санг бий болгох, түүний олон нийтэд нээлттэй байлгах шаардлагатай гэж үзлээ.

Түүнчлэн, Конвенцын 31 дүгээр зүйлийн (а)-д заасан мэдээллийн нууцлалын тухайд, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтад "эрүүл мэндийн мэдээлэл" гэж хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг" гэж заасан бөгөөд тус хуулийн 9.1 дэх хэсэгт зааснаар эрүүл мэндийн мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарахаар хуульчилсныг тэмдэглэв.

Конвенцын 32 дугаар зүйлд заасан Олон Улсын хамтын ажиллагааны тухайд:

Конвенцын 32 дугаар зүйлд:

[170] Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын судалгаа" 11 дэх тал.

1.Оролцогч улсууд нь энэхүү конвенцын зорилт, зорилгыг хэрэгжүүлэх өөрийн үндэсний хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнтэй холбогдуулан улс хооронд үр дүнтэй арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд олон улсын, бүс нутгийн болон иргэний нийгмийн байгууллагууд ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай хамтран ажиллах бүхий л зохистой арга хэмжээг авна. Тухайн арга хэмжээ нь дараах байдалтай байж болно:

a) олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдийг оролцуулан олон улсын хамтын ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамарсан, хүртээмжтэй байх явдлыг хангах;

b) байгаа нөөц бололцоондоо тулгуурлан, түүний дотор мэдээлэл, туршлага, хөтөлбөр болон тэргүүний туршлагуудаа солилцох замаар чадавхыг бэхжүүлэх явдлыг дэмжих;

c) шинжлэх ухаан, техникийн мэдлэг болон судалгаа шинжилгээний салбар дахь хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

d) шаардлагатай тохиолдолд техник, эдийн засгийн туслалцаа, түүний дотор хүртээмжтэй болон туслах технологийг хүртэх явдлыг хөнгөвчлөх, тэдгээрийг өөр хоорондоо харилцан солилцох, түүнчлэн технологийг шилжүүлэх замаар үзүүлэх.

2. Оролцогч аливаа улс энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд энэ зүйлийн заалт аливаа байдлаар нөлөөлөхгүй.

Конвенцын 32 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Конвенцын зорилт, зорилгыг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагааны хэрэгжилтийн хүрээнд манай Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр НҮБХС, Азийн Хөгжлийн Банк (АХБ), Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), БНХАУ-ын засгийн газар, ЮНЕСКО, Дэлхийн банк, Хүүхдийг ивээх сан, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, АИФО Италийн төрийн бус байгууллага, ADRA, Канад сан, Мерси Кор, Европын холбооны “SOCIEUX PLUS” зэрэг олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж хамтран ажиллаж байна.

Олон Улсын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг боловсруулсан бөгөөд эдгээрээс дийлэнх хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэндийг хангахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүд эзэлж байна.

Засгийн газрын бодлого, үйл ажиллагаанд техник, арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг дурдвал:

1.Тусгай хэрэгцээт хүүхдийг нийгмийн амьдралд идэвхтэй, бүтээлчээр оролцуулах, тэгш хамруулан сургах материаллаг орчноор хангах чиглэлээр НҮБХС, Азийн Хөгжлийн банк, Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран дэмжлэг үзүүлж байна. 2018 оны 3 дугаар сард Улаанбаатар хот дахь Япон Улсын элчин сайдын яам, Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар, Японы ХИС хамтран “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь төсөл”-ийг хэрэгжүүлсэн.[171]

[171]“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” Төслийн эцсийн үнэлгээний тайлан, 17 дахь тал.

2.Азийн хөгжлийн банк болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг Монгол Улсын 6 аймгийн ХБИ-ийг хамруулан хэрэгжүүлж байна.[172]

3.Япон Улсын Олон Улсын хамтын ажиллагааны агентлаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хэрэгжүүлэх үүднээс дараах хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төсөл”–ийг хэрэгжүүлэхээр МУЗГ, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамтай хамтран ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дэвшилт гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амжиргаа, нийгмийн оролцоог сайжруулах зорилгын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдүүдэд чиглэсэн.[173]
- “Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран 2016 оноос 2020 он хүртэл хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог сайжруулах, дэмжих зорилгоор хэрэгжиж дууссан.[174]

4.БНХАУ-ын Засгийн газраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран 2017-2020 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-ийн төслийг хэрэгжүүлсэн.[175]

5.БНХАУ-ын Засгийн газраас “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолборын төсөл”-ийг хэрэгжүүлж байна.[176]

6.ЮНЕСКО-ийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хэрэгжүүлэх үүднээс дараах хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж байна.[177] Үүнд:

- 2017 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг олон нийтэд сурталчлах төсөл”-ийг өөрсдийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн бөгөөд төслийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль сурталчлах, хуулийн хэрэгжилтийг хангахад үүрэг хүлээгчдийг чадваржуулах” сургалт зохион байгуулсан.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг бодлого боловсруулагчид, сэтгүүлчид, олон нийтэд сурталчлах” төслийг 2018-2019 онд хэрэгжүүлсэн.

7.Дэлхийн Банкны санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Яамны хэрэгжүүлж буй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл” нь хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх зорилготой. Төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд Завхан, Өвөрхангай, Увс, Дундговь, Орхон аймаг, Баянгол, Сонгинохайрхан, Багануур, Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар,

---

[172] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудас үзэх - https://mlsp.gov.mn/content/detail/1416

[173] Мөн тэнд

[174] “Japan International Cooperation Agency” цахим хуудас, үзэх - https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/015/index.html.

[175]Мөн тэнд.

[176]Сангийн яам цахим хуудас, үзэх - https://mof.gov.mn/article/entry/china-01.

[177]UNESCO Монголын Үндэсний комиссын цахим хуудас үзэх - http://unesco.mn/?page_id=398

хэлтсүүдийн иргэдэд үйлчлэх өрөө, сургалтын танхим, ганцаарчилсан зөвлөгөөний өрөөг бүрэн засварлаж, шаардлагатай тавилга, хэрэгслээр хангасан.[178]

8.Хүүхдийг ивээх сан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хэрэгжүүлэх үүднээс дараах хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж байна.[179] Үүнд:

- Хүүхдийг ивээх сан "Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн малчин эцэг, эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг сайжруулах нь" төслийг 2021-2022 онд Австралийн сайн дурын хөтөлбөрийн нөлөөллийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. Зайн болон явуулын сургалтаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бичиг үсэггүй малчин эцэг, эхчүүдийн унших, бичих, тоо бодох чадварыг дээшлүүлэхээс гадна хүүхэдтэйгээ ажиллах арга барилыг сайжруулах, цаашлаад төслийн үр дүнг бусад орон нутагт түгээн дэлгэрүүлэхэд оршино. Уг төсөл нь Өвөрхангай аймгийн Арвайхээр, Уянга, Хархорин сумдын малчдад чиглэгдсэн байна.
- Өвөрхангай аймгийн Насан туршийн боловсролын төв, Ховд аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх замаар хүүхдийнхээ сурч хөгжих болон сайн сайхан байдлыг дэмжих чадавхыг сайжруулах нь" төслийг 2022-2023 онд санхүүжүүлэн хэрэгжүүлж байна.

9.Шведийн олон улсын хөгжлийн агентлаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хэрэгжүүлэх үүднээс дараах хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- БСШУЯ болон Шведийн олон улсын хөгжлийн агентлаг /SIDA/-тай хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол" төсөл хэрэгжүүлж буй. Уг төслийн хүрээнд нийслэлийн Хан-Уул дүүргийн 46 дугаар цэцэрлэг, ерөнхий боловсролын 15 дугаар сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургууль, цэцэрлэгт сурч, хөгжих загвар орчин бүрдүүлэх зорилт тавьж зарим тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг байна.[180]
- "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг интеграцчилан сургах Данида"төсөл 1994 оноос 1998 онд хэрэгжсэн. 2005-2007 онд Шведийн Олон улсын байгууллага SIDA, БСШУЯны БДБГ- ын дэргэд багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга барилыг нь сайжруулах зорилгоор төсөл хэрэгжүүлсэн. [181]

10.АИФО Италийн төрийн бус байгууллага нь Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Тэгш нийгэм Холбоо ТББ-тай хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх нь" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. [182]

11.ADRA нь "Боловсролын хөтөлбөр" хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй, хараа хяналтгүй, гэмт хэрэгт холбогдсон, алслагдсан аймаг сумдын сургууль завсардсан болон эмзэг бүлгийн айл өрхийн хүүхэд багачууд, залуучуудад нөхөн боловсрол олгох, боловсролынх нь түвшинг ахиулах сургалтууд, адал явдалд суурилсан гадаад орчны сургалтыг зохион байгуулсан. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан Монгол хэлний дохионы анхны толь бичгийг боловсруулах ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн.[183]

---

[178] Дэлхийн Банк цахим хуудас, үзэх - https://www.facebook.com/WorldBankMongolia/photos/a.111733500236954/529881418422158/?locale=ms_MY.

[179] "Save the Children"цахим хуудас, үзэх- https://savethechildren.mn/mn/page/education.

[180]"Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаархи Монгол Улсын анхдугаар илтгэл", 34 дэх тал.

[181]Д.Сарантуяа " Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах аргад хийсэн судалгааны үр дүн, 85 дахь тал.

[182] "МУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх хөтөлбөрийн сайн жишээ"

[183]ADRA Mongolia цахим хуудас - үзэх

12.Канад сан нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хэрэгжүүлэх үүднээс дараах хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж байна.[184] Үүнд:

- Канад сан нь “Хүүхдийн эмнэлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв байгуулах, тохижуулан засварлах, шаардлагатай эрүүл мэндийн тоног төхөөрөмжийг суурилуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах нь” төслийг Ховд аймагт 2021-2022 оны хугацаанд хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хүчил төрөгчийн дутагдлаас сэргийлэхэд хүүхдийн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, 0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгын хүрээнд хэрэгжсэн.
- “Нийгмийн эмзэг бүлгийн ажилгүй эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах зорилгоор хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах, орон нутгийн 0-5 насны хүүхдийг чанартай сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах нь” төслийг хэрэгжүүлсэн.
- “Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг дэмжих үе тэнгийн сурагчдын сайн дурын багийг чадавхжуулж, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан тусгай хөтөлбөр боловсруулах замаар тэгш хамруулан сургах боломжийг нэмэгдүүлэх нь” төслийг Сэлэнгэ аймагт 2019-2020 оны хугацаанд Сайхан сумын Ерөнхий боловсролын сургуультай хамтран хэрэгжүүлсэн.
- “Харааны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадавхжуулах, ингэхдээ орон нутгийн номын санг хэрэгцээт програм хангамж, тоног төхөөрөмжөөр хангах, харааны бэрхшээлтэй иргэдийг цахим технологи ашиглахад зааж сургахад номын санч нарыг сургагч багшаар бэлдэх нь” төслийг 2019-2020 он хугацаанд Дархан-Уул, Дорнод, Увс аймгуудад Хэрэглээний Сэтгэл Судлалын Хүрээлэн ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн.
- “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрүүл мэндийн ажилтнуудыг чадваржуулах замаар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд хүрэх НҮЭМ-ийн үйлчилгээг сайжруулах нь” төслийг Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоотой хамтран Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Өвөрхангай, Хэнтий, Улаанбаатар зэрэг газарт 2015-2016 онд хэрэгжүүлж байсан.
- “Хараагүйчүүдийн брайл хэвлэлийн төвийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран 2014-2015 онд Улаанбаатар хотод хэрэгжүүлж байсан.
- “Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд эрүүл, тэгш эрхийг хангахуйц орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төслийг 116-р сургуультай хамтран 2013-2014 оны хугацаанд хэрэгжүүлсэн байна. Энэхүү төсөл нь дотуур байранд амьдарч буй харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдрах нөхцөл, гадна орчныг сайжруулах зорилготой.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах нь” төслийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхчүүдийн холбоотой хамтран 2009-2010 оны хугацаанд Баянхонгор аймагт хэрэгжүүлсэн.

13.Мерси Кор нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хэрэгжүүлэх үүднээс дараах хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж байна.[185] Үүнд:

---

https://www.facebook.com/profile/100064566794248/search/?q=%D1%85%D3%A9%D0%B3%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D0%B1%D1%8D%D1%80%D1%85%D1%88%D1%8D%D1%8D%D0%BB%D1%82%D1%8D%D0%B9.

[184]Canada-Монгол дахь Канад сан цахим хуудас үзэх- https://canadafundmongolia.mn/2021/11/11/2021-2022/.

[185]“Мерси кор монгол хөгжлийг бүтээлцсэн он жилүүд” нэгдсэн тайлан.

- Мерси Кор нь 2009 онд Монголд анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх” төсөл (FIELD) хэрэгжүүлж эхэлсэн.
- 2010 онд “Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх төсөл“ (FIELD төсөл) хэрэгжүүлж, ХБИ-ийн Эрхийн талаарх НҮБийн конвенцын зарчим, заалтуудыг зам тээвэр, боловсрол, барилгын тухай Монгол улсын хуулиудад тусгасан.
- 2015 онд “Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх II” төсөл (FIELD II) хэрэгжүүлж, ХБИ-ийн байгууллагуудтай хамтран хүртээмжтэй байдлын улсын стандартыг хэрэгжүүлэх, иргэдэд таниулах, ХБИ-ийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, ХБИ-д сонгуульд оролцох боломжийг нь бүрдүүлсэн.

14.Европын холбооны “SOCIEUX PLUS” байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний гэр бүлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр (2023-2025)”-ийг хэрэгжүүлж байна.[186]

Товч дүгнэлт: Конвенцын 32 дугаар зүйлийн хэрэгжилтийн тухайд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах зорилгоор бүс нутгийн болон олон улсын түвшин дэх хамтын ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн хэд хэдэн томоохон төслүүд хэрэгжиж байна. Тодруулбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр НҮБХС, Азийн Хөгжлийн Банк (АХБ), Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), БНХАУ-ын засгийн газар, ЮНЕСКО, Дэлхийн банк, Хүүхдийг ивээх сан, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, АИФО Италийн төрийн бус байгууллага, ADRA, Канад сан, Мерси Кор, Европын холбооны “SOCIEUX PLUS” зэрэг олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж хамтран ажиллаж байгаа нь сайшаалтай.

Хэрэгжилтийн үнэлгээний явцад олон улсын хамтын ажиллагааны явцад хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа нийт 20 орчим төсөл байгаа хэдий ч тэдгээрийг практикт бүрэн хэрэгжүүлж дуусгасан эсэх, мөн хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээний тайлан байхгүй байна. Түүнчлэн 2015 онд хорооноос өгсөн зөвлөмжид дурдсан дээрх төсөл хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах, эд материал, барилга байгууламжаас илүү хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах үйл ажиллагааны талаарх мэдээлэл, энэхүү нөхцөл байдалд дорвитой өөрчлөлт гараагүй байна.

Мөн олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад хэдэн доллар эсхүл төгрөгийн санхүүжилт олгогдсон зэргийг тодруулах шаардлагатай гэж үзлээ.

Конвенцын 33 дугаар зүйлд заасан Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих тухайд:

Конвенцын 33 дугаар зүйлд:

[186]Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын цахим хуудас – үзэх https://www.facebook.com/profile/100064667650624/search/?q=%D1%85%D3%A9%D0%B3%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D0%B1%D1%8D%D1%80%D1%85%D1%88%D1%8D%D1%8D%D0%BB%D1%82%D1%8D%D0%B9

“1.Оролцогч улсууд нь төрийн байгууллагын тогтолцоондоо нийцүүлэн засгийн газартаа нэг буюу хэд хэдэн шатны байгууллагыг энэхүү конвенцыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүрэг гүйцэтгүүлэхээр томилох бөгөөд төрөл бүрийн салбарын төрөл бүрийн түвшинд тухайн асуудлыг зохицуулах механизмыг засгийн газрын бүрэлдэхүүнд бий болгох, томилох боломжийг судалж үзнэ.

2.Оролцогч улсууд нь өөрсдийн эрх зүйн болон засаг захиргааны тогтолцоондоо нийцүүлэн өөрийн улсын хувьд шаардлагатай нэг буюу хэд хэдэн бие даасан механизмыг оролцуулан энэхүү конвенцын хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, хамгаалах ажиллагааг эрхэлсэн бүтцийг шаардлагатай тохиолдолд байгуулах, томилох, бэхжүүлэх, тогтвортойгоор ажиллуулна. Ийм механизмыг байгуулахдаа оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаарх зарчмуудыг анхааралдаа авна.

3. Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэднийг төлөөлөх байгууллагууд ийнхүү хяналт тавих ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох, хамрагдах ёстой.” гэж заасан.

Конвенцын 33 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын хувьд конвенцын хэрэгжилтийг хангах үндсэн байгууллага нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон тус яамны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байна. Энэхүү хоёр байгууллага Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг эдлүүлэх, тэдэнд шаардлагатай нийгмийн болон хууль эрх зүйн баталгааг бий болгох, хангах чиг үүргийг хүлээсэн. Харин албан бусаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан орон тооны бус зөвлөл нь конвенц болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тодорхой төрлийн арга хэмжээ, үйл ажиллагааг салбар дунд удирдан зохион байгуулах, мөн орон нутаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдах зохион байгуулж байна.

Гэсэн хэдий ч конвенц болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжилтийг хангах хариуцлагын механизм Монгол Улсад туйлын дутмаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотойгоор эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд хориглох 6 төрлийн хориглолт (хуулийн 6.1, 9.5, 17.4, 17.5, 28.7, 31.2)-ыг тусгасан хэдий ч эдгээр хориглолтыг зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлага тодорхойгүй байна. Монгол Улсын Зөрчлийн тухай хуульд холбогдох хууль тогтоомжид заасан хориглолтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгасан бөгөөд тус хуульд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах, эрх хэсэх гэсэн 4 төрлийн шийтгэлийг оногдуулахаар заасан.

Харамсалтай нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан хориглосон агуулга бүхий заалтыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлага нь Зөрчлийн тухай хуульд тусгагдаагүй учир тэдэнд шийтгэл оногдуулах ямар ч боломжгүй байна. Ийнхүү конвенцод заасан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тухайлан заасан, энэ төрлийн харилцааны суурь хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд оногдуулах

шийтгэлийн хэлбэр, хэмжээг Зөрчлийн тухай хуульд зааж өгөөгүй учир конвенцыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

Харин дээр дурдсан орон тооны бус зөвлөл нь конвенц болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлд идэвхитэй ажиллаж байгаа бөгөөд тус зөвлөлийн талаарх дараах хэсэгт дэлгэрэнгүй авч үзэв.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 11-р сарын 09-ний өдрийн дугаар 136 “Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай” тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Орон тооны бус зөвлөл”-ийг ажиллах журмыг баталсан.[187] Улмаар энэхүү зөвлөлийн бүтэц, ажиллах журмыг 2022 онд шинэчил, түүнд 2023 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08-р сарын 07-ны өдрийн дугаар 21 “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх батлах тухай” тогтоолын 31 дүгээр хавсралтаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн баталсан.

Зөвлөлийн үйл ажиллагааны талаар судлахад 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дугаар 1 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан бөгөөд тус төлөвлөгөөнд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дэд бүтэц, мэдээллийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, дэд болон салбар зөвлөлийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах гэсэн үндсэн дөрвөн багц үйл ажиллагааны хүрээнд нийт 31 багц ажлыг хийж, хэрэгжүүлэхээр тусгасан байна.[188]

Тэдгээрээс зарим нэгийг тодруулан авч үвэл, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-ийг батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн болон түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулахад шаардагдах хөрөнгийг 2024 оны төсөвт тусгах”, салбартаа болон харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн үнэлгээг төрийн бүх шатны байгууллагад 2023 онд багтаан хийж, 50-иас доошгүй хувийг хүртээмжтэй болгох”, “хөгжлийн бэрхшээлийн суурь шалтгаан, нөхцөлийн талаар үндэсний хэмжээнд судалгаа хийх” зэрэг ажлууд багтжээ.

[187] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенци, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангаж хэрэгжүүлэх, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг салбар дундын зохицуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлэхэд чиглэх бөгөөд тус зөвлөл 2023 оны байдлаар үйл ажиллагаа явуулсаар байна. Зөвлөлийн даргаар Монгол Улсын Сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга ажиллаж байгаа ба зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан байна.

[188] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2022 оны 12-р сарын 01-ний өдрийн №01 тогтоолын нэгдүгээр хавсралт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.

Хүснэгт – 26. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүн /2025/

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журмын 8.1-д зааснаар Зөвлөл нь төрийн захиргааны төв байгууллага /яамдууд/-ын дэргэд дэд зөвлөлтэй байхаар заасан.

Холбогдох яамдуудын дэргэдэх дэд салбар зөвлөлийн хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг энэхүү судалгааны 9 дэх хэсгээс харах боломжтой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах Үндэсний зөвлөлийг 2016 оноос байгуулан ажиллаж байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг салбар бүрт ханган ажиллах, үндэсний зөвлөлд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд болон салбар зөвлөл бүх яам, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллаж байна.

Салбар дундын зохицуулалтыг бүрэн хийхийн тулд 2018 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болох Засгийн газрын хэрэгжүүлэгч

агентлагийг анх удаа байгуулагдсан. Түүнчлэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, дэмжин хөгжихөд хувь нэмэр оруулдаг 600 гаруй төрийн бус байгууллага бий.[189]

Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих чиг үүрэгтэй.[190]

Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар нь Монгол Улсын Их Хурлын 2018 оны 56 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 250 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А\233 дугаар тушаалаар байгуулагдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, салбар дундын уялдаа холбоог хангах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг байна.[191]

Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар харьяалах нутаг дэвсгэртээ дараах эрхийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

- Дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламж, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах, хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, спорт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шат дараалсан арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавnх”-аар хуульчилсан.[192]

Гэсэн хэдий ч конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Барилгын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Авто замын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжуудад тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангахтай холбоотой нарийвчилсан процессын зохицуулалтууд нэн дутмаг байна.

Тэрчлэн 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 45 дугаар зүйлд тус хуулийн хэрэгжилт, хяналттай холбоотой дараах 3 зохицуулалт байна:

45.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

45.1.1.энэ хуулийн 6.5.1, 6.5.2-т заасан зөрчил гаргасан хувь хүнийг, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтад 14 хоногоос доошгүй хугацаагаар хамруулна.

---

[189]Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа, Мэдээллийн лавлах, 2021, 5 дахь тал.

[190]Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг.

[191] Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын албан ёсны цахим хууда үзэх http://www.gadpwd.gov.mn/

[192]Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйл.

45.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд гэм хор, хохирол, хор уршиг учирсан бол буруутай этгээдээр холбогдох хуульд заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлнэ.

Харин 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг зөрчсөн холбоотой аливаа хариуцлага хүлээлгэх заалт байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой 6 төрлийн хориглолт (хуулийн 6.1, 9.5, 17.4, 17.5, 28.7, 31.2) тусгагдсан бөгөөд эдгээр хориглолт бүрийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх нь хуулийн хэрэгжилт, цаашлаад конвенцын хэрэгжилтэд онцгой ач холбогдолтой.

Гэтэл хууль тогтоомжийн уялдаа холбоо хангагдаагүй буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хориглосон үйлдэл гаргасан тохиолдолд холбогдох иргэн, хуулийн этгээдэд ямар хариуцлага оногдуулах нь тодорхойгүй үлдээжээ.

Товч дүгнэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “...энэхүү конвенцын хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, хамгаалах ажиллагааг эрхэлсэн бүтцийг шаардлагатай тохиолдолд байгуулах...”, гэж заасан боловч манай улсад тус конвенцын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавих үүрэгтэй талаар хуульчилсан боловч шууд байдлаар конвенцын хэрэгжилтэд хяналт тавихаар зохицуулсан зохицуулалт байхгүй байна. Харин энэхүү үүргийг албан бусаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл, түүний дэд болон салбар зөвлөл хангаж байгааг онцлох нь зүйтэй. Харамсалтай нь энэ бүтцэд байнгын ажлын алба байхгүй, мөн тодорхой төсөв, мөнгө хуваарилдаггүй тул энэхүү бүтцийг эрх зүйн орчинд албажуулан тусгайлсан ажлын албатай болгож болох юм.

Иймд конвенцын дээрх заалттай нийцүүлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хууль тогтоомж болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэх, хамгаалах ажиллагааг явуулах үүргийг хуульчлах, түүнчлэн тус үүргээ хэрэгжүүлэхдээ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Хорооны зөвлөмж, анхны илтгэлд тусгасанчлан Конвенцын хэрэгжилтийг хянахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудыг бүрэн дүүрэн оролцуулах байдлаар үйл ажиллагаа явуулах, шаардлагатай арга хэмжээ авах, мөн конвенцын хэрэгжилтийг хангах тусгайлсан бүтэц бий болгох, эсхүл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийг ажлын албатай болгох талаар зохицуулж өгөх нь зүйтэй гэж дүгнэв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн төрөл, хэлбэрийг Зөрчлийн тухай хуульд тусгаагүйгээс үүдэн тус хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд хариуцлага оногдуулах боломжгүй байна. Иймд Зөрчлийн тухай хуульд яаралтай холбогдох нэмэлт оруулах хуулийн төслийг

боловсруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зөрчсөн зөрчилд оногдуулах шийтгэлийг тодорхойлох шаардлагатай байна.

ГУРАВ. САЙЖРУУЛАХ, ШИНЭЧЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ

Судалгааны хоёр дахь хэсгийн зүйл, заалтуудын хэрэгжилтийн үнэлгээнээс харахад НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахын тулд хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг даруй арилгах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар зохицуулсан хууль тогтоомжуудын дагалдах батлагдах ёстой дүрэм, журмуудыг батлах болон хууль хэрэгжүүлэх үндсэн механизм болох хариуцлага, шийтгэлийг илүү тодорхой болгох шаардлагатай байна.

Конвенц болон ХБХЭтХ-ийг хэрэгжилтийг хангахын тулд олон тооны хуулийг өөрчлөх, шинэчлэх хэрэгтэй байгаа хэдий яаралтай шинэчлэх, өөрчлөлт оруулах шаардлагатай дараах 11 хууль тогтоомж байна гэж үнэлгээний баг үзлээ. Үүнд:

1. Автотээврийн тухай хууль /1999 он/;
2. Харилцаа холбооны тухай хууль /2001 он/;
3. Дээд боловсролын тухай хууль /2023 он/;
4. Боловсролын ерөнхий хууль /2023 он/;
5. Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай /2008 он/;
6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /2011 он/;
7. Нийгмийн халамжийн тухай /2012 он/;
8. Авто замын тухай /2017 он/;
9. Зөрчлийн тухай /2017 он/;
10. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /2019 он/;
11. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /2021 он/.

ДӨРӨВ.ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ГАДААД УЛС ОРНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1.АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль (ADA)

Энэ хуулийн үндэс нь 1973 оны сэргээн засах тухай хуулийн 504 дүгээр хэсгээс эхтэй. АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулиар **х**өгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрлөх, нийтийн үйлчилгээ хүртэх, нийтийн албан байгууллагаас үйлчилгээ авахад ялгаварлан гадуурхахыг хориглосон. Үүнээс гадна 1975 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хууль (IDEA) үйлчилдэг. 1990 онд баталсан АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль нь хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахыг хориглосон иргэний эрхийг баталгаажуулсан хууль юм. (42 U.S.C. § 12101) 1964 оны иргэний эрхийн тухай хуульд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний ялгаварлан гадуурхагдахаас хамгаалахтай адил зохицуулалтыг агуулдаг: арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, угсаа гарал, бусад хууль бус шинжээр ялгаварлан гадуурхахыг хориглоно. Уламжлалт ойлголт дээр энэхүү хуулиар нэмж, ажил олгогчийг тухайн ажилтанд тохирсон тоноглолоор хангах, нийтийн барилга байгууламжийн хүртээмжийн асуудлыг зохицуулсан. 1986 онд Хөгжлийн бэрхшээлийн үндэсний зөвлөл энэхүү хуулийн төслийг зөвлөмж болгосноор 1988 онд сенат ба конгресст танилцуулсан. Сүүлийн хувилбараар 1990 оны 07 сарын 26-нд батлагдсан. 2008 онд өөрчлөлт оруулсан ба нэмэлт өөрчлөлт 2009 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болж үйлчилжээ. Хуулийн бүтэц нь 1. хөдөлмөр эрхлэлт, 2. нийтийн байгууллага (нийтийн тээвэр)

3.нийтийн тоноглол (бизнесийн байгууламж) 3.1 үйлчилгээний амьтан 4. телекоммуникаци 5. бусад асуудал хэмээх бүтэцтэй.

Энэ хуулиар хөгжлийн бэрхшээл гэдгийг биеийн болон оюуны бэрхшээлийг ойлгоно хэмээн заасан. Хөгжлийн бэрхшээл нь заавал үргэлжилсэн байнгын эсхүл хүнд хэлбэрийн байхыг шаардахгүй. Тэгш хөдөлмөрлөх боломжийг хангах комиссын баталсан журмаар хөгжлийн бэрхшээлийг дараах байдлаар ангилна: дүлий, хараагүй, оюуны бэрхшээл, хэсэгчлэн эсхүл эрхтэн дутуу эсхүл хөдөлгөөний хязгаарлалтын улмаас тэргэнцэр ашиглах, аутизм, хавдар, цус харвалт, чихрийн шижин, эпилепси, ХДХВ халдвар, мэдрэлийн хавсарсан эмгэг, булчингийн сулрал, сэтгэл гутралын хүнд эмгэг, биполар эмгэг, өнгөрсний траума стрессийн эмгэг, албадсан зуршлын эмгэг, шизофрени.

Үүнээс өөр бусад биеийн болон оюуны нөхцөл байдал тухайн хувь хүний илрэх симптомоос хамаараад "зовиурыг багасгах" (эмчилгээ, засал, туслах хэрэгсэл, нөхөн сэргээх бусад чиг үүрэг бүхий бусад хэрэгсэл), "идэвхижсэн үе шат"-анд байгаа үед хөгжлийн бэрхшээл гэж үзэх боломжтой. Зарим тусгай нөхцөл болох нийгэмшээгүй, хууль бус үйлдэл хийх зуршилтай, хүүхэд сонирхогч гаж зуршил, өөрт хэрэггүй эд зүйл хулгайлах зуршил, бэлгийн гаж зуршил зэрэг нь "хөгжлийн бэрхшээл"-д хамаарахгүй. Мөн хүйсийн өөрчлөлт зэрэг бусад онцлог нөхцөл ч хөгжлийн бэрхшээлд хамаарахгүй.

I дүгээр бүлэг—Хөдөлмөр эрхлэлт 42 U.S.C. §§ 12111–12117.

Энэ хууль нь "хамаарах ААН"-д үүрэг хүлээлгэсэн. Ажилд орох хүсэлт гаргах явц, ажилд томилох, ажилтны хөгжил, дэвшил, ажлын сургалт, давуу талуудыг зохицуулна. "Хамаарах ААН" гэдэг нь 15 ба түүнээс олон ажилтантай ажил олгогчийг, ажил олгох агентлаг, хөдөлмөрийн байгууллага болон хөдөлмөр-менежментийн хамтарсан хороог ч багтаана. Энд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуулт асуух талаар шууд хязгаарлалт үйлчлэх бөгөөд эмнэлгийн үзлэг, эмчилгээний мэдээллийн нууцыг хадгалах үүрэг хүлээнэ. Холбогдох ААН-үүд нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж ажил гүйцэтгэх нэмэлт тоноглолоор хангах үүрэг хүлээнэ. Шаардлагатай нэмэлт тоноглол гэдэг нь ердийн ажлын байр, ажлын тоног төхөөрөмж, хэрэгслийг уг ажлыг гүйцэтгэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгайлсан хэрэгцээ шаардлагад тохируулан өөрчлөлтийг төлөвлөн, улмаар түүнийгээ хэрэгжүүлэхийг ойлгоно.

Ихээхэн хүндрэлтэй бий болгох, эсхүл маш их зардлаар бий болгохоор тусгай тоноглол хэрэгтэй бол түүнийг ажил олгогч заавал хангах үүрэг хүлээхгүй. Тусгай тоноглолоор хангагдсан ажилтан ажлын хамгийн гол чиг үүргийг гүйцэтгэх үүрэгтэй, ажил гүйцэтгэх ердийн шаардлагыг хангах ёстой болно. Хар тамхи хэрэглэдэг ажилд орох хүсэлт гаргагчийг ажил олгогчийн шаардлага хангахгүй гэж үзнэ. 15-аас дээш ажилтантай ажил олгогч бүх ажилтандаа шаардлагатай тоноглолыг хангахад шударга хандах үүрэгтэй. Хэдийгээр тухайн ажилтан ажил үүргээ хангалттай гүйцэтгэж байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүний бүх стандартыг ажил олгогч дагах үүрэгтэй.

АНУ-ын Дээд шүүхээс *Board of Trustees of the University of Alabama v. Garrett* хэрэгт зарим мужуудын бие даасан байдлыг тодорхойлох Үндсэн Хуулийн 11 дүгээр нэмэлтэд заасан эрхийг 1 дүгээр бүлэг хөндсөн, үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзсэн. Шүүхээс мужийн ажил олгогчид АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль зөрчсөн гэдэгт үндэслэж болохгүй гэсэн. Харин ажилтан Холбооны Хууль зүйн департмент эсхүл Хөдөлмөрлөх тэгш боломжийг хангах комисст өөрсдийн нэрийн өмнөөс гомдол мэдүүлэх эрхтэй гэжээ.

II дугаар бүлэг—нийтийн албан байгууллага (нийтийн тээвэр) *42 U.S.C. §§ 12131–12165*.

Энэ хуулийн хоёрдугаар бүлэг нь нийтийн бүх албан байгууллага, хот, тосгон, дүүрэг, мужийн түвшний бүх сургууль хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахыг

хориглоно. 2 дугаар бүлэг нь албан байгууллагаас үзүүлдэг үйлчилгээ, хөтөлбөрт оролцох, хамрагдах боломжийн талаар зохицуулсан. Хүртээмж нь АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн хүртээмжийн стандартыг дизайнд заасан биеийн хувьд болон ялгаварлан гадуурхаагүй бодлого, үйл ажиллагаанд илрэх хөтөлбөрийн хүртээмж байх ёстой. 2 дугаар бүлэг нь нийтийн тээврийн хэрэгслийг Тээврийн департментийн зохицуулалтанд нийцсэн байдлаар хүртээмжийг бий болгохоор зохицуулсан. Үндэсний төмөр замын зорчигчдын корпораци (Amtrak), бусад холбогдох байгууллагууд мөн хамаарна. Энэхүү хэсэг нь нийтийн албан байгууллага нь замын үйлчилгээг, дамжих, суух үйлчилгээг бий болгохыг шаарддаг. Хуулиар нийтийн тээврийн хэрэгслээр зай талбайн хувьд тэргэнцэртэй явж болох хамгийн бага түвшний стандартыг байгуулахыг заасан. 2 дугаар бүлэг нь холбооны улсын болон муж улсын, орон нутгийн орон сууц, орон байрны тоноглол, мөн орон байрны зааварчилгааны талаар агуулсан байна. Орон байр болон тэгш боломжийн оффис нь энэхүү зохицуулалтын хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй.

Үйлчилгээний амьтан

Хуулиар үйлчилгээний амьтаныг (сургасан амьтан) тодорхой зохицуулжээ. Зааварчилгаа нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамгаалахад зориулсан төдийгүй өөрийн байрандаа үйлчилгээний амьтаныг байршуулах бизнес эрхлэгчийн эрсдлийг багасгахад чиглэдэг. Бизнес эрхлэгч нь тухайн амьтныг үйлчилгээний сургасан амьтан мөн эсэх, ямар нарийн ур чадвар гүйцэтгэх чадвартай болохыг асуух эрхтэй боловч харин тухайн амьтныг ямар нэг үүрэг гүйцэтгэхийг хүсэх, эсхүл амьтны тусгай үнэмлэх шаардах эрхгүй. Түүнчлэн тухайн иргэний хөгжлийн бэрхшээлийн төрлийг асуух эрхгүй. Дараах хоёроос бусад тохиолдолд орон байрнаас хөөх эрхгүй: амьтан нь хяналтаас гарч, эзэн нь түнийгээ хянах чадваргүй бол (нохой ресторанд ороод хяналтгүй архирах г.м) эсхүл амьтан бусад хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд аюул заналхийлж байгаа.

Аллерги болон айдас нь бусад хүмүүсийн эрүүл мэнд болон аюулгүй байдалд хамаарахгүй, өөрөөр хэлбэл энэ үндэслэлээр амьтантай байхыг хориглох боломжгүй. Бизнес эрхлэгчид хэдийгээр ердийн үеийн журмаар амьтан нэвтрүүлэхийг хориглодог байлаа ч хоолны үйлчилгээ үзүүлдэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүнийг амьтныг хамт нэвтрүүлэх үүрэгтэй. Энэ тохиолдолд бизнес эрхлэгч нь амьтны хоол бэлдэх, ариун цэврийн өрөөнд тусдаа талбай гаргаж өгөх үүрэг хүлээхгүй. Үйлчилгээний нохойтой орсоны төлөө илүү төлбөр нэхэмжлэх эрхгүй, эсхүл шударга бусаар ганцааранг бусад хүнээс тусгаарлаж суулгах ёсгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь бусад ердийн хүнээс "дор" ямар ч үйлчилгээ хүртэх ёсгүй. Хэдийгээр ийм төрлийн бизнес эрхлэгч нь хүний улмаас учруулсан хохирлыг хариуцдаг хэдий ч харин хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө амьтнаас өмчид нь учруулсан хариуцлага хүлээнэ.

III дугаар бүлэг—нийтийн байгууламж (үйлчилгээний төхөөрөмж) *42 U.S.C. §§ 12181–12189.*

АНУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль нь нийтийн байгууламжинд нэвтрэх барилгын стандартыг тогтоосон. 3 дугаар бүлгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийн улмаас нийтийн газар дээр түрээслэж, өмчилж, эсхүл хамтран ажиллаж буй этгээдээс ямар ч хүн бараа, үйлчилгээ, байгууламж, эсхүл тоноглолын хувьд ялгаварлан гадуурхагдахгүйгээр бүрэн, тэгш хүртэх эрхтэй болохыг тусгасан. Нийтийн байгууламж гэдэгт зочид буудал ба дэн буудал зэрэг ч хамаарах бөгөөд тээвэр, боловсрол, хоолны газар, дэлгүүр, үйлчилгээний газар, амралтын зэрэг ихэнхи орон байрыг ойлгоно. Мөн нийтийн зар мэдээг хамааруулан ойлгоно.

3 дугаар бүлгийн хүрээнд 1992 оны 7 дугаар сараас хойшхи бүх шинэ барилга, өргөтгөл, өөрчлөн засварлах ажил нь энэ хуульд ишлэсэнээр Хөгжлийн бэрхшээлтэй

америк хүний хүртээмжийн зааварчилгаа (Americans With Disabilities Act Accessibility Guidelines)-нд нийцсэн байхыг шаардана.

Энэ хуулийн 3 дугаар бүлэг нь өмнө баригдсан барилга байгууламжинд мөн үйлчлэхээр заасан.3 дугаар бүлэгт хэрэглэсэн "ялгаварлан гадуурхалт" гэдэг нь барьсан барилга, байгууламжин дахь архитектурын саадыг "зайлуулахгүй байгаа"-г хэлнэ хэмээн заажээ. 42 U.S.C. § 12182(b)(2)(A)(iv). Өөрөөр хэлбэл барилга байгууламжийг нийцүүлж өөрчлөх, засварлах, өргөтгөх нь энэ хуулийн дагуу үүрэг болгосон билээ. Хуулиар тогтоосон стандарт нь "саад бэрхшээлийг зайлуулах" товчхондоо Хөгжлийн бэрхшээлтэй америк хүний хүртээмжийн зааварчилгааны (ADAAG) дагуу "хялбар хэрэглэхүйц",,, тухайлан тодорхойлсоноор "...их хэмжээний хүндрэл, бэрхшээл эсхүл зардал гаргалгүйгээр хялбар байдлаар гүйцэтгэх". Хуулийн "хялбар хэрэглэхүйц байдал" гэдэг нь түүнийг засварлахад гарах зардал ба тухайн бизнес эрхлэгч эсхүл өмчлөгчийн амин зуулга хоёрыг харьцуулдаг. Тиймээс "хялбар хэрэглэхүйц байдлыг" санхүүгийн чадвартай корпорацид боломжтой, харин жижиг, орон нутгийн бизнесийн хувьд боломж муутай байх магадлалтай. Тиймээс ч энэхүү бүлэгт дараах тусгай зохицуулалтыг оруулжээ. хувийн клуб, шашны байгууллага нь энэхүү бүлгийн дагуу үүрэг хүлээхгүй. Түүхэн өмчид хамаарах жагсаалтанд багтах газар, байгууламжийн тухайд гуравдугаар бүлгээр зохицуулсан стандартыг байж болох боломжтой хувилбараар хангах үүрэг хүлээлгэсэн. Ингэхдээ "түүхэн ач холбогдолтой тухайн барилгын ирээдүйн нөхцөл байдлыг муутгахгүйгээр хамгаалах"-ын тулд "өөр хувилбарын стандарт"-ыг ашиглаж болно гэж зөвшөөрсөн. 2010 онд Хууль зүйн департментын оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бассейн, спа, жакузи нь орц, гарц болон усан сан луу орох боломжтой байх ёстой гэсэн зохицуулалт оруулсан. Гэсэн хэдий ч ""хялбар хэрэглэхүйц байдлыг" лифтийг засаж, тоноглосоноор ч орц, гарцыг дэмжиж байна гэж ойлгож болно гэж үзсэн. Бусад шаардлагын тухайд бассейны хэмжээнээс хамаарч орц, гарцыг байгуулна гэдгийг Section 242-ын дагуу бий болгохыг ойлгож байна. Тухайн үйлчилгээ эрхлэгч нь энэхүү журмыг хэрэглэхдээ бассейн нь шинэ хуучин эсэхээс үл хамааран хэрэгжүүлэх боломжийг сонгож болно. Өмнө барьсан байгууламжийн хувьд бүрэн гүйцэт стандартыг дагахыг шаардахгүй (Section 242 and 1009 of the 2010 Standards)

IV дүгээр бүлэг—харилцаа холбоо

Энэ хуулийн 4 дүгээр бүлэг нь 1934 оны харилцаа холбооны тухай хуулийн зохицуулалт дээр нэмж 47 U.S.C. § 225 -ийн зохицуулалт оруулсан. Энэхүү хэсэг нь АНУ дахь харилцаа холбооны компаниуд хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид тохирох шаардлагатай чиг үүргийг нэвтрүүлэх үүрэгтэй, ялангуяа дүлий болон муу сонсдог, эсхүл хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүний тухайд зориулахыг онцолдог. Нийтийн цахилгаан бичгийн машин (TTY), дүлийн хүнд зориулсан цахилгаан харилцаа холбооны бусад машиныг (TDD) суурилуулах зохицуулалт бүхий 4 дүгээр бүлэг нь 1990 оны эхээр хүчин төгөлдөр үйлчилж эхлэсэн. 50 муж улс болон Колумби дүүрэгт хоёр-шугам бүхий сателлит гэдгээрээ нэрлэгдсэн үйлчилгээг (TRS, STS) бий болгохоор үүрэг болгосон. Өнөөдөр телекоммуникацийн дамжуулалтын тухайд өргөн нэвтрүүлгийн шугамыг ашиглан интернэтээр дамжуулан хэрэглэгчид түлхүү болоод байна. Видео дамжуулалтын үйлчилгээ нь бичгийн хэлбэрээр бичвэрийг дамжуулдаг. Бусад боломж нь хэлмэрч туслаж дохионы буюу бичгийн хэл рүү орчуулдаг. 2006 онд Холбооны харилцаа холбооны комиссын мэдээгээр видео дамжуулалтын үйлчилгээг сард дунджаар 2 сая минут хэрэглэж байгаа ажээ.

V дугаар бүлэг—бусад зохицуулалт *42 U.S.C. §§ 12201–12213*

5 дугаар бүлэг техникийн бусад зохицуулалтыг агуулдаг. Тухайлбал, 504 дэх хэсгийг нэмэлт өөрчлөлт хийх, хүчингүй болгохгүй байх, цуцлахгүй байхыг тусгасан. ХБИ-ий эсрэг албадлага хэрэглэх, хүч хэрэглэхийг мөн энэ хэсэгт зохицуулсан. III-3.6000 дахь

заалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүнд тусалж буй бусад этгээдээс өөрсдийн эрхийг бүрэн эдлэх, ямар нэг албадлагаас ангид байх эрхтэй болохыг зааж, хувь хүн, хуулийн этгээдээс айлгах, заналхийлэх, бусдын хэрэгт оролцохыг хориглосон байна.

2008 оны нэмэлт өөрчлөлт

Хөдөлмөрлөх тэгш боломж хангах комиссоос 1990 оны хуулийн хөдөлмөр эрхлэхэд хамаарах хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох үүрэг хүлээсэн. Энэ дагуу комиссоос амьдралын үйл ажиллагаанд "их эсхүл үлэмж хязгаарлагдсан" хувь хүний байдлыг зохицуулсан тайлбар гаргасан. Гэтэл хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Хөдөлмөрлөх тэгш боломж хангах комиссыг "их эсхүл үлэмж хязгаарлагдсан" гэдгийн оронд "ихээхэн хязгаарлагдсан" хэмээх илүү амьдралд нийцэх стандартаар солихыг зааварчилсан. 2008 оны 9 дүгээр сарын 25-нд нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь "хөгжлийн бэрхшээл" гэдгийг өргөжүүлсэн. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь энэ хуульд олон хүнийг хамааруулахаар өөрчлөлт болсоныг онцолсон. Энэ хууль нь "амьдралын гол үйлдэл", тодруулбал, өөрийгөө асрах, ердийн үйлдэл гүйцэтгэх, харах, сонсох, идэх, унтах, алхах, зогсох, өргөх, тонгойх, ярих, амьсгалах, сурах, унших, төвлөрөх, бодох, харилцах, болон ажиллах үйлдэл, мөн түүнчлэн биеийн үндсэн чиг үүргийг эрхтэн хамтран гүйцэтгэх зэрэг хамаарахыг ойлгох бөгөөд зөвхөн дээр дурдсан үйлдлээр хязгаарлагдахгүй болохыг тусгажээ. Энэхүү 1999 оны Холбооны дээд шүүхийн шийдвэрээр ажилтны үйлдлийн хязгаарлалт нь хэрэв нэмэлт арга хэмжээ авснаар залруулж болохоор бол түүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үзэхгүй, ийм ажилтны хязгаарлалтын тухайд сайжруулах арга хэмжээг үл харгалзан тодорхойлох ёстой гэжээ. Энэхүү шүүхийн хязгаарлалтын гортиг нь ийм төрлийн амьдралын гол үйлдэл хязгаарлагдмал байгаа тохиолдолд тухайн ажилтныг хөгжлийн бэрхшээлтэй гэж болно гэдгийг харгалзсан. 2008 онд Боловсрол, Хөдөлмөрийн АНУ-ын комисс нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг тус хуулийг туйлын тодорхой болгож байгаа бөгөөд холбогдох хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлагдахгүй хамгаалагдах боломжтой боллоо хэмээн тэмдэглэсэн байна. Ийнхүү дээрхи нэмэлт өөрчлөлт оруулсанаар хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг илүү өргөн хүрээнд авч үзэхээр зохицуулжээ.

Шүүмжлэл дагуулсан сэдэв

Хөдөлмөр эрхлэлт

Энэ хууль гарсанаар хби-ийн хөдөлмөр эрхлэлт буурна, бизнес эрхлэгчдэд санхүүгийн нэмэлт дарамт үзүүлнэ, хуулийн эрсдэлтэй үр дагавар бий болгоно, тиймээс ихэнхи ажил олгогч чимээгүйгээр энэ хуулийг дагахгүй хэмээн үзэж байв. 1991-1995 оны хооронд хб-тэй эрэгтэй хүний хөдөлмөр эрхлэлт 7.8 хувь буурсан. 2003 онд цалин, хөдөлмөр эрхлэлтийн хувьд урт хугацаан эерэг үр дагавар харагдахгүй байсан бол 2005 оноос хби-ийн хөдөлмөр эрхлэлт 45 хувьд хүрчээ.

"Мэргэжлийн заргалдагч"

Энэ хууль гарснаар хөдөлмөр эрхлэлтийн салбарын шууд нэг хэсэг болсон. Хуулийн дагуу орц, гарцыг болон хүртээмжийг бий болгох үүргээ биелүүлээгүй эсхүл ажил олгогчийн хувьд үүргээ биелүүлээгүй аан-ийг хувь хүн шүүхэд өгөх эрхтэй, гэхдээ түүнд ямар ч санхүүгийн ашиг тус шууд очихгүй. 3 дугаар бүлэгт заасан өмгөөлөгчийн хөлс нөхөн олгогдох учир хуульчдын хувьд мэргэших нэг сэдэл болсон. Шүүхээс тэмдэглэснээр энэ хууль гарснаар цөөн тоогоор нэхэмжлэгчдийн тоо нэмэгдсэн, гэхдээ энэ нь хуулийн хэрэгжилтийг хангуулахад чухал ач холбогдолтой билээ. 1998 оны сүүлээр гомдлын 86 хувь ажил олгогчид мөнгөн дарамт учруулахгүйгээр шийдвэрлэжээ.

"Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хууль" 2006, (Individual Disability Education Act Improvement Act, IDEA)[193]

АНУ-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлуудыг зохицуулсан гол хууль нь 2006 онд шинэчлэгдэн батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хууль" юм. Тус хуульд хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй эрсдэлтэй хүүхдийг илрүүлэх, үнэлэх, оношлох, тодорхойлох, боловсролын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бүхий л зохицуулалтыг тусгаснаараа АНУ-ын гол эрхзүйн баримт бичиг болж байна. Энэ хуулийн гол үзэл санаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол үнэ төлбөргүй, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд (ГСТ) суурилан хүртээмжтэй хувилбараар, үүнийг хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын суурь хөтөлбөрт аль болох олон талаараа оролцоотой байлгах зарчимд суурилсан байдаг. ГСТ нь тухайн хүүхдийн онцлог, тусгай хэрэгцээ нь ердийн сургалтын хөтөлбөрөөр суралцахад ямар хүндрэл учруулж байгааг тодорхойлон, ердийн хөтөлбөрийн дагуу суралцахад шат дараатай, хэмжигдэхүйц зорилтуудыг дэвшүүлэн, хүүхдэд гарч байгаа ахиц дэвшлийг тогтмол үнэлж байхаар боловсруулагддаг байна. Энэ хуулиар хөгжлийн бэрхшээлийг дараах 13 төрөлд ангилж үзжээ.

- Оюуны бэрхшээл
- Хараа, сонсголын эмгэг *(хоёулаа нэг дор)
- Хэл ярианы бэрхшээл
- Харааны бэрхшээл
- Сэтгэлзүйн эмгэг/ Serious emotional impairment
- Суралцах бэрхшээл
- Хөгжлийн хоцрогдол
- Хавсарсан бэрхшээл
- Тулах эрхтний бэрхшээл/Orthopaedic
- Сонсголын эмгэг
- Тархины гэмтэл
- Аутизм
- Бусад эрүүл мэндийн эмгэгүүд

[193] Г.Жаргалмаа,Д.Одгэрэл, IRIM судалгааны төв, Боловсролын их сургууль, " ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ ҮЗЭЛ САНААНЫ ХҮРЭЭНД БОЛОВСРОЛЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДИЙГ ҮНЭЛЖ БУЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА",2018.07.03-ны онол, практикийн бага хурлын илтгэл

Үнэлгээний үе шат

Боловсролын үнэлгээ нь дараах 4 үндсэн үе шаттайгаар хэрэгжиж байна:

- Тухайн хүүхдэд тусгай хэрэгцээт боловсролын (ТХБ) үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлох
- Тохирсон ГСТ боловсруулах
- ГСТ-ний явцыг үнэлэх
- 3 жил тутам тухайн хүүхдэд үргэлжлүүлэн ТХБ-ийн үйлчилгээ шаардлагатай эсэхийг давтан үнэлдэг.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө: ГСТ нь тухайн суралцагч, түүний эцэг эх, багш нар хамтран боловсролын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн жилийн сургалтын төлөвлөгөө, зорилго зорилтыг тодорхойлсон суралцах болон заах аргазүйн гол хэрэглэгдэхүүн юм. Эхний үнэлгээнээс гарсан бүх зөвлөмжийг ГСТ-д тусгах бөгөөд тус төлөвлөгөө нь цаашид үнэлгээг үргэлжлүүлэн хийх, сургалтын зорилго зорилтыг багшид таниулах гол зааварчилгаа болдог. ГСТ–г хүүхдийн хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалсан тусгай хэрэгцээтэй уялдуулж боловсруулдаг. Ихэнх улсад ГСТ боловсруулах аргыг өргөн ашиглаж байгаа бөгөөд дор дурдсан асуудлуудыг тус төлөвлөгөөнд зайлшгүй анхаарах шаардлагатай гэж үздэг:

- Тухайн хичээлийн жилийн зорилго (хэмжигдэхүйц)
- Тухайн хүүхдийг ердийн сургалтын хөтөлбөрт хамруулах стратеги
- Хүүхдийн хөгжлийн явцын тэмдэглэл
- Эцэг эхчүүдийн оролцооны талаарх зааварчилгаа
- Эцэг эхчүүдэд мэдээлэл хүргэх заавар (тухайлбал, тайлагнах карт ашиглах гэх мэт)
- Сургалтын төлөвлөгөөг жилийн турш үнэлэх, шинэчлэх заавар

Хүснэгт – 27. Боловсролын үнэлгээний үе шат, Боловсролын тэнхим, Массачусетс муж, АНУ

ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ
• Сурагч, эцэг эх болон бусад мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх • Хэл, соёлын ялгаатай байдлыг нь харгалзаж авч үзэх • Сурагчийн хувийн хэрэгтэй нь танилцах • Сурагчийн сурлагын түүхтэй танилцах • Олон талын орчинд хүүхдийг ажиглах • Сургалтын хөтөлбөрийн дагуу сурагчийн гүйцэтгэлийг үнэлэх • Сурагчийн суралцах арга барил, онцлогийг тодорхойлох
СУРАГЧИЙН ДАВУУ ТАЛ БОЛОН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ
ГСТ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ
• Сургалтын нэмэлт дэмжлэг, нэмэлт сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан ашиглах • Сургалтын хөтөлбөрт хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцүүлсэн зохицуулалт, тохируулгуудыг хийх • Багшийн хүүхэдтэй ажиллах арга, сургалтын материал, сургалтын орчинд хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэн шаардлагатай өөрчлөлтүүдийг нэвтрүүлэх
4-6 долоо хоногийн дараа дээрх арга хэмжээний үр нөлөө, сурагчид гарч байгаа өөрчлөлтөд үнэлгээ хийнэ

Асуудал шийдэгдсэн	Асуудал хэвээр байсаар байгаа буюу хүүхдэд өөрчлөлт гараагүй	Асуудал хэвээр байсаар байгаа бөгөөд хүүхдийг хөгжлийн ямар нэг бэрхшээлтэй гэж таамаглаж байгаа
	Сургалтын өөр бусад олон талт хувилбарыг нэвтрүүлэх эсвэл сургуулиас гадуурх интервенцийг үзүүлэх	Тусгай боловсролын мэргэжлийн үнэлгээний төвд хандах

Source: Massachusetts Department of Education, 2001

Оролцогч талууд

Үнэлгээний багийг бүрдүүлэх гол зарчим нь хүүхдийн амьдралд хамгийн оролцоотой, хүүхдийн талаар хамгийн сайн мэдээлэлтэй байж болох талууд болон ТХХ-ийн үнэлгээний мэргэжилтэн гэсэн үндсэн 2 төрлийн хүмүүсээс бүрдүүлнэ. Нийтлэг туршлагаар үнэлгээ хийх багт ангийн багш, тусгай боловсролын багш, сургуулийн сэтгэл зүйч, хүүхдийн эмч, эцэг эх асран хамгаалагч, шаардлагатай гэж үзвэл тухайн хүүхэд, мөн түүнчлэн харьяа орон нутгийн нийгмийн ажилтан нараас бүрдсэн баг үнэлгээг хийж гүйцэтгэж байна. Үнэлгээний үйл явц дахь талуудын оролцоог авч үзвэл:

- Хамгийн анхан шатны илрүүлэлт, албан бус үнэлгээг хийх хүн нь ангийн багш, сургуулийн эмч, сэтгэл зүйч нар байна. Хүүхэдтэй ажиллах явцад хөгжлийн ямар нэг бэрхшээл, эрсдэл байна гэж үзвэл хүүхдийн хөгжил, зан үйлд албан ёсны ажиглалт (formal observation), анхан шатны сорил үнэлгээ хийх, нэмэлт даалгавар өгч ажиллуулах зэргээр хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулж, хүүхдийн хувийн мэдээллийн хавтас үүсгэнэ.
- Багш, сэтгэл зүйч, сургуулийн эмч нар анхан шатны үнэлгээний үр дүнг хүүхдийн эцэг эхэд мэдэгдэж цааш албан ёсны мэргэжлийн үнэлгээний багт хандах эсэх зөвшөөрөл авна.
- Эцэг эхийн зөвшөөрөлтэйгөөр мэргэжлийн үнэлгээний багт хүсэлт гаргах ба хүсэлтийг хуулийн дагуу 60 хоногийн хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй.
- Мэргэжлийн үнэлгээний баг хүүхдийн хавтаст хэрэг, сургууль, гэр бүл, анги хамт олон зэрэг нийгмийн бүхий л орчны хүчин зүйлийг харгалзан, хүчин төгөлдөр, стандарчилагдсан аргачлалуудын дагуу үнэлгээг хийж эхэлнэ. Боловсролын үнэлгээг хичээлийн анги танхим, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, олон нийтийн дундахь амьдрал зэрэг хүүхдийн бүхий л орчинг харгалзаж хамгийн бодитой, үндэслэлтэй мэдээлэл цуглуулахыг зорьдог. Хүүхдийн насны онцлог, үе тэнгийнхэн, гэр бүлийн нөхцөл байдал, нийгэм орчны нөлөөлөл зэргээс шалтгаалж хүүхдийн хөгжил, төлөвшил тогтмол өөрчлөгдөж байдаг тул дээрх гадны хүчин зүйлсийг үнэлгээнд зайлшгүй харгалзах шаардлагатай гэж үздэг байна.

Үнэлгээ нь нэг удаагийн эсвэл нэг аргачлалын дагуу тодорхойлогдох үйл явц биш бөгөөд тодорхой хугацаа, хүчин чармайлт, санхүүгийн тодорхой нөөц, мэргэжлийн хүмүүсийн оролцоо шаарддаг үйл явц болох нь дээрх процессоос харагдаж байна.

Үнэлгээний аргачлал

Бүх нийтэд боловсролыг хүртээмжтэй олгох олон улсын чиг хандлагатай холбоотойгоор үнэлгээний хандлагууд сүүлийн жилүүдэд багагүй өөрчлөгдөж байгаа. Уламжлалт

үнэлгээний чиг хандлага нь тодорхой хэм хэмжээ гарган тухайн шаардлагад ТХХ хүрэх эсэх ганцхан шалгууураар үнэлдэг байсан бол шинэ хандлагаар үнэлгээ хийхдээ хүүхдийн талаарх олон талт эх сурвалжуудаас цуглуулсан мэдээлэлд үндэслэн давуу болон сул талыг нь харгалзан үзэх болжээ. Хүүхдийн хөгжлийг үнэлэхдээ хүүхдийн нөхцөл байдалд үндэслэн байж болзошгүй гэж үзэж байгаа хөгжлийн бүхий л хүрээг хамран, олон талын эх сурвалжийн мэдээллийг ашиглан хүчин төгөлдөр, найдвартай үнэлгээний хэрэглэгдэхүүнийг ашиглан мэргэшсэн боловсон хүчний удирдлага дор төрөлх хэл дээр зохион байгуулна. (Salvia et.al., 2010)

Үнэлгээний баг хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулахдаа асуумж (questionnaire), шалгах хуудас (checklist), хөгжлийн үнэлгээний сорил (test), ажиглалт (formal observation), ярилцлага (interview) хийх, хүүхэд өөрийнхөө нөхцөл байдлыг үнэлэх (self-assessment) зэрэг тоон болон чанарын олон аргуудаас нэг удаад гурваас дээш, хүчин төгөлдөр үнэлгээний хэрэглэгдэхүүнийг ашиглахыг зөвлөдөг.

Үнэлгээнд ашиглаж буй зарим аргачлалуудаас танилцуулбал:

- **Оюун ухааны тест:**
- Векслерийн Хүүхдийн Оюун хөгжлийн түвшинг тодорхойлох тест (Wechsler Intelligence Scale for Children, WISC) Ихэнх тохиолдолд сургуулийн сэтгэл зүйчид тус аргачлалыг ашиглан үнэлгээ хийдэг бөгөөд хүүхдийн оюун ухааны хөгжлийн түвшинг өргөн хүрээнд үнэлж тогтоодог. Тус аргачлал нь хүүхдийн нас, суралцаж буй түвшинд үндэслэн хүүхдийн гүйцэтгэл, оюуны чадамжийг үнэлдэг стандарт норматив (norm-based) аргачлал.
- Stanford Binet Intelligence Scale: (Binet Simon-ий тестээс гарган авсан) Сургуулийн сэтгэл зүйч эсвэл тусгай боловсролын баг энэхүү аргачлалыг ашиглан үнэлгээ хийнэ. Векслерийн аргачлалтай мөн ижил стандартад суурилсан. Тус аргачлалыг танин мэдэхүйн буюу оюун ухааны бэрхшээлээс шалтгаалан үе тэнгийнхнээсээ сурлагын хувьд хоцрогдож байгаа сурагчдыг таних, үнэлэх зорилгоор ашиглаж байна.
  - **Бүлгийн оюун ухааны тест** (Group Intelligence test): Тус аргачлал нь ерөнхий боловсролын сургуулийн ердийн ангийн нийт сурагчдын түвшинг тогтоох зорилгоор ашиглаж буй бүлгийн аргачлал. Тус аргачлалаар суралцах бэрхшээлтэй хүүхдүүдийг анхан шатны түвшинд илрүүлэх боломжтой ба хүүхдийн танин мэдэхүйн чадвар болон академик ур чадварыг таних зорилгоор ашиглаж байна.
  - **Ур чадварын үнэлгээ**: Мэргэшсэн паталогич, хүүхдийн хариуцсан эмч зэрэг мэргэжлийн хүмүүс хүүхдийн биеийн ерөнхий хөдөлгөөний үйл ажиллагаа нарийн булчингийн үйл ажиллагаа, сонсох, ярих, хэлний ур чадваруудыг оношлох зорилгоор тусгай аргуудыг ашигладаг. Тус үнэлгээний үр дүн нь хүүхдийн онцлогт нийцүүлэн боловсролын орчинд байх шаардлагатай тохируулгуудыг ГСТ-г төлөвлөхөд чухал ач холбогдолтой.
  - **Амьдралын түүх судлал**: Тус үнэлгээг ярилцлагын аргаар хийж гүйцэтгэх бөгөөд ангийн багш, эцэг эх, сэтгэл зүйч, хүүхдийн эмч зэрэг хүүхэдтэй ойр ажиллах мэргэжилтнүүд хариуцан зохион байгуулдаг. Хүүхдийн давуу болон сул тал, хөгжлийн ямар нэг хоцрогдол байсан эсэх, хүүхдийн хөгжилд нөлөөлөхүйц өмнөх туршлага, эрүүл мэндийн түүх, хөгжлийн milestone, генетикийн хүчин зүйл, гэр бүл найз нөхдийн харилцаа, хобби, зан авирын асуудлууд, сурлагын амжилтууд зэрэг хүүхдийн өнгөрсөн амьдралтай холбоотой бүхий л мэдээлэлд үнэлгээ хийдэг.
  - **Ажиглалт** (Formal Observation Records): Тухайн хүүхэдтэй ажиллаж буй хэн ч хүүхдийн сурлагын үзүүлэлт болон зан авирын онцлогийн талаарх ажиглалтын үр

дүнгээ тэмдэглүүлж болно. Нэг болон түүнээс дээш сарын ажиглалтын үр дүн нь хүүхдийн нөхцөл байдлын талаарх урьдач таамаг, ерөнхий дүр зургийг багшид олгох боломжтой. Ялангуяа ангийн багш нар нь тухайн насны хүүхдүүдийн хөгжил, гүйцэтгэлийн талаар хамгийн сайн мэдээлэлтэй байдаг тул хөгжлийн хувьд ямар нэг хоцрогдол, сурлагын бэрхшээлтэй байгаа хүүхдийг таньж илрүүлэх хамгийн боломжтой тал гэж үздэг. Ингэхдээ багшийн өгсөн даалгаврыг хэрхэн гүйцэтгэж байгаа байдал, үзүүлж байгаа хариу үйлдэл, гүйцэтгэл зэрэг тодорхой ажиглагдсан үр дүнгүүдийг баримтжуулан тэмдэглэж явна.

Дээрх аргачлалуудад үндэслэн үнэлгээний баг хүүхдийн бэрхшээл, тусгай хэрэгцээг тодорхойлбол ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж эхэлнэ. Эцэг эх, асран хамгаалагч нь ГСТ хүлээн зөвшөөрвөл хүүхэд өөрийн тусгай хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээг хүртэж эхэлдэг байна. (J. Ysseldyke, 2010).

Дүгнэлт: Энэ хууль гарснаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд оролцоход ялгаварлан гадуурхахгүй байх нөхцөлийг тодорхойлон заасан хувьдаа дэлхийн бусад улсад ихээхэн нөлөө үзүүлжээ. Монгол Улсын хувьд авч үзвэл зохих туршлагын тухайд Америкийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зохицуулалтаас **1./**15-аас дээш ажилтантай аж ахуйн нэгжүүд нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж ажил гүйцэтгэх нэмэлт тоноглолоор хангах үүрэг хүлээх хэдий ч ажил олгогчид энэ нь ихээхэн хүндрэлтэй бий болгох, эсхүл маш их зардлаар бий болгохоор тусгай тоноглол хэрэгтэй бол түүнийг ажил олгогч заавал хангах үүрэг хүлээхгүй байх хувилбарыг зохицуулсан байна. **2./**Нийтийн байгууламжинд нэвтрэх стандартыг энэ хууль батлагдахаас өмнө баригдсан барилга байгууламжид мөн үйлчлэхээр заасан. Өөрөөр хэлбэл барилга байгууламж "хялбар хэрэглэхүйц" буюу "их хэмжээний хүндрэл, бэрхшээл эсхүл зардал гаргалгүйгээр хялбар байдлаар гүйцэтгэх" боломжтой бол өмнө баригдсан барилга, байгууламж мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний нэвтрэх орц, гарц, хүртээмжийг бий болгох үүрэг хүлээнэ. Ингэхдээ бүх барилгыг өөрчлөх боломжтой эсэхийг бодит байдал дээр авч үзэхийн тулд "хялбар хэрэглэхүйц байдал" гэдэг нь түүнийг засварлахад гарах зардал ба тухайн бизнес эрхлэгч эсхүл өмчлөгчийн амин зуулга хоёрыг харьцуулан үзнэ хэмээн уян хатан байдлаар зохицуулсан нь практик хэрэглээний хувьд ач холбогдолтой байна. **3./** Харилцаа холбооны олон янз хэлбэрийг өргөн ашиглахаар заасан нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах, дамжуулах, хөгжих боломжийг олгоход шаардлагатай зохицуулалт ажээ**.** Америкийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хуулиас **4./** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үр дүнтэйгээр ердийн сургуульд тэгш хамруулан сургахад олон талын оролцоо, хичээл зүтгэл шаардлагатай бөгөөд хүүхдийг боловсролд хамруулах процесс нь бүхэлдээ сайтар төлөвлөгдсөн, зохион байгуулттай байж мөн түүндээ зарцуулагдах тодорхой төсөвтэй байх ёстой болохыг дээрх орнуудын туршлагаас харж болохоор байна. Үүний тулд хамгийн суурь нь нэгдмэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн болон боловсролын хэрэгцээ шаардлагыг нь багш, эцэг, эх суралцагчид хамтран тусгайлан үнэлгээний загвараар тодорхойлж, түүнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан шаардлагатай туслах хэрэгсэл, дэмжлэгээр хангах явдал байна.

2. Болгар улс

Болгар улс нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд татан оролцуулах тухай хуулийг 2004 онд баталж, 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэхүү хууль нь 6 бүлэг, 55 зүйлтэй, мөн нэмэлт зүйлтэй.

1 дүгээр бүлэг- Нийтлэг үндэслэл (1-4 дүгээр зүйл)

Энэ хуулийн 2 дугаар зүйлд хуулийн зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрх;

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд нэгдэн оролцох, эрхээ эдлэх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдгээрийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрийн орчинд нэгтгэн оролцуулах

орчин нөхцөл, баталгааг бүрдүүлж өгөхөд оршино. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцох нийгмийн харилцааг дараах 7 салбараар тодорхойлжээ.

1. Эрүүл мэндийн болон нийгэмшүүлэх сэргээн засал;
2. Боловсрол, техник мэргэжлийн сургалт;
3. Хөдөлмөр эрхлэлт;
4. Ахуйн болон архитектурын саадгүй хүртээмжтэй орчин;
5. Нийгмийн үйлчилгээ;
6. Нийгэм-эдийн засгийн халамж, хамгаалалт;
7. Хүртээмжтэй мэдээлэл

2 дугаар бүлэг- Удирдах байгууллага (5-9 дүгээр зүйл)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулахтай холбоотой төрийн бодлогыг Сайд нарын зөвлөл тодорхойлно.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах чиглэлээр хамтарч бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах Үндэсний зөвлөлийг Сайд нарын зөвлөлийн дэргэд байгуулна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой эрхзүйн актыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, урьдчилсан санал авсны дараагаар батална. Сайд нарын зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах Үндэсний зөвлөлийн Үйл ажиллагааны журмыг баталж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх байгууллагуудын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилготой байна.Тус газар нь Софи хотод төвтэй, төсөвт хөрөнгөтэй хуулийн этгээд, хоёрдугаар түвшний захиран зарцуулах эрхтэй нэгж байх бөгөөд Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайдын гүйцэтгэгч агентлагийн статустай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын үйл ажиллагаа, бүтэц, орон тоог Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайдын саналыг үндэслэн Сайд нарын зөвлөлөөс баталсан Үйл ажиллагааны журмаар зохицуулна.

8 дугаар зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын үүргийг зааснаар нь

1. Туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, байгууламжийн үйлдвэрлэл, импорт, борлуулалт, засвар үйлчилгээний стандарт, шалгуурыг батлах, туслах хэрэгслийн хангалт баталсан шалгуур, стандартад нийцэж буй эсэхэд хяналт тавих;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын бүртгэлийг хөтлөх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хуулийн төсөл боловсруулахад оролцох, санал оруулах;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес санаачилга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тустай бизнесийн санаачилгыг хөхиүлэн дэмжих хөтөлбөр боловсруулж, төслүүдийг санхүүжүүлэх;
5. Сайд нарын зөвлөлөөс даалгасан нэмэлт ажил үүргийг гүйцэтгэх.

9 дүгээр зүйлд мэдээллийн сан бүрдүүлэх асуудлыг дэлгэрэнгүй зохицуулжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газар нь байнгын хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлнэ. Энэхүү мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, эрүүл мэндийн болон нийгмийн нөхөн заслын зайлшгүй шаардлагатай холбоотой төлөвлөлтийн үйл ажиллагаанд зориулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог гаргах, тэдгээрийн нийгэм-эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийхэд ашиглана. Эмч нарын үндэсний мэргэжилтнүүдийн зөвлөл, эмч нарын бүсийн мэргэжилтнүүдийн зөвлөл, Үндэсний нийгмийн хамгааллын хүрээлэн, Үндэсний статистикийн хүрээлэн, Эрүүл мэндийн мэдээллийн Үндэсний төв, Хүүхэд хамгаалах байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой чиглэлээр ажилладаг бусад байгууллагууд тус энэ хуульд заасан мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг гарган өгнө. Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн дагуу дээрх санд мэдээлэл нь орсон хувь хүн өөрийн мэдээллийг ил болгохыг зөвшөөрөөгүй тохиолдолд хувь хүний хувийн мэдээллийг ил болгохыг хориглоно. Мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх журмыг энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журмаар зохицуулна.

3 дугаар бүлэг - хөгжлийн бэрхшээл ба нийгмийн харилцаанд оролцогчдын чадварын үнэлгээ (10-13 дугаар зүйл)

Хөгжлийн бэрхшээлийг эмнэлгийн магадлагаа болон нийгэмшлийн үнэлгээгээр тогтоон үнэлнэ. Эмнэлгийн магадлагааг үндэслэн нийгэмшлийн үнэлгээг хийх ба нийгэмшлийн үнэлгээгээр дараах асуудлыг тодорхойлно. Үүнд:

1. Нөхөн засал хийх зайлшгүй шаардлага;
2. Мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чадвар;
3. Нийгмийн харилцаанд нэгдэн оролцох чадвар.

Нийгэмшлийн үнэлгээг:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эцэг эх (өргөж авсан эцэг эх), асран хамгаалагч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн;
3. Хүүхэд хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүл, хамаатан садан, ойрын хамаатан эсхүл өргөж авсан гэр бүлийн

хүсэлтээр хийнэ. Нийгэмшлийн үнэлгээнд тулгуурлан нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах тусгайлсан төлөвлөгөөг боловсруулна.

Нийгэмшлийн үнэлгээнд дараах асуудлыг багтаана. Үүнд:

1. Нөхцөл байдлын үнэлгээ;
2. Нийгмийн харилцаанд хамруулахад шаардлагатай арга хэмжээний зөвлөмж;
3. Тэтгэмж өгөх шаардлагатай нь тогтоогдсон тохиолдолд хууль заасан нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулахад сар бүр тэтгэмж олгохыг дэмжсэн санал.

   Дээр дурьдсан нийгэмшлийн үнэлгээг Нийгмийн тусламж үйлчилгээний газрын Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны зөвлөлдөх хороо гүйцэтгэнэ. Энэхүү хорооны бүрэлдэхүүнийг Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны даргын тушаалаар батлах ба бүрэлдэхүүнд дараах этгээд багтана. Үүнд:

1. Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны даргын томилсон Нийгмийн тусламж үйлчилгээний газрын Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны мэргэжилтнүүд;
2. Хотын дарга нарын томилсон хотын захиргааны төлөөллүүд;
3. Үндэсний хөдөлмөр эрхлэлтийн газрын Хөдөлмөрийн газрын захиргааны даргын томилсон Хөдөлмөрийн газрын захиргааны мэргэжилтэн;

4. Шаардлагатай тохмолдолд бусад мэргэжилтнүүдийг нэмж оролцуулна.

Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны зөвлөлдөх хорооны үйл ажиллагаа, ажиллах зарчим, нийгэмшлийн үнэлгээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журмаар тогтооно.

4 дүгээр бүлэг - нэгтгэн оролцуулах салбарууд (14-48 дугаар зүйл)

Энэ бүлэг нь дотроо таван хэсэгтэй: Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, сэргээн засах, Боловсрол ба мэргэжлийн сургалт, Хөдөлмөр эрхлэлт ба ажлын байр, Амьдрах болон архитектурын саадгүй хүртээмжтэй орчны нөхцөлийг тогтоох, Нийгэм-эдийн засгийн хамгаалал.

Нэгдүгээр хэсэг- Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, сэргээн засах салбарт Сайд нарын зөвлөл нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх нэн тэргүүний зорилго, арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэрэгслүүдийг тодорхойлсон урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг батална. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөх үндэсний байгууллагууд, ажил олгогчдыг төлөөлөх үндэсний байгууллагууд болон хөдөлмөр эрхлэгчдийг төлөөлөх үндэсний байгууллагууд нь дараах замаар хөгжлийн бэрхшээлээс сэргийлэхэд туслалцаа үзүүлнэ. Үүнд:

1. Амьдралын хэв маяг, амьдрах орчинтой холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийг хязгаарлах эрүүл мэндийн болон экологийн боловсрол олгох;
2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх;
3. Ажлын байран дээр хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах.

Эмнэлгийн сэргээн засал гэдэг нь Эрүүл мэндийн байгууллагын тухай болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан олон талын мэргэшил бүхий багийн хэрэгжүүлэх эрүүл мэндийн үйл ажиллагаа бөгөөд үүнд доорхыг хамруулна. Тухайлбал:

1. Эмийн эмчилгээ;
2. Физик эмчилгээ;
3. Хэл яриа, хараа засал;
4. Кинезитерапи (булчингийн тогтолцооны эмчилгээ);
5. Хөдөлгөөн засал (эрготерапи);
6. Сэтгэл засал;
7. Хөдөлмөр засал;
8. Туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүний жор бичих.

Эмнэлгийн үйл явцад зайлшгүй шаардлагатай тохиолдолд хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдийн гэр бүл эмнэлгийн засал, эмчилгээнд оролцоно. Нийгэмшлийн сэргээн засал гэдэгт харах, сонсох, ярих, хөдлөх чадварыг сэргээн засах замаар бие даан амьдрах чадвартай болгох, сэтгэл зүйн туслалцаа, нийгмийн үйлчилгээ үзүүлэх болон бусад үйл ажиллагааг хамруулна.

Хоёрдугаар хэсэг- Боловсрол ба мэргэжлийн сургалтын салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хүмүүжил, боловсролын цогц үнэлгээг Боловсрол, шинжлэх ухааны яамны бүсийн зааварлагчдаас бүрдсэн баг тогтооно. Боловсрол, шинжлэх ухааны яамны дор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нэгдсэн боловсролыг дэмжих нэгдсэн боловсролын нөөцийн төвүүдийг байгуулна. Боловсрол, шинжлэх ухааны яам нь доорхыг ханган ажиллана. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зохих насанд нь Бүх нийтийн боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1-10-т заасан сургууль болон мөн хуулийн 18 дугаар зүйлд заасан сургуулийн өмнөх боловсролд хамруулах;

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэгдсэн боловсролыг дэмжсэн орчин нөхцөлийг бүрдүүлэх;
3. Хараагүй, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг сонсгол-яриа, хэл-яриа, сэтгэл заслын сэргээн засах эмчилгээнд эрт хамруулах;
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дунд боловсролын хөтөлбөрийг дүүргэтэл эсхүл 18 нас хүртэл нь сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин үеийн технологи, техник хэрэгслээр хангах;
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах.

Боловсрол, шинжлэх ухааны яам нь боловсролын ердийн орчинд нэгдэн орох чадваргүй, боловсролын тусгай хэрэгцээ бүхий хүүхдүүдийг сурч боловсрох боломж, нөхцөлөөр хангана. Хөгжлийн бэрхшээл 16 наснаас нь хойш илэрсэн иргэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол, насанд хүрэгсдийн боловсрол болон үндсэн ур чадвар олгох тусгай хөтөлбөрийн анхны сэргээн заслын зэрэг нэмэлт хөтөлбөрүүдэд үнэ төлбөргүй хамрагдах эрхтэй байна.

Ахлах сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, үнэлгээний үйл явцад дэмжлэг болох үүднээс тэдгээрийг дэмжсэн орчин, тусгай байгууламж, сургалтын тохиромжтой материал, нэмэлт багш нарыг бүрдүүлсэн байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах мэргэжилтнүүдийг сургах нөхцөлийг хангана. Дараах этгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн боловсрол олгоно. Үүнд:

1. Үндэсний хөдөлмөр эхлэлтийн газар;
2. Ажил олгогч нар болон томилогч байгууллагууд;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдүүд болон Худалдааны тухай хуулийн заалтын дагуу бүртгүүлсэн хувь хүмүүс;
4. Мэргэшсэн үйлдвэр, хоршоод.

Гуравдугаар хэсэг - Хөдөлмөр эрхлэлт ба ажлын байрны салбарт тусгайлсан, нэгдсэн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр ажил, хөдөлмөр эрхлүүлнэ. Хөдөлмөр, нийгмийн бодлогын яам, Үндэсний хөдөлмөр эрхлэлтийн газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөрийн зах зээлд ижил тэгш оролцох боломжоор хангасан хөдөлмөр эрхлэлтийг хөхиүлэн дэмжих үндэсний хөтөлбөр, арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлүүлж буй ажил олгогч нарыг дэмжих хөрөнгийг баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд олгоно. Ажил олгогч, ялангуяа томилогч этгээд нь ажилтан томилогдсон даруйд, эсхүл томилогдсоноос хойш хөгжлийн бэрхшээлтэй болсон бөгөөд ажлын байр тохижуулахад шаардагдах зардал нь хэт өндөр биш, ажил олгогчид их хэмжээний дарамт учруулахуйц бус бол ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тохируулах үүрэгтэй байна. Ажил олгогч, ялангуяа томилогч этгээд нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байрандаа саадгүй нэвтрэх боломж бүрдүүлж өгөх;
2. Ажлын байрыг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохируулж өгөх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байранд тоног төхөөрөмж байрлуулж өгөх

зорилгоор тэтгэлэг хүсч төслөө Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газарт хүргүүлж болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газар нь жил бүр ажил олгогчдын ирүүлсэн төслийг санхүүжүүлэхэд зарцуулах хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэнийг 3 жилээс доошгүй хугацаагаар ажлын байраар хангана. Хэрэв ажлын байраар хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хангаагүй бол хүлээн авсан мөнгөн дүнг хүүгийн хамт буцааж төлөх үүрэг хүлээнэ.

Ажил олгогч нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн заалт ёсоор аливаа хөнгөлөлт урамшуулал эдлээгүй бол дараах хөнгөлөлт урамшууллыг эдэлнэ. Үүнд:

1. Энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журамд заасны дагуу ажил олгогчийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэрийн нэмэлт даатгалд төлсөн шимтгэлийн 30 хувийг төсвөөс санхүүжүүлнэ.
2. Энэ хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зорилгоор зарцуулсан хөрөнгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу дансанд бүртгэх ба татварыг Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн нийтлэг үндэслэлийн дагуу тооцно. Ажил олгогч нь хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдэд Хөдөлмөрийн тухай хуулийн 315 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан ерөнхий тооны ажлын байрны ½-ээс багагүй тооны ажлын байр гаргаж өгнө. Ажил олгогч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зориулалтын ажлын байрны талаар Үндэсний хөдөлмөр эрхлэлтийн газрын харьяа нэгжид мэдэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан сул чөлөөтэй ажлын байрны зарыг 14 хоногийн дотор зарлах үүрэгтэй байна.

   Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоод гэж дараах шаардлагыг хангасан үйлдвэр, хоршоодыг ойлгоно. Үүнд:

   1. Худалдааны тухай хууль эсхүл Хоршооны тухай хуулийн дагуу бүртгүүлсэн;
   2. Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг эсхүл үйлчилгээ үзүүлдэг;
   3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:
      a. Хараагүй, харааны бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын нийт ажилтны 20-оос доошгүй хувь;
      b. Дүлий, сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын нийт ажилтны 30-аас доошгүй хувь;
      c. Хөгжлийн бусад бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын нийт ажилтны 50-аас доошгүй хувь.
   4. Энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан бүртгэлд хамрагдсан байна.

   Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодыг энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журамд заасан зориулалтын төсөл, хөтөлбөрүүдээр дамжуулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газраас санхүүжүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоод нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын бүртгэлд бүртгүүлнэ. Сайд нарын зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын үйлдвэрлэх бараа бүтээгдэхүүн, үзүүлэх үйлчилгээг төрийн худалдан авах ажиллагааны тухай хуульд заасан журмын дагуу тодорхойлно.

Дөрөвдүгээр хэсэг-Амьдрах болон архитектурын саадгүй хүртээмжтэй орчны нөхцөлийг тогтоох салбарт төрийн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь Газар нутгийн зохион байгуулалтын тухай хуульд тодорхойлсон нөхцөл, шаардлагын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг багтаасан хүн амд зориулан хотын байгууламжуудыг бүтээн байгуулж, барих ажлыг зохион байгуулна. Бүсийн хөгжил, нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ хариуцсан яам нь доорх асуудлаар эрхзүйн акт, дүрэм журам, норм, стандартыг боловсруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин, архитектурын саадгүй хүртээмжтэй орчныг бий болгох нөхцөл шаардлагыг тогтооно. Үүнд:

1. хотын газар нутаг, түүний элементүүд;
2. барилга, байгууламж, тэдгээрийн элементүүд;
3. одоогийн барилга байгууламж, хүрээлэн буй орчныг олон нийтийн хэрэгцээнд нийцүүлэн тохируулах элементүүд.

Тээвэр, харилцаа холбооны яам нь доорх асуудлаар эрх зүйн акт, стандарт боловсруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тээврийн үйлчилгээг хүртээмжтэй болгох нөхцөл шаардлагыг тогтооно. Үүнд:

1. Нийтийн хэрэгцээнд саадгүй, хүртээмжтэй тээврийн хэрэгслээр үйлчлэх;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн тээврээр саадгүй зорчуулах зорилгоор нийтийн амьдрал, нийтийн тээвэрт техникийн байгууламжуудыг шинээр нэвтрүүлэх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн жолоодож буй эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн тээвэрлэлт, зогсолт, зогсоолын тусгай нөхцөл шаардлагыг хангах;
4. Хөтөч нохойтой яваа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх нийтийн тээврийн хэрэгслийн саадгүй орц, гарцыг хангах.

Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах хэрэгсэл, байгууламж, хэрэглэгдэхүүний үйлдвэрлэл, импорт, борлуулалт, засвар үйлчилгээний нөхцөл шаардлагыг тогтоосон тушаал батална. Туслах хэрэгсэл, тэдгээрийг үйлдвэрлэх болон засч сэлбэх материалыг импортын болон нэмүү өртгийн татвараас чөлөөлнө. Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайд жил бүр тушаал гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах хэрэгсэл, байгууламж, хэрэглэгдэхүүний жагсаалтыг батална. Залуучууд, спортын яам болон Боловсрол, шинжлэх ухааны яам нь хотын захиргаа, биеийн тамирын клубүүд болон спортын холбоодтой хамтран дараах байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оруулах нөхцөлийг хангана. Үүнд:

1. Биеийн тамирын талбай, төхөөрөмж хэрэгслүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ашиглуулах зорилгоор байрлуулж, тохируулах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан спортын арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;
3. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад туслалцаа үзүүлэх;
4. Хүүхдүүдэд сургуулиас гадуурх үйл ажиллагаанд нь туслалцаа үзүүлэх.

Соёлын яам нь хотын захиргаатай хамтран дараах байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оруулах нөхцөлийг хангана. Үүнд:

1. Үйлчилгээ, замын чиглэл, архитектур-тээврийн болон соёл, амралтын зориулалттай нийтийн талбайд байрлах бусад байгууламжуудын талаар тусгайлсан мэдээллээр хангах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүтээлч үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, авъяас чадварыг хөгжүүлэх.

Хотын захиргаад нь өөрийн эрх мэдлийн хүрээнд доорхыг хангана. Үүнд:

1. Цэцэрлэг, сургуулиудад саадгүй хүртээмжтэй архитектурын орчныг бүтээн байгуулах;
2. Одоогийн тээврийн хэрэгслийг нийтийн тээвэрт тохируулан өөрчлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх техникийн хувьд өөрчлөн тохируулсан тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх зэргээр нийтийн тээврийг хүртээмжтэй саадгүй болгох;
3. Хөтөч нохойгоор замчлуулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтийн газар саадгүй нэвтрүүлэх;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тээврийн тусгай үйлчилгээ үзүүлэх;
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд оруулахад шаардлагатай материаллаг нөхцөл, хэрэгслээр хангах.

Болгарын үндэсний телевиз, Болгарын үндэсний радио, Болгарын шуудангийн газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар мэдээллийг

хүргэнэ. Эдгээр байгууллагууд хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай хөтөлбөрүүдийг оруулна.

Тавдугаар хэсэг- Нийгэм-эдийн засгийн хамгаалал салбарт мэргэшсэн үйлдвэр, хөдөлмөр-эрүүл мэндийн байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулсан ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хоршоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөх үндэсний байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх үндэсний байгууллагуудын гишүүдийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэрийн нэмэлт даатгалын шимтгэлд ажил олгогчийн зүгээс төлсөн 30 хувийг санхүүжүүлэх хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөрөнгө оруулалт, сэргээн засал, нийгмийн харилцаанд нэгдэн оролцох үйл ажиллагаанд зарцуулна. Хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэд хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэрэг, хувийн хэрэгцээ шаардлагаас хамаарч нийгмийн харилцаанд нэгдэн ороход зориулсан сар бүрийн тэтгэмж авах эрхтэй байна. Дээрхи тэтгэмж нь хувь хүний орлогод нэмэлт байдлаар, ялгаатай олгогдох санхүүгийн хэрэгсэл байх ба дараах нэмэлт зардлыг хамарна. Үүнд:

1. Тээврийн үйлчилгээ;
2. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ;
3. Боловсрол;
4. Рашаан сувилал, сэргээн заслын үйлчилгээ;
5. Эрүүл хооллолтын дэглэм, эм тариа;
6. Хүртээмжтэй мэдээлэл;
7. Бусад үндсэн хэрэгцээг хангах.

Сар бүр олгох тэтгэмжийн нийт дүн нь 2 дахь хэсэгт заасан хэрэгслийн нийт дүн болно. Тэтгэмжийг энэ хуулийн комиссын саналыг үндэслэн нийгэмшлийн үнэлгээнд тулгуурлан олгоно. Нийгэмшлийн үнэлгээнд тусгасан бүхий л нөхцөл байдлыг шалган судалсны дараа Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны дарга эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөл болох этгээд нь тэтгэмж олгохыг зөвшөөрсөн тушаал гаргана. Нийгмийн харилцаанд нэгдэн ороход зориулсан тэтгэмж олгохоос татгалзсан шалтгааныг заавал тайлбарлана. Энэхүү заасан шийдвэрийг Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн нөхцөл, шаардлагын дагуу Нийгмийн тусламж үйлчилгээний бүсийн захиргааны даргад хандан давж заалдаж болно. Төрийн эсхүл хотын захиргаанаас бүтэн тусламж авч эрүүл мэндийн байгууллага, мэргэшсэн байгууллагад нэг сараас дээш хугацаагаар байгаа хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэд нь дээр дурдсан байгууллагуудад байрлаж байх хугацаандаа тэтгэмжийг авах эрхгүй болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 18 нас хүртэл болон дунд сургуулиа төгсөх хүртэл буюу 20 нас хүрэхээс өмнө хүртэл олгох амьжиргааны баталгаажих доод түвшний 70 хувьтай тэнцэх хэмжээний сар тутмын тэтгэмжийг хууль ёсны төлөөлөгч этгээд авах эрхтэй байна.

Хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэд зайлшгүй шаардлагаасаа хамаарч зохих тэтгэмж авч, дараах хөнгөлөлтийг эдлэх эрхтэй байна. Үүнд:

1. Хувийн тээврийн хэрэгсэл худалдан авах, хэрэгцээндээ нийцүүлэн тохируулах, зогсоолын талбайгаа тохируулан өөрчлөх;
2. Хувийн тээврийн хэрэгсэл импортлох;
3. Гэрээ дахин засварлах;
4. Харааны бэрхшээлтэй, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд хажуудаа хүнтэй явах, сонсголын бэрхшээлтэй иргэд дохионы хэлмэрчтэй байх.

Хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдийн импортлох Болгар ливээр илэрхийлэгдэх үнэ бүхий хувийн тээврийн хэрэгслийн хүчин чадал, мотор нь Сайд нарын зөвлөлөөс тогтоосон тодорхой үзүүлэлтэд нийцсэн байх ба тэдгээр нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвараас чөлөөлөгдөнө. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрийн хэрэгцээ шаардлагын дагуу зохих

хэмжээний тэтгэмж авах, техникийн туслах хэрэгсэл, хөгжлийн бэрхшээлийг хөнгөвчлөх хэрэглэгдэхүүн, төхөөрөмжөө худалдан авах, засуулахад Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайдын жил бүр батлан гаргадаг жагсаалтын дагуу хөнгөлөлт эдэлнэ. Зохих хэмжээний тэтгэмж, хөнгөлөлт, тэдгээрийг олгох нөхцөл, шаардлагыг энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журмаар тодорхойлно. Тэтгэмж, тусламжаас татвар, шимтгэл авахгүй. Харин хууль бусаар авсан их хэмжээний тэтгэмж, тусламжийг төрийн өмчийг хураан авах журмын дагуу хүүгийн хамт эргүүлэн төлүүлнэ. Улмаар уг этгээдийн тэтгэмж, тусламж авах эрхийг нэг жилийн хугацаатай түдгэлзүүлнэ. Хөгжлийн байнгын бэрхшээлтэй хүнийг асарч байсан, нийгмийн баталгаагүй болсон этгээдэд Нийгмийн халамжийн хуулийн нөхцөл, шаардлагын дагуу тэтгэвэрт гарах үед нь даатгуулаагүй хугацааг нөхөн тооцно. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу тухайн хугацааны эрүүл мэндийн даатгалыг төлөгдсөнд тооцно. Хөгжлийн байнгын бэрхшээлтэй оюутнууд, хөгжлийн байнгын бэрхшээлтэй эцэг, эхтэй хүүхдүүдэд Ерөнхий боловсролын тухай хууль болон Дээд боловсролын тухай хуулийн дагуу тэтгэлэг болон бусад хөнгөлөлт олгоно. Хотын өмчийн тухай хуулийн дагуу хотын захиргаад нь хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдийг хотын орон сууцжуулалтын сангаас орон байраар хангана.

5 дугаар бүлэг - Санхүүжилт

Энэ хуулийн хүрээнд хийгдэх санхүүжилтийг дараах эх үүсвэрээс хийнэ. Үүнд:

1. Улсын төсөв;
2. Хотын төсөв;
3. Үндэсний болон олон улсын хөтөлбөрүүд;
4. Дотоодын болон гадаадын хувь хүн, байгууллагын хандив;
5. Бусад эх үүсвэр.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн болон тэдгээрийн төлөөх тэдгээрийг төлөөлөх байгууллагууд нь энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журамд тодорхойлсон нөхцөл, шаардлагын дагуу улсын төсвөөс тэтгэлэг авах эрхтэй байна.

6 дугаар бүлэг - Захиргааны хариуцлага тооцох

Энэ хуулийн хүрээнд захиргааны зөрчлийг магадлан тогтоох албан тушаалтнуудыг дараах байгууллагаас томилно. Үүнд:

1. Төрийн санхүүгийн дотоод хяналтын газрын дарга – санхүүгийн зөрчлүүдэд;
2. Хөдөлмөрийн ерөнхий захиргаа – Гүйцэтгэгч агентлаг – хөдөлмөр эхлэлт, ажлын байртай холбоотой зөрчлүүдэд;
3. Боловсол, шинжлэх ухааны сайд – боловсролтой холбоотой зөрчлүүдэд;
4. Үндэсний барилгын хяналт шалгалтын захиргааны дарга – архитектурын саадгүй хүртээмжтэй орчинтой холбоотой зөрчлүүдэд;
5. Автомашины захиргаа – Гүйцэтгэгч агентлагийн дарга, ялангуяа Төмөр замын захиргаа-Гүйцэтгэгч агентлагын дарга – саадгүй хүртээмжтэй тээвэртэй холбоотой зөрчлүүдэд;
6. Нийгмийн тусламж үйлчилгээний газар-нийгмийн тусламж үйлчилгээтэй холбоотой зөрчлүүдэд.

Торгууль, шийтгэлийг хуулиар олгогдсон эрх бүхий байгууллага, Сайд нарын зөвлөлөөс гаргасан актын дагуу ногдуулна. Энэхүү хуулийн дагуу ногдуулсан торгуулийн 50 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын орлого болно. Энэхүү зүйлд заасан байгууллагууд нь жил бүр 12 дугаар сарын 31-нийг хүртэл хийсэн хяналт шалгалт, ногдуулсан торгууль шийтгэлийн талаарх мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газарт хүргүүлнэ.

Болгар улс 2004 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд татан оролцуулах тухай хуулийг баталсаны дараагийн алхамыг Европын хүний эрхийн

комиссоос[194] 2016 онд дүгнэсэнээр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм чанарыг хүлээн зөвшөөрч, өмнөөс нь бусад этгээд бүх шийдвэр гаргадаг албадмал тогтолцоог өөрчилж, Европын социал харта, Европын хүний эрхийн шүүхийн шийдвэр болон бусад олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлсэн шинэ, дэвшилттэй хуулийн төсөл батлах юм. Энэхүү хуулийн төслөөр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний бүрэн болон цагаар харгалзан дэмжигчтэй байсныг халж, түүний оронд эрхээ хэрэгжүүлэх бүх талын дэмжлэг, арга хэмжээгээр хангах үүрэг хүлээлгэнэ. Хэрэв энэ үүргээ биелүүлэхгүй байгаа тохиолдолд шүүхэд хандан энэхүү үүргийн хэрэгжилтийг шалгуулах эрхийг нээх юм. Өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрх зүйн чадамжгүй хэмээн үзэж, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, боловсрох, өмчтэй байх, эдийн засгийн эрхтэй байх, гэр бүлтэйгээ хамт байх бүх эрхийг нь хасаж, нийтийн асрах газарт байлгадаг байсныг дуусгавар болгох хуулийн төсөл боловсруулагдан хэлэлцэгдэж байна.

Дүгнэлт: Болгар улсын дээрхи хуульд 1./ Зорилтыг тодорхойлохдоо хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдгээрийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх хэмээн заасан нь дэвшилттэй, өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийн эрхийн хангах, баталгааг бүрдүүлэхээс гадна гэр бүлд үзүүлэх дэмжлэг зайлшгүй чухал билээ. 2./ Хэрэгжүүлэх байгууллагын чиг үүргийн хувьд Монгол улстай тун төстэй Сайдын зөвлөл,Үндэсний зөвлөл, салбар яамд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газар хэмээх нэгжүүд бодлого, хөтөлбөр, хэрэгжилтийн хариуцахаар заасан. Гэвч, тухайлбал, "Төрийн байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулахтай холбоотой эрхзүйн акт, стратеги, хөтөлбөр, стандарт болон бусад баримт бичгийг боловсруулан батална." гэдэг заалт хэт ерөнхий заалт болжээ.Иймэрхүү хэт ерөнхий заалт, байгууллага хоорондын дунд ойлгомжгүй орхих нь хуулийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлдөг болохыг бид үр дагаврын үнэлгээнээс ажигласан. 3./ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын хэрэгжүүлэхээр заасан А.Туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, байгууламжийн үйлдвэрлэл, импорт, борлуулалт, засвар үйлчилгээний стандарт, шалгуурыг батлах, туслах хэрэгслийн хангалт баталсан шалгуур, стандартад нийцэж буй эсэхэд хяналт тавих; Б.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын бүртгэлийг хөтлөх; В.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хуулийн төсөл боловсруулахад оролцох, санал оруулах;Г.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес санаачилга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тустай бизнесийн санаачилгыг хөхиүлэн дэмжих хөтөлбөр боловсруулж, төслүүдийг санхүүжүүлэх; Д.Сайд нарын зөвлөлөөс даалгасан нэмэлт ажил үүргийг гүйцэтгэх болон хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг Монгол Улс харгалзан үзэх боломжтой. 4./ Хөгжлийн бэрхшээлийг эмнэлгийн магадлагаа, нийгэмшлийн үнэлгээгээр тогтоон үнэлэх туршлага нь хамаарах оролцогчдыг бүрэн хамааруулсан, цаашид авах арга хэмжээ, тусламж хүртэх эсэхийг тодорхойлдог ач холбогдолтой байна. 5./ Хөгжлийн бэрхшээл 16 наснаас нь хойш илэрсэн иргэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол, насанд хүрэгсдийн боловсрол болон үндсэн ур чадвар олгох тусгай хөтөлбөрийн анхны сэргээн заслын зэрэг нэмэлт хөтөлбөрүүдэд үнэ төлбөргүй хамрагдах эрх олгосон нь дэвшилттэй зохицуулалт гэж үзэж байна. 6./ Ажил олгогч, ялангуяа томилогч этгээд нь ажилтан томилогдсон даруйд, эсхүл томилогдсоноос хойш хөгжлийн бэрхшээлтэй болсон бөгөөд ажлын байр тохижуулахад шаардагдах зардал нь хэт өндөр биш, ажил олгогчид их хэмжээний дарамт учруулахуйц бус бол ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн

[194] https://www.coe.int/en/web/commissioner/-/steps-forward-in-protecting-persons-with-disabilities-in-bulgaria?desktop=true

тохируулах үүрэг хүлээхээр уян хатан байдлаар зохицуулжээ. Сайд нарын зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын үйлдвэрлэх бараа бүтээгдэхүүн, үзүүлэх үйлчилгээг төрийн худалдан авах ажиллагааны тухай хуульд заасан журмын дагуу тодорхойлох нь тухайн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг иргэдэд давуу тал бий болгох боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын дарга нь энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журамд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даасан бизнесийн үйл ажиллагааг санаачлан хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг батлахаар мөн тусгагдсан байна. 7./ Амьдрах болон архитектурын саадгүй хүртээмжтэй орчны нөхцөлийг тогтоохдоо одоогийн барилга байгууламж, хүрээлэн буй орчныг олон нийтийн хэрэгцээнд нийцүүлэн тохируулах элементүүдийг чиглэлийн яам тогтоохоор заажээ. 8./Хөгжлийн байнгын бэрхшээлтэй хүнийг асарч байсан, нийгмийн баталгаагүй болсон этгээдэд Нийгмийн халамжийн хуулийн нөхцөл, шаардлагын дагуу тэтгэвэрт гарах үед нь даатгуулаагүй хугацааг нөхөн тооцно. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу тухайн хугацааны эрүүл мэндийн даатгалыг төлөгдсөнд тооцохоор оруулсан нь тун ач холбогдолтой заалт гэж үзэж байна. 9./ Энэхүү хуулийн дагуу ногдуулсан торгуулийн 50 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын орлого болохоор заасан нь эргээд хөгжлийн бэрхшээлтэй газрын санхүүжилтийн эх үүсвэр болох хувьдаа тодорхой ажээ.

3. Япон улс

Япон улс нь нэгдмэл нэг хуулиар бус салбар, субьект, харилцаагаар ялгаатай нарийвчилсан хуулиудаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн байдлыг зохицуулдаг байна. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль (1970), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ерөнхий хууль (2011), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн халамжийн хууль (2013), Бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн хууль (1949), Оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн хууль (1960), Сэтгэцийн эрүүл мэнд,сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн хууль (1995), Хүүхдийн халамжийн хууль (1949), Нийгмийн халамжийн үйл ажиллагааны хууль (2000), Бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хариуцах үндсэн хууль (1993), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие даахыг дэмжих хууль (2006), Биемахбодын хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэмжих нохойны тухай хууль (2002), Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ерөнхий тусламж үзүүлэх тухай хууль (2006), Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй зүй бусаар харьцахаас сэргийлэх хууль (2012), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2013), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль (2016) гэсэн нарийвчилсан хуулиуд, улмаар дагалдах журмууд. [195]

Эдгээр хуулийг бүрэн эхээр нь үзэх эх сурвалж, хэлний бэрхшээл байсан тул зөвхөн Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагын төслийн гаргасан гарын авлагаас Монгол улсад туршлага болох боломжтой дараах зохицуулалтыг онцолж байна.

1.Хөгжлийн бэрхшээлийн халамжийн бодлогын замналын хувьд 2006 оноос Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие даахын дэмжих хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд хэрэглэгчийн дарамтыг хөнгөлөх, компаниудад онц хөнгөлөлт үзүүлэх, шилжилтийн үеийн зохицуулалтыг хамаарчээ. 2007 онд тус хуулийн агуулгын тухайд шилжилтийн үеийн зохицуулалт өнгөрч харин асрамжийн байгууллагын дэд бүтцийг дэмжих арга хэмжээ нэмэгджээ. 2011 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зүй зохисгүй хандахаас урьдчилан

[195] Японы хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлогын гарын авлага, Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл, 2018 он

сэргийлэх хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалж асарч буй иргэдэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх хууль батлагдсан. 2012 онд Орон нутгийн нийгэмд энгийн иргэдтэй хамт амьдрах нөхцөлийг хэрэгжүүлэхэд шинээр Хөгжлийн эрүүл мэндийн бодлогыг гаргаж ирэхэд шаардлагатай хууль зүйн акын талаархи хууль, болон Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газраас бараа бүтээгдэхүүн худалдан авахыг дэмжихтэй холбоотой хууль баталсан. 2013 онд Хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахыг хориглох хууль батлагдаж, 2016 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхлэсэн.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилд авахыг дэмжих тухай хуулиар тогтоосон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах квот нь ердийн 56-аас дээш хүнтэй аж ахуйн нэгж 2.0, бусад 50-аас дээш хүнтэй аж ахуйн нэгж 2.3 хувь хэмээн хувиар тодорхойлсон байна. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд аваагүй бол 50 000 иен сар бүр төлбөр төлөхөөс гадна ажилд авах үүргээс давуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авсан бол хүн тус бүрийн тоогоор сар бүр 27 000 иен олгохоор заажээ.

3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг тусгай дэмжлэг бүхий боловсролоор дамжуулан олгодог. Энэ нь тусгай дэмжлэг үзүүлдэг анги, тусгай дэмжлэг үзүүлдэг сургууль, бага болон дунд сургуульд тусгай дэмжлэг бүхий боловсролын ахиц дэвшил, тусгай дэмжлэг үзүүлдэг багшийн мэргэжлийн лиценз гэсэн салбарлаж хэрэгждэг байна. Сургууль бүр олон төрлийн байгууллагатай сүлжээ үүсгэн, хүүхдийн хөгжилд нийцсэн уялдаа холбоо бүхий дэмжлэг үзүүлдэг байна.

4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх үйлчилгээнд хамрагдах төлөвлөгөөг тухайн иргэн, гэр бүлийнхэнтэй ярилцан амьдралын бүх нөхцөлийг тухайлбал, гэр бүлийн бүтэц, сэтгэцийн нөхцөл байдал, амьдралын хэв маягийг харгалзан тухайн хүнийг тухайн орон нутагтаа бие даан амьдарахрад нь тусалж дэмжихээр боловсруулдаг төлөвлөгөө байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн үйлчилгээний зэрэглэл нь хөгжлийн бэрхшээлийн онцлог, бие сэтгэл санааны байдалд нийцэх халамж, асаргааны хэмжээг илэрхийлсэн зэрэглэл байдаг. Үнэлгээний дагуу аль халамжийн арга хэмжээнд хамрагдах болохыг шийдвэрлэдэг ажээ.

5.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран харилцан зан чанар, хувь хүний онцлогийг хүндэтгэсэнээр хамт амьдрах нийгмийг бодит болгоно хэмээн Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хуулинд зорилгоо тодорхойлжээ. Энэхүү хуулиар ялгаварлан гадуурхалтын хэлбэрийг тодорхойлж, зөвхөн төрийн байгууллага төдийгүй хувийн байгууллага, олон нийтэд үүрэг хүлээлгэсэн тогтолцоо бүрдүүлж ажиллахаар заасан бөгөөд эцэстээ татан оролцуулсан хамтран амьдрах нийгмийг бий болгохыг зорихоор тусгажээ. Хэрэв хуульд үүрэг хүлээлгэсэн субьектүүд биелүүлэхгүй бол хариуцлага хүлээнэ.

6.Хөдөлмөрлөх чадваргүй хүмүүст нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэхдээ бие эрхтэн, сэтгэцийн хүндрэлтэй, оюун ухааны хомсдолтой, хөгжлийн бэрхшээлтэй гэж 4 ангилж ялгавартай ханддаг. Бие эрхтний хүндрэлтэй ХБ-тэй иргэд нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх хувийг эзлэх бөгөөд тэдэнд үзүүлэх үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэсэн мэргэжлийн байгууллагын төрөлжсөн гэж ангилдаг. Төрөлжсөн байгууллагын үйлчилгээ: хараа, сонсгол, оюун ухаан, хөдлөх эрхтний хүндрэлийг багасгах сэргээн засах үйлчилгээг мэргэжлийн түвшинд төрөлжсөн үйлчилгээний байгууллагаар дамжуулан үзүүлэх нь ХБ-тэй хүмүүсийн халамжийн үйлчилгээний нэг хэсэг болдог. Төрөлжсөн байгууллагын үйлчилгээнд хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүсийн онцлог нь тохирсон ажил хийлгэх, ярилцлага, семинарт, оруулах ажлын арга барил эзэмшүүлэх, түр хугацааны хөдөлмөр эрхлүүлэх зэрэг ажил хийдэг.

Дүгнэлт: Япон улс хууль зүйн системийн хувьд төрөлжүүлэн нарийвчилсан олон хуулиар уг харилцааг зохицуулдаг онцлогтой тул холбогдох харилцааг маш сайн дэлгэрэнгүй, ихээхэн тодорхой зохицуулдаг онцлогтой ажээ. Дээрх хэсэгт онцолсон 5 асуудлыг Монгол улс салбарын хуульдаа жишиг болгон харгалзах боломжтой гэж үзэв.

ТАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1.ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц нь нийт 50 зүйл, 138 хэсэг, 111 заалттай бөгөөд үнэлгээний баг энэхүү конвенцын хэрэгжилтийн үнэлгээгээр мэдээллийн хүрээ хязгаар, нээлттэй байдал, үндэсний онцлог зэрэгт үндэслэн конвенцын 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 31, 32, 33 дугаар зүйлүүд болон тэдгээрийн холбогдох хэсэг, заалтуудын хэрэгжилтийг үнэлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тусгасан эрх зүйн актын хувьд Монгол Улсын Үндсэн хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд жин дарах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалсан, нийгмийн бүхий л харилцаанд адил тэгш эрхтэй оролцох боломжийг бусад хуулиас илүү өргөн хүрээнд зохицуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын дээр дурдсан зүйлүүдийн 82.4% нь буюу 23 зүйл, 79 хэсэг, 81 заалт нь Монгол Улсын эрх зүйн орчинд (Үндсэн хууль болон бусад 930 орчим хууль тогтоомжид) тусгалаа олсон бол үлдсэн 17.6% нь дотоодын хууль тогтоомжид тусгагдаагүй, эсхүл хэтэрхий ерөнхий зохицуулагдсан шинжтэй байна. Тодруулбал, НҮБ-ын конвенцын 14-р зүйл эрх чөлөө, хувийн халдашгүй байдлыг хамгаалах, 15-р зүйл Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх, 17-р зүйл Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах, 18-р зүйл чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй зорчих, 21-р зүйл Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх, 26-р зүйл нөхөн сэргээлт, сэргээн засах, 33 дугаар зүйл конвенцын хэрэгжилт, хяналттай холбоотой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх нь манай улсын эрх зүйн орчинд тусгалаа олоогүй, эсхүл хэт ерөнхий зохицуулагдсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдалтай уялдуулан зайлшгүй нарийвчилсан хуулийн зохицуулалтыг болгох хэрэгтэй байна.

Монгол Улсын хувьд конвенцод нэгдэн орж анхны тайлангаа хэлэлцүүлж, мөн хорооноос зөвлөмж ирснээс хойш конвенц болон зөвлөмжид дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн суурь болсон хууль, эрх зүйн орчны шинэтгэлийг эрчимтэй явуулж байгаа нь үнэлгээний явцад ажиглагдлаа. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд шинэчлэн баталсан, мөн Монгол Улсын Засгийн газар Конвенцын 9 дүгээр зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд оролцох боломжийг бий болгох, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, хүрээлэн буй орчин, үйлчилгээ байгууламж зэрэг бүхий л түвшинд хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү харилцааг нарийвчлан зохицуулах Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийг боловсруулан олон нийтээр хэлэлцүүлж байна. Мөн 2018 оноос Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлого, хөтөлбөрийн, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой зохицуулалт, үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгасан байна.

Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг асуудлыг зөвхөн хууль, эрх зүйн актад тусгаад орхих нь практикт тулгараад буй асуудлыг бүхэлд нь шийдвэрлэх арга биш болох нь 2016 онд шинэчлэн батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль бүрэн утгаараа хэрэгжиж чадахгүй байгаагаас харагдаж байна. Тодруулбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлгээг хууль

батлагдсанаас хойш 2 жилийн дараа явуулахад давхардал 24,4 хувь, зөрчил 35,5 хувь, хийдэл 13,3 хувь байгааг тогтоосон. Ийнхүү 2018 тус хуульд байгаа асуудлыг тодорхойлж чадсан боловч үүнийг засан сайжруулах зорилгоор томоохон өөрчлөлт, шинэчлэлтийг огт хийгээгүй байна. Хэдийгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийт 6 удаагийн өөрчлөлт, 3 удаагийн нэмэлт, 1 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж байсан хэдий ч тэдгээр нь тус хуулийн үндсэн агуулгыг өөрчлөх бус, харин бусад хууль тогтоомжийг өөрчилсөнтэй холбоотой дагалдаж орсон өөрчлөлтүүд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн агуулга, хамрах хүрээ, зохицуулалтын түвшинд өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулиас дэвшилттэй зүйл олон хэдий ч хуулийн хэрэгжилт өнөөг хүртэл хангалтгүй, мөн Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Хүүхдийн эрхийн тухай, Нийгмийн халамжийн тухай зэрэг бусад салбар хуулиудаар зохицуулагдах харилцааг нэг хуульд багтаан зохицуулахыг оролдсоноороо алдаа дутагдалтай болжээ.

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль гол үзэл баримтлалаа эрхийн хууль байх уу, процессын харилцаа буюу илүү журамласан, үйл ажиллагааг зохицуулах уу гэдгээ тогтоох хэрэгтэй байна. Учир нь, одоогийн хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг зохицуулсан боловч журамласан харилцааг мөн зарим хэсэгтээ зохицуулсан, энэ нь Нийгмийн халамжийн тухай хууль болон Боловсролын ерөнхий тухай хуулиар зохицуулагдаж байгаа нь процессын харилцааг зохицуулах шинжийг бий болгож, улмаар хууль хоорондын давхардлын эх үндэс болж буй. Хэрэв эрхийг зохицуулах бол эрхийг бүлэглэж тогтоох, тухайн эрхийг хэрхэн эдлэх харилцааг зохицуулсан салбар хуулийг нэрлэж оруулах хэлбэрээр зохицуулалтыг оновчтой болгох хэрэгтэй. Мөн хуулийн бүтцийн хувьд нийгмийн халамж, боловсрол, амьдрах орчны зохицуулалт нь давхардсан, логик уялдаагүй байна. Жишээ нь, хуулийн 7 ба 8 дугаар бүлэг нь нийгмийн халамжийн бодлогыг зохицуулсан атал тус тусдаа бүлэг болсон, 9 дүгээр бүлэгт бусад эрхийг заахдаа хүүхдийн эрх, эмэгтэйчүүдийн эрхийг оруулсан нь өмнөх салбар эрхүүд нь хүүхэд, эмэгтэйчүүдэд хамаагүй мэт логикийн хувьд ойлгомжгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дахь зохицуулалтын нэр томьёог бусад хуультай уялдуулах шаардлага байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.6 дахь хэсэгт нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн хүний харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулахаас Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулахгүй гэдгийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.6 дахь хэсэг нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгтэй зөрчилдөж байна. Мөн өндөр насны тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас авах эрх үүссэн бол халамжийн сангаас олгох тэтгэвэр авах боломжгүй зэрэг ойлгомжгүй нөхцөлийг бий болгож байгаа нь конвенцын 12, 28 дугаар зүйлүүдэд заасан эрх зөрчигдөх нэгэн шалтгаан болж байна.

Практикт үүсээд байгаа эдгээр болон бусад хүндрэлийг даван туулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг нэг мөр болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын яамнаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах шаардлагатай байна.

Үнэлгээний багийн зүгээс 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 24, 25, 26, 27, 28, 29, 31, 32, 33 дугаар зүйлүүд тус бүр дээр товч дүгнэлтийг бичсэн бөгөөд тэдгээр дүгнэлтэд энэхүү хэсэгт доорх байдлаар конвенцын зүйлүүдийг хоёр ангилан хэсэгчилсэн дүгнэлт бичих нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. **Конвенцын хэрэгжиж байгаа зүйл, хэсэг заалтууд;**

Энэхүү хэсэгт үнэлгээнд хамрагдсан конвенцын зүйл, хэсэг, заалтуудын эрх зүйн орчинд тусгалаа олсон байдал, тэдгээрийн практикт хэрэгжиж байгаа байдлыг үнэлгээний явцад цугларсан судалгаа, мэдээлэл тулгуурлан үнэлэхэд явцад конвенцод заасан болон зөвлөмжид тусгагдсан үйл ажиллагаануудыг тодорхой түвшинд хэрэгжүүлж байгаа гэж үзэн энэхүү ангилалд оруулсан. Гэсэн хэдий ч энэ нь бүрэн хэрэгжиж байгаа гэсэн үг биш болохыг анхаарах шаардлагатай.

2. **Конвенцын хэрэгжилт хангалтгүй байгаа зүйл, хэсэг, заалтууд.**

Энэхүү хэсэгт үнэлгээнд хамрагдсан зүйл, хэсэг, заалтууд нь эрх зүйн орчинд тусгагдсан, эсхүл тусгагдаагүй болон ерөнхий байдлаар зохицуулагдсан, мөн тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд үүнээс үүдэн конвенцод заасан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдөж байгаа зүйлүүдийг энэхүү ангилалд оруулсан болно.

Дээрх байдлаар конвенцын хэрэгжилтийг үнэлсэн зүйл, заалтууд болон хорооноос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бичсэн хэсгүүдийг багцлан хэрэгжиж байгаа эсхүл хэрэгжихгүй байгаа зүйл, хэсгүүдийг багцах байдлаар дараах хэсэгт дүгнэлээ.

5.2.КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЖ БАЙГАА ЗҮЙЛ, ЗААЛТУУД.

7 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд: хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдийн нэгэн адил хүний бүх эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн, адил тэгш эдлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх арга хэмжээнд нэн тэргүүнд тэдний ашиг сонирхлыг хүндэтгэх болон тэднийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангах зэрэг заалтуудын хэрэгжилт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн орчныг сайжруулах (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016, Хүүхдийн эрхийн тухай 2016, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай 2016 онд баталсан г.м.), холбогдох бусад ажлуудыг Монгол Улсын гүйцэтгэх эрх мэдлийн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд авч хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусадтай ижил төвшинд бүх эрхийг эдлүүлэх зорилтоос Монгол Улс юуны өмнө боловсролын салбарт ихээхэн анхаарал хандуулж байгааг онцлох нь зөв байна.

ГБХНХЯ-ны тоон мэдээллээр 2022-2023 ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад нийт 16909 хүүхэд суралцаж байна. Харин сургуулийн өмнөх боловсролд нийт 4039 хүүхэд тус тус суралцаж байна.

8 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх: нийгмийн бүх хүрээнд нэмэгдүүлэх, тэдний оруулж буй хувь нэмрийг нийгэмд эергээр таниулах үндсэн суурь эрх зүйн зохицуулалт Монгол Улсад бий болсон байна. Харин эдгээрийг практикт хэрэгжүүлж байгаа байдал сургалт, уулзалт, хурал

зохион байгуулах, зэргээр нийгмийн тодорхой бүлэг, хүмүүсийн дунд өрнөж байгаа хэдий ч нийгмийн бүхэлд нь хамарч чадахгүй байгааг анхаарч сайжруулах шаардлагатай. Монгол Улсад нийт 20 орчим яамд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн дэд зөвлөлтэй бөгөөд тэдгээр тогтмол үйл ажиллагаагаа явуулж, салбар бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцог нэмэгдүүлэх, нийгэмд эерэг хандлагыг бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлж, жил бүр тодорхой тайлан мэдээллийг нээлттэй мэдээлсээр байна.

9 дүгээр зүйл.Хүртээмж: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжтэй холбоотой конвенцын заалт тохиолдолд хэрэгжиж чадаагүй зарим нэг дүр зураг ажиглагдаж байгаа буюу Улаанбаатар хотын хүн ам ихээр явдаг төвийн дүүргийн 12 барилга нь “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин” MNS 6055:2009 стандартад нийцэж байгаа эсэхийг судлахад тэдгээр барилгын 75 хувь нь стандартад нийцээгүй дүн гарсан.

Гэсэн хэдий ч Монгол Улсын зүгээс хүртээмжийг нэмэгдүүлэхээр хэд хэдэн томоохон ажлын үр дүнгийн илрэл нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг баталж, тус хуулийн 23.5-д “дохионы хэл”-ний шаардлагыг телевизийн зарим төрлийн нэвтрүүлэг заавар байх шаардлага байхаар шинэлэг хуулийг зохицуулалтыг бий болгожээ. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар, Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэхүү хүндрэлийг шийдвэрлэх, цогц үйл ажиллагааг эхлүүлэхээр Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгээд байгааг онцлох нь зүйтэй.

Мөн Барилгын тухай, Хот байгуулалтын тухай хуулиудын дагуу Барилгын хөгжлийн төв нь хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх шатанд “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” /БНбД 30-01-04/, "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНбД 31-23-22/, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага” /БД 31-101-04/”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт” /БД 31-112-11/ болон холбогдох бусад норм, стандартын шаардлагыг хангуулан хянаж баталгаажуулан ажиллаж байна.

10 дугаар зүйл. Амьд явах эрх: энэхүү эрхийн хэрэгжилт эрх зүйн орчинд тодорхой тусгагдсан бөгөөд хүний амьд явах эрхийг дотоодын хууль тогтоомжоор хангалттай сайн хамгаалсан байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний амьд явах эрхийг ямар нэг байдлаар бусниулсан, тэдний энэхүү эрхийг бусад хүмүүсийнхээс ялгамжтай байдлаар авч үзэх шаардлагагүй бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоор амьд явах эрхийн баталгаа бүрэн хангагдсан байна.

13 дугаар зүйл. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрх: Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот дахь шүүхүүд болон 21 аймаг дахь шүүхүүд хөгжлийн бэршээлтэй иргэдэд шүүхийн үйлчилгээг ойртуулах, шүүхэд ажиллаж байгаа шүүхийн захиргааны ажилтнуудыг сургах, бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх тодорхой ажлуудыг зохион байгуулж байгаа бөгөөд энэ нь шүүхийн үйл ажиллагааны тайлангийн салшгүй нэг хэсэг болсныг дурдах нь зүйтэй. Харин цагдаагийн байгууллагын зүгээс сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдээс дуудлага, мэдээлэл хүлээн авах зорилгоор тусгайлсан программыг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглан 2020 онд 91, 2021 онд 103 иргэнээс яаралтай тусламж, мэдээллийг богино зурвасаар хүлээн авч, холбогдох байгууллагад асуудлыг шилжүүлсэн нь сайшаалтай байна.

Гэхдээ зарим тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа мөрдөгч, прокурор гэрч, хохирогч, яллагдагчийг орчуулагч, хэлмэрч авах эрхээр хангаагүй, заавал энэхүү эрхийг хангах ёстой гэдгээ өөрсдөө мэдээгүй тохиолдолд гарч байгааг эрх бүхий байгууллагуудад анхааралдаа авч, ажилтан албан хаагчдын гаргаж буй энэ мэт зөрчлийг таслан зогсоох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх сөрөг хандлагыг өөрчлөх зайлшгүй шаардлага байна.

15 дугаар зүйл.Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх: эрүүдэн шүүхтэй холбогдсон нөхцөл байдал, эрүү шүүлтийн эсрэг үйл ажиллагаа, авах арга хэмжээ, түүний суурь зохицуулалт Монгол Улсын эрх зүйн орчинд бий болсон бөгөөд мөн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод нэгдэн орсон байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон бусад үед аливаа хэлбэрээр эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус харьцах асуудал зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүний хэмжээнд бус нийтлэг байдлаар хурцадмал буюу эрүү шүүлттэй холбоотой асуудлууд гарсаар байна. Цагдаа, прокурор болон Хүний эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагад эрүү шүүлттэй холбоотой ирсэн гомдол, холбогдох тоон мэдээлэл нь тооны хувьд зөрүүтэй байгаа хэдий ч тухайлан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй холбогдсон, тэдний эрхийг ноцтой зөрчсөн талаарх мэдээлэл байхгүй байна.

Монгол Улсын хувьд Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд заасны дагуу Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааг албажуулж, тус гишүүн хуульд заасан шаардлагатай үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхээс гадна Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайланг 2022 оноос эхлэн гаргаж, энэ талаарх мэдээлэл Монгол Улсад илүү нээлттэй болж байгаа сайшаалтай байна.

Мөн 2021 болон 2022 оны нийт 25,000 гаруй шүүхийн шийдвэрүүдээс шүүлт хийж үзэхэд нийт 50 орчим хэрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс холбогдсон бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрүүдэн шүүсэн, хүнлэг бус харьцсан, нэр төрийг нь доромжилсон тоон мэдээлэл, эсхүл шүүхийн шийдвэр байхгүй байна.

18 дугаар зүйл.Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх: Конвенцын 18 дугаар зүйлд заасан эрхүүд талаарх дотоодын эрх зүйн орчны нөхцөл байдлыг авч үзэхэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулиар тус тус биеллээ олсон байна. Нөгөөтээгүүр, дээрх үүргээ хэрэгжүүлээгүй, үүргээ биелүүлэхээс зайлсхийсэн тохиолдол нь зөрчлийн шинжтэй бол Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулах, хэрэв уг үүргээ биелүүлээгүй, үүргээ хэрэгжүүлээгүй нь гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тооцогдохоор бол Эрүүгийн хуульд тусгах шаардлагатай бөгөөд хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай.

20 дугаар зүйл. Хувийн хөдөлгөөнийг дэмжих: Монгол Улсын Засгийн газар болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам нийгмийн халамжийн сангаас тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд протез, ортопед, тусгай хэрэгслийн

хөнгөлөлтийг хууль заасан хугацаанд үзүүлэх, энэхүү нөхцөлийг тогтоосон жагсаалтын 1-2 жилийн давтамжтайгаар шинэчилж байна.

Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Бионик хиймэл эрхтний сэлбэг, засварын үйл ажиллагаанд тодорхой хөнгөлөлт авах, ухаалаг гар утас, харилцаа, мэдрэхүйг хөгжүүлэх туслах хэрэглэгдэхүүн, тайвшруулах хэрэгслүүдийн жишиг үнэ, түүнд олгох хөнгөлөлтийг эдлэх эрх зүйн орчин шинэчлэгдсээр байна.

Харин нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийг хэмжээ нь 2020 оны жишгээр байгаа бөгөөд энэ нь 16,000-288,000 төгрөгийн хооронд байгаа нь Монгол Улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (550,000)-нээс бага байгаа буюу хорооноос өгсөн зөвлөмжийн "..хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонголт хийх боломж олгож, тэтгэмжийг нэмж, чанартай туслах хэрэгсэл, технологи, үйлчилгээг олдоцтой болгох" хэсэг бүрэн биелэгдэж чадаагүй гэж үзэж болох хэрэгжилтийг илүү сайжруулах хэрэгтэй.

23 дугаар зүйл. Орон байр гэр бүлийг хүндэтгэх: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүл болох, хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, мөн тэд хүүхэд үрчлэхтэй холбоотой эрх зүйн орчны тухайд оюуны хөгжлийн бэрхшээлтэйгээс бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн конвенцод болон зөвлөмжид заасан эрх аливаа байдлаар хязгаарлагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэйгээс нь шалтгаалан тэднийг үр хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, эсхүл хүүхэд үрчилж авахыг хязгаарласан хууль тогтоомж зөвхөн оюуны хөгжлийн бэрхшээлээс бусад тохиолдолд байхгүй.

Мөн конвенцод заасан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд шаардлагатай тусламж, дэмжлэгийг төрөөс үзүүлэхэд нөхцөл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 онд шинэчлэн батлагдсанаар тодорхой хэмжээнд сайжирчээ.

27 дугаар зүйл. Ажил хөдөлмөр эрхлэлт: Монгол Улс хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж болох 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн хуулийг шинэчлэн найруулж тус хуулийг 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Хуулийн шинэчилсэн найруулгад хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхтэй холбоотой үндсэн зохицуулалтууд тусгагдсан, мөн 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах хуулийн зохицуулалтын агуулга хэвээр байгаагийн сацуу тухайн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй төлөх төлбөрийг хөдөлмөрийн хөлстэй уялдуулсан, ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үүргийг хуульчилсан зэрэг хэд хэдэн дэвшилттэй заалтууд тусгагджээ.

Шинэ хуулийн хэрэгжилтийг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэхэд хуулийн хэрэгжилтийн хангалт улсын хэмжээнд 2022 оны байдлаар 60.0% байгаа бол энэхүү үзүүлэлт төрийн байгууллагуудад 59%, хувийн хэвшилд 61% байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын хэмжээнд 3838 хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулах боломжтой байсан.

Улмаар Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлд 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах заалтыг хэрэгжүүлэх тохиолдолд

тухайн байгууллага хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (2022 онд 420,000, 2023 онд 550,000 төгрөг, 2024 онд 660,000, 2025 онд 770,000 төгрөг)-тэй тэмцэх мөнгөн хөрөнгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөхөөр заасан.

Түүнчлэн Хөдөлмөрийн хуулийн 144.2 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн хуульд заасан торгууль нь иргэнийг 150,000 төгрөг, аж ахуйн нэгжийг 1,500,000 төгрөг байгаа бөгөөд мөн учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулахаар тус тус заасан нь хуулийн хэрэгжилтийг хангахад онцгой ач холбогдол бүхий хариуцлагын механизм юм.

32 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах зорилгоор бүс нутгийн болон олон улсын түвшин дэх хамтын ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн хэд хэдэн томоохон төслүүд хэрэгжиж байна. Тодруулбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр НҮБХС, Азийн Хөгжлийн Банк (АХБ), Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), БНХАУ-ын засгийн газар, ЮНЕСКО, Дэлхийн банк, Хүүхдийг ивээх сан, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, АИФО Италийн төрийн бус байгууллага, ADRA, Канад сан, Мерси Кор, Европын холбооны “SOCIEUX PLUS” зэрэг олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж хамтран ажиллаж байгаа нь сайшаалтай.

Хэрэгжилтийн үнэлгээний явцад олон улсын хамтын ажиллагааны явцад хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа нийт 20 орчим төсөл байгаа хэдий ч тэдгээрийг практикт бүрэн хэрэгжүүлж дуусгасан эсэх, мөн хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээний тайлан байхгүй байна. Түүнчлэн холбогдох төсөл хөтөлбөрүүдэд хэчнээн хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан, тэд ямар мэдлэг чадвар эзэмшсэн талаарх мэдээллийг илүү ил тод, нээлттэй мэдээлэх шаардлагатай байна.

Мөн олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад хэдэн ам.доллар эсхүл төгрөгийн санхүүжилт олгогдсон, түүний үр дүн хэрхэн гарсан, ямар ажил хийгдсэн талаар нэгдсэн мэдээллийн сан бий болгох нь зүйтэй үзлээ.

5.3. КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА ЗҮЙЛ, ЗААЛТУУД

5 дугаар зүйл. Адил тэгш байдал, үл алагчлал

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ахлуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл идэвхтэй ажиллаж байна. Мөн Монгол Улсын холбогдох яамдад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл ажиллаж байгаа бөгөөд тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох яам нь тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг анхааран авч үзэж, жил бүр үйл ажиллагаагаа явуулж байгаа нь сайшаалтай. Гэсэн хэдий ч энэхүү орон тооны бус зөвлөлийн даргыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дээр тодорхой зааж өгөөгүй учир зарим тохиолдолд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, зарим тохиолдолд Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд тэргүүлж байгаа буюу удирдлага нь тогтворгүй байна Иймээс зөвлөлийг тэргүүлэх даргыг тодорхой тусгаж, зөвлөлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах шаардлагатай. Нөгөөтээгүүр орон бус зөвлөл учир үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх төсвийн эх үүсвэр хангалтгүй байгаа учир

санхүүжилтийн эх үүсвэр болон үйл ажиллагааны нарийвчилсан дарааллыг хуульд тусгах шаардлагатай.

Цаашилбал, судалгаанд дурдагдсан мэдээллээс үзэхэд конвенцын 7 дугаар зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аливаа алагчлалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, үндсэн эрх, эрх чөлөөг эдлүүлэх заалт практикт оновчтой хэрэгжиж чадаагүй бөгөөд тэдний эрх одоо ч гэсэн зөрчигдсөөр байгаа боловсрол, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхэд төрүүлэх эрхийн зөрчил зэргээс харагдаж байна.

6 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд: дотоодын их, дээд сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд нийт 145,267 оюутан суралцаж байгаагийн ердөө 0.15 хувь буюу 230 нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дээд боловсрол эзэмшиж байгаа байдал туйлын хангалтгүй буюу боловсролын тэгш бус нөхцөлд байгааг тодорхой илтгэнэ. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд бэрхшээлтэй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс хоёр дахин их хувиар ажилд орох боломжтой байгаа нь хөдөлмөр эрхлэлтэд хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдтэй зөвлөлдөх, тэднийг оролцоог нэмэдүүлэх агуулга манай улсад хэрэгжиж чадаагүй, тэд хөдөлмөрийн харилцаанд оролцохдоо тэгш эрх эдэлж чадахгүйг байгааг харуулна.

Мөн Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдрал, болон гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх үүргийг хүлээлгэсэн боловч бодит байдалд 20-с дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 32,8% нь огт гэрлээгүй, 14,9% нь салсан буюу бэлэвсэн амьдралтай байна. Тэдэнд гэр бүл төлөвлөлт нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг дутмагаас гадна олон нийт, эмч мэргэжилтнүүд тэдний хүүхэд төрүүлэх, хүнтэй гэрлэх эрхтэй, мэдрэмжтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй хандлагыг зайлшгүй өөрчлөх шаардлага бий болжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцсон холбогдох судалгаанд оролцогчдын 74 хувь нь Гэр бүлийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өмнө нь өртсөн байгаа нь конвенцын заалт практикт биеллээ олоогүйг илтгэнэ.

11 дүгээр зүйл. Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн агуулга нь гамшиг, аюулт үзэгдэл, осол гарсан үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэдээлэл хэрхэн хүргэх, хамгаалах талаар зохицуулсан бөгөөд зүйлийн нэр нь онцгой байдлын үед гэсэн нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-4.1.3 дахь заалттай нийцэхгүй байгаа тул Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 36.1 дэх хэсгийн “нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол” гэж өөрчлөх нь зүйтэй байна.

Мөн конвенцын 11 дүгээр зүйлд заасан эрсдэл бүхий нөхцөл байдал бий болсон Коронавируст халдварын цар тахлын дэгдэлтийн ид үе буюу 2020-2021 онуудад Засгийн газар, Улсын онцгой комиссын зүгээс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст яаралтай тусламж хүргэх, тэднийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах тусгайлсан төлөвлөгөө, үйл ажиллагааны заавар байгаагүй бөгөөд үндсэн төлөвлөгөөний зарим хэсгээр зохицуулж байсан нь тэдний эрх зөрчигдөх шалтгаалж болж, эрхийн зөрчлийг таслан зогсоох үүднээс Хүний Эрхийн Үндэсний комисс шаардлагатай зөвлөгөө, зөвлөмжийг хүргүүлэн

ажиллаж байсан нь энэ чиглэлийн эрх зүйн орчин, түүнд үндэслэсэн төлөвлөгөө, үйл ажиллагааг даруй бий болгох шаардлагатай харуулж байна.

Конвенцын 12 дугаар зүйл.Хуулийн өмнө эрх тэгш байх: энэхүү эрхийн үндсэн зарчмыг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудад тусгасан.

Харамсалтай нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэхүү хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн хүрээнд хуулийн дагуу маргаан, хэрэг, аливаа эрх зүйн харилцааг шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломж хомс байна. Тухайлбал, оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхийн журмаар тогтоох, шүүхэд хүсэлт гаргах, шүүхийн ажиллагааг явуулах бүхий л үйл ажиллагаанд оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэний өөрийн нь оролцоо, түүний хүсэл зориг, санал бодлыг сонсох, харгалзан үзэх хуулийн зохицуулалт байхгүй бөгөөд энэхүү ажиллагаа Иргэний хууль (18.2, 18.3, 18.4), Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (133, 142, 143)-д зааснаар бүхэлдээ тэдний оролцоогүйгээр, бусад этгээдээс хамааралтайгаар явагдаж байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, конвенц, хорооноос өгсөн зөвлөмжийн хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх хэсэг Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зохицуулалтаар хязгаарлагдах, хэрэгжихгүй байх, тэднийг нийгмийн харилцаанд бие даан оролцох, хэлцэл хийх эрхийг зөрчиж байна гэж үзлээ.

Конвенцын 14 дүгээр зүйл. Эрх чөлөө, хувийн халдашгүй байх эрх: Конвенц болон хорооны зөвлөмжид тусгагдсан “...оюуны болон сэтгэц нийгмийн бэрхшээлтэй хүмүүсийг албадан эмнэлэгт хэвтүүлэх, институтэд байлгах гэх мэтээс хамгаалах хуулийн хамгаалалт Үндсэн хуулиас өөр хангалттай байхгүй байгаа” талаарх зөвлөмжтэй холбоотой нөхцөл байдал өнөөг хүртэл энэ хэвээр байгаа бөгөөд холбогдох хуулийн зохицуулалтууд оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хязгаарласан, тэднийг эрхийг хүндэтгэх бус албадан эмчлэх, номхотгох, эрэн сурвалжлах зэргээр өнөөдрийг хүртэл явж ирсэн нь 2015 оноос хойш энэ талаар эрх зүйн орчинд өөрчлөлт гараагүйг харуулж буй.

Үүний улмаас энэ төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдөх, албадан эмчлэгдэх, эмнэлгээс сайн дураар гарах боломж хязгаарлагдаж, энэ төрлийн зөрчил тасрахгүй байна.

17 дугаар зүйл. Хувийн нэгдмэл байдлыг хангах: Оюуны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүний хүүхэд төрүүлэх эрхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын зохицуулалт нь конвенцын заалт болон хорооноос 2015 онд өгсөн зөвлөмжтэй хэр нийцэж байгааг авч үзэхэд хэрэгжиж чадаагүй байна. Эрүүл мэндийн сайдын оюуны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид тэдний хүсэлт, зөвшөөрлөөр хожуу үед үр хөндөх эрхийг олгосон Эрүүл мэндийн сайдын баталсан “Үр хөндөлтийг зохицуулах тухай” журам өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилсээр байгаа хэдий ч тус журмаас оюуны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүн хүүхэд төрүүлэх хориглох заалтыг хассан. Энэ нь конвенц, зөвлөмжийн “...сэтгэц нийгмийн болон оюун ухааны бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хязгаарлаж, албадан үрийн сувгийг боох, үр хөндөхийг зөвшөөрдөг хууль болон холбогдох тогтоол журмыг Эрүүл мэндийн хуулиас хасах” болон хэсэг биелэгдсэн бол “үр хөндөхийг зөвшөөрдөг хууль болон холбогдох тогтоол журмыг Эрүүл мэндийн хуулиас хасах” хэсэг биелэгдээгүйг харуулж байна.

Конвенцын 19 дүгээр зүйл. Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх: хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах болон тухайн оршин сугаа орчиндоо байх эрх болон хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг авч үзэхэд эрх зүйн зохицуулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон барилгын тухай, Авто замын тухай, Орон сууцны тухай зэрэг 10 орчим хууль тогтоомжид тусгасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дэд бүтэц байхгүй, төр захиргаа олон нийтийн үзвэр үйлчилгээний газрууд тэдний асуудлыг орхигдуулсны улмаас хязгаарлагдмал нөхцөл байдалд амьдрахаас өөр аргагүй байдал хэвээр байна. Дүүргийн хөдөлмөр хамгааллын хэлтэс, хорооны байр, Засаг даргын тамгын газрын байр, эмнэлэг, банк зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн заавал зорчих шаардлагатай нийгмийн суурь үйлчилгээг үзүүлж байгаа газруудын дэд бүтцийг авч үзэхэд талаас илүү нь хөгжлийн бэрхшээлтэй хүний орчин байх эрхийн хангах үзүүлэлтийн муу гэсэн үнэлгээтэй байна.

Хэрэгжилтийн үнэлгээний хэсэгт дурдагдсан судалгаанд хамрагдсан байгууламжуудын 90% нь авто зогсоолдоо хөгжлийн бэрхшээлтэй хүний авто зогсоолын төлөвлөлт хийгээгүй, зогсоолын өргөн стандарт бус өргөн, 90%-д нь тэмдэг тэмдэглэгээ байхгүй, 8 байгууллагын налуу зам нь стандарт бус зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрах болон тухайн орчиндоо оршин байх нөхцөл бүрэн хангагдаагүй хэвээр байна.

Конвенцын 24 дүгээр зүйл.Сурч боловсрох эрх: энэхүү эрхийн үндсэн агуулга Монгол Улсын эрх зүйн орчинд тусгалаа бүрэн олсон хэдий ч тэдгээрийн хэрэгжилт практикт төдий л сайн биш байгааг илэрхийлж байна.

БШУЯ-ны 2022 оны тоон мэдээлэлд 1498 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа талаар мэдээлсэн бөгөөд Улаанбаатарт 835, Зүүн бүсэд 112, төвийн бүсэд 199, Хангайн бүсэд 236, Баруун бүсэд 111 хүүхэд тус тус хамрагдаж байна. Харин Ерөнхий боловсролын 1-12 дугаар ангиудад 5673 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа бөгөөд үүнээс бага ангид 2653 хүүхэд, дунд ангид 2285 хүүхэд, ахлах ангид 735 хүүхэд тус тус суралцаж байгаа нь нийт суралцагчдын тоотой харьцуулахад бага байсан.

Харин 2024 оны тоон мэдээллээр сургулийн өмнөх боловсролд хөгжлийн бэрхшээлтэй 2,150 хүүхэд, үүнээс Улаанбаатар хотод 1,199 хүүхэд, баруун бүсийн аймагт 193 хүүхэд, хангайн бүс 268 хүүхэд, төвийн бүс 313 хүүхэд, зүүн бүс 130 хүүхэд тус тус хамрагдсан.

Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 6,273 хүүхэд, их дээд сургуульд 653 суралцаж байна.

Орчны бэрхшээл болох орц, гарц, шат, довжоо, нойлын өрөө зэрэг байгаа бөгөөд сургуулиуд налуу зам, шат хийсэн хэдий ч стандарт нормыг хангаж чадаагүй байна. Өөрөөр хэлбэл гялгар, гөлтгөр материалаар хийсэн нь халтирч унах эрсдэлд оруулж байна. Ихэнх сургуулиуд налуу зам, шат, лифт, чиглүүлэгч зэргийг төлөвлөөгүй, мөн нэг үндсэн багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүрч заахад бэрхшээлтэй, ачаалалтай байдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон ганцаарчилсан дэмжлэг хангалтгүй зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй үндсэн нөхцөл болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Барилгын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль болон тус салбарын хуулиудын хэрэгжилтийг хангах механизм, хөшүүрэг сул байсаар байна. Барилгын стандарт, норм-шаардлага хангахгүй байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар Боловсролын яамны үүрэг хүлээсэн журам, стандартууд ихэнхи нь батлагдаагүй зэргээс шалтгаалж байна.

25 дугаар зүйл. Эрүүл мэндээ үйлчилгээгээр хангагдах эрх: хөгжлийн бэрхшээлтэй хүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр хангагдах, нөхөн сэргээгдэх болон бусад төрлийн эмчилгээ үйлчилгээ авах эрхүүд УИХ, ЗГ-аас гаргаж байгаа бодлого, хөтөлбөрүүд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тодорхой тусгалаа олсон хэдий ч Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тодорхой зохицуулалтгүй байна.

Түүнчлэн холбогдох хуулийн зохицуулалт, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт практикт хангалттай биш байгаа буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 20.1, 20.2, 20.3 дахь заалтыг хэрэгжилт хангалттай биш байгаа нь Эрүүл мэндийн яамны тайлан мэдээллээс харагдаж байна.

Мөн конвенцын 25 дугаар зүйл болон зөвлөмжид заасан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх тусгайлсан хөтөлбөр, эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор Засгийн газар болон Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамнаас тухайлан гаргаагүй.

Харин Ковид-19 цар тахлын үед Гэр бүл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн холбогдох бусад байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал хандуулж хөгжлийн бэрхшээлтэй тусламж, үйлчилгээнд зайлшгүй хамрагдах шаардлагатай нийслэл хотын нийт 1076 иргэний тусламж, үйлчилгээ үзүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг эмчлэх 120 ор дэлгэн ажиллуулсан. Энэ хүрээнд нийт 24 хөгжлийн бэрхшээлтэй батлагдсан тохиолдол, 19 хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнд тусламж, үйлчилгээ үзүүлж хэвтүүлэн эмчилсэн болон бусад үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн байна.

26 дугаар зүйл. Нөхөн сэргээлт: конвенцын 26 дугаар зүйлийг алдаатай орчуулснаас үүдэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зөвхөн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрх зүйн зохицуулалт давамгайлж байна.

Тэрчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхөн сэргээлт, сэргээлт засалтай холбоотой нарийвчилсан, тухайлсан хуулийн зохицуулатыг эрх зүйн орчинд нарийвчлан тусгаагүй бөгөөд зөвхөн Эрүүл мэндийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудад нөхөн сэргээлт, сэргээн засах үйлчилгээ, эмчилгээний маш ерөнхий агуулгууд тусагдсан. Мөн иргэдийг аливаа байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна. Монгол Улсын Их Хурлаас 2024 оны Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай анхдагч хуулийг баталсан хэдий ч тус хуульд энэхүү агуулга мөн л орхигджээ.

Харин эрүүл мэндийн нөхөн сэргээлт, сэргээн засах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөц мөн л дутмаг байна. Тодруулбал, Монгол Улсад 2022 оны байдлаар ЭМДЕГ-тай гэрээ байгуулан ажиллаж буй 46 сувилалд ажиллавал зохих хүний нөөцийг тооцож

үзэхэд, улсын хэмжээнд хамгийн багадаа 92-184 мэргэжлийн хөдөлгөөн засалч, 46-138 мэргэжлийн хөдөлмөр засалч, 46 хэл засалч, нийгмийн ажилтан, эмнэлзүйн төрөлжсөн мэргэшлийн эмч шаардлагатай байгаа хэдий ч хүний нөөцийн, шаардлагатай эмч, мэргэжилтэн, засалчид дутмаг байгааг судалгаагаар тогтоосон.

Бүх насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан нөхөн сэргээлт, сэргээн засалтыг конвенцод заасан эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарт өргөн хүртээх нөхцөлийг хараахан бий болгож чадаагүй хэдий ч нийгмийн тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн зарим нэг ажил хийгдэж байна.

31 дүгээр зүйл. Статистик болон мэдээлэл цуглуулах: Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэний статистик мэдээллийг Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар тус тус жил түр гаргаж байгаа боловч одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний статистик мэдээллийн нэгдсэн мэдээлэл гаргадаг, мөн олон нийтэд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тухай бүр танилцуулдаг, нээлттэй мэдээлдэг тусгайлсан бүтэц, байгууллага байхгүй байна. Мөн холбогдох төрийн байгууллагуудаас гадна судалгаа, шинжилгээ явуулах аргаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдсон шинэ төрлийн статистик, дата, мэдээлэл ихээр бий болж байна.

Нөгөөтээгүүр Монгол Улс 2008 онд нэгдэж орсон конвенцыг 2017 онд орчлуулсан хэдий ч зарим нэг нэр томьёог буруу, алдаатай, зөрүүтэй орчуулснаас үүдэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ангиллыг буруу тодорхойлох, түүнээс улбаалсан статистик мэдээллийн зөрүүтэй байдал хурцаар хөндөгдөж байна. Үүний үр дагавраар конвенцод заасан харилцаа, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхүүд Монгол Улсын хууль тогтоомжид зөрүүтэй байдлаар томьёологдох, буруу эрх зүйн ойлголтууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд зөрчил учруулах хүртэл асуудал үүсгэж болзошгүй.

Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасан “энэхүү конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор бодлого, стратеги боловсруулах, статистик болон судалгааны мэдээллийг оролцуулан шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулах, тэдгээр мэдээллийг тухайн бодлогод ашиглах үүрэг хүлээнэ” гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэгдсэн статистик болон судалгааны мэдээллийг төвлөрүүлсэн санг бий болгох, конвенцын орчуулгыг эргэн харж, түүнийг дахин орчуулах, дотоодын эрх зүйн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй холбогдох зарим нэг нэр томьёог олон улсын жишиг нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

33 дугаар зүйл. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих: конвенцын 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “...энэхүү конвенцын хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, хамгаалах ажиллагааг эрхэлсэн бүтцийг шаардлагатай тохиолдолд байгуулах...”, 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтад “Засаг дарга нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах бүрэн эрхтэй” гэж заасан боловч манай улсад тус конвенцын хэрэгжилтэд хяналт тавьдаг тухайлсан байгууллагыг холбогдох хууль тогтоомжид зааж өгөөгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавих үүрэгтэй талаар

хуульчилсан боловч шууд байдлаар конвенцын хэрэгжилтэд хяналт тавихаар зохицуулсан зохицуулалт байхгүй байна. Тэрчлэн конвенцын хэрэгжилтийг хангах ажлыг ГБХНХЯ, Хөгжлийн бэрхгээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас гадна албан бусаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл, түүний дэд болон салбар зөвлөл гүйцэтгэж байгааг онцлох нь зүйтэй. Харамсалтай нь энэ бүтцэд байнгын ажлын алба байхгүй, мөн тодорхой төсөв, мөнгө хуваарилдаггүй тул энэхүү бүтцийг эрх зүйн орчинд албажуулан тусгайлсан ажлын албатай болгож болох юм.

Гэсэн хэдий ч конвенц болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжилтийг хангах хариуцлагын механизм Монгол Улсад туйлын дутмаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотойгоор эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд хориглох 6 төрлийн хориглолт (хуулийн 6.1, 9.5, 17.4, 17.5, 28.7, 31.2)-ыг тусгасан хэдий ч эдгээр хориглолтыг зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлага тодорхойгүй байна. Монгол Улсын Зөрчлийн тухай хуульд холбогдох хууль тогтоомжид заасан хориглолтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгасан бөгөөд тус хуульд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах, эрх хэсэх гэсэн 4 төрлийн шийтгэлийг оногдуулахаар заасан.

Харамсалтай нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан хориглосон агуулга бүхий зохицуулалтыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлага нь Зөрчлийн тухай хуульд тусгагдаагүй учир тэдэнд шийтгэл оногдуулах ямар ч боломжгүй байна. Ийнхүү конвенцод заасан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тухайлан заасан, энэ төрлийн харилцааны суурь хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн хэлбэр, хэмжээг Зөрчлийн тухай хуульд зааж өгөөгүй учир конвенцыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тухайлсан гомдлыг хянан шийдвэрлэх процесс Монгол Улсад шаардлагатай байна.

Иймд конвенцын дээрх заалттай нийцүүлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хууль тогтоомж болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэх, хамгаалах ажиллагааг явуулах үүргийг хуульчлах, түүнчлэн тус үүргээ хэрэгжүүлэхдээ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Хорооны зөвлөмж, анхны илтгэлд тусгасанчлан Конвенцын хэрэгжилтийг хянахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудыг бүрэн дүүрэн оролцуулах байдлаар үйл ажиллагаа явуулах, шаардлагатай арга хэмжээ авах, мөн конвенцын хэрэгжилтийг хангах тусгайлсан бүтэц бий болгох, эсхүл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийг ажлын албатай болгох талаар зохицуулж өгөх нь зүйтэй гэж дүгнэв.

5.4. ЗӨВЛӨМЖ:

Үнэлгээний багийн зүгээс НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенцын хэрэгжилтийн үнэлгээ, түүний ерөнхий болон хэсэгчилсэн дүгнэлтэд тус тус үндэслэн конвенцын болон зөвлөмжийг хэрэгжилтийг сайжруулах дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

5.4.1.Эрх зүйн орчныг сайжруулах, конвенцыг хэрэгжилтийг хангах чиглэлээр:

- Улсын Их Хурал, Засгийн газраас болон салбарын яамдаас боловсруулж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой үйл ажиллагааг тусгах тохиолдолд тэдгээрийг хэрэгжүүлэгчийн болон санхүүжилтийн тооцоолол, түүний эх үүсвэрийг тодорхой заах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн албан ёсны орчуулгыг дахин хийх, ийнхүү конвенцийн албан ёсны шинэ орчуулгад үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдох хууль зүйн нэр томьёог бүхэлд нь шинэчлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016/-д байгаа давхардал 24,4 хувь, зөрчил 35,5 хувь, хийдэл 13,3 хувийн давхардал, хийдэл, зөрчлийг яаралтай шийдвэрлэх эсхүл хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулах;
- Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг 2025 онд багтаан Засгийн газрын хурлаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх, батлуулах;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3-т заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон энэхүү хуультай шууд уялдаа бүхий зөвлөмжийн хавсралтад заасан хууль тогтоомжуудад хэрэгжилтийн үр дагаврыг үнэлгээ, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй холбогдсон заалтуудыг заавал үнэлгээнд хамруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан хориглосон агуулга бүхий заалтыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлага нь Зөрчлийн тухай хуульд тусгагдаагүй учир тэдэнд шийтгэл оногдуулах ямар ч боломжгүй байгааг даруй өөрчлөх буюу Зөрчлийн тухай хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэлд оногдуулах шийтгэлийг тусгах байдлаар нэмэлт оруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн боломжит хэлбэрээр гаргасан өргөдөл, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх тухайлсан зохицуулалтыг Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар тухайлсан гомдлын механизмыг бий болгох;
- Оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхийн журмаар тогтоох, шүүхэд хүсэлт гаргах, шүүхийн ажиллагааг явуулах бүхий л үйл ажиллагаанд оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэний өөрийн нь оролцоо, түүний хүсэл зориг, санал бодлыг сонсох, харгалзан үзэх хуулийн зохицуулалт байхгүй бөгөөд энэхүү ажиллагаа Иргэний хууль (18.2, 18.3, 18.4), Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (133, 142, 143)-д зааснаар бүхэлдээ тэдний оролцоогүйгээр, бусад этгээдээс хамааралтайгаар явагдаж байгааг өөрчлөх. Ийнхүү өөрчлөхдөө холбогдох өөрчлөлтийг Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан хэлцэл хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх буюу холбогдох нэмэлт, өөрчлөлтийг Иргэний хуульд оруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, практикт бүрэн хэрэгжүүлэх зорилгоорх холбогдох нэмэлт, өөрчлөлтийг дараах хууль тогтоомжуудтай яаралтай оруулах:

- Автотээврийн тухай хууль /1999 он/;
- Харилцаа холбооны тухай хууль /2001 он/;
- Иргэний хууль /2002/
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /2002 он/;
- Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай /2008 он/;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /2011 он/;
- Нийгмийн халамжийн тухай /2012 он/;
- Авто замын тухай /2017 он/;
- Гамшгаас хамгаалах тухай /2017 он/;
- Зөрчлийн тухай /2017 он/;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /2019 он/;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /2021 он/.

- Конвенцын 14-р зүйл эрх чөлөө, хувийн халдашгүй байдлыг хамгаалах, 15-р зүйл Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх, 17-р зүйл Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах, 18-р зүйл чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй зорчих, 21-р зүйл Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх, 26-р зүйл нөхөн сэргээлттэй холбоотой хэсгүүдийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд болон Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Иргэний бүртгэлийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиудад нарийвчлан тусгаж, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой харилцааг тухайн зохицуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбоотой бусад хууль тогтоомжуудад заасан хэм хэмжээний актууд (дүрэм, журам, стандарт)-ын хэрэгжилтийг сайжруулах, батлагдаагүй журмуудыг яаралтай батлах, мөн шаардлагатай журмуудыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх этгээд болон санхүүжилтийн эх үүсвэрийг журамд тодорхой заах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг биелүүлээгүй, эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтанд оногдуулах хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэнд, нөхөн сэргээлтийн эрх зүйн зохицуулалт эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжуудад бүрэн тусгагдаагүй байгааг харгалзан үзэж эрүүл мэндийн салбарын шинэчлэн найруулах хууль тогтоомж, дүрэм журмуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй холбоотой бүлгийг заавал тусгах;
- Конвенцын хэрэгжилтийн улс орны хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргийг холбогдох яам /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, харьяа байгууллагуудын/-ны чиг үүрэг тусгайлан оруулах;
- Конвенцын хэрэгжилтийг хангах тусгайлсан байгууллага байгуулах эсхүл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл”-ийг ажлын албатай болгох, санхүүжилтыг улсын төсөвт тусгах буюу холбогдох өөрчлөлтийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд оруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх дэмжлэг үзүүлсэн бол төрөөс урамшуулах, татвараас чөлөөлөхтэй холбоотой тодорхой зохицуулалтуудыг холбогдох хууль тогтоомжуудад тусгах.

5.4.2.Төрийн байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийг ил тод, нээлттэй болгох чиглэлээр:

- Улсын Их Хурал болон Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тусгайлсан бодлогыг боловсруулах, үүнийг хэрэгжилтийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах орон тооны бус зөвлөл, түүний дэд болон салбар зөвлөлөөр хангуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөл, түүний дэд болон салбар зөвлөлийг бүрэн ажиллуулж, тэдгээрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, мөн үйл ажиллагааны зардлыг тухайн байгууллагын үйл ажиллагааны жилийн төсөвт заавал тусгах;
- Хөдөө орон нутаг, хотын захад амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст уян хатан байдлаар очиж үйлчлэх боломж, туслах хэрэгсэл, тохируулах хэрэглэгдэхүүнээр хангах асуудал, ганцаарчилсан тусламж, дэмжлэг, төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар төрийн эрх бүхий байгууллагууд дараагийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах;
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам зэрэг төрийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр төсөвлөсөн төсөв, санхүүгийн төлөвлөгөө, тэдгээрийн тайлан, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон олон нийтэд нээлттэй мэдээлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон мэдээлэл, статистик, судалгаа мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, эсхүл холбогдох төрийн бусад байгууллага нээлттэй байршуулах;
- Холбогдох төрийн байгууллагаас олон улсын байгууллагууд болон бусад улсуудтай хамтран, эсхүл тэдгээрийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг явцын мэдээлэл (төслийн хэрэгжилт, зарцуулсан төсөв, хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, гарч буй өөрчлөлт г.м.)-ийг олон нийтэд нээлттэй байршуулах, хагас жил тутам мэдээлэх;
- Холбогдох төрийн байгууллага олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцоог хангаж ажиллах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй холбогдсон аливаа шийдвэр гаргахад тэдний дуу хоолой, тулгамдаж байгаа асуудлыг заавал сонсох хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулах (энэ төрлийн уулзалт, хэлэлцүүлгийг хуулийн төсөл танилцуулах, мэдээлэл хүргэх, олон нийтийн үйл ажиллагаагаа явуулахад зохион байгуулж байгаа хэдий ч тэдгээр нь жилд нэг удаа, эсхүл 6 сард нэг удаа буюу хэт хол зайтай байгаа тул давтамжийг ойртуулж, өмнөх уулзалтаас гарсан саналыг шийдвэрлэсэн байдал, үр дүнг танилцуулах зорилгоор давтамжийг нэмэгдүүлэх нь зүйтэй байна).

5.4.3.Төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийг ил тод, нээлттэй болгох чиглэлээр:

- Олон улсын болон төрийн байгууллагын захиалгын дагуу, эсхүл хуульд заасны дагуу хийж гүйцэтгэсэн сургалт, судалгаа, үзүүлсэн үйлчилгээ мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх;
- Барилга, байгууламж, авто зам зэрэг нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст орж ажиллаж байгаа төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгах, өөрт тулгамдаж байгаа асуудлаа тухайн комиссыг томилсон эрх бүхий байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Өөрийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эмзэг мэдээллийг чанд нууцлах.

5.4.4.Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн, нөхөн сэргээлтийн чиглэлээр:

- Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох, протез ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ, тэдгээрийн хөнгөлөлтийг жил бүр зах зээлийн ханштай уялдуулан шинэчлэн тогтоох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгож байгаа тэтгэмж, тэтгэлгийн зарим нь тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага байгааг анхаарч, тэтгэмж, тэтгэлгийг хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх (хамгийн багадаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүргэх);
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай нөхөн сэргээлтийг үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр ажиллах мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн үйлчилгээ тогтмол авч байгаа болон авах шаардлагатай хүмүүсийн мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрээр Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус бүрдүүлэх.

6. НОМ ЗҮЙ

Ном, Гарын авлага, Эрдэм шинжилгээний ажил
1. Г.Совд нарын хамтын бүтээл, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000 он, 2. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, 1966 он 3. Г.Гал-Эрдэнэ, А.Анар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн төвшинг тогтоох нь”, 2021 он, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, “Бэрх биш ээлтэй” төсөл, “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт – 2021”, Эрдэм шинжилгээний онол практикийн хурлын эмхтгэл, 4. У.Бадамсүрэн, “Харааны бэрхшээлтэй иргэдийн гэр бүл төлөвлөлтөд тулгамдаж буй зарим асуудал,” 2021 он, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, “Бэрх биш ээлтэй” төсөл, “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт – 2021”, Эрдэм шинжилгээний онол практикийн хурлын эмхтгэл, 5. Г.Жаргалмаа, Н.Болормаа, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс” 2021 он, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, “Бэрх биш ээлтэй” төсөл, “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт – 2021”, Эрдэм шинжилгээний онол практикийн хурлын эмхтгэл, 6. Ц.Сүхбаатар, “Монголын ахмадуудын өнөөгийн байдал, цаашдын хандлага, зорилтын тухай”, 2019 он Философийн хүрээлэн, Монголын ахмадын холбоо, “Ахмадуудын нийгэм эдийн засгийн байдал, цаашдын хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл”, 7. Г.Жаргалмаа,Д.Одгэрэл, IRIM судалгааны төв, Боловсролын их сургууль, " Тэгш хамруулан сургах үзэл санааны хүрээнд боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийг үнэлж буй олон улсын туршлага", 2018 он 8. Д.Сарантуяа “ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах аргад хийсэн судалгааны үр дүн, 2019 он 9. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2022 он 10. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2021 он 11. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2020 он 12. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа, Мэдээллийн лавлах, 2023 он 13. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа, Мэдээллийн лавлах, 2022 он 14. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа, Мэдээллийн лавлах, 2021 он 15. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа, Мэдээллийн лавлах”, 2020 он 16. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын судалгаа, 2022 он 17. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаархи Монгол Улсын анхдугаар илтгэл 18. Японы хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлогын гарын авлага, Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл, 2018 он 19. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2019 он

20. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2021 он

Тайлан, илтгэл, зөвлөмж

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, “Бэрх биш ээлтэй” төсөл, “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт – 2021”, Эрдэм шинжилгээний онол практикийн хурлын эмхтгэл,
2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка төсөл, Хууль зүйн доктор, Д.Сүнжид, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”, 2018 он,
3. Монгол Улсын Засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийгн тухай” Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2 болон 3 дугаар тайлан, 2023 он,
4. Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хорооноос ирүүлсэн асуумжийн хариулт, 2020 он,
5. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, 2016 он
6. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл, 2017 он,
7. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл, 2020 он,
8. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дэх илтгэл, 2021 он,
9. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл, 2022 он,
10. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дэх илтгэл, 2023 он,
11. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2024 он,
12. Боловсрол, шинжлэх ухааны яам, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, “Эс Ай Си Эй” ХХК, “Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”, 2023 он,
13. Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, "Ковид-19 ба хөгжлийн бэрхшээл чанарын судалгааны тайлан”
14. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороонд Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаас илгээж буй Сүүдэр илтгэл
15. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, (2020 он),
16. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, (2021 он),
17. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, (2022 он),
18. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, (2023 он),
19. Дохио хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо” НҮТББ, “Монгол дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээний тайлан”, 2023 он.
20. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 сарын 11- ээс 20-ны өдрүүдэд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмжүүд” 2017 он
21. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2022 он тайлан”,
22. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар III, “Хөдөлмөрийн тухай хуулийн 111 (шинэчилсэн найруулгын 144) зүйлийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн тайлан”, 2022 он,

23. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Зорилтот бүлгийн сонгогчдын эрхийн хэрэгжилтэд хийсэн хяналт, үнэлгээ, мониторинг, 2021 он
24. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын судалгаа” Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” Төслийн эцсийн үнэлгээний тайлан, 2022 он
21. Мерси кор монгол хөгжлийг бүтээлцсэн он жилүүд” нэгдсэн тайлан 2020 он

Цахим хуудас

1. United Nations, Sixty-first session of the General Assembly by resolution A/RES/61/106, Convention On The Rights of Persons With Disabilities (CRPD), 2007 Холбоос:https://www.un.org/en/development/desa/population/migration/generalassembly/docs/globalcompact/A_RES_61_106.pdf
2. United Nations, Department of Econimic and Social Affairs, Social Inclusion, Convention On The Rights Of Persons With Disabilities (CRPD) Холбоос:https://social.desa.un.org/issues/disability/crpd/convention-on-the-rights-of-persons-with-disabilities-crpd
3. Монгол Улсын Хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг соёрхон батдах тухай, 1 дүгээр зүйл. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдөр баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсан хууль. Холбоос:https://legalinfo.mn/mn/detail/10034
4. Монгол Улсын Их Хурлын 2020 рны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “АЛСЫН ХАРАА - 2050” Монгол Улсын Урт Хугацааны Хөгжлийн Бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Хоёр хүний хөгжил. Холбоос:https://legalinfo.mn/mn/detail/15406
5. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн албан ёсны цахим хуудас, Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимйн танилцуулга, Холбоос:https://ses.msue.edu.mn/Category/dep
6. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан ёсны цахим хуудас, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг, Холбоос:https://mlsp.gov.mn/content/detail/1659
7. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийн танлцуулга, Холбоос: https://mlsp.gov.mn/content/detail/1659
8. Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг, Онцгой байдлын ерөнхий газар, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Холбоос: https://nema.gov.mn/instructions
9. Эрүүл мэндийн сайдын 2010 оны 04-р сарын 01-ний өдрийн “Үр хөндөлтийг зохицуулах тухай журам” Холбоос: https://legalinfo.mn/mn/detail?lawId=210116
10. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комиссын боловсрол, судалгааны хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Өнөржаргалын 2021 оны 11-р сарын 13-ны өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөр үржихүйн эрхийн талаар” ярилцлага Холбоос: https://www.unuudur.mn/a/215256
11. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”, танилцуулга, Холбоос: https://mlsp.gov.mn/content/detail/33
12. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Холбоос: https://rdccd.mn/
13. Монгол Улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам Холбоос: https://mlsp.gov.mn/content/detail/953

14. Монгол Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Холбоос: https://www.parliament.mn/nn/29907/
15. Үндэсний Статистикийн Хороо, Статистийн мэдээллийн нэгдсэн сан, Холбоос: https://www.nso.mn/
16. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын цахим хуудас үзэх Холбоос: http://www.gadpwd.gov.mn/
17. Japan International Cooperation Agency" цахим хуудас, Холбоос: https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/015/index.html
18. UNESCO Монголын Үндэсний комиссын цахим хуудас, Холбоос: http://unesco.mn/?page_id=398
19. Монгол Улсын Сангийн яам цахим хуудас, Холбоос: https://mof.gov.mn/article/entry/china-01
20. "Save the Children" цахим хуудас, Холбоос: https://savethechildren.mn/mn/page/education
21. Дэлхийн Банк цахим хуудас, Холбоос:https://www.facebook.com/WorldBankMongolia/photos/a.111733500236954/529881418422158/?locale=ms_MY
22. Canada-Монгол дахь Канад сан цахим хуудас, Холбоос: https://canadafundmongolia.mn/2021/11/11/2021-2022/

Статистик тоон мэдээлэл

1. Боловсрол, шинжлэх ухааны яам, Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 2022/2023 оны тоон мэдээлэл, Холбоос: https://moe.gov.mn/post/132091
2. Боловсрол, шинжлэх ухааны яам, Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн 2022-2023 оны хичээлийн жилийн мэдээ, насны ангиллаар,
3. Холбоос: https://moe.gov.mn/post/161374
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар "Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчийн статистик тоон мэдээ" Холбоос: http://www.gadpwd.gov.mn/index.php/page/277
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн албан ёсны цахим хуудас, Мэргэжлээс шалтгаалах өвчний төрөл, тоо, хувиар – 2021 он, Холбоос: https://mlsp.gov.mn/content/detail/3065
6. Эрүүл мэндийн яам, сэргээн засах тусламж үйлчилгээний тоон үзүүлэлт - 2024 он. Холбоос: https://moh.gov.mn/uploads/files/2598e2246e41cd2c5bed46674840580341cd8b4b.pdf
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар "Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчийн статистик тоон мэдээ" 2024 он Холбоос: http://www.gadpwd.gov.mn/index.php/page/803
8. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны статистик мэдээ, 2021 он, Холбоос: https://mlsp.gov.mn/content/detail/953

---oOo---